

“ЭКСПОРТЫН ЗАМЫН ЗУРАГЛАЛ”

Судалгааны ажлын хураангуй.....	7
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	9
1.1. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨЛӨН ГЭДЭСНИЙ ЭКСПОРТ	9
1.2.СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ	14
1.3.ГОО САЙХНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ	16
1.4.МОНГОЛ ГЭРИЙН ЭКСПОРТ	18
1.5.АРЬС ШИРНИЙ ЭКСПОРТ	20
1.6.НООС, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ	24
1.7.САМРЫН ИДЭЭНИЙ ЭКСПОРТ	30
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЭКСПОРТЫН “AS IS” ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАМЫН ЗУРАГЛАЛ.....	32
2.1.ЭКСПОРТЫН ҮЙЛ ЯВЦЫН ТУХАЙ	32
2.2. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨЛӨН ГЭДЭС.....	36
2.2.1. Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц	36
2.2.2. Хил, гааль дээрх үйл явц.....	49
2.2.3. Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц.....	53
2.2.4.Экспортын замын зураглал	55
2.3.СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН	63
2.3.4. Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц	63
2.3.2.Хил, гааль дээрх үйл явц.....	68
2.3.3.Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц.....	70
2.3.4.Экспортын замын зураглал	72
2.4. ГОО САЙХНЫ БҮТЭЭГДЭХҮҮН.....	77
2.4.1. Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц	77
2.4.2.Хил, гааль дээрх үйл явц.....	81
2.4.3.Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц.....	82
2.4.4.Экспортын замын зураглал	84
2.5.МОНГОЛ ГЭР.....	88
2.5.1. Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц	88
2.5.2.Хил, гааль дээрх үйл явц.....	90
2.5.3.Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц.....	91
2.5.4.Экспортын замын зураглал	92
2.6.АРЬС ШИРЭН БҮТЭЭГДЭХҮҮН.....	96
2.6.1.Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц	96
2.6.2.Хил, гааль дээрх үйл явц.....	99
2.6.3.Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц.....	101
2.6.4.Экспортын замын зураглал	102
2.7.НООС, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН.....	108
2.7.1.Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц	108
2.7.2.Хил, гааль дээрх үйл явц.....	115
2.7.3.Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц.....	117

2.7.4.Экспортын замын зураглал	118
2.8.САМРЫН ИДЭЭНИЙ ЭКСПОРТЫН ЗАМЫН ТОЙМ СУДАЛГАА.....	125
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ОРЦУУДЫН ИМПОРТЫН ЗАМЫН ЗУРАГЛАЛ	131
3.1.Хүнсний орцын импорт	131
3.2.Сав баглаа, боодлын импорт	134
3.3.Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт	137
3.4.Химийн бодис, будгийн импорт.....	138
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭКСПОРТЫН “ТО ВЕ” ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	142
4.1.ЭКСПОРТОД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД	142
4.2.ГАДААД УЛС ОРНУУДЫН САЙН ТУРШЛАГА	149
4.2.1.Экспорт, импортын замын зураглал	149
4.2.2.Экспортыг хөнгөвчлөх бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээний туршлага	165
4.3.ЭКСПОРТЫН ҮЙЛ ЯВЦЫН “ТО ВЕ” ШИНЖИЛГЭЭ	172
4.3.1.Мах, махан бүтээгдэхүүн, өлөн гэдэс	173
4.3.2.Сүү, сүүн бүтээгдэхүүн.....	177
4.3.3.Гоо сайхны бүтээгдэхүүн	179
4.3.4.Монгол гэр.....	181
4.3.5.Арьс шир	182
4.3.6.Ноос, ноолууран бүтээгдэхүүн	185
4.4.ЭКСПОРТЫН ҮЙЛ ЯВЦЫГ САЙЖРУУЛАХ САНАЛ	188
4.5.ЗӨВЛӨМЖ	194
Хавсралт	199

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Махны экспорт \мянган ам.доллаароор\	10
Хүснэгт 2. Махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ ба орлого	12
Хүснэгт 3. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспорт \кг-аар\.....	14
Хүснэгт 4. Сүүн бүтээгдэхүүний экспортын орлого \мянган ам.доллаароор\	15
Хүснэгт 5. Гоо сайхны зарим бүтээгдэхүүний экспортын хэмжээ \кг-аар\.....	16
Хүснэгт 6. Гоо сайхны зарим бүтээгдэхүүний экспортын орлого \мянган ам.доллаароор\	17
Хүснэгт 7. Савангийн экспортын хэмжээ болон орлого \мянган ам.доллаароор\	17
Хүснэгт 8. Арьс, ширэн түүхий эдийн экспортын хэмжээ \ширхэг\.....	21
Хүснэгт 9. Арьс, ширэн түүхий эдийн экспортын орлого \мянган ам. доллаароор\	21
Хүснэгт 10. Боловсруулсан арьс ширний экспортын хэмжээ \ дм2\	22
Хүснэгт 11. Боловсруулсан арьс ширний экспортын орлого \мянган ам.доллаароор\.....	22
Хүснэгт 12. Боловсруулсан арьс ширэн эдлэлийн экспортын орлого \мянган ам.доллаароор\.....	23
Хүснэгт 13. Хагас боловсруулсан ноос, ноолуурын экспортын тоо хэмжээ \кг-аар\	24
Хүснэгт 14. Хагас боловсруулсан ноос, ноолуурын экспортын орлого \мянган ам.доллаароор\	25
Хүснэгт 15. Хагас боловсруулсан ноос, ноолуурын бүтээгдэхүүний экспортын хэмжээ \кг-аар\.....	25
Хүснэгт 16. Хагас боловсруулсан ноос, ноолуурын бүтээгдэхүүний экспортын орлого \мянган ам.доллаароор\	26
Хүснэгт 17. Сүлжмэл хувцасны экспортын хэмжээ \ширхгээр\	26
Хүснэгт 18. Сүлжмэл хувцасны экспортын орлого \мянган ам.доллаароор\	27
Хүснэгт 19. Сүлжмэл бүтээгдэхүүний экспортын хэмжээ \ширхгээр\	28
Хүснэгт 20. Сүлжмэл бүтээгдэхүүний экспортын орлого \мянган ам.доллар\	28
Хүснэгт 21. Гаалийн хилээр гарах бараа, тээврийн хэрэгсэлд хийх гаалийн хяналт, бүрдүүлэлт	35
Хүснэгт 22. Махны эрүүл ахуйн олон улсын стандарт шаардлага	36
Хүснэгт 23. БНХАУ-ын малын шинэ, хөлдөөсөн, гулууз маханд тавигдах стандартууд.....	39
Хүснэгт 24. Махны экспортод ОХУ-ын талаас шаарддаг бичиг баримтууд	41
Хүснэгт 25. Япон улсын дулааны аргаар мах боловсруулахад тавигдах шаардлага	41
Хүснэгт 26. Мах, махан бүтээгдэхүүний экспортын бичиг баримтын жагсаалт	42
Хүснэгт 27. Экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явцын хугацаа, зардал: Адууны мах, дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах.....	43
Хүснэгт 28. Экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явцын хугацаа, зардал: Боловсруулсан өлөн гэдэс	44
Хүснэгт 29. Экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явцын хугацаа, зардал: Боловсруулсан махан бүтээгдэхүүн	44
Хүснэгт 30. Гэрчилгээ, зөвшөөрлүүдийн хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт.....	48
Хүснэгт 31. Хагас боловсруулсан махны экспортын хил, гааль дээрх үйл явц	52
Хүснэгт 32. Боловсруулсан өлөн гэдэс (агаарын тээвэр) экспортын хил, гааль дээрх үйл явц	53
Хүснэгт 33. Боловсруулсан махан бүтээгдэхүүний экспортын хил, гааль дээрх үйл явц.....	53
Хүснэгт 34. Экспортын тээврийн зардал \улс орноор, тээврийн хэрэгслээр\	54
Хүснэгт 35. Төлбөрийн нөхцөлүүд	55
Хүснэгт 36. Худалдаа хөгжлийн банкны шилжүүлэг хүлээн авах шимтгэл.....	55
Хүснэгт 37. Түүхий мах, дулааны аргаар боловсруулсан махны экспортын үйл явцын шат дараалал.....	55
Хүснэгт 38. Боловсруулсан өлөн гэдэсний экспортын үйл явцын шат дараалал	57
Хүснэгт 39. Боловсруулсан махан бүтээгдэхүүний экспортын үйл явцын шат дараалал	57
Хүснэгт 40. Мах, махан бүтээгдэхүүний экспортод импортлогч улсуудаас тавигдаж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал.....	59
Хүснэгт 41. Мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл явц дахь зардлын тооцоо.....	60
Хүснэгт 42. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын бичиг баримтын жагсаалт.....	64
Хүснэгт 43. Сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн хугацаа, зардал.....	67
Хүснэгт 44. Сүү, сүүн бүтээгдэхүүний гэрчилгээ, зөвшөөрлийн хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт	67
Хүснэгт 45. Сүү, сүүн бүтээгдэхүүний хил, гааль дээрх үйл явц.....	70
Хүснэгт 46. Экспортын тээврийн зардал \улс орноор, тээврийн хэрэгслээр\.....	71
Хүснэгт 47. Экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явц.....	72
Хүснэгт 48. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын үйл явцын шат дараалал.....	72
Хүснэгт 49. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортод импортлогч улсуудаас тавигдаж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал.....	74

Хүснэгт 50. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын үйл явц дахь зардлын тооцоо	74
Хүснэгт 51. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортод шаардлагатай бичиг баримтын жагсаалт	78
Хүснэгт 52. Гоо сайхны бүтээгдэхүүнийг экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц, хугацаа, зардал	80
Хүснэгт 53. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдийн хүсэлт гаргахад бүрдүүлэх материал	80
Хүснэгт 54. Гоо сайхны бүтээгдэхүүний хил, гааль дээрх үйл явц	81
Хүснэгт 55. Экспортын тээврийн зардал \улс орноор, тээврийн хэрэгслээр\	83
Хүснэгт 56. Экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явц	84
Хүснэгт 57. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын үйл явцын шат дараалал	84
Хүснэгт 58. Гоо сайхны экспортод импортлогч улсуудаас тавигдаж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал	85
Хүснэгт 59. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын үйл явц дахь зардлын тооцоо	86
Хүснэгт 60. Импортлогч орнуудын Монгол гэрт тавигддаг стандарт, шаардлагууд	88
Хүснэгт 61. Монгол гэрийн экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдийн хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт	89
Хүснэгт 62. Монгол гэрийн экспортын баримт бүрдүүлэлтийн үйл явцын хугацаа, зардал	90
Хүснэгт 63. Монгол гэрийн экспортын хил, гааль дээрх үйл явц	90
Хүснэгт 64. Монгол гэрийн экспортын тээврийн зардал \улс орноор, тээврийн хэрэгслээр\	91
Хүснэгт 65. Монгол гэрийн экспортын бүтээгдэхүүний төлбөрийг хүлээн авах үйл явц	92
Хүснэгт 66. Монгол гэрийн экспортын үйл явцын шат дараалал	92
Хүснэгт 67. Монгол гэр экспортод импортлогч улсуудаас тавигдаж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал	93
Хүснэгт 68. Монгол гэрийн экспортын үйл явц дахь зардлын тооцоо	93
Хүснэгт 69. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортод бүрдүүлж буй бичиг баримт	97
Хүснэгт 70. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортлоход шаардлагатай гэрчилгээ, зөвшөөрлүүдийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт	98
Хүснэгт 71. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын баримт, бичиг бүрдүүлэлтийн хугацаа, зардал	99
Хүснэгт 72. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын хил, гааль дээрх үйл явцын дараалал, хугацаа, зардал	100
Хүснэгт 73. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын тээврийн зардал \улс орноор, тээврийн хэрэгслээр\	101
Хүснэгт 74. Экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явц	102
Хүснэгт 75. Хагас болон гүн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүний экспортын үйл явцын шат дараалал	102
Хүснэгт 76. Япон улсаас арьс ширэн бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал	103
Хүснэгт 77. БНХАУ-аас арьс ширэн бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал	104
Хүснэгт 78. Итали улсаас арьс ширэн бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал	104
Хүснэгт 79. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын үйл явц дахь зардлын харьцуулсан тооцоо	105
Хүснэгт 80. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын бичиг баримтын бүрдүүлэлт	109
Хүснэгт 81. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортлоход шаардлагатай зөвшөөрөл, гэрчилгээг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт	109
Хүснэгт 82. Ноолууран эцсийн бүтээгдэхүүн экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн хугацаа, зардал	110
Хүснэгт 83. Хагас боловсруулсан /ноолууран топс/ бүтээгдэхүүн экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн хугацаа, зардал	113
Хүснэгт 84. Ноос, ноолууран бүтээгдэхүүний хил, гааль дээрх үйл явцын дараалал, хугацаа, зардал ...	117
Хүснэгт 85. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын тээврийн зардал \улс орноор, тээврийн хэрэгслээр\	118
Хүснэгт 86. Экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явц	118
Хүснэгт 87. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын үйл явцын шат дараалал	118
Хүснэгт 88. ХБНГУ-ын ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал	119
Хүснэгт 89. БНСУ-ын ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал	120
Хүснэгт 90. БНХАУ-ын ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал	120

Хүснэгт 91. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын үйл явц дахь зардлын тооцоо	121
Хүснэгт 92. Самрын идээний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдийн хүсэлт гаргахад зарцуулах хугацаа, зардал	129
Хүснэгт 93. Хүнсний орцын материалын импорт	131
Хүснэгт 94. Хүнсний орцын материалын импортын үйл явцын шат дараалал	133
Хүснэгт 95. Сав баглаа, боодлын импортын үйл явцын шат дараалал	134
Хүснэгт 96. Үйлдвэрлэлийн энгийн орцын импортын хугацаа ба зардал	134
Хүснэгт 97.Импортын аккредитив	136
Хүснэгт 98. Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импортын үйл явцад зарцуулах цаг, зардал	137
Хүснэгт 99. Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импортын хугацаа, зардал.....	137
Хүснэгт 100. Тоног төхөөрөмжийн импортын тээврийн зардал /улс орнуудаар/.....	138
Хүснэгт 101. Химийн бодис, будгийн импортын бичиг баримт бүрдүүлэлтэд зарцуулах цаг, зардал	139
Хүснэгт 102. Химийн бодис, будгийн импортын хугацаа, зардал	140
Хүснэгт 103. Химийн бодис, будгийн тээврийн зардал /улс орнуудаар/	141
Хүснэгт 104. АНР шинжилгээний үнэлгээний арга	142
Хүснэгт 105. Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц дахь тулгамдаж буй асуудлууд	142
Хүснэгт 106. Хил, гааль дээрх үйл явцад тулгамдаж буй асуудлууд	143
Хүснэгт 107. Экспортын тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явцад тулгамдаж буй асуудлууд	144
Хүснэгт 108. Орцуудын импортын төлбөр шилжүүлэх, бичиг баримт бүрдүүлэх, бүтээгдэхүүнийг хүлээн авах үйл явцад тулгамдаж буй асуудлууд	146
Хүснэгт 109. Экспортын бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль дээрх үйл явц, тээвэр, төлбөр хүлээн авах явцыг сайжруулах санал.....	147
Хүснэгт 110. Импортын бүтээгдэхүүний төлбөр шилжүүлэх, бичиг баримт бүрдүүлэх, бүтээгдэхүүнийг хүлээн авах үйл явцыг сайжруулах санал	148
Хүснэгт 111. Монгол, ОХУ, БНХАУ-ын логистикийн гүйцэтгэлийн индексийн харьцуулалт, 2018.....	149
Хүснэгт 112. Гадаад улс орнуудын экспортын бичиг баримт бүрдүүлэлт	150
Хүснэгт 113. Итали улсын экспорт, импортод шаардагддаг бичиг баримтууд	150
Хүснэгт 114. БНЭУ-ын экспорт, импортод шаардагддаг бичиг баримтууд	150
Хүснэгт 115. Бразил улсын экспорт, импортод шаардагддаг бичиг баримтууд	151
Хүснэгт 116. Австрали улсын экспорт, импортод шаардагддаг бичиг баримтууд	156
Хүснэгт 117. Гадаад улс орнуудын хил, гааль дээрх үйл явц	158
Хүснэгт 118. Гадаад улс орнуудын хил, гаалийн үйл явцыг хялбарчлахаар хэрэгжүүлж буй ажлын туршлага	161
Хүснэгт 119. Монгол улсын LPI-ийн үнэлгээ	163
Хүснэгт 120. Экспортын үйл явцыг хөнгөвчилсөн гадаад улс орнуудын туршлагаас Монгол Улсад хэрэглэх боломжууд.....	171
Хүснэгт 121. Мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал	174
Хүснэгт 122.Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал	178
Хүснэгт 123. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал	180
Хүснэгт 124. Монгол гэрийн экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал	181
Хүснэгт 125. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал	183
Хүснэгт 126. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал	185
Хүснэгт 127. Экспортын үйл явцыг хөнгөвчлөхөд оролцогч талуудын хариуцах ажлын санал.....	192
Хүснэгт 128. Экспортын үйл явцыг хөнгөвчлөх саналууд ба тэдгээрийн хууль эрх зүйн хүрээнд тусгагдсан байдал	193

Товчилсон үгсийн жагсаалт

Англи хэл дээр:

AHP	Analytic hierarchy process
HS	Harmonized System
CDS	Customs Decisions System
CBP	Customs and Border Protection
DDP	Delivery Duty Paid
DAP	Delivered-at-Place
FEC	Front End Credibility
FCA	Free Carrier Agency
eTIR	electronic Transports Internationaux Routiers (French abbreviation translates as International Road Transport)
IPR	Inward Processing Relief
ITDS	International Trade Data System
HACCP	Hazard Analysis and Critical Control Point
TN VED	Commodities Classification Code of Foreign Economic Activity (Russian abbreviation in English)
REC	Russian Export center
SAD	Single administrative document
USPTO	United States Patent and Trademark Office

Монгол хэл дээр:

ААН	Аж ахуйн нэгж
АНЭУ	Арабын Нэгдсэн Эмират Улс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНАСАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс
ЕАБХАБ	Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага
ЕХ	Европын Холбоо
ЕАЭУ	Евроазийн эдийн засгийн холбоо
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НМХГ	Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газар
ОХУ	Оросын Холбооны Улс
СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
ХААЗД	Хөдөө аж ахуйн зохистой дадал
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн газар
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
УМЭАЦЛ	Улсын мал эмнэлэг ариун цэврийн лаборатори
ЧХШХЦЕГ	Чанарын Хяналт Шалгалт, Хорио Цээрийн Ерөнхий Газар

ЭКСПОРТЫН ЗАМЫН ЗУРАГЛАЛ

Судалгааны ажлын хураангуй

Монгол Улсад үйлдвэрлэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд экспортлоход зарцуулах зардал, цаг хугацааны шинжилгээг гүйцэтгэсний үндсэн дээр экспортын замын зураглалыг боловсруулж цаашид сайжруулах боломж, арга замыг тодорхойлоход судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны ажлын хүрээнд мах, махан бүтээгдэхүүн, өлөн гэдэс, сүү, сүүн бүтээгдэхүүн, гоо сайхны бүтээгдэхүүн, Монгол гэр, арьс шир, ноос, ноолууран бүтээгдэхүүн, самрын идээний экспортын замын зураглалыг боловсруулав.

Судалгааг (i) тоон /дэс дараалалтай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх/, (ii) чанарын /ажиглалт, ярилцлага, судалгаа/ арга зүй ашиглан сайжруулалт, зөвлөмж бэлтгэх байдлаар явууллаа.

Судалгаанд аль болох олон оролцогч талаас эх үүсвэртэй мэдээлэл цуглуулан өгөгдлийг гурвалжлах (Триангуляц) аргаар харьцуулсан дүн шинжилгээ хийж мэдээллийг нарийвчлалыг бататгав. Бүтэцлэх арга (агуулгын дүн шинжилгээ)-ний аргаар үйл явц, процедурын шинж чанар, динамикийг шинжлэхэд ашигласан. Ажиглалтын аргыг экспортын болон нэмүү өртөг шингэсэн орцын импортын процессын бодит чанарын шинжилгээг гүйцэтгэхэд ашиглалаа. Экспортын бичиг баримт бүрдүүлэлт, хил, гааль дээрх үйл явц, тээвэрлэлт, төлбөр төлөлтийн үйл явцад тулгамдаж буй асуудлуудыг оролцогч талуудаас авсан асуулгад тулгуурлан АНР шинжилгээний арга зүйгээр үнэлсэн болно.

Маж, махан бүтээгдэхүүн, өлөн гэдэс, сүү, сүүн бүтээгдэхүүн, Монгол гэр, гоо сайхны бүтээгдэхүүн, ноос, ноолууран бүтээгдэхүүн, арьс ширэн бүтээгдэхүүний экспортын динамик судалгааг 2006-2020 оноор гүйцэтгэсэн.

Гадаад улс орнуудын туршлагад БНХАУ, ОХУ, Итали, Бразил, АНУ, Литви, Бельги, БНЭУ, Казакстан, БНТУ, Герман, Швед, Австрали улсууд болон Олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, туршлагыг баримт бичгийн судалгааны нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх арга зүйгээр судлав. Судалгааны үр дүнд улс орнуудын экспортын замын зураглал нь бүтээгдэхүүний нэр төрлөөс хамаарч өөр өөр байгаа боловч экспортын үйл явцыг хялбарчлахдаа нэг цонхны үйлчилгээ, цахим платформ үүсгэх, олон улсын цахим сүлжээнд нэгдэх, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг нийтлэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Маж, махан бүтээгдэхүүн, өлөн гэдэс, сүү, сүүн бүтээгдэхүүн, гоо сайхны бүтээгдэхүүн, Монгол гэр, арьс шир, ноос, ноолууран бүтээгдэхүүнийг экспортлоход болон зөвшөөрөл, гэрчилгээ авахад шаардагдах баримт бичгийн жагсаалтыг гаргаж эдгээр баримт бичигт зарцуулах цаг хугацаа, зардлыг тооцсоноос гадна хил, гааль дээрх үйл явц, тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явцын цаг хугацаа, зардлыг тооцож эцэст нь экспортын замын зураглалыг AS IS шинжилгээний арга зүйгээр гүйцэтгэв. Мөн түүнчлэн орцуудын импортын замын зураглалыг гаргалаа.

Судалгаанд оролцогч талуудын санал болон судалгааны үр дүнд тулгуурлан экспортын үйл явцыг хөнгөвчлөх, хялбарчлах арга зам, саналыг судалгааны объект болох бүтээгдэхүүн тус бүрээр боловсруулж ТО ВЕ шинжилгээг гүйцэтгэлээ.

Экспортод гаргах шат дамжлагыг бууруулах, хөнгөвчлөх талаар оролцогч талуудыг цахим сүлжээнд нэгтгэх, Цар тахлын сөрөг нөлөөг бууруулах (тээвэр, ариутгал, төлбөрийн хугацааг зохицуулах), Экспортын бүтээгдэхүүнд шинжилгээ хийх лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, тоог өсгөх, Далайд гарцгүй орны хувьд олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллах, өмнө нь шийдэгдсэн өндөр ач холбогдолтой ажлуудыг урагшлуулах, Гааль,

мэргэжлийн хяналтын бичиг баримтын давхардлыг арилгах, Олон улсын худалдааны талаар мэргэшсэн сайн зөвлөх, эксперттэй байх, Гадаад зах зээлд бүтээгдэхүүнийг борлуулах дистрибьютер, түнш, харилцагчтай байх, дүрэм, журамд өөрчлөлт оруулах зэрэг тулгамдсан асуудлууд дээр суурилж гадаад улс орнуудын туршлага, дотоод нөөц бололцоог бүрэн ашиглахад чиглэсэн саналуудыг өгсөн болно. Эцэст нь, төрийн байгууллагууд, экспортлогч аж ахуйн нэгжүүд, мэргэжлийн холбоодод хандаж зөвлөмж боловсруулав.

ТАЛАРХАЛ

“Экспортын замын зураглал” зөвлөх үйлчилгээг санхүүжүүлж арга зүйн зөвлөгөө өгч хамтарч ажилласан “Экспортыг дэмжих төсөл”-ийн захирал О.Онон, зохицуулагч Б.Дөлгөөн, Бизнес хөгжлийн ахлах мэргэжилтэн М.Баттулга, мэргэжилтэн О.Бүрэнжаргал, Должинсүрэн нарт талархлаа илэрхийлье.

“Экспортын замын зураглал” судалгааны ажилд оролцож санал бодлоо илэрхийлж хамтран ажилласан ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын газрын дарга, доктор Л.Чой-Иш, ГХЯ-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дэд захирал Г.Өлзийсайхан, ЗТХЯ, МХЕГ, ГЕГ, СХЗГ, ХААБ, ХААБ, УМЭАЦЛ, ХХААХҮйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн мэргэжилтэн нар, МЭЕГ-ын дарга Б.Ганзориг, СХЗГ-ын газрын дарга В.Ганзориг, АХБ-ны мэргэжилтэн Д.Өнөржаргал, “Траст трейд” ХХК, “Ашид гэр” ХХК, “Голден гоат” ХХК, “Глобал Номадик продактс” ХХК, “Монос” ХХК, “Говь” ХК, “Мон-Ирээдүй” ХХК, “Nord Road” ХХК, “Ланд бридж” ХХК, “Сүндэр логистик” ХХК, “Мат карго” ХХК, “Тэгш Чанар” ХХК, “Journey” ХХК, “Unique travel” ХХК, “Ази фарм” ХХК, “Монгол Тогоруу” ХХК, “Мах Импекс” ХХК, Голомт банк, Хаан банк, Хас банк, ХХБ-ны захирал, менежер, ажилтан нарт талархлаа илэрхийлье.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨЛӨН ГЭДЭСНИЙ ЭКСПОРТ


Монгол Улсын хэмжээнд бүртгэлтэй мал төхөөрөх 69 үйлдвэр, мах боловсруулах 135 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна. Мал, мах бэлтгэлийн улирлын хамаарлаас шалтгаалж 90-150 хоногт нийт 5.1 сая толгой бог, 1.3 мянган толгой бод мал төхөөрөх хүчин чадал суурилагдсан байна¹.

БНХАУ бол Монгол махны хамгийн том импортлогч орон юм. Монголын махны холбооны мэдээгээр, адуу, үхэр, хонь, ямааны махыг БНХАУ руу экспортлоход зориулж нийт 94.5 мянган тонн махны экспортын квотыг мах үйлдвэрлэгчдэд олгожээ. Үүнээс 54.5 мянган тонныг худалдааны ерөнхий ангиллаар, 40.0 мянган тонныг татвар зохицуулалтын хүрээнд нэмж олгожээ.

БНХАУ-д адууны мах экспортлох эрхтэй 8 аж ахуйн нэгж, хонь ямаа, үхрийн мах экспортлох эрхтэй 6 аж ахуйн нэгж, дулааны аргаар боловсруулсан мах экспортлох эрхтэй 5 аж ахуйн нэгж, нядалгааны эрхтэй 8 аж ахуйн нэгж ОХУ-д мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн 29 аж ахуйн нэгж, Вьетнам улсад дулааны аргаар боловсруулсан хонь, ямаа, үхрийн мах экспортлох эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн 4 аж ахуйн нэгж тус тус байна.

Монгол Улсын махны экспортыг HS 0201, 0202, 0204, 02045000, 0205, 0206, 0210 кодтой бүтээгдэхүүнүүдийн хувьд 2006-2020 оноор дараах хүснэгтээр харуулав.

Зураг 1. Махны экспорт (тонн)



Эх үүсвэр: (ГЕГ, 2021)

Сүүлийн 2 жилд үхрийн шинэ мах, хөлдүү мах экспортлоогүй бөгөөд ямааны мах, утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүний экспортын хэмжээ өссөн. Адууны мах, малын дайвар бүтээгдэхүүний экспорт өсөж байсан боловч 2020 онд буурсан. Махны экспортын 2011 оноос эхлэн буурсан шалтгаан нь зудаас хамаарсан малын тооны бууралт, малын өвчлөл, гадаад улс

¹ <https://mofa.gov.mn/exp/blog/10/81>

орнуудын импортын шаардлагыг хангаж чадахгүй байсантай холбоотой бол 2020 оноос эхлэн буурсан шалтгаан нь цар тахлын сөрөг нөлөө байна.

Монгол Улс БНХАУ, ОХУ, БНАСАУ, Казахстан, Вьетнам, Иран, АНЭУ, Япон зэрэг 15 улсад хонь, ямаа, үхэр, адууны мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог. Иран улс руу хонь, ямааны хөлдүү мах, Казахстан, Туркменистан улс руу хонины сүүл зэрэг дайвар бүтээгдэхүүн түлхүү экспортолж байна. Махны экспортын орлогыг дараах хүснэгтээр харуулав.


Хүснэгт 1. Махны экспорт (мянган ам.доллаар)

	Үхрийн шинэ мах	Үхрийн хөлдүү мах	Хонь, ямааны мах	Ямааны мах	Адууны мах	Малын дайвар бүтээгдэхүүн	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн
2006	309.1	4,425.0	0.5	-	10,279.4	1,207.3	355.4
2007	-	6,263.3	151.7	-	9,769.0	685.1	57.4
2008	-	8,497.8	280.4	-	10,983.6	928.0	18.5
2009	-	17,789.1	774.4	339.4	14,464.2	430.8	2.0
2010	-	8,063.9	25,850.0	20,835.7	18,971.0	1,499.5	-
2011	-	13,926.1	1,153.6	965.3	8,837.4	196.2	13.0
2012	-	3,301.3	1,775.3	1,485.7	4,765.3	511.9	13.0
2013	-	-	2,209.3	-	7,573.0	1,320.9	-
2014	-	1,590.6	-	-	4,971.5	238.9	277.5
2015	6.9	2,621.9	117.0	110.6	7,318.5	88.3	28.5
2016	-	1,592.3	361.5	159.6	14,392.6	59.2	93.9
2017	0.7	1,643.3	8,267.0	-	44,529.2	189.4	233.4
2018	130.4	3,175.8	15,567.7	2,643.2	64,974.0	2,179.7	131.3
2019	-	-	24,164.6	2,592.6	57,688.6	2,509.4	163.8
2020	-	-	4,828.3	2,639.0	33,283.4	1,257.1	403.1

Эх үүсвэр: ГЕГ, 2021

Монгол Улсаас экспортолсон нийт махны экспортын орлогын 78.5 хувийг адууны махны экспортын орлого эзэлдэг. Монгол Улсын адууны махны экспорт 2020 онд 17.6 мянган тонн байсан ба 97.6 хувийг БНХАУ руу экспортолсон бол үлдсэн хувийг Казахстан, Япон, ОХУ руу экспортолжээ. ОХУ жилд дунджаар 5.38 сая ам.долларын адууны махыг Монгол улсаас импортолдог нь ОХУ-ын нийт махны импортын 1.6 хувийг эзэлж байна.


Зураг 2. Адууны махны экспорт (экспортлогч улсуудаар, тонн)



Эх үүсвэр: ГЕГ, 2021

Хонь, ямааны шинэ, хөргөсөн, хөлдөөсөн махны экспортын хэмжээг дараах зургаар харуулав. Махны экспортын квот тогтоосон хэдий ч тахлын улмаас эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлууд тулгарч байгаатай холбогдуулан мах боловсруулах компаниуд 2020 оны 1-р сараас эхлэн үйл ажиллагаа нь тасалдаж экспортын хэмжээ буурсан.


Зураг 3. Хонь, ямааны мах \экспортлогч орнуудаар, тонн\



Эх үүсвэр: ГЕГ, 2021

Монгол Улсын хонь, ямааны махны экспортын хэмжээ 2020 онд 1.8 мянган тонн болсон бөгөөд өмнөх 2 жилтэй харьцуулахад 3 дахин буурчээ. Энэ нь мөн л дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр улс орнууд хилээ хааж, олон улсын тээвэрт саад тотгор учирсантай холбоотой юм. Хонь, ямааны махны экспортын 24.8 хувийг Иран улс эзэлж байгаа бол БНХАУ, Вьетнам, БНАСАУ, Казакстан, Малайз, Хонконг улсууд руу жилд 20 тонноос дээш, харин АНЭУ, Катар, ХБНГУ, Тайвань, Азербайжан зэрэг улсууд руу жилд 20 тонноос бага хэмжээтэй экспортыг хийдэг.

Зураг 4. Үхрийн хөлдүү махны экспорт \тонноор\



Эх үүсвэр: ГЕГ, 2021

Сүүлийн 2 жилд үхрийн хөлдүү мах экспортлоогүй, харин 2018 онд 1.1 мянган тонн мах экспортолжээ. Монгол Улсын үхрийн махны экспортын 80 гаруй хувийг ОХУ дангаараа эзэлдэг гол импортлогч орон нь юм. ОХУ нь Европын хамгийн их хүн амтай улс бөгөөд БНХАУ-ын хүн амтай харьцуулахад нэг хүнд ногдох махны хэмжээ 28%-иар илүү хэрэглэдэг².

HS 1601, 1602, 1604 код бүхий хиам, зайдас, лаазалсан махан бүтээгдэхүүн, лаазалсан загас, түрсний экспортын хэмжээ болон экспортын орлогыг сүүлийн 15 жилийн байдлаар дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ ба орлого

	Тоо хэмжээ кг\			Үнийн дүн \мянган ам.доллороор\		
	Хиам, зайдас	Лаазалсан махан бүтээгдэхүүн	Лаазалсан загас, түрс	Хиам, зайдас	Лаазалсан махан бүтээгдэхүүн	Лаазалсан загас, түрс
2006	3.0	237,719.6	-	-	384.4	-
2007	-	300,415.2	-	-	481.3	-
2008	-	242,160.1	45.0	-	542.0	0.3
2009	411.4	475,060.2	-	2.3	1,381.0	-
2010	40.0	85,592.1	362.0	0.1	283.0	1.9
2011	-	125,557.6	590.5	-	309.1	2.9
2012	-	25,406.0	593.6	-	139.1	3.9
2013	-	231.5	2,011.7	-	2.1	12.0
2014	-	23,115.2	8,657.7	-	123.7	26.5
2015	1,340.4	170,269.5	319.7	5.3	608.6	2.7
2016	12,524.8	436,744.5	303.8	38.1	1,550.9	1.4
2017	25,310.5	2,830,773.9	56.8	126.3	8,501.7	0.5
2018	158,690.0	29,222,173.1	216.0	620.8	79,038.6	0.5
2019	10,126.0	18,501,089.1	-	50.4	50,311.9	-
2020	-	21,181,374.0	5,510.4	-	60,242.4	12.3


Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

2018 онд хиам, зайдас 158.7 тонн, лаазалсан махан бүтээгдэхүүн 29.2 мянган тонныг экспортолж байсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Хиам, зайдас, лаазалсан махан бүтээгдэхүүн, лаазалсан загас, түрсний экспортын хэмжээ 2006-2009 онд өсөлттэй байсан ч 2010 оноос буурч 2015 оноос дахин нэмэгдсэн бөгөөд сүүлийн 15 жилд хэлбэлзэл ихтэй байжээ. Уг хэлбэлзэл нь гадаад зах зээл дэх эрэлтээс хамаарч байгаа бөгөөд боловсруулах үйлдвэрүүд байнгын худалдан авагчтай болох, албан ёсны дистрибьютер ажиллуулах шаардлагатайг илтгэнэ.

Монгол Улсын экспортын гол нэрийн махан бүтээгдэхүүнүүд нь хиам, зайдас, лаазалсан махан бүтээгдэхүүн байна. Махан бүтээгдэхүүний экспортоос 2020 онд 60.3 сая ам.долларын орлого олжээ. Боловсруулсан махан бүтээгдэхүүний 99.6 хувийг БНХАУ-д, 0.4 хувийг ОХУ-д экспортолдог.

² R. Perez, UNCTAD, and M. Boldbaatar, MICC, 2021


Зураг 5. Өлөн гэдэс, давсаг, гүзээний экспортын тоо хэмжээ болон орлого



Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

HS 0504 кодтой өлөн гэдэс, давсаг, гүзээний экспортын хэмжээ 2020 онд 857.3 тонн ба 9.3 сая ам.долларын орлого олсон байна. Эндээс бог малын өлөн гэдэсний экспортын хэмжээ 503.1 тонн, экспортын орлого 8.9 сая ам.доллар юм.

Зураг 6. Өлөн гэдэсний экспорт улс орнуудаар, хувь



Өлөн гэдэсний экспортын 25.5 хувийг Нидерланд, 19.8 хувийг Итали, 15.9 хувийг Ливан, 13.1 хувийг Австри, 8.1 хувийг Япон улсуудад экспортолдог. Харин Египет, Швейцар, ХБНГУ, Франц, Турк, Польш улсуудад үлдсэн хувийг нь экспортолж байна. Монгол Улс ЕХ руу экспортлох амьтан, ургамлын гаралтай 18 нэр төрлийн 70 бүтээгдэхүүний жагсаалтыг 2020 онд Европын Комисст хүргүүлсэн бөгөөд уг жагсаалтад өлөн гэдэсний багтаасан, нөгөө талаас Европын орнуудад өлөн гэдэсний эрэлт өндөр байгаа нь уг бүтээгдэхүүний экспорт нэмэгдэх боломжтойг харуулж байна.

Монгол Улсын махны экспортын тоо хэмжээг экспортолсон улс орнуудаар дараах зургаар нэгтгэн харуулав.

Мах, махан бүтээгдэхүүн, өлөн гэдэсний экспорт



Сүүлийн 2 жилд үхрийн хөлдүү мах экспортлоогүй. Үхрийн махны экспортын **80 гаруй хувийг** ОХУ эзэлдэг.



БНХАУ бол Монгол махны хамгийн **том импортлогч** орон юм.

Нийт махны экспортын орлогын **78.5 хувийг** адууны мах эзэлдэг.

2020 онд Монгол Улсын адууны махны экспорт **17.6 мянган** тонн байсан.



- Нидерланд
- Итали
- Ливан
- Австри
- Япон
- Бусад




Европын орнуудад өлөн гэдэсний эрэлт өндөр байгаа нь уг бүтээгдэхүүний **экспорт нэмэгдэх** боломжтойг харуулж байна.

Монгол Улс ЕХ руу экспортлох **амьтан, ургамлын гаралтай 18 нэр төрлийн 70 бүтээгдэхүүний** жагсаалтыг 2020 онд Европын Комисст хүргүүлсэн бөгөөд уг жагсаалтад өлөн гэдсийг багтаасан.



Хонь, ямааны махны экспортын хэмжээ 2020 онд **1.8 мянган** тонн болсон бөгөөд өмнөх 2 жилтэй харьцуулахад **3 дахин буурчээ.**



Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр улс орнууд **хилээ хааж**, олон улсын тээвэрт саад тотгор учирсантай холбоотой юм.

1.2.СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Монгол Улсын хэмжээнд сүү, сүүн бүтээгдэхүүний 204 үйлдвэр, цех /улирлын чанартай/ байгаагаас МХЕГ-ын эрсдэлийн үнэлгээ хийгдсэн 34 үйлдвэр цех, 77 хөргөлтийн төв үйл ажиллагаа явуулж тэдгээрт нийт 1680 гаруй хүн ажилладаг. Сүүний боловсруулах салбарын суурилагдсан хүчин чадал жилд 470.5 мянган тонн бөгөөд хүчин чадлынхаа 35 хувийг ашиглаж байна³.

Сүүлийн 15 жилийн байдлаар, HS 0401 кодтой шингэн сүү, цөцгий, HS 0402 кодтой өтгөрүүлсэн хуурай сүү, HS 04012110 кодтой хуурай сүү, HS 04019910 кодтой өтгөрүүлсэн сүү, HS 0403 кодтой тараг, цагаан идээ, HS 0404 кодтой шар сүү, HS 0405 кодтой цөцгийн тос, HS 0406 кодтой бяслаг, аарцны экспортын хэмжээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспорт кг-аар

	Шингэн сүү, цөцгий	Өтгөрүүлсэн, хуурай сүү, цөцгий	Хуурай сүү	Өтгөрүүлсэн сүү	Тараг, цагаан идээ	Шар сүү	Цөцгийн тос	Бяслаг ба аарц
2006	-	30.0	30.0	-	164.4	-	20,054.0	42.0
2007	-	75.0	75.0	-	15,540.9	-	-	-
2008	261,187.9	64,020.0	64,020.0	-	11.2	-	-	12,970.0
2009	-	20,200.0	20,200.0	-	142.0	-	20.0	10,000.0
2010	18.0	2,000.0	2,000.0	-	20,000.0	-	-	-
2011	-	23,263.6	3,023.6	-	22.6	-	-	-
2012	-	6,738.7	3,560.0	106.7	-	-	-	9.6
2013	-	5,880.0	3,252.0	-	12.0	-	-	84.8
2014	-	4,597.6	1,080.0	277.6	13.2	-	-	-
2015	-	490.2	79.2	411.0	1,300.0	-	9.9	130.0
2016	360.0	6,092.0	6,092.0	-	23,274.8	5.5	1,690.0	10,542.1

2017	1,360.0	242,956.0	242,938.0	18.0	65,776.9	100.0	117.3	15,097.6
2018	1,980.0	120,287.5	106,800.0	-	30,306.0	100.0	375.0	6,071.0
2019	-	795.0	795.0	-	1,673.4	-	2,000.0	3,333.2
2020	-	-	-	-	199,298.8	-	299.6	42,039.4

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Шингэн сүү, цөцгий, өтгөрүүлсэн сүү, шар сүүний экспорт тогтвортой бус байна. Харин цөцгийн тос, бяслаг, аарцыг сүүлийн 5 жилд экспортлох хэмжээ харьцангуй нэмэгджээ. 2020 онд тараг, цагаан идээ 199.3 тонн, бяслаг, аарц 42.1 тонныг экспортолсон нь нийт экспортын сүү, сүүн бүтээгдэхүүний 99.9 хувийг эзэлж байна. НҮБ-ын ХХААБ-ын суурин төлөөлөгч Винод Ахужа “Сүүлийн 30 жилд Азийн бүсийн сүүн бүтээгдэхүүний эрэлт гурав дахин нэмэгдсэн нь бүсийн хэмжээнд хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах, малчид, фермерийн аж ахуйг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байна” хэмээсэн нь сүү, сүүн бүтээгдэхүүний эрэлт дэлхий дахинд өсөж байгааг илтгэнэ.

Хүснэгт 4. Сүүн бүтээгдэхүүний экспортын орлого (мянган ам.доллаар)

	Шингэн сүү, цөцгий	Өтгөрүүлсэн, хуурай сүү, цөцгий	Хуурай сүү	Өтгөрүүлсэн сүү	Тараг, цагаан идээ	Шар сүү	Цөцгийн тос	Бяслаг ба аарц
2006	-	0.7	0.7	-	2.3	-	23.0	0.3
2007	-	3.3	3.3	-	14.3	-	-	-
2008	209.1	65.1	65.1	-	0.3	-	-	24.6
2009	-	36.7	36.7	-	0.3	-	0.1	20.0
2010	0.4	6.3	6.3	-	20.0	-	-	-
2011	-	40.6	4.7	-	0.9	-	-	-
2012	-	15.0	8.0	0.2	-	-	-	0.1
2013	-	14.5	8.6	-	0.1	-	-	1.2
2014	-	9.0	1.6	0.6	0.1	-	-	-
2015	-	1.2	0.1	1.0	3.8	-	0.1	0.7
2016	0.4	15.1	15.1	-	53.6	0.0	6.5	55.4
2017	2.3	828.9	828.9	0.0	441.8	0.5	0.8	127.5
2018	2.0	344.9	297.8	-	91.6	1.6	6.2	76.6
2019	-	6.2	6.2	-	2.0	-	44.9	15.8
2020	-	-	-	-	119.5	-	2.4	227.2

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Монгол Улс 2020 онд 227.2 мянган ам. долларын бяслаг, аарц, 119.5 мянган ам.долларын тараг, цагаан идээ, 2.4 мянган ам.долларын цөцгийн тос экспортолжээ. Одоогоор манай улсын сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, нэр төрөл цөөн байна. Цаашид бяслаг, аарц, жимс сүүний холимог бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлохын тулд гадаад зах зээлийн судалгааг нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай юм.

Монгол Улсын сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээг экспортолсон улс орнуудаар дараах зургаар нэгтгэн харуулав.

Сүү, сүүн бүтээгдэхүүний экспорт



Монгол улсын сүү боловсруулах салбарын суурилагдсан хүчин чадал жилд **470.5 мянган** тонн.

үүнээс

35 хувийг ашиглаж байна.

HS 0401 шингэн сүү, цөцгий,
HS 0402 өтгөрүүлсэн хуурай сүү,
HS 04012110 хуурай сүү,
HS 04019910 өтгөрүүлсэн сүү,
HS 0403 тараг, цагаан идээ,
HS 0404 шар сүү,
HS 0405 цөцгийн тос,
HS 0406 бяслаг, аарцны



2020 онд тараг, цагаан идээ **199.3 тонн**, бяслаг, аарц **42.1 тонныг** экспортолсон.



Нийт экспортын **99.9%**



Монгол Улс **2020** онд **227.2 мянган** ам.долларын бяслаг, аарц, **119.5 мянган** ам.долларын тараг, цагаан идээ, **2.4 мянган** ам.долларын цөцгийн тос экспортолжээ.

1.3.ГОО САЙХНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар нь харьцангуй шинэ салбар бөгөөд 1990 оноос өмнө зөвхөн гар нүүрийн саван үйлдвэрлэж байжээ. Харин 1989 оноос хувийн хэвшлийн анхны үйлдвэрүүд байгуулагдаж нүүр, арьс арчилгааны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхэлсэн.

Монгол Улсын гоо сайхны салбарт бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрх бүхий 30 орчим компани буюу “Монос”, “Монкрем”, “BOJSS COSMETIC”, “ИНАРУ” Нэгдэл, “МонЭко”, “NAURAL ESSENTIALS-Lhamour”, Стилетто ХХК-ууд тус салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Улсын хэмжээнд 2019 оны байдлаар 8.0 тэрбум төгрөгийн гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бөгөөд жилээс жилд үйлдвэрлэлийн хэмжээ өссөн. Сүүлийн 5 жилийн дунджаар үйлдвэрлэлийн хэмжээ жилд 21 хувиар өсөж, бүтээгдэхүүний нэр төрөл олширч байна (ХХААХҮЯ, 2021)⁴.

HS 3304 кодтой биеийн арьс арчилж, хамгаалах ариун цэврийн болон нүүр, хумс заслын бэлдмэл, HS 3305 кодтой үс арчлах зориулалтын бэлдмэл, HS 33051000 кодтой шампунь, HS 3307 кодтой ариун цэврийн бусад бэлдмэл, хэрэгслийн экспортын хэмжээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5. Гоо сайхны зарим бүтээгдэхүүний экспортын хэмжээ кг-аар\

	Биеийн арьс арчилж, хамгаалах ариун цэврийн болон нүүр, хумс заслын бэлдмэл	Үс арчлах зориулалтын бэлдмэл	Амны хөндий буюу шүдний ариун цэврийг сахих зориулалтын бэлдмэл, оо	Ариун цэврийн бусад бэлдмэл, хэрэгсэл
2006	-	-	-	-
2007	-	-	46.4	-
2008	-	-	-	-

⁴ <https://mofa.gov.mn/exp/blog/11/1863>

2009	-	-	-	-
2010	1,507.3	482.4	62.4	1,545.0
2011	235.0	1,121.4	81.8	57.6
2012	4,859.8	813.3	247.8	567.3
2013	5,635.4	1,815.4	3,058.1	60.2
2014	-	-	229.0	-
2015	-	-	144.0	-
2016	-	-	270.9	-
2017	-	-	431.2	-
2018	-	-	39.6	-
2019	-	-	33.3	-
2020	-	-	-	-

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Дэлхийн гоо сайхны бүтээгдэхүүний зах зээл 2017-2019 онд өсөлттэй байсан ч 2020 онд өмнөх жилийн борлуулалттай харьцуулахад найман хувиар буурсан. Хэдийгээр гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ дотоодод өссөн ч экспортод маш бага хэмжээний бүтээгдэхүүнийг экспортолдог. Салбарын судлаачдын судалгаагаар, гоо сайхны бүтээгдэхүүний экспортод нарийн шинжилгээ хийх лабораторийн хүчин чадал, хүрэлцээ, хангамж, малын гаралтай түүхий эдийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх дэвшилтэт технологийн нэвтрэлт сул байгаа нь сөргөөр нөлөөлдөг байна.

Хүснэгт 6. Гоо сайхны зарим бүтээгдэхүүний экспортын орлого (мянган ам.доллаар)

	Биеийн арьс арчилж, хамгаалах ариун цэврийн болон нүүр, хумс заслын бэлдмэл	Үс арчлах зориулалтын бэлдмэл	Шампунь	Амны хөндий буюу шүдний ариун цэврийг сахих зориулалтын бэлдмэл, оо	Ариун цэврийн бусад бэлдмэл, хэрэгсэл
2006	0.2	-	-	-	0.2
2007	4.0	-	-	1.0	0.2
2008	14.8	0.3	-	-	-
2009	1.4	1.1	-	-	-
2010	18.8	4.9	-	0.6	0.5
2011	14.1	6.0	-	1.1	0.4
2012	29.5	8.7	-	2.8	1.4
2013	34.9	7.1	-	1.2	0.8
2014	80.5	9.9	-	2.8	1.3
2015	183.1	69.7	-	1.7	1.2
2016	386.5	8.8	-	2.6	0.4
2017	178.4	21.7	-	4.5	10.9
2018	98.7	3.7	2.7	0.2	3.9
2019	229.3	33.8	26.6	0.1	3.7
2020	40.4	3.8	1.0	-	1.5

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Гоо сайхны бүтээгдэхүүний экспортоос 2020 онд 45.4 мянган ам.долларын орлого олжээ. Уг экспортын орлогын 89.0 хувийг биеийн арьс арчилж, хамгаалах ариун цэврийн болон нүүр, хумс заслын бэлдмэлийн экспортын орлого бүрдүүлж байна.

HS 3401 кодтой саван, HS 34011100 кодтой гар нүүрийн саван (эмчилгээний зориулалтын), HS 34011910 кодтой эдийн саван, HS 3402 кодтой угаалгын бодисын экспортын хэмжээ болон экспортын орлогыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 7. Савангийн экспортын хэмжээ болон орлого (мянган ам.доллар)

	Тоо хэмжээ \кг\				Үнийн дүн \мянган ам.доллар\			
	Саван	Гар нүүрийн саван	Эдийн саван	Угаалгын бодис	Саван	Гар нүүрийн саван	Эдийн саван	Угаалгын бодис
2006	10.0	-	10.0	-	-	-	-	7.4
2007	8.8	-	-	-	0.2	-	-	-
2008	57.0	-	-	-	0.3	-	-	-
2009	1,200.0	-	-	-	2.4	-	-	14.4
2010	202.8	-	-	138.8	2.0	-	-	4.4
2011	557.0	1.0	111.0	2.8	4.1	0.0	0.7	0.0
2012	327.7	325.4	-	3,200.0	4.0	3.7	-	17.5

2013	758.0	54.0	704.0	63.0	1.5	0.4	1.1	0.1
2014	1,344.9	1,157.8	-	-	8.6	7.2	-	294.4
2015	1,050.2	693.3	-	-	187.6	88.7	-	0.3
2016	1,177.9	431.9	-	-	10.5	5.9	-	94.1
2017	2,287.1	1,122.6	-	-	30.9	24.4	-	18.6
2018	858.0	409.6	-	-	15.0	10.0	-	0.2
2019	68,318.8	65,294.4	2,979.6	-	175.7	155.3	19.9	0.4
2020	165.5	106.6	-	-	4.5	4.0	-	6.6


Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Экспортод гаргаж буй саван, савангийн төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого 15.1 мянган ам.долларт хүрчээ. Уг экспортын орлогын 43.7 хувийг угаалгын бодис, 29.8 хувийг саван, 26.5 хувийг эмчилгээний зориулалтын гар нүүрийн саван бүрдүүлдэг.

Монгол Улсын гоо сайхны бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээг экспортолсон улс орнуудаар дараах зургаар нэгтгэн харуулав.

Зураг 9. Гоо сайхны бүтээгдэхүүний экспорт

Гоо сайхны бүтээгдэхүүний экспорт



Дэлхийн гоо сайхны бүтээгдэхүүний зах зээл 2017-2019 онд өсөлттэй байсан ч 2020 онд өмнөх жилийн борлуулалттай харьцуулахад **найман хувиар буурсан**.




Гоо сайхны бүтээгдэхүүний экспортоос 2020 онд **45.4 мянган** ам.долларын орлого олсон.

Нийт орлогын 89%



Экспортод гаргаж буй саван, савангийн төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого **15.1 мянган ам.долларт** хүрчээ.

- Угаалгын бодис
- Саван
- Гар нүүрийн саван



Биеийн арьс арчилгаа, хамгаалах Нүүр, хумс заслын бэлдмэл

Гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ дотоодод өссөн ч экспортод маш бага хэмжээний бүтээгдэхүүнийг экспортолдог.


1.4.МОНГОЛ ГЭРИЙН ЭКСПОРТ

Монгол гэр үйлдвэрлэлийн чиглэлээр “Хангай гэр” ХХК, “Дээдсийн гэр” ХХК, “Халх гэр хужирт” ХХК, “Монгол гэр хужирт” ХХК, “Зүүн сайн” ХХК, “Тэнгэрлэг өргөө” ХХК, “Өвөг дээдсийн гэр” ХХК, “Хорол өргөө” ХХК, “Их өргөө” ХХК, “Монгол гэр” ХХК, “Өнө монгол гэр” ХХК, “Батдэлгэрэх” ХХК, “Мөнгөн гэр” ХХК “Уянгын гурван эрдэнэ” ХХК, “Удунвара эрдэнэ” ХХК, “Уянга хийц” ХХК, “Сэлнэн” ХХК зэрэг 150 гаруй аж ахуйн нэгж, иргэн үйл ажиллагаа явуулж байна (dnn.mn, 2021)⁵. Франц, Польш, Канад зэрэг улсуудад Монгол гэрийг дамжуулан борлуулдаг сүлжээ ажилладаг.

⁵ <https://dnn.mn>

HS 9406 кодтой Монгол гэрийн экспортын хэмжээ болон экспортын орлогын дүнг дараах зургуудаар харуулав.


Зураг 10. Монгол гэрийн экспортын хэмжээ (тоогоор)



Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Монгол гэрийн экспорт 2006 онд 18.7 мянган ширхэг байсан бол сүүлийн жилүүдэд буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2020 онд 624 Монгол гэрийг л экспортолжээ. Монгол гэрийн экспортын тоо хэмжээ буурсан шалтгаан нь цар тахлын улмаас дэлхий нийтэд аялал жуулчлалын салбар зогсонги байдалд орсон, тэвээр логистикийн үйл ажиллагаанд доголдол гарсантай холбоотой. Тухайлбал: 2020 оны 2 дугаар улирлын байдлаар, Монгол Улсад 43,779 жуулчин ирсэн нь өмнөх онуудаас 5 дахин буурсан үзүүлэлт байна⁶.

Зураг 11. Монгол гэрийн экспортын орлого (мянган ам.доллаар)



Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

2006 онд 18.7 мянган гэрийг 1.1 сая доллароор экспортолж байсан бол 2020 онд 624 гэрийг 1.3 сая ам.доллаароор экспортолсон нь нэгж бүтээгдэхүүний экспортын үнэ нэмэгдсэнийг илтгэнэ.

⁶ С.Даваасүрэн (2020), Цар тахал (ковид-19) ба Монголын эдийн засаг


Монгол Улсын Монгол гэрийн экспортын тоо хэмжээг экспортолсон улс орнуудаар дараах зургаар нэгтгэн харуулав.

Зураг 12. Монгол гэрийн экспорт



Монгол гэрийн экспорт **2006** онд **18.7 мянган** ширхэг байсан бол сүүлийн жилүүдэд **буурсан** үзүүлэлттэй байна.

Монгол гэрийн экспортын орлого (мянган ам.доллаар)



2006 онд **18.7 мянган** гэрийг **1.1 сая** доллароор экспортолж байсан бол **2020** онд **624** гэрийг **1.3 сая** ам.доллаароор экспортолсон нь нэгж бүтээгдэхүүний экспортын **үнэ нэмэгдсэнийг** илтгэнэ.

1.5.АРЬС ШИРНИЙ ЭКСПОРТ

Арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа 2000 оноос эхлэн сэргэж Улаанбаатар, Дархан хотод арьс шир боловсруулах 34 үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна. Үүний зэрэгцээ арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 100 гаруй жижиг, дунд үйлдвэрүүд нийслэл, аймаг орон нутагт ажилладаг.

Бүтцийн хувьд, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн салбарт арьс ширийг хагас боловсруулах 14, гүн боловсруулах хуурай цех 4, гүн боловсруулах жижиг үйлдвэр 12, гүн боловсруулах том үйлдвэр 10, завод ноос, ноолуур угаах 6 аж ахуй нэгж, урьдчилан цэвэрлэх байгууламж НӨҮГ, Хөнгөн үйлдвэрлэлийн судалгаа туршилт үйлдвэрлэлийн Армоно корпораци ТӨААТҮГ үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсад арьс ширний гарц 2011-2019 онд 8.4-17.6 сая ширхэгт хүрч, 8 жилд 71.3%-аар буюу жилд дунджаар 13.1%-аар өссөн. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 9,873,603.7 сая төгрөг, арьс ширний салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 79,978.5 сая төгрөг бөгөөд арьс ширний салбарын үйлдвэрлэл нь аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн 0.3% -ийг эзэлж байна (ХХААХҮЯ, 2021)⁷.

⁷ <https://mofa.gov.mn/exp/blog/11/176>

Арьс шир боловсруулах үйлдвэрүүд 18,089.5 мянган ширхэг арьс ширийг хагас боловсруулах, 2508.2 мянган ширхэг арьс ширийг гүн боловсруулах суурилагдсан хүчин чадалтай боловч хагас боловсруулах хүчин чадлын 33.8%, гүн боловсруулах хүчин чадлын 68.6%-ийг тус тус ашигладаг (ХХААХҮЯ, 2021)⁸.

HS 4101 кодтой үхэр, адууны боловсруулаагүй шир, хуулдас, HS 41012011 кодтой энгийн хатаасан үхрийн шир, HS 41012012 кодтой энгийн хатаасан адууны шир, HS 41012022 кодтой давсалж хатаасан адууны шир, HS 41012032 кодтой шинэ буюу давсалсан нойтон адууны шир, HS 4102 кодтой хонины арьс, HS 4103 кодтой бусад мал, амьтдын арьс, HS 41039010 кодтой тэмээний ширний экспортын хэмжээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 8. Арьс, ширэн түүхий эдийн экспортын хэмжээ (ширхэг)

	Үхэр, адууны боловсруулаагүй шир, хуулдас	Энгийн хатаасан үхрийн шир	Энгийн хатаасан адууны шир	Давсалж хатаасан адууны шир	Шинэ буюу давсалсан нойтон адууны шир	Хонины арьс	Бусад мал, амьтдын арьс	Тэмээний шир
2006	306,455.0	3,502.0	102,802.0	6,000.0	151,600.0	-	13,201.0	7,880.0
2007	237,483.0	46.0	1,200.0	3.0	233,730.0	39.0	11,292.0	11,250.0
2008	276,540.0	-	-	500.0	276,040.0	-	12,933.0	11,100.0
2009	264,796.0	-	-	2,191.0	262,600.0	133.0	17,069.0	-
2010	345,106.0	-	1,800.0	2,000.0	333,196.0	1,530.0	86.0	-
2011	273,580.0	-	-	-	273,580.0	2,000.0	2,493.0	2,400.0
2012	200,700.0	-	35,400.0	-	154,700.0	52,200.0	5,989.0	5,900.0
2013	350,205.0	-	11,800.0	1,700.0	196,200.0	10.0	8,648.0	8,600.0
2014	240,010.0	-	-	-	65,400.0	15,960.0	89.0	1.0
2015	117,850.0	-	-	-	6,200.0	-	66.0	-
2016	460,420.0	-	-	15,500.0	110,920.0	-	3,742.0	-
2017	171,020.0	-	-	-	33,300.0	-	104.0	-
2018	300.0	-	-	-	300.0	-	154.0	-
2019	592,833.0	24,000.0	14,198.0	526,335.0	28,300.0	-	135.0	-
2020	344,020.0	-	88,620.0	205,900.0	37,200.0	-	16,615.0	16,500.0

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Арьс, ширэн түүхий эдийн экспортын хэмжээ 2014 оноос буурсан ч сүүлийн 2 жилд экспортын хэмжээ өсжээ. Үхэр, адууны боловсруулаагүй шир, хуулдас, энгийн хатаасан үхрийн шир, энгийн хатаасан адууны шир, давсалж хатаасан адууны шир, шинэ буюу давсалсан нойтон адууны шир, хонины арьс, бусад мал, амьтдын арьс, тэмээний ширийг 100 хувь БНХАУ-д экспортолдог. Дээрх экспортын хэмжээ буурсан нь тухайн цаг хугацаанд БНХАУ-ын Хэбэй муж дахь арьс ширний үйлдвэрүүдийн үйл ажиллагаа тасалдаж арьс ширний эрэлт буурсантай холбоотой байсан. Харин 2020 оноос БНХАУ-ын боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа дахин сэргэж дахин арьс ширний эрэлт өссөн нь манай улсын экспортын хэмжээ өсөхөд нөлөөлсөн.

Хүснэгт 9. Арьс, ширэн түүхий эдийн экспортын орлого (мянган ам. доллароор)

	Үхэр, адууны боловсруулаагүй шир, хуулдас	Энгийн хатаасан үхрийн шир	Энгийн хатаасан адууны шир	Давсалж хатаасан адууны шир	Шинэ буюу давсалсан нойтон адууны шир	Хонины арьс	Бусад мал, амьтдын арьс	Тэмээний шир
2006	4,935.8	63.0	1,657.7	96.0	2,428.5	-	283.3	130.1
2007	3,821.9	1.0	19.2	0.1	3,761.5	0.4	232.9	134.9
2008	4,460.3	-	-	8.0	4,452.3	-	292.5	198.2
2009	3,969.8	-	-	35.1	3,934.7	0.6	190.8	-
2010	3,887.7	-	18.0	24.0	3,737.2	7.8	74.3	-
2011	2,863.6	-	-	-	2,863.6	8.5	110.3	40.8
2012	2,162.1	-	354.0	-	1,636.1	95.7	58.8	42.5
2013	4,105.9	-	118.0	47.6	1,970.6	0.1	152.7	130.7
2014	2,870.8	-	-	-	654.0	63.8	39.3	0.7
2015	1,799.4	-	-	-	74.4	-	34.6	-
2016	8,554.8	-	-	254.4	2,447.6	-	73.5	-

⁸ ХХААХҮЯ, “Арьс ширний үйлдвэрлэлийн танилцуулга”, 2020

2017	2,965.8	-	-	-	581.0	-	146.9	-
2018	5.1	-	-	-	5.1	-	112.4	-
2019	1,764.8	24.0	53.7	1,607.3	79.8	-	64.0	-
2020	496.6	-	125.0	239.1	95.6	-	112.6	70.8

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

2020 онд арьс, ширэн түүхий эдийн экспортоос 1.1 сая ам.долларын орлогыг болсон бөгөөд нийт экспортын 43.6 хувийг үхэр, адууны боловсруулаагүй шир, хуулдаснаас бүрдүүлжээ.

Боловсруулсан арьс шир буюу HS 4104 кодтой үхэр, адууны боловсруулсан шир, HS 4105 кодтой хонь, хурганы боловсруулсан арьс буюу шеврет, HS 4106 кодтой ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевро, HS 4107 кодтой бусад амьтны боловсруулсан арьс, HS 4113 кодтой савхи: ямаа буюу ишигний, HS 4114 кодтой илгэн савхи экспортын хэмжээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 10. Боловсруулсан арьс ширний экспортын хэмжээ |дм2|

	Үхэр, адууны боловсруулсан шир	Хонь, хурганы боловсруулсан арьс буюу шеврет	Ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевро	Бусад амьтдын, боловсруулсан арьс	Савхи: Ямаа буюу ишигний	Илгэн савхи
2006	27,716,930.0	147,549,556.5	54,155,950.0	-	-	-
2007	47,230,034.0	180,128,667.0	36,239,960.0	1,200.0	-	-
2008	23,397,637.0	183,264,924.6	29,445,785.7	-	-	-
2009	23,368,735.4	128,738,376.0	82,946,890.0	-	-	-
2010	55,405,713.0	150,911,381.5	106,047,550.8	-	-	-
2011	66,913,408.0	331,512,365.0	120,890,407.5	-	4,304.0	-
2012	42,989,774.4	182,469,325.0	61,074,327.0	-	-	-
2013	43,140,546.0	162,166,560.0	92,093,750.0	17,775.5	-	-
2014	58,448,803.0	110,230,364.0	128,755,315.0	590.0	-	3,332.0
2015	70,676,629.0	147,747,225.0	122,269,083.3	275,924.0	247,985.0	-
2016	86,388,300.0	29,204,880.0	61,734,380.0	-	277,317.5	-
2017	102,025,382.0	82,245,690.0	123,074,087.5	106,112.0	545,490.6	22,648.0
2018	79,495,756.6	116,161,464.0	145,527,385.0	173,007.0	553,580.0	-
2019	68,618,118.6	54,021,120.0	120,891,870.0	72,089.0	231,000.0	-
2020	23,423,758.2	49,208,360.0	85,185,905.0	121,092.0	6,228.0	19,500.0

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Үхэр, адууны боловсруулсан ширний экспортын 88.6 хувийг БНХАУ-д, 3.6 хувийг Тайланд улсад экспортолсон бол хонь, хурганы боловсруулсан арьс буюу шевретийн экспортын 93.1 хувийг БНХАУ руу, 6.9 хувийг Турк улс руу экспортолсон. Ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевроны экспортын 41.3 хувийг Итали, 30.7 хувийг БНХАУ, 27.0 хувийг Турк улс руу экспортолжээ.

Хүснэгт 11. Боловсруулсан арьс ширний экспортын орлого |мянган ам.доллаар|

	Үхэр, адууны боловсруулсан шир	Хонь, хурганы боловсруулсан арьс буюу шеврет	Ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевро	Бусад амьтдын, боловсруулсан арьс	Савхи: Ямаа буюу ишигний	Илгэн савхи
2006	6,284.6	24,462.0	7,984.9	-	-	-
2007	7,499.6	25,002.3	5,384.8	0.2	-	-
2008	4,458.8	26,940.9	4,566.9	-	-	-
2009	3,766.5	13,058.4	7,794.2	-	-	-
2010	6,171.2	13,646.7	7,839.7	-	-	-
2011	9,695.3	28,197.9	9,935.7	-	0.7	-
2012	5,339.1	16,074.2	6,549.5	-	-	-
2013	5,364.9	15,316.8	9,883.6	2.9	-	-
2014	7,981.9	10,880.5	13,737.6	0.1	-	0.3
2015	8,284.6	12,274.3	10,256.8	101.9	29.6	-
2016	9,953.6	1,644.2	3,897.4	-	32.9	-
2017	10,167.6	3,149.5	6,229.9	0.6	6.9	2.5
2018	8,431.0	3,109.5	4,980.9	5.4	25.1	-
2019	6,376.2	1,185.9	4,031.2	19.2	13.2	-
2020	2,274.3	1,007.7	3,120.4	25.6	0.7	0.4

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Нийт боловсруулсан арьс ширний экспортын орлогын 48.5 хувийг ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевро, 35.4 хувийг үхэр, адууны боловсруулсан шир, 15.7 хувийг хонь, хурганы боловсруулсан арьс буюу шевретийн экспортын орлого бүрдүүлдэг. Цаашид хагас боловсруулсан арьс ширний экспортоос илүүтэй эцсийн бүтээгдэхүүний экспортыг дэмжих нь зүйтэй.

Боловсруулсан арьс ширэн эдлэл буюу HS 4201 кодтой мал, амьтанд зориулсан шир, суран тоног хэрэглэл, HS 4202 кодтой чемодан, цүнх, үүргэвч, уут гэр, HS 4203 кодтой савхин хувцас, HS 42031010 кодтой цулгуй савхин дээл, HS 42031020 кодтой цулгуй савхин цамц, HS 42031050 кодтой савхин бусад хувцас, HS 4205 кодтой арьс ширэн буюу савхин бусад эдлэлийн экспортын орлогыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 12. Боловсруулсан арьс ширэн эдлэлийн экспортын орлого 1 мянган ам.доллаар

	Мал, амьтанд зориулсан шир, суран тоног хэрэглэл	Чемодан, цүнх, үүргэвч, уут гэр	Савхин хувцас	Цулгуй, савхин дээл	Цулгуй, савхин цамц	Савхин бусад хувцас	Арьс ширэн буюу савхин бусад эдлэл
2006	0.1	38.3	62.0	4.7	-	25.4	13.1
2007	-	46.4	58.1	3.4	3.6	26.7	0.1
2008	0.5	26.9	50.1	1.5	-	26.9	1.2
2009	1.3	46.9	16.6	4.5	-	3.5	0.1
2010	4.5	638.2	107.2	16.0	-	7.5	2.3
2011	4.9	246.7	41.1	1.8	7.3	3.4	0.4
2012	20.2	136.4	70.8	0.6	4.5	41.0	5.4
2013	18.8	249.7	62.8	10.3	-	28.5	6.5
2014	70.8	60.4	56.4	0.1	2.7	47.1	2.9
2015	3.1	625.7	251.9	0.3	30.1	93.8	7.7
2016	29.0	536.4	5,295.7	5,161.6	12.6	15.6	1.9
2017	113.7	391.6	242.1	26.2	25.6	86.1	21.0
2018	10.1	128.5	64.5	-	3.0	21.9	7.0
2019	35.7	220.1	289.5	228.7	-	13.0	31.6
2020	55.8	322.5	7.8	0.4	-	2.2	7.0

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Монгол Улсаас 2020 онд 397.0 мянган ам. долларын боловсруулсан арьс ширэн эдлэлийг экспортолжээ. Нийт экспортын 81.2 хувийг чемодан, цүнх, үүргэвч, уут гэр, 14.0 хувийг мал, амьтанд зориулсан шир, суран тоног хэрэглэлийн экспорт эзэлдэг.

Савхин хувцасны экспортыг улс орнуудаар нь авч үзвэл, нийт экспортын 31.7 хувийг Канад улс, 26.2 хувийг Казакстан, 21.6 хувийг АНУ руу экспортолжээ. Салбарын яамнаас арьс ширэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж жилд 15 сая арьс шир боловсруулах, Дарханы арьс, ширний үйлдвэрийн цогцолборыг байгуулах, Хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээлийг шийдвэрлэж олгох, Эмээлтийн ҮТП-ийг байгуулах, Ховдын ҮТП-ийг байгуулах, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын чадавхыг сайжруулах зэрэг ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлж эхлээд байна.

Монгол Улсын арьс ширний экспортын тоо хэмжээг экспортолсон улс орнуудаар дараах зургаар нэгтгэн харуулав.

Зураг 13. Монгол Улсын арьсны экспорт

Арьс ширний экспорт



Дархан хотод арьс шир боловсруулах 34 үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсад арьс ширний гарц 2011-2019 онд 8.4-17.6 сая ширхэгт хүрч, 8 жилд 71.3%-аар буюу жилд дунджаар 13.1%-аар өссөн.



Арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадал

- 18,089.5 мянган ширхэг арьс ширийг хагас боловсруулах




33.8% ашиглаж байна.

- 2508.2 мянган ширхэг арьс ширийг гүн боловсруулах



68.6% ашиглаж байна.

Савхин хувцасны экспорт



2020 онд арьс, ширэн түүхий эдийн экспортоос 1.1 сая ам.долларын орлогыг болсон бөгөөд нийт экспортын 43.6 хувийг үхэр, адууны боловсруулаагүй шир, хуулдаснаас бүрдүүлжээ.

Нийт боловсруулсан арьс ширний экспортын орлогын 48.5 хувийг ямаа, ишигний боловсруулсан арьс, 35.4 хувийг үхэр, адууны боловсруулсан шир, 15.7 хувийг хонь, хурганы боловсруулсан арьс экспортын орлого бүрдүүлдэг.

Үхэр, адууны боловсруулсан ширний экспорт



■ БНХАУ ■ Тайланд ■ Бусад

Хонь, хурганы боловсруулсан арьс экспорт



■ БНХАУ ■ Турк

Ямаа, ишигний боловсруулсан арьс экспорт



■ Итали ■ БНХАУ ■ Турк

1.6.НООС, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Ноолуур боловсруулах салбарт гүн боловсруулах үйлдвэр 15, анхан шатны боловсруулах үйлдвэр 23, сүлжмэлийн жижиг дунд үйлдвэр 59, өрхийн жижиг цех 150-200 үйл ажиллагаа явуулдаг.

Ноос боловсруулах салбарт хивс үйлдвэрлэх 2 үйлдвэр, 4 нэхэх үйлдвэр, 9 ээрэх үйлдвэр, нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх 1 үйлдвэр, 25 угаах үйлдвэр, 23 хялгас ялгах үйлдвэр, 56 сүлжих үйлдвэр, эсгий эдлэл үйлдвэрлэх 16 үйлдвэр, ноосон бордоо үйлдвэрлэх 1 үйлдвэр, 120 эсгийлэх үйлдвэр, нийт 257 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

HS 5102 кодтой бусад мал, амьтны сэмлээгүй буюу самнаагүй үс, хялгас, HS 51021120 кодтой ямааны угаасан ноолуур, HS 51021942 кодтой тэмээний угаасан эр ноос, HS 51021944 кодтой тэмээний угаасан эм ноосны экспортын хэмжээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 13. Хагас боловсруулсан ноос, ноолуурын экспортын тоо хэмжээ кг-аар

	Бусад мал, амьтны сэмлээгүй буюу самнаагүй үс, хялгас	Ямааны угаасан ноолуур	Тэмээний угаасан эр ноос	Тэмээний угаасан эм ноос
2006	3,610,762.7	1,671,236.9	420,187.4	468,717.7
2007	3,121,673.0	1,509,003.8	355,738.5	523,193.6
2008	3,748,216.3	1,929,181.6	180,087.1	468,300.0
2009	6,622,280.8	3,526,788.6	361,948.9	688,989.2
2010	7,135,193.7	3,015,507.1	373,249.5	728,397.2
2011	6,164,233.2	2,829,549.5	403,163.7	628,945.1
2012	5,869,203.5	3,597,757.9	393,882.1	638,380.3

2013	6,452,930.1	4,070,246.6	365,741.4	625,300.2
2014	7,222,208.0	4,035,414.1	265,335.3	824,773.8
2015	7,047,707.0	4,988,215.9	152,652.6	332,236.2
2016	7,800,290.2	5,413,452.2	256,024.6	562,831.4
2017	8,280,701.4	5,409,652.5	146,899.1	968,656.5
2018	9,495,744.9	5,286,608.2	419,434.4	310,233.0
2019	8,784,869.1	5,688,703.0	310,105.7	740,739.0
2020	9,436,522.4	6,339,831.4	11,960.0	824,710.2

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Ямааны угаасан ноолуурын 99.9 хувийг, тэмээний угаасан эр ноосыг 100 хувь, тэмээний угаасан эм ноосны 99.5 хувийг БНХАУ руу экспортолдог. Харин тэмээний угаасан эм ноосны 0.5 хувийг ХБНГУ-д экспортолсон байна. Ноос, ноолуурт анхан шатны боловсруулалт хийж экспорт хийж байгаа нь нэгдүгээрт, БНХАУ-ын санхүү, хүний нөөц, технологийн хувьд бэхэжсэн томоохон үйлдвэрүүдэд эрэлт байнга үүсдэг, хоёрдугаарт, Монгол Улсын боловсруулах үйлдвэрүүдийн 27 хувь нь л эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл явуулдаг. Боловсруулах үйлдвэрүүд эцсийн бүтээгдэхүүнийг их хэмжээгээр үйлдвэрлэж чадахгүй байгаа нь Монгол Улсад ээрэх хүчин чадал бага суурилагдсантай холбоотой.

Хүснэгт 14. Хагас боловсруулсан ноос, ноолуурын экспортын орлого 1мянган ам.доллороор

	Бусад мал, амьтны сэмлээгүй буюу самнаагүй үс, хялгас	Ямааны угаасан ноолуур	Тэмээний угаасан эр ноос	Тэмээний угаасан эм ноос
2006	66,766.0	63,017.0	776.6	1,051.1
2007	67,167.8	63,416.0	952.8	1,454.8
2008	80,976.8	77,228.8	341.5	1,130.6
2009	99,741.6	90,948.3	720.0	1,263.3
2010	111,968.2	104,625.1	742.3	1,311.7
2011	139,989.6	131,934.0	1,124.5	1,545.3
2012	149,515.9	145,379.5	1,028.4	1,581.4
2013	193,901.4	188,819.2	815.1	1,330.6
2014	235,721.3	223,815.4	763.3	2,797.2
2015	212,920.2	197,181.0	425.0	1,174.8
2016	211,816.5	192,534.6	814.5	1,809.3
2017	227,222.9	205,639.5	328.9	3,235.0
2018	281,093.9	251,956.2	1,737.3	1,121.4
2019	302,811.8	283,289.7	920.8	2,769.4
2020	205,088.5	185,313.1	47.8	2,328.6

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Ямааны угаасан ноолуурын экспортоос олсон орлого 185.3 сая ам.доллар, тэмээний угаасан эр ноосны орлого 47.8 мянган ам.доллар, тэмээний угаасан эм ноосны орлого 2.3 сая ам.доллар байна.

HS 51052910 кодтой ноолууран топс, HS 51053110 кодтой ямааны самнасан ноолуур, HS 51053130 дахин боловсруулсан богино ноолуур, HS 5106 кодтой хонины сэмлэсэн ноосон, жижиглэн баглаагүй ээрмэл, HS 5107 кодтой хонины самнасан ноосон, жижиглэн баглаагүй ээрмэл (камволь)-ийн экспортын хэмжээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 15. Хагас боловсруулсан ноос, ноолуурын бүтээгдэхүүний экспортын хэмжээ кг-аар

	Ноосон топс	Ямааны самнасан ноолуур	Дахин боловсруулсан богино ноолуур	Хонины сэмлэсэн ноосон, жижиглэн баглаагүй ээрмэл	Хонины самнасан ноосон, жижиглэн баглаагүй ээрмэл (камволь)
2006	-	1,427,510.0	9,785.9	365.0	91,272.7
2007	-	1,784,525.3	43,409.6	961.0	29,529.0
2008	-	1,587,793.8	1,561.3	4,458.5	216.8
2009	-	1,623,267.0	398.5	1,149.6	48,795.7
2010	-	976,535.1	18,281.9	520.5	21.6
2011	-	537,097.4	60,521.5	-	70.0
2012	-	532,889.3	16,240.3	-	-

2013	-	564,470.1	10,552.2	308.6	-
2014	-	636,606.8	2,364.7	63.6	-
2015	-	558,910.2	300.0	80.7	152.1
2016	6,345.5	508,973.2	-	169.1	989.0
2017	-	581,095.2	17,137.7	21.7	2,525.5
2018	-	630,225.7	31,005.9	99.8	7,612.0
2019	19,203.0	507,249.0	52,156.0	78,870.6	6,495.6
2020	11,646.2	259,999.0	96.0	66,548.2	27,916.5

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Самнасан ноолуурын 80.9 хувийг Итали, 6.5 хувийг Их Британи, 5.3 хувийг БНХАУ, 4.9 хувийг БНСУ руу экспортолжээ. Дахин боловсруулсан богино ноолуурыг 100 хувь Япон улс экспортолсон.

Хүснэгт 16. Хагас боловсруулсан ноос, ноолуурын бүтээгдэхүүний экспортын орлого (мянган ам.доллаар)

	Ноосон топс	Ямааны самнасан ноолуур	Дахин боловсруулсан богино ноолуур	Хонины сэмлэсэн ноосон, жижиглэн баглаагүй ээрмэл	Хонины самнасан ноосон, жижиглэн баглаагүй ээрмэл (камволь)
2006	-	81,740.6	225.9	62.0	481.2
2007	-	114,277.0	2,086.1	149.5	137.3
2008	-	98,667.3	87.7	623.1	1.3
2009	-	68,370.2	16.7	179.1	116.9
2010	-	68,821.2	860.3	57.2	2.0
2011	-	57,433.3	3,862.0	-	0.4
2012	-	47,829.9	760.1	-	-
2013	-	56,081.2	560.5	8.2	-
2014	-	61,931.8	91.3	1.3	-
2015	-	40,711.2	16.5	0.6	0.9
2016	62.8	33,189.1	-	1.3	96.1
2017	-	38,522.1	317.2	0.3	265.0
2018	-	54,944.2	100.3	2.3	587.7
2019	144.1	45,319.3	11.6	23.7	665.2
2020	54.7	16,877.0	0.9	107.6	369.1

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Самнасан ноолуурын орлого 2020 онд 16.9 сая ам.доллар, хонины самнасан ноосон, жижиглэн баглаагүй ээрмэл (камволь)-ийн орлого 369.1 мянган ам.долларт хүрчээ. Ноолуурын салбарын экспорт нийт экспортын орлогын 10 орчим хувийг эзлэх бөгөөд 20 гаруйхан хувь нь бэлэн бүтээгдэхүүн үлдсэн хэсэг нь угаасан ноос, самнасан ноолуур хэлбэрээр экспортлогдож байна.

Ноолууран сүлжмэл бүтээгдэхүүнүүд болох HS 6101 кодтой сүлжмэл пальто, цув, дулаан хүрэм (эр), HS 6102 кодтой сүлжмэл пальто, цув, дулаан хүрэм (эм), HS 6103 кодтой сүлжмэл костюм буюу комплект, ансамбль, жакет, өмд, комбинзон (эр), HS 6104 кодтой сүлжмэл костюм, ансамбль, хантааз, платье, банзал, өмд, комбинзон (эм), HS 6105 кодтой сүлжмэл дотуур цамц (эр), HS 6106 кодтой сүлжмэл дотуур цамц (эм)-ны экспортын хэмжээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 17. Сүлжмэл хувцасны экспортын хэмжээ (ширхгээр)

	Сүлжмэл пальто, цув, дулаан хүрэм (эр)	Сүлжмэл пальто, цув, дулаан хүрэм (эм)	Сүлжмэл костюм буюу комплект, ансамбль, жакет, өмд, комбинзон (эр)	Сүлжмэл костюм, ансамбль, хантааз, платье, банзал, өмд, комбинзон (эм)	Сүлжмэл дотуур цамц (эр)	Сүлжмэл дотуур цамц (эм)
2006	91.0	2,009.0	-	-	1,167,056.0	1,733,632.0
2007	164.0	2,180.0	-	-	928,289.0	898,109.0
2008	1,183.0	5,601.0	-	-	383,156.0	418,281.0
2009	1,387.0	3,742.0	-	-	23,521.0	152,304.0
2010	919.0	10,907.0	678.0	14,007.0	86,259.0	262,299.0
2011	893.0	6,115.0	642.0	16,340.0	74,040.0	233,016.0
2012	500.0	7,202.0	835.0	14,840.0	49,116.0	147,113.0
2013	315.0	5,504.0	841.0	18,059.0	36,718.0	241,770.0

2014	535.0	11,921.0	-	-	42,600.0	181,819.0
2015	515.0	26,341.0	-	-	32,242.0	159,676.0
2016	974.0	27,140.0	-	-	31,090.0	184,843.0
2017	2,894.0	46,662.0	-	-	43,429.0	231,189.0
2018	1,265.0	28,604.0	-	-	33,489.0	188,421.0
2019	503.0	31,190.0	-	-	40,191.0	184,595.0
2020	425.0	14,696.0	-	-	47,865.0	135,585.0

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

HS 6101 кодтой сүлжмэл пальто, цув, дулаан хүрэм (эр)-ний нийт экспортын 61.1 хувийг БНХАУ, 17.3 хувийг АНУ, 6.3 хувийг Бельги, 5.5 хувийг БНСУ руу экспортолсон бол HS 6102 кодтой сүлжмэл пальто, цув, дулаан хүрэм (эм)-ний 24.3 хувийг Франц, 24.0 хувийг БНСУ, 11.1 хувийг ХБНГУ, 10.7 хувийг Их Британи, 9.7 хувийг АНУ руу экспортолжээ.

61043120 кодтой ямааны ноолууран жакет ба хүрэмний экспортын 29.0 хувийг БНСУ, 22.7 хувийг Их Британи, 20.3 хувийг АНУ-д, 61044120 кодтой ямааны ноолууран платьены экспортын 37.1 хувийг ХБНГУ-д, 16.5 хувийг АНУ, 12.0 хувийг БНСУ-д; 61045120 кодтой ямааны ноолууран банзлын экспортын 62.0 хувийг БНСУ-д; 61046120 кодтой ямааны ноолууран эмэгтэй өмдний экспортын 23.9 хувийг БНСУ, 21.1 хувийг ХБНГУ-д; 6106 кодтой эмэгтэйчүүдийн эсвэл охидын сүлжмэл кофт, цамц, блузкны экспортын 29.1 хувийг ХБНГУ-д, 27.7 хувийг Франц улсад, 22.2 хувийг БНСУ-д экспортолсон.

Хүснэгт 18. Сүлжмэл хувцасны экспортын орлого Үянган ам.доллороор

Тусгай код	Сүлжмэл пальто, цув, дулаан хүрэм (эр)	Сүлжмэл пальто, цув, дулаан хүрэм (эм)	Сүлжмэл костюм буюу комплект, ансамбль, жакет, өмд, комбинзон (эр)	Сүлжмэл костюм, ансамбль, хантааз, платье, банзал, өмд, комбинзон (эм)	Сүлжмэл дотуур цамц (эр)	Сүлжмэл дотуур цамц (эм)
2006	0.3	72.0	1,239.8	6,907.5	3,109.0	4,547.6
2007	17.2	144.9	958.9	3,074.4	2,376.4	2,723.6
2008	32.9	405.5	311.0	1,246.7	2,930.8	5,321.8
2009	40.1	192.6	44.9	265.9	1,212.0	4,925.4
2010	59.3	646.5	36.7	645.7	4,921.4	8,512.0
2011	113.9	506.7	92.4	905.1	5,875.1	9,887.8
2012	166.3	839.0	168.6	952.7	3,685.5	6,760.0
2013	34.1	514.3	36.2	1,143.4	2,248.9	10,832.9
2014	116.8	1,154.2	38.7	1,418.5	2,568.1	9,184.2
2015	89.6	2,077.5	59.9	1,501.5	1,961.6	7,843.9
2016	80.6	2,390.9	28.3	1,510.7	1,669.4	8,796.3
2017	420.4	5,481.2	86.2	2,463.1	2,244.7	10,522.9
2018	315.5	3,598.0	196.3	3,742.5	1,915.6	8,785.0
2019	95.3	4,370.2	296.7	5,230.7	2,526.1	10,032.3
2020	77.6	1,503.9	986.5	3,043.5	3,027.3	7,440.3

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Экспортын орлого нь экспортын тоо хэмжээтэй уялдаж Сүлжмэл дотуур цамц (эм)-ны экспортоос 7.4 сая ам.доллар, Сүлжмэл костюм, ансамбль, хантааз, платье, банзал, өмд, комбинзон (эм)-ний экспортоос 3.0 сая ам.доллар, Сүлжмэл дотуур цамц (эр)-ны экспортоос 3.0 сая ам.долларын орлого олжээ.

Монгол улсын самнасан ноолуур, угаасан ноос зэрэг хагас боловсруулсан бүтээгдэхүүнүүдийн дийлэнх хэсэг нь БНХАУ руу экспортлогдож харин эцсийн бүтээгдэхүүний гол зах зээл нь Япон, БНСУ, Европын зах зээл байна. Монголын ноолууран бүтээгдэхүүнийг АНУ-д бүтээгдэхүүнийг татваргүй экспортлох талаар хэлэлцээр хийгдэж байгаа билээ. Мөн Япон улстай чөлөөт худалдааны хэлэлцээр, GPS+ орнуудад бүтээгдэхүүнийг экспортлох зам нээгдсэн нь боловсруулах үйлдвэрийнхэнд таатай нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн ЕАЭЗХ болон БНХАУ, БНСУ-тай чөлөөт худалдааны тогтолцоонд шилжихээр судалгаа хийгдэж байна. Гэвч Монгол улсын экспортолж буй эцсийн бүтээгдэхүүн өчүүхэн бага байгаа нь нэгэнт бий болсон боломжийг дутуу ашиглах нөхцөлийг бүрдүүлж байна.

HS 6107 кодтой сүлжмэл дотуур хувцас (эр), HS 6107 кодтой сүлжмэл дотуур хувцас (эм), HS 6109 кодтой сүлжмэл футболка, майк, HS 6110 кодтой Свитер, пуловер, джемпер, жилет болон бусад сүлжмэл гадуур цамц, HS 6111 кодтой хүүхдийн сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэглэл, HS 6114 кодтой сүлжмэл бусад хувцас, HS 6115 кодтой сүлжмэл оймс, оймсон зүйлс, HS 6116 кодтой сүлжмэл бээлий, ханцуйвчны экспортын хэмжээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 19. Сүлжмэл бүтээгдэхүүний экспортын хэмжээ \ширхгээр\

	Сүлжмэл дотуур хувцас (эр)	Сүлжмэл дотуур хувцас (эм)	Сүлжмэл футболка, майк	Свитер, пуловер, джемпер, жилет болон бусад сүлжмэл гадуур цамц	Хүүхдийн сүлжмэл хувцас	Сүлжмэл бусад хувцас	Сүлжмэл оймс, оймсон зүйлс	Сүлжмэл бээлий, ханцуйвч
2006	4,416.0	34,679.0	6,368,259.0	4,339,502.0	769.0	2,087.0	-	3,003.0
2007	-	2,696.0	5,845,973.0	1,807,635.0	150,922.0	1,775.0	-	2,492.0
2008	281,535.0	8,700.0	1,710,523.0	670,957.0	2,158.0	303.0	-	4,921.0
2009	-	-	20,381.0	64,882.0	3,388.0	108.0	-	4,837.0
2010	-	11.0	8,142.0	49,800.0	1,141.0	1,749.0	327,285.0	13,806.0
2011	53.0	5.0	8,693.0	96,390.0	4,872.0	2,640.0	256,866.0	15,974.0
2012	37.0	1.0	8,536.0	131,567.0	1,408.0	621.0	351,978.0	11,943.0
2013	63.0	1,404.0	6,434.0	96,417.0	1,205.0	291.0	651,756.0	20,770.0
2014	570.0	812.0	6,505.0	101,882.0	1,284.0	747.0	-	18,175.0
2015	51.0	164.0	6,429.0	116,028.0	2,690.0	1,301.0	-	24,405.0
2016	109.0	140.0	9,426.0	108,992.0	1,643.0	1,500.0	-	65,893.0
2017	21.0	217.0	12,651.0	132,136.0	3,662.0	2,315.0	-	83,206.0
2018	103.0	184.0	17,366.0	236,276.0	1,836.0	3,052.0	-	123,245.0
2019	116.0	760.0	13,192.0	323,498.0	1,463.0	4,073.0	-	190,539.0
2020	178.0	729.0	9,546.0	291,498.0	3,212.0	2,888.0	-	223,093.0

Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Сүлжмэл футболка, майкны экспортын 31.0 хувийг БНХАУ-д, 11.4 хувийг Их Британи улсад экспортолсон бол свитер, пуловер, джемпер, жилет болон бусад сүлжмэл гадуур цамцны экспортын 32.6 хувийг БНСУ-д, 20.6 хувийг Их Британи, 18.0 хувийг АНУ-д экспортолсон.

Ямааны ноолууран сүлжмэл свитер, джемперын экспортын 32.6 хувийг БНСУ-д, 23.9 хувийг Их Британи, 21.0 хувийг АНУ-д экспортолж, оёмол пальто, цув, дулаан хүрэм, нөмрөг (эр)-ний экспортын 88.0 хувийг ХБНГУ-д, 4.2 хувийг БНХАУ-д, 4.1 хувийг АНУ-д экспортолжээ. Оёмол пальто, цув, дулаан хүрэм, нөмрөг (эм)-ний экспортын 37.7 хувийг БНХАУ-д, 31.5 хувийг ХБНГУ-д экспортолжээ.

Хүснэгт 20. Сүлжмэл бүтээгдэхүүний экспортын орлого \мянган ам.доллар\

	Сүлжмэл дотуур хувцас (эр)	Сүлжмэл дотуур хувцас (эм)	Сүлжмэл футболка, майк	Свитер, пуловер, джемпер, жилет болон бусад сүлжмэл гадуур цамц	Хүүхдийн сүлжмэл хувцас	Сүлжмэл бусад хувцас	Сүлжмэл оймс, оймсон зүйлс	Сүлжмэл бээлий, ханцуйвч
2006	7.6	56.4	13,240.8	17,620.2	4.8	43.7	17.0	18.6
2007	-	4.7	12,290.8	13,251.6	2,080.7	31.0	20.4	24.9
2008	788.3	19.1	4,264.0	2,716.7	20.2	8.4	32.9	43.1
2009	-	-	80.1	2,793.2	104.3	5.4	49.6	45.7
2010	-	0.4	199.5	1,912.4	27.3	12.7	122.2	118.7
2011	0.7	0.0	286.5	4,326.7	93.1	23.1	108.8	142.1
2012	2.6	0.0	364.4	5,282.0	30.8	5.1	105.4	112.2
2013	3.0	19.2	198.9	3,800.1	27.8	4.3	115.4	177.2
2014	1.2	7.0	256.1	3,896.2	29.5	14.0	164.5	172.6
2015	4.8	14.6	237.3	5,225.5	90.3	22.5	213.9	237.6
2016	3.6	16.0	334.0	6,025.8	36.3	51.7	1,235.4	344.4
2017	0.7	26.2	500.2	6,527.9	95.2	34.6	1,678.1	395.2
2018	0.1	17.7	502.0	12,588.9	36.5	32.8	1,902.8	559.4
2019	10.3	86.2	517.4	18,251.0	21.4	65.2	2,897.0	675.7
2020	11.8		266.6	14,088.7	59.7		2,464.3	575.1

Эх үүсвэр: (ГЕГ, 2021)

Сүлжмэл хувцас ба хувцасны экспортын статистик мэдээнээс харахад, 2020 онд 37.2 сая ам.долларын экспортын орлогыг олжээ. Нийт экспортын 37.9 хувийг свитер, пуловер, джемпер, жилет болон бусад сүлжмэл гадуур цамцны экспорт, 20.0 хувийг сүлжмэл дотуур цамцны экспорт эзэлж байна.


Нэхмэл эдлэлийн экспортын статистик мэдээнээс харахад, 2020 онд 2.5 сая ам.долларын орлогыг олжээ. Нийт экспортын орлогын 31.4 хувийг хөнжил ба аяны хөнжлийн экспорт, 31.1 хувийг бусад бэлэн эдлэл, хувцасны загварын экспорт, 27.1 хувийг ямааны ноолууран хөнжлийн экспорт эзэлж байгаа тул эдгээр гурван төрлийн бүтээгдэхүүнүүд ач холбогдолтой байна. Ямааны ноолууран хөнжлийн нийт экспортын 50.4 хувийг АНУ-д, 30.2 хувийг ХБНГУ-д экспортолсон.

Гурван улсын эдийн засгийн коридорын хүрээнд Хил гаалийн хяналтыг хөнгөвчлөх, ургамлын хорио цээр, мал эмнэлгийн ариун цэврийн шаардлагуудыг хөнгөвчлөх, ойртуулан ижилсүүлэх тухай зорилтууд тавигдсан бөгөөд хил орчмын эдийн засгийн солилцоог идэвхжүүлэх чиглэлийн төслүүд, жишээ нь хилийн ойролцоох болон хил дамнасан чөлөөт бүс байгуулах, иргэд жуулчлалын болон арилжааны зорилгоор зорчих нөхцөлийг хөнгөвчлөхөөр ажлуудыг эхлүүлээд байна. Иймд эдгээр ажлуудыг хэрэгжүүлэхтэй зэрэгцүүлэн ноолуурын ээрэх, тэр тусмаа нарийн ээрэх хүчин чадлыг нөөцийн хэмжээнд тохируулан нэмж суурилуулах арга хэмжээг яаралтай авах шаардлагатай.


Монгол Улсын ноос, ноолуурын экспортын тоо хэмжээг экспортолсон улс орнуудаар дараах зургаар нэгтгэн харуулав.

Зураг 14. Монгол Улсын ноос, ноолуурын экспорт

Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспорт



Ноолуурын салбарын экспорт нийт экспортын орлогын **10 орчим хувийг** эзлэх бөгөөд 20 гаруйхан хувь нь бэлэн бүтээгдэхүүн үлдсэн хэсэг нь угаасан ноос, самнасан ноолуур хэлбэрээр экспортлогдож байна.




1.7.САМРЫН ИДЭЭНИЙ ЭКСПОРТ

“Монголын самрын бизнес эрхлэгчид, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн эрхийг хамгаалах холбоо” ТББ байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд тус байгууллага нь ойн дагалт баялгийг хамгаалах, ашиглах ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээтэй хуш модны самрын бизнес эрхлэгч, үйлдвэрлэгчдийг дэмжих, хууль эрх зүйн боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх мэдээллээр хангах үйл ажиллагаа явуулдаг (dnn.mn, 2021)⁹. Тус байгууллагын дэргэд “Ногоон экспортын сан” ТББ байгуулж МҮХАҮТ-тай хамтран “Самрын кластер” байгуулсан байна.

Монгол Улсын хэмжээнд самар бэлтгэж экспортлохыг хориглосон. Харин хагас боловсруулсан самрын чөмөг буюу хуш модны самрын идээг 20 гаруй үйлдвэр, 11 ААН боловсруулж 8-10 мянган тонн самрын чөмгийг экспортолдог. Нийт экспортын 80 гаруй хувийг БНХАУ-ын Жилин мужид экспортолдог. Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн дагуу хуш модны самрын татварыг тэглэсэн бөгөөд цаашид тус улсад экспортлох зорилт тавьжээ.

Самар нь нэмүү өртөг шингэснээр бараг 20 дахин илүү үнэд хүрдэг бүтээгдэхүүн юм. Манай улсад самрыг орон нутгийн иргэд түүж, бэлтгэн цайруулаад худалдаачдад нэг кг-ыг нь 10.0 мянга орчим төгрөгөөр нийлүүлдэг. Харин Монголоос экспортолсон самрын идээг БНХАУ-д 95.0 хувь цэвэрлэн боловсруулж АНУ, Европын зах зээлд кг-ыг нь 162.0-300.0 мянган төгрөгөөр экспортолдог. HS 0802 кодтой самар, самрын идээний экспортыг хэмжээг дараах зургаар харуулав.

Зураг 15. Самар, самрын идээний экспорт кг-аар\




Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Монгол Улсаас 2017 онд хамгийн их буюу 12.5 мянган тонн самрын идээ БНХАУ руу экспортологдсон байна. Сүүлийн 2 жилд экспортын хэмжээ багасаж 2019 онд 23.5 тонн, 2020 онд 40.0 тонн самрын идээг экспортолжээ.

⁹ <https://dnn.mn>

Зураг 16. Самарын идээний экспортын орлого (мянган ам.доллаар)




Эх үүсвэр: <https://www.customs.gov.mn/>

Самрын идээний экспортоос 2017 онд 57.0 сая ам.долларын орлого олсон бөгөөд нэг кг 4.6 ам доллар буюу тухайн үеийн ханшаар тооцвол, нэг кг-ыг нь 11225 төгрөгөөр экспортолсон байна. Харин 2020 онд 40 тонн самрын идээг нийт 131.0 мянган ам доллароор экспортолсон нь нэг кг нь 3.3 ам. доллар буюу 9332 төгрөгөөр л экспортолжээ.


Монгол Улсын самрын идээний экспортын тоо хэмжээг экспортолсон улс орнуудаар дараах зургаар нэгтгэн харуулав.

Зураг 17. Монгол Улсын самрын идээний экспорт

Самрын идээний экспорт



2020 онд 40 тонн самрын идээг нийт 131.0 мянган ам доллароор экспортолсон нь нэг кг нь 3.3 ам. доллар буюу 9332 төгрөгөөр л экспортолжээ.



Монголоос экспортолсон самрын идээг БНХАУ-д 95.0 хувь цэвэрлэн боловсруулж АНУ, Европын зах зээлд кг-ыг нь 162.0-300.0 мянган төгрөгөөр экспортолдог.

Монгол Улсаас 2017 онд хамгийн их буюу 12.5 мянган тонн самрын идээ БНХАУ руу экспортлогдсон байна. Сүүлийн 2 жилд экспортын хэмжээ багасаж 2019 онд 23.5 тонн, 2020 онд 40.0 тонн самрын идээг экспортолжээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЭКСПОРТЫН “AS IS” ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАМЫН ЗУРАГЛАЛ

2.1. ЭКСПОРТЫН ҮЙЛ ЯВЦЫН ТУХАЙ

Бичиг баримт, гэрчилгээ, зөвшөөрлийн танилцуулга:

Стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл:

Түүхий мах болон дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн экспортлогч үйлдвэр, аж ахуйн нэгж нь Монгол Улсын ХХААХҮЯ-аас стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл (квот) авна. Сонгон шалгаруулалтын хугацааг тухайн жил ХХААХҮЯ-аас тогтоож цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлнэ.

Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ:

Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/67 дугаар тушаалын дагуу олдог бөгөөд, цахим болон цаасан хэлбэртэй байна. Тус тушаалын гуравдугаар хавсралтын дагуу 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ олгоход Хөдөө аж ахуйн биржийн итгэмжлэгдсэн агуулахад анхан шатны тордолт, чанарын хамгаалалт хийсэн тухай тодорхойлолт шаарддаг болно.

Бодлогын гэрээ:

Монгол Улсаас түүхий мах, дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрх (стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл, квот)-тэй үйлдвэр (экспортлогч) нь ХХААХҮЯ-тай бодлогын гэрээ байгуулна. Энэхүү гэрээ нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, хүнсний хангамж, үнийн төвшинг тогтвортой хадгалахад чиглэгдэнэ.

- ✚ Үйлдвэрийн танилцуулга
- ✚ Бүтээгдэхүүний мэдээлэл, төлөвлөгөө
- ✚ Мал эмнэлгийн гэрчилгээ
- ✚ Бэлтгэсэн түүхий эдийн 30-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрт нийлүүлсэн тухай гэрээ, төлбөрийн баримт эсхүл экспортод гаргахаар зориулалтын агуулахад хадгалж буй баримт
- ✚ Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, шинжээчийн дүгнэлт
- ✚ Малын гаралтай болон энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрсөн цэгт хог хаягдлын гэрээ
- ✚ Хоёр орны хооронд байгуулсан протоколын дагуу боловсруулж, батлуулсан технологийн заавар

Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ:

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/67 дугаар тушаалын дагуу МЭЕГ-аас мал, амьтны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгодог бөгөөд тус гэрчилгээ нь мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн олон улсын стандарт шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болохыг баталгаажуулна.

- ✚ УБГ-ний хуулбар
- ✚ Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг
- ✚ Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл
- ✚ Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт
- ✚ Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа
- ✚ Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил

Гарал үүслийн гэрчилгээ:

Гарал үүслийн гэрчилгээг авах хүсэлтээ Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын албан ёсны веб хуудас <https://www.mongolchamber.mn/p/22> холбоосоор онлайн

хэлбэрээр илгээнэ. Гарал үүслийн гэрчилгээ нь аль улсад зориулж гаргаж байгаа болон гарал үүсэл нь аль улсын гэдгээс хамаарч FORM A, FORM B, FORM E, FORM D гэсэн хувилбаруудтай байна.

- ✚ УБГ-ний хуулбар
- ✚ Өргөдлийн маягт бөглөх
- ✚ Гадаад худалдааны гэрээний хуулбар
- ✚ Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт
- ✚ Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл, чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар

Тохирлын гэрчилгээ:

Стандарт, Хэмжил Зүйн Газраас тохирлын гэрчилгээ авах ба энэхүү гэрчилгээ нь экспортод гаргах бүтээгдэхүүн нь холбогдох стандартуудын дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болохыг баталгаажуулдаг.

- ✚ Иргэн аж ахуйн нэгийн хүсэлт, албан тоот, өргөдөл - /маягт 1-ийн дагуу/
- ✚ Иргэний цахим үнэмлэхийн хуулбар /хувь хүн/, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- ✚ Худалдах, худалдан авах гэрээ
- ✚ Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг
- ✚ Бүтээгдэхүүнд сорилт, туршилт хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ сорилтын дүн
- ✚ Мэргэжлийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл /зөвхөн шаардлагатай тохиолдолд/
- ✚ Үйлчилгээний төлбөр тушаасан баримт

Төлбөр төлөх заавар:

- ✚ Төлбөр төлөх данс: Төрийн сан – 100900009012
- ✚ Данс эзэмшигч: Стандарт, хэмжил зүйн газар
- ✚ Төлбөрийн хэмжээ: Экспорт болон импортын тохирлын гэрчилгээ 1ш – 79000₮
- ✚ Гүйлгээний утга: Хуулийн этгээдийн нэр, Тохирлын гэрчилгээний төрөл
- ✚ Төлбөрийн баримтын хуулбарыг бүрдүүлэх материалын хамт авч ирэх эсвэл имэйл хаягаар явуулна.

Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ:

Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээг МХЕГ-ын <https://www.igov.mn/services> цахим системээр дамжуулан хүсэлтээ гаргаж авах боломжтой.

Экспортын гэрчилгээ (Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ):

Экспортын гэрчилгээг МХЕГ-ын <https://www.igov.mn/services> цахим системээр дамжуулан хүсэлтээ гаргаж авах боломжтой. МХЕГ-ын даргын 2019 оны А/81 дугаар тушаалд Экспортын гэрчилгээ олгоход хүсэлт хүлээн авахаас олгох, эс олгох хүртэл явагдах шат шатны процессыг дараах байдлаар нарийвчлан оруулжээ. Үүнд:

“Иргэн, хуулийн этгээдээс МХЕГ-т ирүүлсэн хүсэлтийг тус газрын “Зөвлөгөө, мэдээллийн төв”-д ажил үүрэг гүйцэтгэж байгаа Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын (ахлах) байцаагч шалгах хуудас ашиглан хүсэлт гаргагчийн дэргэд нягтлан шалгаж, хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ. Хүсэлт шалгах хуудасны шаардлагыг хангаж буй бол хүлээн авч, хүсэлт гаргагчид тасалбар өгнө. Хүсэлтийг хянан хүлээж авсан улсын байцаагч нь МХЕГ-ын албан бичиг хариуцсан ажилтанд нэн даруй хүлээлгэн өгнө. МХЕГ-ын албан бичиг хариуцсан ажилтан хүсэлтийг цахим системд бүртгэж, даргын туслахад хүлээлгэн өгнө. Даргын туслах хүсэлтийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж, МХЕГ-ын дарга (дэд дарга)-аар цохуулан Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын албан хэрэг хариуцсан улсын байцаагчид өгнө. МХЕГ-ын дарга (дэд дарга) хүсэлтийг нэн даруй буюу 24 цагийн дотор цохно.

Экспорт, импорт хилийн хорио цээрийн хяналтын газрын албан хэрэг хариуцсан улсын байцаагч даргын туслахаас хүсэлтийг хүлээн авч “бүртгэх дэвтэр”-т бүртгэн хяналтын газрын дарга, түүний түр эзгүйд хэлтсийн дарга, газар, хэлтсийн даргын түр эзгүйд ажил үүргийг нь түр орлож байгаа улсын ахлах байцаагчид танилцуулна. Хүсэлттэй танилцсан газрын/хэлтсийн

дарга ажлын нэг өдөрт багтаан цохолт хийж, цахимаар холбогдох улсын байцаагчид шилжүүлнэ. Уг цохолтын дагуу албан хэрэг хариуцсан улсын байцаагч хүсэлтийг цаасаар шилжүүлэн өгч, "бүртгэх дэвтэр"-т хүлээн авсан тухай тэмдэглэл хийж, гарын үсэг зуруулна. Хүсэлтийг хүлээн авсан улсын байцаагч нь хууль, журмын дагуу шалгаж гэрчилгээ мэдэгдэл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

Хэрвээ олгох боломжгүй бол энэ тухай хүсэлт гаргагчид ажлын нэг өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ. Албан бичигт олгоогүй үндэслэлийг тодорхой бичнэ. Гэрчилгээ мэдэгдэл олгох боломжтой бол хуулийн хугацаанд шуурхай олгоно. Хэвлэгдсэн мэдэгдлийг эрх бүхий албан тушаалтанд танилцуулан гарын үсэг зуруулна. Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг зурсан гэрчилгээ, мэдэгдэлд байгууллагын тэмдэг даруулж баталгаажуулна. Баталгаажсан гэрчилгээ, мэдэгдлийг холбогдох бүртгэлийн дэвтэрт бүртгэн дугаар олгож Зөвлөгөө мэдээллийн төвд ажил үүрэг гүйцэтгэж байгаа холбогдох улсын байцаагчид өгнө. Зөвлөгөө мэдээллийн төвд ажиллаж байгаа улсын байцаагч гэрчилгээ, мэдэгдлийг хүсэлт гаргагчид өгнө. Шалгах хуудсанд заасан баримт бичгээс өөр материал шаардахыг хориглоно.

- ✚ Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хандсан хүсэлт
- ✚ Хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэний иргэний үнэмлэхийн хуулбар
- ✚ Худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг /Орос, англи хэлээр бичигдсэнээс бусад тохиолдолд монгол хэл дээр баталгаат орчуулгаар орчуулсан байх/
- ✚ Стратегийн хүнс экспортлох бол /Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас гаргасан экспортлох тоо, хэмжээ /Квот/
- ✚ Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ
- ✚ Сав баглаа, боодлын мэдээлэл /тоо хэмжээ/ Англи хэлээр
- ✚ Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл
- ✚ Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн

Хил, гааль дээрх үйл явц:

“Улсын хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг”-ийн гаалийн бүрдүүлэлтийг экспортлогч өөрөө эсхүл гаалийн мэдүүлэгчээр дамжуулан гаалийн цахим сүлжээгээр явуулна.

Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хяналт хийх гурван төлөв байдаг бөгөөд эдгээр нь гаалийн эрсдэлийн удирдлагын программд урьдчилан оруулсан шалгуурт тулгуурлан улаан, улбар шар, ногоон гэсэн гурван өнгөөр илэрхийлэгдэнэ.

Ногоон	Бичиг баримт, бараанд шалгалт хийхгүй.
Улбар шар	Бичиг баримтын шалгалт хийнэ
Улаан	Бичиг баримт, бараанд шалгалт хийнэ.

Экспортын барааг хилээр нэвтрүүлэхэд дараах хоёр гаалийн бүсэд давхар хяналт хийгдэнэ. Үүнд:

- ✚ Гүний гаалийн байгууллагын хяналт шалгалт
- ✚ Хилийн гаалийн байгууллагын хяналт шалгалт

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын гаалийн бүрдүүлэлт нь гүний гаалийн хяналт, шалгалтад хамрагддаг бөгөөд хилийн боомт дахь гаалийн хяналт нь гүний гаалийн бүрдүүлэлтийг цахимаар хүлээн авч бичиг баримт болон ачааны лац ломбо, иж бүрэн байдлыг давхар шалган хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл өгдөг байна.

Экспортын гаалийн бүрдүүлэлт дараах үе шаттай явагдана:

1. Тээвэрлэгчид бараа тээвэрлүүлэх захиалга өгөн тээвэрлэлтэд бэлдэх, тээврийн бичиг баримтыг бүрдүүлэх
2. Гаальд мэдүүлэх
3. Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч гаалийн бүсэд нэвтрэх
4. Гааль бараа, тээврийн хэрэгслийг шалгах

5. Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах
6. Гаалийн болон бусад татвар хураамжийг барагдуулах
7. Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
8. Гааль болон Хилийн мэргэжлийн хяналтын алба бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, Хилийн мэргэжлийн хяналтын албанаас экспортын мэдэгдэл өгөх
9. Гаалийн хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх

Хүснэгт 21. Гаалийн хилээр гарах бараа, тээврийн хэрэгсэлд хийх гаалийн хяналт, бүрдүүлэлт

Гаалийн хяналтын бүсэд оруулсан бараа, тээврийн хэрэгслийг гүний гаалийн байгууллагын гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч, хилийн гаалийн байгууллагын бүртгэл хариуцсан гаалийн улсын байцаагч бүртгэнэ. Гаалийн шалгалт хийж, гаалийн хууль тогтоомж зөрчсөн зөрчил илрээгүй тохиолдолд бараа, тээврийн хэрэгслийн онцлогоос шалтгаалан гаалийн тэмдэглэгээний аль тохирохыг сонгон хэрэглэж, мэдүүлгийн D хүснэгтэд тэмдэглэгээний дугаарыг бичнэ.

Ногоон, улбар шар төлөвт сонгогдсон, гаалийн хилээр гаргах бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч гаалийн тэмдэглэгээ хийнэ. Бараа, тээврийн хэрэгслийг шалгасан гаалийн улсын байцаагч дагалдах бичиг баримтад тэмдэглэл хийж, дугаарлан хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулах бөгөөд гаалийн мэдүүлэгт дагалдах бичиг баримтын тоо, дугаарыг тэмдэглэн бараа, тээврийн хэрэгслийг гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримтын хамт гаалийн хяналтад илгээнэ. Бараа, тээврийн хэрэгсэлд шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч нь гаалийн мэдүүлгийг холбогдох бичиг баримтын хамт тухайн ажлын өдөрт багтаан гаалийн мэдүүлэг хариуцсан гаалийн улсын байцаагчид өгнө.

Тээвэрлэгч нь төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэрлэж, гаалийн хилээр гаргах барааны гаалийн мэдүүлгийг үндэслэн манифестыг нөхөн бичиж, бичлэгийг гаалийн байгууллагад сүлжээгээр илгээнэ. Гаалийн улсын ахлах байцаагч манифестын мэдээллийг шалгаж, “Зөвшөөрөх” товч дарж, манифестыг бараа, тээврийн хэрэгсэлд эцсийн бүрдүүлэлт хийх хилийн гаалийн хяналтын бүсэд сүлжээгээр илгээнэ. Эхний бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллагаас хилийн гаалийн байгууллагын хяналтад илгээсэн бараа, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримтыг гаалийн улсын ахлах байцаагч тээвэрлэгчээс хүлээн авч, бүртгэн, бараа, тээврийн хэрэгсэлд шалгалт хийх гаалийн улсын байцаагчийг сүлжээгээр томилно.

Хилийн гаалийн байгууллага бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бүсэд ирмэгц тээвэрлэгчтэй хамтран гүний гаалийн байгууллагын тэмдэглэгээг тулган шалгаж, бараа тээврийн хэрэгслийн дагалдах баримтыг бүртгэлд авна. Энэ үеэс бараа, тээврийн хэрэгсэл хилийн гаалийн байгууллагын хяналтад орно. Гаалийн тэмдэглэгээ гэмтэж ирсэн тохиолдолд тээврийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан тэмдэглэл үйлдэж, тээврийн байгууллагын акт /коммерын акт/-ыг хавсаргана.

Бараа, тээврийн хэрэгслийн гаалийн тэмдэглэгээ гэмтсэн, эсхүл шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд хилийн гаалийн байгууллага бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн шалгалт хийнэ. Хилийн гаалийн байгууллагын хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийн лац, ломбыг гаалийн мэдүүлэгтэй тулган шалгаж, зөрчилгүй тохиолдолд манифестадад “Баталгаажуулах” товч дарж, сүлжээгээр гаалийн улсын ахлах байцаагчид илгээнэ.

Гаалийн шалгалтаар гаалийн хууль тогтоомж зөрчсөн зөрчил илрээгүй, гүний гаалийн байгууллагын тэмдэглэгээ гэмтээгүй, хилийн гаалийн байгууллага бараа, тээврийн хэрэгслийг шалгах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд гаалийн мэдүүлгийн 1 дүгээр хүснэгтэд заасан гаалийн бүрдүүлэлтийн горимд хамаарах хяналтын тэмдгийг гаалийн мэдүүлгийн холбогдох хүснэгтэд дарж, огноог бичин, гарын үсэг зурах бөгөөд хяналтын тэмдгийн баруун доод буланд хувийн дугаар бүхий тэмдгийг тод дарна.

Гаалийн улсын байцаагч гаалийн бүрдүүлэлт хийж дууссан талаар гаалийн хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид мэдэгдэнэ. Гаалийн хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч үндэслэл бүхий мэдээлэл, сэжиг байгаа бол дахин шалгалт хийх, эсхүл бараа, тээврийн хэрэгслийг хилээр гаргах шийдвэрийн аль нэгийг гаргана.

Гаалийн улсын байцаагч замын хүснэгтэд “Монголын гааль зөвшөөрөв” гэсэн хяналтын тэмдэг дарна. Гаалийн улсын ахлах байцаагч сүлжээнд “Зөвшөөрөх” товч дарж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр гаргах зөвшөөрөл өгнө. Хилийн гаалийн байгууллага бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрээс гаргасан талаар бүртгэлд бүртгэнэ.

Эх сурвалж: ГЕГ-ын даргын 2019 оны А/275 тушаал

2.2. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨЛӨН ГЭДЭС

2.2.1. Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц

Хүнсний тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу *СТРАТЕГИЙН ХҮНС* гэдэг нь Монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, малын сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг хэлнэ. Малын мах нь стратегийн хүнсэнд хамаарах тул экспортлох үйл явц нь бусад бүтээгдэхүүнээс ялгаатай.

Мах, махан бүтээгдэхүүний судалгааг дараах нэр төрлийн экспортын бүтээгдэхүүнүүдийн хувьд судаллаа. Үүнд:

- ✚ Адууны түүхий мах
- ✚ Үхэр хонины дулааны аргаар боловсруулсан мах
- ✚ Боловсруулсан өлөн гэдэс
- ✚ Лаазалсан махан бүтээгдэхүүн

Судалгаанд хамрагдсан ААН-үүд:

- ✚ Траст Трейд ХХК
- ✚ Голден Гоат ХХК
- ✚ Мах Импекс ХК
- ✚ Монгол Тогоруу ХХК

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд нь ОХУ, БНХАУ, Япон зэрэг оронд мах, махан бүтээгдэхүүн экспортолдог бөгөөд автозамаар тээвэрлэдэг. Харин өлөн гэдсийг Япон улс руу агаарын тээврээр экспортолдог. 2020 онд цар тахал гарч, хорио цээрийн дэглэм тавигдсантай холбоотойгоор тээврийн хомсдолд өртөж экспортын хэмжээ, давтамж буурсан байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд хамгийн сүүлд 2021 оны 05 дугаар сард БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан мах экспортолсон байсан (цар тахлын нөлөөгөөр 2020 оноос эхлэн экспорт эрс буурсан). Зарим аж ахуйн нэгжийн тухайд, бага хэмжээний мах экспортлохоор бэлтгэж байсан бөгөөд ХХААХҮЯ-нд Бодлогын гэрээ байгуулах хүсэлт болон шаардлагатай бичиг баримтыг өгөөд 20 гаруй хонож байгаа тухай мэдээлсэн. Энэ нь цар тахлын нөлөө болон олон нийтийн баяр наадам, амралт давхацсантай холбоотой байна. Ердийн үед Бодлогын гэрээ байгуулахад дунджаар ажлын тав хоног хэмээн аж ахуйн нэгжүүд мэдэгдсэн.

Мах, махан бүтээгдэхүүнд тавигдах олон улсын стандарт шаардлага

Махны эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар олон улсад мөрдөж буй стандартуудыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 22. Махны эрүүл ахуйн олон улсын стандарт шаардлага

№	Баримт бичгийн нэр	Индекс, код	Монголын үндэсний стандартаар батлагдсан байдал
1	Махны эрүүл ахуйн дадлын дүрэм	CAC/RCP 58; 2005	MNS CAC RCP 58:2013
2	Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо	ISO/MNS 22000	MNS ISO/IEC 22000:2007
3	Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим	CAC/MNS 1- 2003	MNS CAC/ RCP 1 :2003
4	Хүнсний импорт, экспортын хяналт, баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх, үнэлэх болон итгэмжлэх ерөнхий зарчим	CAC/GL 26- 1997	MNS CAC/ GL 26- 2006
5	Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт	CAC/MNS 193:2007	MNS CAC 193:2007
6	Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	CAC/MNS/ MRL 2:2009	MNS CAC MRL 2:2009
7	Хүнс, малын тэжээлийн гарал үүсэл – ерөнхий 7 зарчим ба төлөвлөх, хэрэгжүүлэх тогтолцоонд тавих үндсэн шаардлага	ISO 22005	

8	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 1. Хүнсний үйлдвэр	ISO/TS 22002- 1:2009	
9	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 2. Хүнсний хангамж	SO/TS 22002- 2:2013	
10	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 3. Фермерийн аж ахуй	ISO/TS 22002- 3:2011	
11	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 4. Хүнсний савлагаа	ISO/TS 22002- 4:2013	
12	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 5. Тээвэрлэлт, хадгалалт	ISO/NP TS 22002-5:	
13	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 6. Малын тэжээлийн ба малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл	ISO/TS 22002- 6:2016	

Эх сурвалж: *Стандарт хэмжил зүйн газар*

Мах, махан бүтээгдэхүүний дийлэнх нь ОХУ, БНХАУ-д экспортлогддог бөгөөд хяналт, шалгалт, тавигдах шаардлагын зохицуулалт нь дараах баримт бичгийн хүрээнд явагддаг. Үүнд:

- ✚ Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар болон ОХУ-ын мал эмнэлэг, ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн хяналтын холбооны алба хооронд мал эмнэлгийн хяналтын салбарт хамтран ажиллах тухай протокол, 2011.06.16
- ✚ Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүнийг Монгол Улс, БНХАУ-д экспортолж, импортлох үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, БНХАУ-ын Чанарын Хяналт Шалгалт, Хорио Цээрийн Ерөнхий Газар хоорондын протокол 2011.10.27
- ✚ Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, БНХАУ-ын Чанарын Хяналт Шалгалт, Хорио Цээрийн Ерөнхий Газар хоорондын хяналт шалгалт, хорио цээрийн салбар дахь техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр, 2012.05.17
- ✚ Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хооронд үхрийн махыг Монгол Улс, БНХАУ-д экспортолж үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, нөхцөлийн тухай” протокол, 2016 он
- ✚ Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хооронд: хонь, ямааны махыг Монгол Улс, БНХАУ-д экспортолж үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, нөхцөлийн тухай протокол, 2016 он

Мах, махан бүтээгдэхүүний боловсруулалт, чанарын шаардлагад дараах стандартууд нэн чухал бөгөөд экспортод чухал холбогдолтой. Үүнд:

- ✚ САС RCP 58:2005 Махны эрүүл ахуйн дүрэм журам
- ✚ MNS 5023:2001 Мах, махан бүтээгдэхүүн. Эрүүл ахуй аюулгүй байдлын үндсэн шаардлага
- ✚ MNS 5998 : 2009 32 х. Мал нядлах үйлдвэр. Аюулын дүн шинжилгээ ба эгзгийг хянах цэгийн (НАССР) тогтолцооны загвар
- ✚ MNS 1111:2007 Үхэр, өсвөр үхэр, өрөөл, тал өрөөл, хонь, хурга, ямааны гулууз мах, Техникийн ерөнхий шаардлага
- ✚ MNS 6737:2018 Хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД) хэрэгжүүлэх удирдамж

Мах, махан бүтээгдэхүүн экспортод БНХАУ-аас тавигдах шаардлагууд:

Чанар, магадлан итгэмжлэлийн шаардлагууд:

- ✚ “Hazard Analysis and Critical Control Point (НАССР) System - General Requirements for Food Processing Plant”, National Standard of the PRC, GB/T 27341-2009
- ✚ “National Food Safety Standard Hygienic Specification for Livestock and Poultry Slaughtering and Processing “, National Standard of the PRC, GB 12694-2016
- ✚ General Rules for the Labelling of Prepackaged Foods, National Standard of the PRC, GB 7718 2011

БНХАУ-ын холбогдох хууль, эрх зүй

БНХАУ-ын хүнсний экспорт, импортын аюулгүй байдлыг зохицуулдаг 30 гаруй хууль, дүрэм, журам үйлчилдэг ба эдгээрээс манай улсын экспортлогчид зайлшгүй судлах шаардлагатай хууль, дүрмүүд:

- ✚ “Хүнсний аюулгүй байдлын тухай хууль”
- ✚ “Импорт, экспортын бараа бүтээгдэхүүний хяналт шалгалтын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам”
- ✚ “БНХАУ-ын амьтан, ургамлын хорио цээрийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам”
- ✚ “БНХАУ-ын хилийн эрүүл мэнд, хорио цээрийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам”
- ✚ “Хүнсний болон бусад бүтээгдэхүүний хяналт, удирдлагыг бэхжүүлэх талаар төрийн зөвлөлийн тусгай журам”
- ✚ “Импортын болон экспортын махны хяналт шалгалт, хорио цээрийн байдалд хяналт тавих арга хэмжээ”, Гаалийн журам

БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох аж ахуйн нэгж, компаниуд БНХАУ-ын шаардлагыг хангах арга хэмжээний шат дараалал:

1. Эрх бүхий байгууллагаас тухайн бүтээгдэхүүн нь БНХАУ руу экспортлох эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа гэдгийг баталгаажуулсан гэрчилгээ олгох;
2. Экспортлогч цахим бүртгэлд хамрагдах, дугаар авах: БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох ААН, үйлдвэрүүд БНХАУ-ын “Гаалийн Ерөнхий Газар”-ын харьяа “Баталгаажуулалт итгэмжлэлийн газар”-аас үйлдвэр дээрх хянан магадалгаа хийлгэх шаардлагатай. Хянан магадалгаанд тэнцсэн ААН-үүд БНХАУ-ын хүнсний бүтээгдэхүүний импортын бүртгэлд бүртгэгдсэн байх ёстой.
3. Экспортлогчид болон импортлогчид нь БНХАУ-ын чанарын хяналт, шалгалт болон тусгаарлалтын ерөнхий газарт (ЧХШТЕГ) гаалийн мэдүүлгээ бүртгүүлсэн байх;
4. Үйлдвэрлэгч БНХАУ-ын гэрчилгээ, зөвшөөрлийн ерөнхий газарт бүртгүүлж “Зөвшөөрөгдсөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч” гэрчилгээ авах;
5. Экспортолсон бүтээгдэхүүн нь БНХАУ-ын хилийн боомт дээр очмогц тус улсын эрх бүхий байгууллагын зохих албан тушаалтан хаяг, шошго, бичиг баримт (бүтээгдэхүүний хугацаа бүтээгдэхүүний хяналт шалгалт, аюулгүй байдал) зэргийг шалгана. Хэрэв бүх зүйл хууль, тогтоомжийн дагуу байвал хорио цээрийн хяналт, шалгалтад оруулснаар импортлох эрхийг олгоно.

БНХАУ-д экспортлогчоор бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтын жагсаалт:

1. Компанийн талаарх мэдээлэл
2. Өргөдлийн маягт бөглөсөн байх
3. БНХАУ руу экспортлох эрүүл ахуйн шаардлага хангаж буйг баталгаажуулсан

гэрчилгээ

4. Үйлдвэрийн хянан магадалгаа
5. БНХАУ-ын ЧХШТЕГ-т бүртгүүлсэн гаалийн мэдүүлэг
6. Мах, махан бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун

цэврийн гэрчилгээ гэх мэт

7. Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)
8. Төлбөрийн нэхэмжлэх
9. Сав баглаа боодлын жагсаалт
10. Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)
11. Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл
12. Ачааны манифест

БНХАУ-ын махны импортын шаардлага

1. Мал эмнэлгийн хорио цээрийн ерөнхий шаардлага

- ✚ Газрын амьтны кодекст заасан малын халдварт өвчингүй бүс нутгаас бэлтгэсэн байна.
- ✚ Гарал үүсэл, өвчний мэдээллийн нэгдсэн сүлжээтэй байна.
- ✚ Эргэж мөшгих тогтолцоотой байна.
- ✚ Мал, амьтныг тээвэрлэх тээврийн маршруттай байна.
- ✚ Сүүлийн 6 сар өвчин гараагүй хорио цээр, хяналтын бүсийн мал байна.

- ✚ Тээвэрлэлт нь өвчний хязгаарлалтад орсон эсвэл тандалтад хамрагдсан нутгаар дайран өнгөрч болохгүй.

2. Боловсруулалт ба технологийн шаардлага

Мах боловсруулах үйлдвэрүүд нь мэргэжлийн байгууллагын хяналтын дор үйлдвэрлэлийн НАССР-ийн чанарын стандартыг мөрдөнө. БНХАУ нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд өөрийн “GB” буюу “Guobiao” стандартыг баримталдаг.

Хүснэгт 23. БНХАУ-ын малын шинэ, хөлдөөсөн, гулууз маханд тавигдах стандартууд

Махны төрөл	Стандарт
Хөлдөөсөн, шинээр нь зах зээлд гаргах, гулуузаар нь хөлдөөх, үхрийн мах	<ul style="list-style-type: none"> Нядалгаанд орох үхэр: 18-48 сартай, багадаа 3 сарын турш тэжээж бордсон. Нядалсны дараа орчны 0°C-4°C температурт байлгах, энэ нь махны рН-ийг нэмэгдүүлж махны амтыг сайжруулдаг. Хөргөх өрөөний температур 0°C-4°C температурт 36 цаг байх. Үүнд 7°C дээш температурт байлгаж болохгүй. Махаа хөргөсний дараа -28°C температурт гүн хөлдөөх, үүнд -18°C-т-аас дээш температурт 36 цагаас дээш байлгаж болохгүй.
Хонь ямаа шинээр нь зах зээлд гаргах, гулуузаар нь хөлдөөх	<ul style="list-style-type: none"> Хурганы мах 4-12 сартай, шүд нь гүйцэд ургаагүй. Бордсон хурга, 4-12 сартай, богино хугацаанд таргалсан, шүд нь гүйцэд ургаагүй. Ямааны маханд тавигдах шаардлага хонины махтай адил байна. Хонины мах, 12 сараас дээш настай, дахин шүдлээгүй Малыг цуслах аргаар нядална, үс, арьсыг нь халуун ус ашиглаж цэвэрлэнэ, нядалсны дараа цэвэрлэж угаана, өөх булчингийн гадаргыг гэмтээхгүй, булчирхай, цэвэрлэгдээгүй эд, илүүдэл үс, гэмтсэн хэсгийг цэвэрлэнэ. Хөргөх өрөөний температур 0°C-4°C, үүнд 7°C дээш температурт 10-аас илүү цаг байлгаж болохгүй Хөлдөөх өрөөний температур -28°C, үүнд махыг -18°C-аас дээш температурт удаан байлгаж болохгүй.
Дулааны аргаар боловсруулсан мах	<ul style="list-style-type: none"> Махыг дулааны аргаар боловсруулахдаа дараах шаардлагыг хангасан байна. <ul style="list-style-type: none"> а/ Усанд буцалгах, жигнэх болон тосонд шарахдаа үхрийн мах болон түүний гаралтай бүтээгдэхүүний төв хэсгийн дулааны 80°C болон түүнээс дээш температурт хүргэж 5 минут болон түүнээс дээш хугацаанд байлгана. Эсхүл бусад ямар ч арга хэрэглэсэн үхрийн мах болон түүний гаралтай бүтээгдэхүүний төв хэсгийн дулааныг 70°C болон түүнээс дээш температурт хүргэж 30 минут байлгана. б/ Усанд буцалгах, жигнэх болон тосонд шарахдаа хонь, ямааны мах болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний төв хэсгийн дулааныг 70°C болон түүнээс дээш температурт хүргэж 5 минут болон түүнээс дээш хугацаанд байлгана. Эсхүл бусад ямар ч арга хэрэглэсэн хонь, ямааны мах болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний төв хэсгийн дулааныг 65°C болон түүнээс дээш температурт хүргэж 30 минут байлгана.

Эх үүсвэр: “Монгол улсын гадаад худалдааны талаар баримтлах бодлого”, 2018, “Бодлогын шийдэл” ТББ

Мах, махан бүтээгдэхүүний экспортод ОХУ-аас тавигдах шаардлагууд:

Мал эмнэлэг, ариун цэврийн хянан магадалгаа хийлгэх:

ОХУ-ын Хөдөө аж ахуйн хяналтын алба экспортлогч орны эрх бүхий байгууллагын (Мал эмнэлгийн ерөнхий газар) хүсэлтээр мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хянан магадалгаа хийж, шалгалтын үр дүнгээр тухайн аж ахуйн нэгжид бүтээгдэхүүнээ ОХУ-д экспортлох эрх олгох эсэхийг шийдвэрлэдэг.

Евроазийн эдийн засгийн комиссын 317 дугаар шийдвэрийн 3 дугаар Хавсралтаар баталсан журмын дагуу шалгагдаж эрх авсан үйлдвэр аж ахуйн нэгжүүдийг “Гаалийн холбооны нутаг дэвсгэрт бүтээгдэхүүнээ экспортлох эрх бүхий гуравдагч орнуудын үйлдвэрүүдийн жагсаалт (РЕЕСТР-т)-д бүртгэж, энэ тухайгаа ОХУ-ын Хөдөө аж ахуйн хяналтын алба, Россельхознадзорын вэб хуудсанд байршуулдаг.

ОХУ-ын импортын шаардлага:

1. Мал тус бүрийн эрүүл мэндийн шаардлага:

Үхрийн мах:

- ✚ Үхрийн тархи сархиагтах өвчин, энцефаломиелит ДМАЭМБ-ын ариун цэврийн кодекст заасан ангилалын дагуу эрсдэлгүй нутгаас бэлтгэгдсэн
- ✚ Үхрийн цээж өвчин сүүлийн 12 сар гараагүй
- ✚ Хөх хэлтэх өвчин сүүлийн 9 сар гараагүй
- ✚ Сүрьеэ, бруцеллез өвчин аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэр дээр сүүлийн 6 сар гараагүй
- ✚ Лейкоз өвчин сүүлийн 12 сар гараагүй
- ✚ Дуут хавдар өвчин аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэр дээр сүүлийн 20 хоног гараагүй
- ✚ Уушгины хавьтал халдвар, галзуу өвчин сүүлийн 24 сар гараагүй
- ✚ Шүлхий өвчин сүүлийн 12 сар гараагүй
- ✚ Боом өвчин сүүлийн 20 хоног гараагүй

Адууны мах:

- ✚ Ям өвчин сүүлийн 3 жил гараагүй
- ✚ Төхөөрөхийн өмнө ямлуурт орж сөрөг гарсан
- ✚ Төхөөрөхөөс 15-аас доошгүй хоногийн өмнө арьсны ямлуурын (внутрикожная) сорил тарихад сөрөг үр дүн өгсөн байх
- ✚ Халдварт цус багадаа өвчин сүүлийн 3 сар гараагүй
- ✚ Хулгана яр өвчин 2 сар гараагүй
- ✚ Боом 20 хоног гараагүй
- ✚ Адууны африкийн тахал өвчин сүүлийн 24 сар гараагүй
- ✚ Адууг мал нядалгааны газар нядалсан байна.

Хонь, ямааны мах:

- ✚ Хонины скарпи өвчин Олон улсын мал эмнэлгийн дүрэмд заасны дагуу тус улсад гараагүй
- ✚ Аденоматоз өвчин сүүлийн 3 жил гараагүй
- ✚ Хонь, ямааны цэцэг өвчин сүүлийн 12 сар тухайн нутаг дэвсгэр дээр гараагүй
- ✚ Бруцеллез өвчин сүүлийн 6 сар ферм, аж ахуйн нутаг дэвсгэр дээр гараагүй

2. Малын маханд тавигддаг ариун цэврийн шаардлага:

- ✚ Нян судлал, хими хор судлал, цацрагийн үзүүлэлтүүд ЕАЭЗХ-ны мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагад нийцсэн.
- ✚ Сальмонелл г.м хүний эрүүл мэндэд хортой нян агуулаагүй
- ✚ Гуурын авгалдай илрээгүй
- ✚ Анаэроб бактерийн халдвар байхгүй

3. Махны чанарын шаардлага:

Махны ангилал

ОХУ-ын Мал эмнэлгийн байгууллагаас гаргасан дүрмээр эпизоотологийн болон гельминтологийн өвчлөлтөд өртөх магадлалаас хамааран худалдан авч байгаа махыг 4 ангилалд хуваадаг. Үүнд:

- ✚ “А” ангилал - Эдгээр махыг зөвхөн нөөш бэлтгэх зориулалтаар 2-оос доошгүй цаг, 80°С-т боловсруулна.
- ✚ “В” ангилал - Эдгээр махыг 75°С-т боловсруулалт хийнэ.
- ✚ “С” ангилал - Эдгээр махыг хيام болон чанаж утах технологийн горимын дагуу зохих хэмд боловсруулсан бүтээгдэхүүн болгох.
- ✚ “Д” ангилал - Хязгаарлалтгүй чөлөөтэй худалдаалах.

Махны нядалгааны дараах шаардлага:

- ✚ Махны бүрхүүл хальс хуулагдаагүй, механик хольцгүй
- ✚ Муудсан шинж тэмдэг илрээгүй
- ✚ Гаж үнэр, амтгүй /загас, эмийн ургамал гэх мэт/
- ✚ Махны эдэд цус нөжрөөгүй
- ✚ Дотор эрхтний үлдэгдэлгүй

Хүснэгт 24. Махны экспортод ОХУ-ын талаас шаарддаг бичиг баримтууд

№	Баримт бичгийн нэр	Олгох байгууллага	Тайлбар
1	Дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний импортын зөвшөөрөл (Разрешение на ввоз)	Оросын холбооны улсын хөдөө аж ахуйн хяналтын алба (Россельхознадзор)-аас олгоно	Энэ зөвшөөрлийг импортлогч тал өөрийн орон нутаг дахь хөдөө аж ахуйн хяналтын албанаас авч экспортлогч талд илгээнэ. Энэхүү зөвшөөрлийг аваагүй тохиолдолд барааг ОХУ-ын хилээр нэвтрүүлэхгүй.
2	Тохирлын гэрчилгээ (Декларация о соответствии)	Оросын холбооны улсын тохирлын гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагаас олгоно	Оросын холбооны улсын тохирлын гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагаас дулааны аргаар боловсруулсан бөгөөд импортлох бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрд 1-3 жилийн хугацаагаар олгоно. Энэ гэрчилгээ байхгүй бол тухайн бүтээгдэхүүнийг ОХУ-ын зах зээлд борлуулж болохгүй
3	Автомашинаар бараа тээвэрлэх урьдчилсан мэдээлэл /Предварительная информация для перевозок автотранспортом	Бараа импортлох үед хилийн боомт дахь холбооны гаалийн албанаас олгоно.	Импортлогч энэ мэдээллийг авсны тээвэрлэгчид мэдэгдэх ба үүний дараа тээврийн хэрэгсэл ОХУ-ын хилийн боомт руу орох эртэй болно. Тээвэрлэгч нь энэ мэдэгдлийг цаасаар аваагүй мэдэгдлийн дугаарыг импортлогч талаас авч хилийн шалганы ажилтанд хэлж болно.
4	Гаалийн мэдүүлэг	Холбооны гаалийн алба (Федеральная таможенная служба),	Тухайн экспортын ачилттай холбоотой бүх мэдээлэл болон бичиг баримтуудыг ОХУ-ын гаалийн цахим мэдээллийн санд урьдчилан 3-5 хоногийн өмнө мэдүүлж, бэлтгэл ажлыг хийх

Япон улсад мах, махан бүтээгдэхүүн экспортлоход тус улсаас тавигдах шаардлага:

1. Малын эрүүл мэнд, хорио цээрийн шаардлага

- ✚ Шүлхий өвчний дэгдэлттэй бүсээс бэлтгэсэн малын махыг экспортлохыг хориглоно.

2. Боловсруулалт ба технологийн шаардлага

Дулааны бус аргаар боловсруулах:

- ✚ Махан бүтээгдэхүүний нитритийн дээд хэмжээ 70 ppm-ээс хэтрэхгүй байх.
- ✚ рН-ийн түвшин 6 ба түүнээс доош
- ✚ 40°C-д загсаасан байх
- ✚ Утсан болон хатаасан махны рН-ийн түвшин 4.6-аас бага байх, хэрэв рН-ийн түвшин 4.6-5.1 хооронд бол ус 0.93-аас бага байх

Тусгайлан дулааны аргаар боловсруулах

- ✚ Бэлэн бүтээгдэхүүний нитритийн дээд хэмжээ 70 ppm-ээс хэтрэхгүй байх.
- ✚ Тусгайлан дулааны аргаар боловсруулалт хийхдээ дотоод дулааныг 60°C-д хүртэл 12 минутын турш бэлтгэнэ.
- ✚ Дулааны аргаар боловсруулалт хийхдээ дотоод дулааныг 63°C-д хүртэл 30 минутын турш бэлтгэнэ.
- ✚ Япон улсад экспортлох махыг дулааны аргаар боловсруулахдаа махан бүтээгдэхүүний рН-ийн түвшин 6 ба түүнээс доош байх ба 4°C-д загсаасан байх шаардлагатай.

Хүснэгт 25. Япон улсын дулааны аргаар мах боловсруулахад тавигдах шаардлага

С°	(F°)	Хугацаа	С°	(F°)	Хугацаа
55	(131.0)	97 минут	60	(140.0)	12 минут
56	(132.8)	64 минут	61	(141.8)	9 минут
57	(134.6)	43 минут	62	(143.6)	6 минут
58	(136.4)	28 минут	63	(145.4)	0
59	(138.2)	19 минут			

Эх үүсвэр: “Монгол улсын гадаад худалдааны талаар баримтлах бодлого”, 2018, “Бодлогын шийдэл” ТББ

3. Органик бүтээгдэхүүний шаардлага

- ✚ Ямар нэгэн будагч бодис, амт оруулагч хэрэглээгүй байх
- ✚ Япон Улсад хориотой малын эм, хүнсний нэмэлт хэрэглээгүй байх

4. Бүтээгдэхүүний чанарын шаардлага

✚ 30 сараас доош сартай үхрийн мах

Мах, махан бүтээгдэхүүн экспортлоход бүрдүүлэх бичиг баримт:

Хүснэгт 26. Мах, махан бүтээгдэхүүний экспортын бичиг баримтын жагсаалт

№	Бичиг баримтын жагсаалт	Бичиг баримтыг олгох газар	Экспортлох улс орон			
			БНХАУ	ОХУ	Япон	Европын орнууд
1	Улсын бүртгэлийн гэрчилгээ	Экспортлогч байгууллага	+	+	+	+
2	Стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл (квот)	ХХААХҮЯ	+	+	+	+
3	Үнийн нэхэмжлэх	Экспортлогч байгууллага	+	+	+	+
4	Худалдах, худалдан авах гэрээ	Импортологч болон экспортлогч байгууллага	+	+	+	+
5	Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч байгууллага	+	+	+	+
6	Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ	Бүс, нутгийн анхан шатны мал эмнэлгийн нэгж	+	+	+	+
7	ХХААХҮЯ-тай байгуулах бодлогын гэрээ	ХХААХҮЯ	+	+	+	+
8	Бүтээгдэхүүний дээжид итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори/ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	+	+	+	+
9	Тохирлын гэрчилгээ	Стандарт хэмжил зүйн газар	+	+	+	+
10	Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ	+	+	+	+
11	ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	Мал эмнэлгийн ерөнхий газар	+	+	+	+
12	Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээ, экспортын гэрчилгээ	МХЕГ	+	+	+	+
13	Тээврийн бичиг баримт	Тээвэрлэгч	+	+	+	+

Гадаад улс орнуудын шаардлагаас илүү, нэмэлтээр Монголын талын шаардаж буй бичиг баримтууд:

1. БНХАУ-д экспорт:
 - ✚ Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ
 - ✚ Бодлогын гэрээ
 - ✚ Тохирлын гэрчилгээ
2. ОХУ-д экспорт:
 - ✚ Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ
 - ✚ Бодлогын гэрээ

Мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл явц:

Түүхий мах, дулааны аргаар боловсруулсан мах нь стратегийн хүнсний бүтээгдэхүүн гэсэн ангилалд ордог учир экспорт хийхийн тулд нэн түрүүнд ХХААХҮЯ-аас тухайн жилд экспорт хийх тоо хэмжээг тодорхойлсон экспортын зөвшөөрөл буюу квот авна. Квоттой аж ахуйн нэгж ХХААХҮЯ-тай бодлогын гэрээ байгуулах бөгөөд тус бодлогын гэрээнд заасан тоо хэмжээг Гаалийн ерөнхий газрын цахим сүлжээнд бүртгүүлж, бусад шаардлагатай бичиг баримтын бүрдүүлэлтэд ашигладаг.

Түүхий мах, дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн, боловсруулсан өлөн гэдэс экспортлоход Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газар (НМХГ)-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэст “мах экспортлоход хяналт тавих байцаагч томилуулах тухай” болон “экспортын бүтээгдэхүүний дээжид шинжилгээ хийлгүүлэх тухай” хүсэлт гаргана.

НМХГ-ын томилсон байцаагч махнаас түүврийн аргаар дээж авч бүтээгдэхүүнд ямар үзүүлэлтүүдээр шинжилгээ хийлгүүлэх тухай мэдэгдэл бичиж өгөх бөгөөд дээжийн хамт

итгэмжлэгдсэн лаборатори буюу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид (махан бүтээгдэхүүн, өлөн гэдэсний хувьд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори байж болно) хүргэж өгнө. УМЭАЦТЛ-ын хүлээн авахын эмч дээжийг хүлээн авсан тухай тусгай журналд тэмдэглэл хийж дээжийн код болон тус лабораторид хийлгэсэн шинжилгээний төлбөрийн дүн, төлбөр хүлээн авах банк, дансны мэдээлэл, шинжилгээний хариу бэлэн болох хугацааг экспортлогч аж ахуйн нэгжийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

Экспортлогч аж ахуйн нэгжийн ажилтан УМЭАЦТЛ-ын шинжилгээний дүгнэлтийг МЭЕГ-т өгч “ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ” авах бөгөөд мөн МХЕГ-т бусад шаардлагатай бичиг баримтын хамт өгч “Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ” буюу Экспортын гэрчилгээ авна.

Хүснэгт 27. Экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явцын хугацаа, зардал: Адууны мах, дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах

Алхам	Байгууллага	Өдөр/ цаг													Зардал, ₮	
		0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		13
		0	24	48	72	96	120	144	168	192	216	240	264	288		312
Худалдах, худалдан авах гэрээ	Экспортлогч, импортлогч		+													
Үнийн нэхэмжлэх	Экспортлогч		+													
Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч		+													
Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ /урьдчилан авсан/	Бүс нутгийн анхан шатны мал эмнэлгийн нэгж	+														
Бодлогын гэрээ	ХХААХҮЯ		+	+	+	+										
ГЕГ-ын цахим сүлжээнд экспортын хэмжээг бүртгүүлэх	ГЕГ					+										
Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ					+	+									
Дээжид шинжилгээ хийх	УМЭАЦТЛ						+	+	+	+						Шинжилгээний төрлөөс хамаарна ¹⁰ Жишээ /1 дээж 104,000₮/: Нян – 20,000₮, Эмийн болон пестицидийн үлдэгдэл – 48,000₮, Хүнд хортой элемент – 11,000₮, Цацраг идэвхт элемент – 25,000₮
Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ	МЭЕГ										+	+				12,500₮
Тохирлын гэрчилгээ	СХЗГ											2 цаг				79,000₮

¹⁰ ХХААХҮС-ын 2017 оны А-112 дугаар тушаал “Оношлогоо, шинжилгээнд мөрдөх үнийн тарифыг батлах тухай

Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ									2 цаг							40,000₮
Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ	МХЕГ									+	+	+	+	+			10,000₮
Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч															+	
Нийт																312 цаг	245'500₮

Тайлбар: зөвхөн экспортлох квоттой ААН-үүдэд хамаарна.

Стратегийн хүнсний бүтээгдэхүүн ангилалд хамрагдах мах экспортлох бичиг баримт бүрдүүлэхэд нийт зарцуулах хугацаа 312 цаг бөгөөд зардал 245,500₮ байна.

Дээжийг УМЭАЦТЛ-д хүргэн өгч 3-4 төрлийн шинжилгээ хийдэг бөгөөд хариунаас шалтгаалж гарах зардал болон зарцуулах хугацаа өөр өөр байдаг. Жишээлбэл, Нянгийн шинжилгээ – 20,000₮, Эмийн болон пестицидийн үлдэгдэл – 48,000₮, Хүнд хортой элемент – 11,000₮, Цацраг идэвхт элемент – 25,000₮ буюу нийт 104,000₮ болно. Шинжилгээ хийхдээ нян, мөөгөнцөр зэргийг өсгөвөрлөх арга ашиглан үздэг учир ихэвчлэн 72 цагийг бүрэн шинжилгээнд, хариу авах болон бичиг цаасны ажилтай нийлэн 4-5 өдөр болдог байна.

Хүснэгт 28. Экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явцын хугацаа, зардал: Боловсруулсан өлөн гэдэс

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг									Зардал, ₮					
			1	2	3	4	5	6	7	8	9						
			24	48	72	96	120	144	168	192	216						
1	Худалдах, худалдан авах гэрээ	Экспортлогч, импортлогч	+														
2	Үнийн нэхэмжлэх	Экспортлогч	+														
3	Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч	+														
4	Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	+	+													
5	Дээжид шинжилгээ хийх	УМЭАЦТЛ		+	+	+	+	+									104,000₮*
6	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ	МЭЕГ						+	+								12,500₮
7	Тохирлын гэрчилгээ	СХЗГ								2ц							79,000₮
8	Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ								2ц							40,000₮
9	Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ	МХЕГ									+	+	+	+			10,000₮
10	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэр зууч														+	
	Нийт															216 цаг	245'500₮

*дээжид хийгдэх шинжилгээний үнэ шинжилгээний төрлүүдээс хамаарна

Боловсруулсан өлөн гэдэс экспортлох бичиг баримт бүрдүүлэхэд нийт зарцуулах хугацаа 216 цаг, зардал 245,500₮ байна.

Хүснэгт 29. Экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явцын хугацаа, зардал: Боловсруулсан махан бүтээгдэхүүн

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг								Зардал, ₮						
			1	2	3	4	5	6	7	8							
			24	48	72	96	120	144	168	192							
1	Худалдах, худалдан авах гэрээ	Экспортлогч, импортлогч	+														

2	Үнийн нэхэмжлэх	Экспортлогч	+								
3	Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч	+								
4	Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	+	+							
5	Дээжид шинжилгээ хийх	УМЭАЦТЛ		+	+	+	+				104,000₮*
6	Тохирлын гэрчилгээ	СХЗГ					+				79,000₮
7	Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ					+				40,000₮
8	Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ	МХЕГ					+	+	+	+	10,000₮
9	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч								+	
	Нийт									192 цаг	233'000₮

*дээжид хийгдэх шинжилгээний үнэ шинжилгээний төрлүүдээс хамаарна

Боловсруулсан махан бүтээгдэхүүн экспортлох бичиг баримт бүрдүүлэхэд нийт зарцуулах хугацаа 192 цаг, зардал 233,000₮ байна.

Зураг 18. Экспортын гэрчилгээ, зөвшөөрөл бүрдүүлэлт: стратегийн бүтээгдэхүүн-мах



Зарим бичиг баримт бүрдүүлэлт нь шат дараалалтай бөгөөд стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох махны экспорт нь энэхүү бичиг баримтыг бүрдүүлэхээс өмнө тухайн оны экспортын квот авсан байх шаардлагатай.

Зураг 19. Боловсруулсан өлөн гэдэсний экспортын гэрчилгээ, зөвшөөрөл бүрдүүлэлт



Боловсруулсан өлөн гэдэс нь стратегийн хүнсний бүтээгдэхүүний ангилалд багтдаггүй бөгөөд экспортын квот шаардлагагүй. Зөвшөөрлийн бичиг баримт бүрдүүлэлт нь 5 бичиг баримтаас бүрдэнэ.

Зураг 20. Боловсруулсан махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрөл бүрдүүлэлт



Боловсруулсан махан бүтээгдэхүүн буюу лаазалсан махны бичиг баримт бүрдүүлэлт нь Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ шаарддаггүй байна.

Хүснэгт 30. Гэрчилгээ, зөвшөөрлүүдийн хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт

Зөвшөөрөл, гэрчилгээ	Бүрдүүлэх материал
Стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл (квот)	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын танилцуулга - Экспортлох бүтээгдэхүүний нэр төрөл, багцын хэмжээг заасан албан бичиг - Худалдааны гэрээ - Сүүлийн жилийн санхүүгийн тайлангийн хуулбар /Аудитаар баталгаажсан/ - Хуулийн этгээдийг төлөөлөн сонгон шалгаруулалтад оролцох этгээдэд итгэмжлэл олгосон эрх бүхий албан тушаалтны шийдвэр - Мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт - Татварын албаны тодорхойлолт

	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай тохиолдолд импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн байгууллагаас итгэмжлэгдсэн байх - Хүн амын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд ХХААХҮЯ-тай бодлогын гэрээ байгуулахад татгалзах зүйлгүй талаар мэдэгдсэн албан бичиг
Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ	Харьяалсан бүс нутгийн мал эмнэлгийн нэгжээс мал, түүхий эдэд дагалдуулж өгдөг.
ХХААХҮЯ-тай байгуулах бодлогын гэрээ	<ul style="list-style-type: none"> - Үйлдвэрийн танилцуулга - Мал, мах бэлтгэлийн талаар мэдээлэл, төлөвлөгөө - Мал эмнэлгийн гэрчилгээ - Бэлтгэсэн түүхий эдийн 30-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрт нийлүүлсэн тухай гэрээ, төлбөрийн баримт эсхүл экспортод гаргахаар зориулалтын агуулахад хадгалж буй баримт - Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, шинжээчийн дүгнэлт - Малын гаралтай болон энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрсөн цэгт хог хаягдлын гэрээ - Хоёр орны хооронд байгуулсан протоколын дагуу боловсруулж, батлуулсан технологийн заавар
Бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт	НМХГ-ын томилсон байцаагчийн авсан дээжид шинжилгээ хийж дүгнэлт гаргана.
Тохирлын гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - УБГ-ний хуулбар (баталгаажсан) - Өргөдлийн маягт бөглөх (masm.gov.mn) - Худалдах, худалдан авах гэрээ - Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг - Бүтээгдэхүүний сорилт, туршилт хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн - Мэргэжлийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл (шаардлагатай тохиолдолд) - Үйлчилгээний төлбөр тушаасан баримтын хувь
Гарал үүслийн гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - УБГ-ний хуулбар - Өргөдлийн маягт бөглөх - Гадаад худалдааны гэрээний хуулбар - Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт - Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл, чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар
ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - УБГ-ний хуулбар - Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа - Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил
Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээ, экспортын гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - Албан хүсэлт бичгээр - УБГ-ний хуулбар - Стратегийн хүнс экспортлох бол ХХААХҮЯ-аас гаргасан экспортлох тоо хэмжээ /квот/ - Худалдах, худалдан авах гэрээ эсхүл түүнтэй адилтгах баримт - Сав, баглаа боодлын мэдээлэл, тоо хэмжээ /Англи хэлээр/ - Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн - Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл - Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ - ОХУ болон БНХАУ-д экспортлох бол тухайн улсад бүртгэсэн бүртгэлийн хуулбар /нэг удаа өгөх/ - Гуравдагч оронд экспортлох бол ОХУ болон БНХАУ-аас дамжуулан тээвэрлэх зөвшөөрлийн хуулбар - Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах тухай улсын байцаагчийн дүгнэлт /анх удаа экспорт эхэлж байгаа бол/ - Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

2.2.2. Хил, гааль дээрх үйл явц

Гадаад улс орнуудын сав, баглаа, боодлын стандарт, шаардлага

Монгол-БНХАУ-ын хооронд байгуулсан дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний сав, баглаа, боодол, шошгод дараах шаардлагуудыг тавьсан байна.

Импортлогч орон руу гаргах боловсруулсан бүтээгдэхүүнийг олон улсын ариун цэврийн стандартыг хангасан шинэ материалаар боож баглана. Гадна талын баглаан дээр монгол,

хятад, англи хэлээр стандарт үйлдвэрлэсэн газар, очих газар бүтээгдэхүүний нэр, жин үйлдвэрлэгчийн нэр, бүртгэлийн дугаар, үйлдвэрлэлийн цувааны дугаар, хадгалах нөхцөл, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа, хоёр талаас тэмдэглэсний дагуу хяналт шалгалт, хорио цээрийн нөхцлийг хангасан тэмдэглэгээг заасан байна. Дотор баглаан дээр үйлдвэрлэгч орны нэр бүтээгдэхүүний нэр, аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаар, үйлдвэрлэлийн цувааны дугаарыг заана. Дотор, гадна баглаан дээр мөн зөвхөн импортлогч оронд борлуулахыг заасан тэмдэглэгээг заавал хийнэ (тухайлбал, "зөвхөн Хятадын эх газарт борлуулна" "зөвхөн Монгол улсад борлуулна" гэх мэт).

Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд холбогдох стандартын шаардлагуудыг хангах шаардлага тавигдана.

Манай улсад мөрдөгдөж байгаа сав, баглаа, боодлын стандартууд:

MNS ISO 8367-2:1998	Сав баглаа боодол - Ерөнхий зориулалтын уутны зөвшөөрөгдөх хэмжээ 2-р хэсэг: Нийлэг хальсан уут 2010 оны 05 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.
MNS 6382:2013	Сав баглаа боодлын зориулалттай үелээт картон. Техникийн шаардлага.
MNS 5684:2006	Сав баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
MNS OIML R 87:2008	Савласан бүтээгдэхүүний тоо хэмжээ
MNS ISO 780:2004	Баглаа боодол - Эд зүйлсийг зөөвөрлөхөд тавих зурган тэмдэглэгээ
MNS 1640:1973	Сав. Үндсэн төрөл нэр томьёо.

БНХАУ руу экспортлох мах, махан бүтээгдэхүүний сав баглаа, боодолд БНХАУ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний стандартын газраас гаргасан бүтээгдэхүүний хаяглах, шошголох ерөнхий дүрэм, стандарт (National food safety standard General Rules for the labeling of prepackaged foods GB7718-2011)-ын дагуу тавигддаг стандарт, шаардлагууд¹¹:

Сав, баглаа, боодлын төрлүүд:

- ✚ Түүхий эд боловсруулалтын сав, баглаа, боодол
- ✚ Хэрэглээний сав, баглаа, боодол
- ✚ Гаднах сав, баглаа, боодол
- ✚ Тээврийн сав, баглаа, боодол

Шошго, худалдааны тэмдэг, кодчиллол:

- ✚ Савлагааны гаднах шошго: Хятад эсвэл Англи хэлээр байна.
- ✚ Гарал үүсэл (Улс)
- ✚ Бүтээгдэхүүний нэр
- ✚ Очих улс
- ✚ Үйлдвэрлэлийн лац дугаар (Үйлдвэрлэгчийн тодорхойлсноор)
- ✚ Үйлдвэрлэсэн огноо
- ✚ Цэвэр жин, килограммаар (Англи)
- ✚ Дуусах хугацаа, хадгалах хугацаа
- ✚ Үйлдвэрийн нэр
- ✚ Үйлдвэрийн экспортлогчоор бүртгүүлсэн зөвшөөрлийн дугаар
- ✚ Хөлдөөгөөд -18С хадгалсан
- ✚ Үйлдвэрийн хаяг (Англи)
- ✚ Хяналт хийсэн байгууллагын дардас (Англи)

Савлагааны доторх шошго:

- ✚ Хятад эсвэл Англи хэлээр
- ✚ Бүтээгдэхүүний нэр
- ✚ Гарал үүсэл (Улс)

¹¹ ОХУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох, МҮХАҮТ, 2020

- ✚ Байгууллагын дугаар
- ✚ Үйлдвэрлэлийн лац дугаар (Үйлдвэрлэгчийн тодорхойлсноор)
- ✚ Үйлдвэрийн бүртгэлийн дугаар

ОХУ-д экспортлох мах, махан бүтээгдэхүүний экспортод ОХУ-ын талаас Хүнсний сав баглаа боодол нь зориулалтын, хүнсний бүтээгдэхүүнд үл шилжих/ нэвчих, бат, бөх, бохирдлоос бүрэн хэмжээгээр хамгаалсан, түгээлтийн явцад учирч болох механик, хими, дулааны ачааллыг даахуйц, Сав, баглаа боодлыг бохирдохоос хамгаалсан нөхцөлд хадгалах, Шошгололт нь мөрдөгдөж байгаа, хууль, стандартын шаардлагуудыг хангасан байх шаардлага тавьдаг.

- ✚ Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошго, тээврийн сав баглаа боодол дээрх мэдээллийг Гаалийн холбооны техникийн зохицуулалт ТР ТС022/2011–д заасан шаардлагын дагуу орос хэл дээр бичих.
- ✚ Хүнсний бүтээгдэхүүний шошго дээр бүтээгдэхүүний тухай холбогдох мэдээллийг оруулахаас гадна түүний сав баглаа боодлын бүтэц ямар болох, түүнийг ямар материалаар хийсэн, холбооны орнуудын нутаг дэвсгэр дээр борлуулалтад орж болох тухай тэмдэг, сав баглаа боодлыг дахин эргэлтэд оруулж болох эсэх тухай тэмдэг байрлуулах.
- ✚ Хүнсний бүтээгдэхүүнийг ОХУ/ЕАЭЗХ-ын зах зээлд борлуулахаас сав, таглаанд “Тохирлын гэрчилгээ” авах. “Сав баглаа боодлын аюулгүй байдлын тухай” Гаалийн холбооны техникийн зохицуулалт 49ТРТС005/2011-ыг хангасан байх.

ОХУ-ын “Сав баглаа боодлын аюулгүй байдлын тухай”, Гаалийн холбооны техникийн зохицуулалт ТР ТС 005/2011-д ариун цэвэр, эрүүл ахуй механик нөлөөллийн шалгуур, химийн орчинд тэсвэртэй байдлын шалгуур, битүүмжлэлийн найдвартай байдал зэрэг шаардлагыг хангахаар заасан.

Шошгололт:

- ✚ Жижиглэсэн махны савлагааны гадна талд мал эмнэлэг ариун цэврийн тамга дарагдсан байна.
- ✚ Бүтээгдэхүүний шошго нь уут сав, баглаа, боодлыг задлах үед бүтэн байдлаа хэвээр хадгалах боломжтой байдлаар наагдсан байна.
- ✚ Гулууз (өрөөл, мөчилсөн) маханд нядалгааны газар, мах боловсруулах үйлдвэр (аж ахуйн нэгж)-ийн нэр, бүртгэлийн дугаар бүхий тамга дарагдсан байна.
- ✚ Сав баглаа, боодол нь нэг удаагийнх байх бөгөөд ЕАЭЗХ-ны стандартад нийцсэн байна.

Шошго, худалдааны тэмдэг, кодчиллол:

Гаалийн холбооны техникийн зохицуулалт ТРТС022/2011-д зааснаар, “Хүнсний бүтээгдэхүүний шошгололт”:

- ✚ Бүтээгдэхүүний нэр
- ✚ Бүтээгдэхүүний орц, найрлага
- ✚ Бүтээгдэхүүний тоо хэмжээ (жин)
- ✚ Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо
- ✚ Бүтээгдэхүүнийг хадгалах хугацаа
- ✚ Үйлдвэрлэгчээс тодорхойлсон хадгалах нөхцөл
- ✚ Үйлдвэрлэгчийн нэр, албан ёсны хаяг
- ✚ 100 грамм дахь тэжээллэгийн тухай мэдээлэл
- ✚ Хэрэглэх заавар
- ✚ Хувиргасан амьд организм (ГМО) агуулж байгаа эсэх тухай мэдээлэл
- ✚ Гаалийн холбооны нутаг дэвсгэрт зах зээлийн эргэлтэд оруулж болох тухай нэгдсэн ЕАС тэмдэг
- ✚ Сав баглаа боодлын бүтцийн тухай тэмдэглэл
- ✚ Үйлдвэрлэсэн орон, үйлдвэрлэгч, бүтээгдэхүүний тухай мэдээллийг агуулсан зураасан код буюу бар код.
- ✚ Шошгын мэдээлэл нь орос хэлээр бичигдсэн байх.

Япон улсад мах, махан бүтээгдэхүүнийг экспортлоход Япон улсын талаас сав баглаа, боодлын дараах стандарт шаардлагыг тавьдаг. Үүнд:

- ✚ Байгалийн эсвэл байгалийн гаралтай биш савлагаагаар савласан.
- ✚ Байгалийн гаралтай савлагаа нь импортлогч оронд төрж бойжсон малын гаралтай бүтээгдэхүүн байна.
- ✚ Шошго үйлдвэрлэгчээр хэвлэгдээгүй бол цэвэр жин (килограмм) шошго дээр тамгалсан эсвэл гараар бичсэн.
- ✚ Импортын бүтээгдэхүүнд Японы дотоодод тавигдах шошгололтын шаардлага ижил тавигддаг.

Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүний экспортын гаалийн мэдүүлэгт шаарддаг бичиг баримтууд:

- ✚ Экспортын гаалийн мэдүүлэг
- ✚ Үнийн нэхэмжлэл
- ✚ Баглаа боодлын тодорхойлолт
- ✚ Тээврийн бичиг баримт /ачааны манифест, тээвэр төлсөн баримт г.м./
- ✚ Чанарын гэрчилгээ /тохирлын гэрчилгээ г.м./
- ✚ Барааны гарал үүслийн гэрчилгээ
- ✚ Стратегийн хүнс экспортлох, зөвшөөрөл, бодлогын гэрээний мэдэгдэл
- ✚ Экспортын гэрчилгээ /мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ/
- ✚ Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ
- ✚ Гадаад худалдааны гэрээ
- ✚ Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ

Мах, махан бүтээгдэхүүн, өлөн гэдэс экспортлоход гаалийн байгууллагаас гадна хилийн мэргэжлийн хяналтын байцаагч бараа бүтээгдэхүүний бичиг баримт хийгээд биет байдлыг шалгадаг. Гаалийн бүрдүүлэлтийн хувьд бичиг баримт бүрдүүлэлт бүрэн гүйцэд, зохих журмаар бүрдүүлсэн байхад процесс харьцангуй хялбар явагддаг байна.

Стратегийн хүнсний бүтээгдэхүүн буюу мах, дулааны аргаар боловсруулсан мах экспортлогч нь ХХААХҮЯ-тай бодлогын гэрээ байгуулсны дараа Гаалийн ерөнхий газарт очиж, гаалийн цахим системд экспортын тоо хэмжээг бүртгүүлдэг байна. Тус процесс нь тухайн бодлогын гэрээний хүрээнд нэг удаа явагдах боловч квотын хэмжээнд дахин бодлогын гэрээ байгуулах бүрд давтагдана. Улмаар гүний гаальд экспортын гаалийн бүрдүүлэлт хийлгэхэд гаалийн системээс шалган, бүртгэгдсэн тоо хэмжээнээс хасалт хийх замаар явагддаг.

Стратегийн хүнсний бүтээгдэхүүний экспортын гаалийн бүрдүүлэлтийн явцад, бичиг баримтыг баталгаажуулсны дараа томилогдсон гаалийн хяналтын байцаагч барааг тээврийн хэрэгсэлд ачих үйл явцад хяналт тавин, холбогдох бичиг баримтад гарын үсэг зурж өөрийн тамгыг дарж, тээврийн хэрэгслийг лацдан, ачаа тээврийн падан дээр дугаарыг нь бичдэг.

Бараа ачилтын үед НМХГ-ын Хилийн хяналтын газрын байцаагч “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох үеийн хяналтын хуудас”-ны дагуу бичиг баримтын болон биет шалгалт хийж экспортыг баталгаажуулан хилийн боомт дахь хяналтын албанд “Экспортын мэдэгдэл” бичиж, тээврийн хэрэгслийг лацдан ачаа тээврийн падан дээр дугаарыг нь бичнэ. Мөн “Мал эмнэлгийн гэрчилгээ”-н дээр өөрийн тамгыг дарж гарын үсэг зурна.

Экспортын бүтээгдэхүүн, ялангуяа мах, махан бүтээгдэхүүн, Монгол гэр экспортлоход ямар нэг татвар ногдуулдаггүй буюу татварыг тэглэсэн байдаг бөгөөд зөвхөн гаалийн хураамж төлдөг байна.

Мах, махан бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлт болон хил гааль дээр зарцуулагдах хугацаа болон зардлыг дундажлан доорх хүснэгт болон зурагт харууллаа.

Хүснэгт 31. Хагас боловсруулсан махны экспортын хил, гааль дээрх үйл явц

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг			Зардал ₮
			1	2	3	
			24	48	60	
1	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Гаалийн зуучлагч	+			60,000
2	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гааль	+			28,200

3	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо	Гааль, ХМХГ	+	+		1000
4	Дотоод тээвэрлэлт	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч		+		
5	Хил дээрх гаалийн хяналт шалгалт	Гааль			+	
Нийт					60 цаг	89'200₮

Тээрийн төрөл: Авто тээвэр /БНХАУ руу/

Хүснэгт 32. Боловсруулсан өлөн гэдэс (агаарын тээвэр) экспортын хил, гааль дээрх үйл явц

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг		Зардал ₮
			1	2	
			12	36	
1	Ачаа тээшний зохицуулалт	Тээвэр зууч	+		
2	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Гаалийн зуучлагч		+	60,000
3	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гааль		+	8200
4	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо	Гааль, ХМХГ		+	1000
Нийт				36 цаг	69'200₮

Тээрийн төрөл: Агаарын тээвэр /Япон улс руу/

Хүснэгт 33. Боловсруулсан махан бүтээгдэхүүний экспортын хил, гааль дээрх үйл явц

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг			Зардал ₮
			1	2	3	
			24	48	60	
1	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Гаалийн зуучлагч	+			60,000
2	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гааль	+			8200
3	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо	Гааль, ХМХГ	+	+		1000
4	Дотоод тээвэрлэлт	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч		+		
5	Хил дээрх гаалийн хяналт шалгалт	Гааль			+	
Нийт					60 цаг	69'200₮

Тээрийн төрөл: Авто тээвэр /ОХУ/

Экспортод зарцуулагдах хугацаа болон зардлыг авч үзсэн бөгөөд стратегийн хүнсний ангилалд багтах мах, махан бүтээгдэхүүн мөн стратегийн хүнсний ангилалд багтахгүй боловсруулсан махан бүтээгдэхүүн (лаазалсан мах)-ийг авто тээврээр БНХАУ, ОХУ зэрэг хоёр хөрш улс руу экспорт, харин боловсруулсан өлөн гэдсийг судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн мэдээллээр агаарын тээврээр Япон улс руу экспорт хийхэд тооцож гаргасан.

2.2.3. Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц

Мах, махан бүтээгдэхүүний гол импортлогч орнууд болох БНХАУ, ОХУ, Япон улсуудын тээвэрлэлтийн нөхцөлд тавигддаг стандарт шаардлагуудыг судаллаа.

БНХАУ нь дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн горимыг чанд мөрдөн хийх шаардлагатай бөгөөд зөвхөн гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчээр дамжуулан хийнэ.

Тавигдах шаардлага:

- ✚ Хөргүүртэй чингэлэг бүхий тээвэрлэгч байна.
- ✚ Тээвэрлэлтийн температур, бүтээгдэхүүний гүний температур нь – 18 хэмээс ихгүй байна.
- ✚ Тээвэрлэлт нь өвчний хязгаарлалтад орсон эсвэл тандалтад хамрагдсан нутгаар дайран өнгөрч болохгүй.

ОХУ нь дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн горимыг чанд мөрдөн хийх шаардлагатай бөгөөд зөвхөн гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчээр дамжуулан хийнэ.

Тавигдах шаардлага:

- ✚ Хөргүүртэй чингэлэг бүхий тээвэрлэгч байна.
- ✚ Тээвэрлэлтийн температур, бүтээгдэхүүний гүний температур нь – 18 хэмээс ихгүй байна.
- ✚ Тээвэрлэлт нь өвчний хязгаарлалтад орсон эсвэл тандалтад хамрагдсан нутгаар дайран өнгөрч болохгүй.

Япон улсын тээвэрлэлтэд тавигдах шаардлага:

- ✚ Махан бүтээгдэхүүнийг цаасан хайрцагт хийж, наалттай шошгоор баталгаажуулан огноог гараар бичсэн байна. Тээвэрлэлтийн явцад цаасан хайрцаг онгойсон эсвэл задарсан нөхцөлд шууд устгалд оруулна.
- ✚ Шилжүүлэн тээвэрлэхийг зөвшөөрдөг.

БНХАУ “махны хадгалалтын горимд махаа хөргөсний дараа -28°C температурт гүн хөлдөөх, үүнд -18°C-т-аас дээш температурт 36 цагаас дээш байлгаж болохгүй” гэсэн шаардлагыг тавьдаг.

ОХУ гулууз махны хадгалалтын шаардлагад “хөлдөөлтийн хэм гүний хэсэгт -8°C, хөргөлтийн хэм +4°C-аас ихгүй” гэж заажээ.

Япон улс махны хадгалалтын шаардлагад “хөлдөөж экспортлох махыг 400C-д хөргөсний дараа хөлдөөсөн байх, утсан болон хатаасан махан бүтээгдэхүүнийг ерөөний температурт хадгалсан байх ба рН-ийн түвшин 4.6 байх, утсан болон хатаасан махыг ерөөний температурт хадгалсан байх” гэж заасан.

Гадаад улс орнууд руу экспорт хийх тээврийн зардлын тээврийн төрлөөс хамаарч ялгаатай байдлаар хүснэгтээр харуулав.

Хүснэгт 34. Экспортын тээврийн зардал (улс орноор, тээврийн хэрэгслээр)

	Гадаад улс орнууд	Зарцуулах хугацаа		Зардал, ₮
8	Япон: - Агаарын тээвэр	2-5	48-120	19,900 төг/кг
9	БНХАУ: - Авто тээвэр - Төмөр замын тээвэр	10-12	240-224	5,700,000
		10-15	240-360	8,550,000
10	Вьетнам: - Далайн тээвэр	30-40	720-960	14,250,000

Мах, махан бүтээгдэхүүнийг ОХУ руу Алтанбулагийн боомтоор экспортолдог бол БНХАУ руу Замын-Үүд боомтоор экспортолж байна. Боловсруулсан өлөн гэдсийг агаарын тээвэр ашиглан тээвэрлэдэг бөгөөд зарцуулах хугацаа бага, найдвартай хэдий ч зардал өндөртэй байдаг. Мөн зарим аж ахуйн нэгжүүд ОХУ болон Европын орнууд руу автомашинаар тээвэрлэдэг.

Адууны түүхий мах, дулааны аргаар боловсруулсан үхэр, хонины махыг ОХУ болон БНХАУ руу экспортолдог бөгөөд тээвэрлэлтийг ихэвчлэн автомашинаар хийж байна. Тээвэрлэлтийг хөргүүртэй, чингэлэгтэй, гаалийн итгэмжлэгдсэн тээврийн хэрэгслээр хийдэг /Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/128 дугаар тушаалаар Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох болсон/. Авто тээврийн хэмжээ 25 тонн багтаамжтай бөгөөд зардлын хувьд харилцан адилгүй Нэг автомашины үнэ 4-5 сая боловч тохирсон хугацаа хэтэрсэн болон тээвэрлэгчээс хамаарахгүй шалтгаанаар саатсан өдөр тутамд тооцох тарифтай /нэг өдрийн 100,000-400,000₮/.

Төлбөр хүлээн авах үйл явц

Мах, махан бүтээгдэхүүн экспортлогч компаниудын төлбөрийн нөхцөл нь нээлттэй данс, инкасс, аккредитив, урьдчилсан төлбөр хэлбэртэй байна.

Хүснэгт 35. Төлбөрийн нөхцөлүүд

Төлбөрийн нөхцөл	Төлбөрийн эрсдэл		Банкны нэмэлт баталгаа
	Экспортлогч	Импортлогч	
Нээлттэй данс (Open account)	++++	+	Шаардана
Инкасс (Collection)	+++	++	Шаардана
Аккредитив (Letter of Credit - LC)	++	+++	Шаардана
Урьдчилсан төлбөр (Advance payment)	+	++++	Шаардана

Эх үүсвэр: БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох, “Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” НҮТББ

- ✓ Нээлттэй данс: захиалагчид ачаа бараа ирсний дараа төлбөр төлөх.
- ✓ Инкасс: банк экспортлогч-ийн өмнөөс импортлогчид баримт хүргүүлж, төлбөр нэхэмжлэн авах замаар төлбөр гүйцэтгэх.
- ✓ Аккредитив: импортлогчийн банкнаас экспортлогч талд хандан гаргаж буй хууль ёсны төлбөрийн баталгаа.
- ✓ Урьдчилсан төлбөрт: импортлогч ачааг тээвэрлэхээс өмнө урьдчилан төлөх.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн нөхцөлийг харахад, ихэвчлэн бараагаа тээвэрлэн бүрэн хүлээлгэж өгсний дараа төлбөрөө авдаг бөгөөд цөөн тохиолдолд тодорхой хэмжээний урьдчилгаа авдаг байна.

Дансны шилжүүлгээр харилцах дансанд төлбөр хүлээн авахад ямар нэг шимтгэл, төлбөр төлдөггүй бөгөөд шилжүүлэгч банк, дундын банкны аливаа шимтгэл төлбөрийг импортлогч тал хариуцдаг байна. Харин хугацааны хувьд барааг импортлогч орны хил дээр хүлээлгэн өгснөөс хойш дунджаар 7-14 хоног хүлээдэг.

Хүснэгт 36. Худалдаа хөгжлийн банкны шилжүүлэг хүлээн авах шимтгэл

Харилцах болон картын дансанд оруулахад:	Шимтгэлгүй
Бэлнээр олгох эсвэл хадгаламжийн дансанд оруулахад:	
Төгрөг	Шимтгэлгүй
Ам. доллар	0.2%
Хятадын юань	0.1%
Евро, Английн фунт стерлинг, Солонгосын вон, Японы иен	0.3%
Оросын рубль	1.5%
Туркийн лира	4,0%
Бусад валют	0.6%
Гадаадын банкнаас ирсэн шилжүүлгийг буцаахад:	
Ам. доллар	15\$
Бусад валют	15\$-той тэнцэх тухайн валют

Эх үүсвэр: Худалдаа хөгжлийн банк

Худалдаа хөгжлийн банкны шилжүүлэг хүлээн авах шимтгэл нь улс орон бүрээр ялгаатай бөгөөд хамгийн өндөр нь Туркийн лира 4.0 хувь байна. Харин ам.долларын шилжүүлэгт 15 ам.долларыг шимтгэлд тооцдог.

2.2.4.Экспортын замын зураглал

Мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрөл бүрдүүлэлтэд шаардагдах бичиг баримтын жагсаалт болон үйл явцын шат дарааллыг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 37. Түүхий мах, дулааны аргаар боловсруулсан махны экспортын үйл явцын шат дараалал

	Алхмууд	Олгох байгууллага	Тайлбар
Урьдчилсан шаардлага	Стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох квот	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	Экспортлогч аж ахуйн нэгжид бүтээгдэхүүн экспортлох квот олгоно. Хүн амын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, Мал эмнэлгийн гэрчилгээ олгох тухай албан бичиг олгоно.
	Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ	Харьяалсан бүс, нутгийн анхан шатны мал	Түүхий мах, дулааны аргаар боловсруулсан мах экспортлох бол тухайн махыг бэлтгэн нийлүүлэгч тухайн малыг бэлтгэсэн бүс нутгийн анхан шатны мал эмнэлгийн нэгжээс

		эмнэлгийн нэгж	авсан байна.
	Бодлогын гэрээ	ХХААХҮЯ	Экспортлогч нь ХХААХҮЯ-аас шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тус яамтай бодлогын гэрээ байгуулна.
Бичиг баримт бүрдүүлэлт	Шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	Экспортлогч нь НМХГ-т шинжилгээ хийлгүүлэх хүсэлт гаргана. НМХГ-аас хяналтын байцаагч томилох бөгөөд тус байцаагч бүтээгдэхүүнээс дээж авч тэмдэглэл үйлдэн, ямар үзүүлэлтээр шинжилгээ хийлгүүлэх тухай мэдэгдэл бичиж өгнө.
	Бүтээгдэхүүний дээжид мал эмнэлэг ариун цэврийн шалгуур үзүүлэлтүүдээр шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори/ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	МХЕГ-ын байцаагчийн гаргасан мэдэгдлийн дагуу дээжид шинжилгээ хийн, шинжилгээний дүнг экспортлогчид өгнө.
	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ	Мал эмнэлгийн ерөнхий газар	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг МЭЕГ-аас авах бөгөөд тус гэрчилгээ нь МХЕГ-аас авах экспортын гэрчилгээнд шаардагддаг.
	Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ авах	Стандарт хэмжил зүйн газар	Бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ авах хүсэлтийг СХЗГ-т өгөх бөгөөд энэхүү гэрчилгээ нь экспортын бүтээгдэхүүн холбогдох стандартыг хангасан болохыг баталгаажуулна.
	Бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ авах	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Гарал үүслийн гэрчилгээ нь аль улс оронд экспорт хийгдэхээс шалтгаалан өөр формоор гарна.
	Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ	МХЕГ	Экспортын бүтээгдэхүүнд "Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ буюу экспортын гэрчилгээ олгоно.
Гаалийн бүрдүүлэлт	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч байгууллага	Тээвэрлэгч байгууллагатай тохирон тээврийн бичиг баримтыг бүрдүүлнэ.
	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Тээвэрлэгч байгууллага, Гаалийн зуучлагч	Гаалийн цахим сүлжээнд барааны мэдүүлгийг шивж оруулан илгээнэ.
	Гаалийн хяналт шалгалт бараа, тээврийн хэрэгсэл	Улаанбаатар хот дахь гаалийн газар	Томилогдсон хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийг шалгах
	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Улаанбаатар хот дахь гаалийн газар	- Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, хураамжийг барагдуулах, - Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо	Гааль, Хилийн мэргэжлийн хяналт	Гааль болон Хилийн мэргэжлийн хяналт бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, хилийн мэргэжлийн хяналтын байцаагч экспортын мэдэгдэл өгөх
	Тээвэрлэлт	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч	Тээвэр ихэвчлэн газраар буюу автомашин
	Төлбөр хүлээн авах	Худалдан авагч	Барааг бүрэн хүлээн авсны дараа

Дээрх хүснэгтэд экспортын гэрчилгээ, зөвшөөрөл хөөцөлдөхөөс эхлэн гаалийн хяналт шалгалтын шат дараалал, тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явцыг хураангуйлан оруулсан. Стратегийн хүнсний бүтээгдэхүүн мах экспортлох квот авах аж ахуйн нэгжийг шалгаруулах үйл ажиллагаа нь жил бүр тогтсон хугацаанд явагддаг бөгөөд экспорт хийх үйл явцтай шууд хамааралгүй тул шаардлагатай үйл явцад тооцоогүй. Гэсэн хэдий ч хүснэгт дэх экспортлох үйл явц нь зөвхөн квоттой аж ахуйн нэгжид хамааралтай буюу квот авахгүйгээр стратегийн хүнсний ангилалд багтдаг мах, махан бүтээгдэхүүн экспортлох боломжгүй юм.

Боловсруулсан өлөн гэдэс

Боловсруулсан өлөн гэдэсний хувьд стратегийн хүнсний бүтээгдэхүүний ангилалд багтдаггүй бөгөөд экспортын квот, бодлогын гэрээ гэх мэт ХХААХҮЯ-аас авдаг зөвшөөрөл, бичиг баримтууд шаардлагагүй байна. Судалгаанд хамрагдсан экспортлогч ихэвчлэн агаарын тээврээр Япон улс руу экспортолдог.

Хүснэгт 38. Боловсруулсан өлөн гэдэсний экспортын үйл явцын шат дараалал

	Алхмууд	Олгох байгууллага	Тайлбар
Бичиг баримт бүрдүүлэлт	Шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	Экспортлогч нь НМХГ-т шинжилгээ хийлгүүлэх хүсэлт гаргана. НМХГ-аас хяналтын байцаагч томилох бөгөөд тус байцаагч бүтээгдэхүүнээс дээж авч тэмдэглэл үйлдэн, ямар үзүүлэлтээр шинжилгээ хийлгүүлэх тухай мэдэгдэл бичиж өгнө.
	Бүтээгдэхүүний дээжид мал эмнэлэг ариун цэврийн шалгуур үзүүлэлтүүдээр шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори/ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	МХЕГ-ын байцаагчийн гаргасан мэдэгдлийн дагуу дээжид шинжилгээ хийн, шинжилгээний дүнг экспортлогчид өгнө.
	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ	Мал эмнэлгийн ерөнхий газар	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг МЭЭГ-аас авах бөгөөд тус гэрчилгээ нь МХЕГ-аас авах экспортын гэрчилгээнд шаардагддаг.
	Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ авах	Стандарт хэмжил зүйн газар	Бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ авах хүсэлтийг СХЗГ-т өгөх бөгөөд энэхүү гэрчилгээ нь экспортын бүтээгдэхүүн холбогдох стандартыг хангасан болохыг баталгаажуулна.
	Бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ авах	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Гарал үүслийн гэрчилгээ нь аль улс оронд экспорт хийгдэхээс шалтгаалан өөр формоор гарна.
	Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ	МХЕГ	Экспортын бүтээгдэхүүнд "Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ буюу экспортын гэрчилгээ олгоно.
Гаалийн бүрдүүлэлт	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч байгууллага	Тээвэрлэгч байгууллагатай тохирон тээврийн бичиг баримтыг бүрдүүлнэ.
	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Тээвэрлэгч байгууллага, Гаалийн зуучлагч	Гаалийн цахим сүлжээнд барааны мэдүүлгийг шивж оруулан илгээнэ.
	Гаалийн хяналт шалгалт бараа, тээврийн хэрэгсэл	Улаанбаатар хот дахь гаалийн газар	Томилогдсон хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийг шалгах
	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Улаанбаатар хот дахь гаалийн газар	- Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, хураамжийг барагдуулах, - Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо	Гааль, Хилийн мэргэжлийн хяналт	- Гааль болон Хилийн мэргэжлийн хяналт бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, хилийн мэргэжлийн хяналтын байцаагч экспортын мэдэгдэл өгөх
Тээвэрлэлт	Тээвэрлэгч байгууллага	Тээвэр автомашин, агаарын тээвэр	
Төлбөр хүлээн авах	Худалдан авагч	Барааг бүрэн хүлээн авсны дараа	

Хүснэгтээс харахад, боловсруулсан өлөн гэдэс нь экспортын квот, бодлогын гэрээ гэж шаарддаггүй боловч бусдаар бол мах, түүхий эд экспортлох үйл явцтай ижил байна.

Боловсруулсан махан бүтээгдэхүүн

Боловсруулсан махан бүтээгдэхүүн буюу лаазалсан махан бүтээгдэхүүн нь боловсруулсан өлөн гэдэстэй төстэй үйл явц, шат дарааллаар явагддаг боловч олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авдаггүй ялгаатай.

Хүснэгт 39. Боловсруулсан махан бүтээгдэхүүний экспортын үйл явцын шат дараалал

	Алхмууд	Олгох байгууллага	Тайлбар
Бичиг баримт бүрдүүлэлт	Шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	Экспортлогч нь НМХГ-т шинжилгээ хийлгүүлэх хүсэлт гаргана. НМХГ-аас хяналтын байцаагч томилох бөгөөд тус байцаагч ямар үзүүлэлтээр шинжилгээ хийлгүүлэх тухай мэдэгдэл бичиж өгнө.
	Шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори/ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	МХЕГ-ын байцаагчийн гаргасан мэдэгдлийн дагуу дээжид шинжилгээ хийн, шинжилгээний дүнг экспортлогчид өгнө. Шинжилгээний төрлөөс хамаарна, төрөл бүр өөр өөр тарифтай,

	Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ авах	Стандарт хэмжил зүйн газар	Бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ авах хүсэлтийг СХЗГ-т өгөх бөгөөд энэхүү гэрчилгээ нь экспортын бүтээгдэхүүн холбогдох стандартыг хангасан болохыг баталгаажуулна.
	Бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ авах	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Гарал үүслийн гэрчилгээ нь аль улс оронд экспорт хийгдэхээс шалтгаалан өөр формоор гарна.
	Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ	МХЕГ	Экспортын бүтээгдэхүүнд "Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ" буюу экспортын гэрчилгээ олгоно.
Гаалийн бүрдүүлэлт	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч байгууллага	Тээвэрлэгч байгууллагатай тохирон тээврийн бичиг баримтыг бүрдүүлнэ.
	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Тээвэрлэгч байгууллага, Гаалийн зуучлагч	Гаалийн цахим сүлжээнд барааны мэдүүлгийг шивж оруулан илгээнэ.
	Гаалийн хяналт шалгалт бараа, тээврийн хэрэгсэл	Улаанбаатар хот дахь гаалийн газар	Томилогдсон хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийг шалгах
	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Улаанбаатар хот дахь гаалийн газар	- Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, хураамжийг барагдуулах, - Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо	Гааль, Хилийн мэргэжлийн хяналт	- Гааль болон Хилийн мэргэжлийн хяналт бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, хилийн мэргэжлийн хяналтын байцаагч экспортын мэдэгдэл өгөх
	Тээвэрлэлт	Тээвэрлэгч байгууллага	Тээвэр автомашин, агаарын тээвэр
	Төлбөр хүлээн авах	Худалдан авагч	Барааг бүрэн хүлээн авсны дараа

Экспортын бүтээгдэхүүний дээжийг экспортлогчид ихэвчлэн Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид шинжлүүлдэг байна.

Зураг 21. Мах, махан бүтээгдэхүүний экспортын замын зураглал



Мах, махан бүтээгдэхүүн нь стратегийн хүнсний бүтээгдэхүүний ангилалд багтах эсэхээс хамаарч бичиг баримт, гэрчилгээ зөвшөөрлийн төрөл, тавигдах шаардлага өөр өөр байдаг байна. Мөн түүнчлэн, аль улс руу экспортлох гэдгээс хамаарч бичиг баримтын бүрдүүлэлт өөр байх тохиолдол бий. Жишээ нь гарал үүслийн гэрчилгээ гэхэд аль улс руу экспортолж байгаагаас хамааран 4 өөр төрлийн загвартай байна. Гүний гаальд бүрдүүлэлт хийн авто

тээврээр экспортолж байгаа тохиолдолд гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчээр тээвэрлүүлэх шаардлагатай байдаг.

Хүснэгт 40. Мах, махан бүтээгдэхүүний экспортод импортлогч улсуудаас тавигдаж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал

Экспортын үйл явц	БНХАУ		Япон		ОХУ	
	Хугацаа \цагаар, өдрөөр\	Зардал, ₮	Хугацаа \цагаар, өдрөөр\	Зардал, ₮	Хугацаа \цагаар, өдрөөр\	Зардал, ₮
Баримт бичгийн бүрдүүлэлт						
БНХАУ руу экспортлох эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа гэдгийг баталгаажуулсан гэрчилгээ	Урьдчилж тавигдах шаардлага бөгөөд нэг удаа явагдана					
Үйлдвэрийн хянан магадалгаа	Урьдчилж тавигдах шаардлага бөгөөд нэг удаа явагдана				Урьдчилж тавигдах шаардлага бөгөөд нэг удаа явагдана	
Мах, махан бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ	5 өдөр / 120 цаг	104,000	5 өдөр / 120 цаг	104,000	5 өдөр / 120 цаг	104,000
Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)	5 өдөр / 120 цаг	10,000	5 өдөр / 120 цаг	10,000	5 өдөр / 120 цаг	10,000
Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)	2 цаг	40,000	2 цаг	40,000	2 цаг	40,000
Хил, гааль дээрх үйл явц						
Экспортлогч БНХАУ-ын гаалийн байгууллага (GACC)-д бүртгүүлсэн байх						
Үйлдвэрлэгч БНХАУ-ын гэрчилгээжүүлэлтийн газар (CNCA)-д бүртгүүлсэн байх						
Импортлогч БНХАУ-ын гаалийн байгууллага (GACC)-д бүртгүүлсэн байх						
Импортлогч хүнсний үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх						
БНХАУ-ын ЧХШТЕГ-т бүртгүүлсэн гаалийн мэдүүлэг	48-168 цаг /2-7 өдөр/		48-120 цаг /2-5 өдөр/		72-168 цаг /3-7 өдөр/	
Төлбөр хүлээн авах үйл явц						
Гадаад улсын гаалийн хашаан дотор очих хүртэлх тээвэр, төлбөрийн шилжүүлгийн банкны шимтгэл	72-168 цаг /3-7 өдөр/, төлбөр хүлээн авахад шимтгэл төлдөггүй		72-168 цаг /3-7 өдөр/, төлбөр хүлээн авахад шимтгэл төлдөггүй		72-168 цаг /3-7 өдөр/, төлбөр хүлээн авахад шимтгэл төлдөггүй	
Экспортын барааг ачуулсны дараах үйл явц	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч хариуцдаг				Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч хариуцдаг	
Нэхэмжлэх явуулсны дараах төлбөр хүлээн авах хугацаа	25-30 өдөр		20-30 өдөр		25-30 өдөр	
Нийт	25-35 өдөр / 600-840 цаг	154,000	20-35 өдөр / 480-840 цаг	154,000	25-35 өдөр / 600-840 цаг	

Хүснэгт 41. Мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл явц дахь зардлын тооцоо

	БНХАУ	Япон
Монгол дахь экспортын үйл явцад нийт зарцуулах зардал, ₮	334'700₮	314'700₮
Тээвэр, ₮	5'700'000₮	497'500'000₮
Гадаад орны импортын шаардлага хангахтай холбоотой нэмэгдсэн зардал, ₮		
Нийт зардал, ₮	6'034'700₮	497'814'700₮
Нэг тонн бүтээгдэхүүнд ногдох зардал	241'388₮	19'912'588₮

*Өлөн гэдэс экспортыг 200 кг агаарын тээврээр тооцов.

Монгол улс дахь мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл явцад 314.7-334.7 мянган төгрөг зарцуулж байгаа бол гадаад орны импортын шаардлага хангахтай холбоотой нэмэгдэх зардал экспортын явцад гарахгүй байна. Дулааны аргаар боловсруулсан махыг БНХАУ-д экспортлоход экспортын үйл явцтай холбоотойгоор 1 кг мах тутамд 241.4 төгрөг, 1 кг өлөн гэдэс тутамд 19.9 мянган төгрөгийн зардал гарна. Эдгээр зардлын бараг 100 хувийг тээврийн зардал эзэлж байна.

ДҮГНЭЛТ

Мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл явц нь стратегийн хүнсний ангилалд багтах эсэхээс хамаарч өөр өөр байна. Стратегийн хүнсний ангилалд багтах мах нь улаан мах буюу адууны түүхий мах, үхэр, хонь, ямааны дулааны аргаар боловсруулсан мах болно. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд ихэвчлэн дулааны аргаар боловсруулсан үхэр, хонины махыг БНХАУ-д экспортолж байна. Ийнхүү экспортлохын тулд БНХАУ-ын ЧХШХЦЕГ-ийн хянан магадлагаа хийлгэхээс эхэлдэг бөгөөд шалгуур шаардлага нь үйлдвэрийн орчин, түүхий эд бэлтгэл, гарал үүслийн бүс, хадгалалт, тээвэрлэлт, дотоод хяналт зэрэг маш өргөн хүрээг хамардаг. Тус үйл явц “Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хооронд үхрийн махыг Монгол Улс, БНХАУ-д экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, нөхцөлийн тухай” протокол, “Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хооронд: хонь, ямааны махыг Монгол Улс, БНХАУ-д экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, нөхцөлийн тухай” протоколуудын дагуу явагддаг.

Стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлоход ХХААХҮЯ-аас экспортын зөвшөөрөл квот авдаг бөгөөд жилд нэг удаа олгогддог. Экспортын үйл явцын хувьд худалдан авагчаа олох, үнэ болон нийлүүлэх нөхцөлөө тохирохоос эхэлдэг. Худалдан авагч олох, үнэ нөхцөлөө тохирох, гэрээ байгуулах зэрэг нь аж ахуйн бүрд харилцан адилгүй байсан бөгөөд өөрсдөөс нь болон худалдан авагчаас шууд хамааралтай үйл явц байсан нь учраас зарцуулах цаг хугацаа, зардлыг худалдах, худалдан авах гэрээг байгуулснаас хойш авч үзсэн.

Худалдах, худалдан авах гэрээ байгуулсны дараа бүтээгдэхүүнээ савлаж үнийн нэхэмжлэх (Proforma or Commercial Invoice) болон сав баглаа боодлын жагсаалт (Packing List)-аа илгээдэг байна. Үүний дараагаар ХХААХҮЯ-тай Бодлогын гэрээ байгуулах бөгөөд тус гэрээг байгуулахад экспортлох махны нийт хэмжээ болон гэрээний дагуу дотоодын зах зээлд 10 хувийг нийлүүлэх, мөн экспортод бэлтгэсэн махны гарал үүслийн гэрчилгээ буюу дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ зэргийг бүрдүүлж өгдөг.

Бодлогын гэрээ байгуулсны дараа ХХААХҮЯ-аас дагалдах бичиг 3 хувь гардаг бөгөөд СХЗГ, МХЕГ, ГЕГ-т тус тус хүргүүлдэг байна. ГЕГ тухайн дагалдах бичгийг хүлээн авч бодлогын гэрээгээр заасан тоо хэмжээг ГЕГ-ийн дотоод CEPS системд бүртгэдэг. Хожим гаалийн бүрдүүлэлт хийхэд тухайн системд бүртгэгдсэн тоо хэмжээг тулган хасалт хийж тооцдог байна. Дагалдах бичгийн 2 дахь хувийг НМХГ-т хүргүүлж, байцаагч томилуулдаг бөгөөд томилогдсон байцаагчийн ажлын ачааллаас шалтгаалж 1-2 өдөр зарцуулдаг. Томилогдсон байцаагчийг үйлдвэр дээр ирүүлж бүтээгдэхүүнээс дээж авхуулдаг бөгөөд авсан дээжийг УМЭАЦТЛ-д хүргэн өгч шинжилгээнд хамруулдаг. Шинжилгээ хийхдээ нян, мөөгөнцөр зэргийг өсгөвөрлөх

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН



Хагас боловсруулсан мах

- Худалдах, худалдан авах гэрээ
- Үнийн нэхэмжлэх
- Сав баглаа боодлын жагсаалт
- Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ /урьдчилан авсан/
- Бодлогын гэрээ
- ГЕГ-ын цахим сүлжээнд экспортын хэмжээг бүртгүүлэх
- Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт
- Дээжид шинжилгээ хийх
- Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ
- Тохирлын гэрчилгээ
- Гарал үүслийн гэрчилгээ
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ
- Тээврийн бичиг баримт, Ачааны манифест

312 цаг, 245'500₮



Махан бүтээгдэхүүн

- Худалдах, худалдан авах гэрээ
- Үнийн нэхэмжлэх
- Сав баглаа боодлын жагсаалт
- Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт
- Дээжид шинжилгээ хийх
- Тохирлын гэрчилгээ
- Гарал үүслийн гэрчилгээ
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ
- Тээврийн бичиг баримт, Ачааны манифест

192 цаг, 233'000₮



Өлөн гэдэс

- Худалдах, худалдан авах гэрээ
- Үнийн нэхэмжлэх
- Сав баглаа боодлын жагсаалт
- Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт
- Дээжид шинжилгээ хийх
- Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ
- Тохирлын гэрчилгээ
- Гарал үүслийн гэрчилгээ
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ
- Тээврийн бичиг баримт, Ачааны манифест

216 цаг, 245'500₮

ЭКСПОРТЫН БИЧИГ БАРИМТ БҮРДҮҮЛЭЛТ



ХИЛ ГААЛЬ ДЭЭРХ ҮЙЛ ЯВЦ



- Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг
- Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт
- Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо
- Дотоод тээвэрлэлт
- Хил дээрх гаалийн хяналт шалгалт

60 цаг, 89'200₮

- Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг
- Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт
- Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо
- Дотоод тээвэрлэлт
- Хил дээрх гаалийн хяналт шалгалт

60 цаг, 69'200₮

- Ачаа тээшний зохицуулалт
- Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг
- Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт
- Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо

36 цаг, 69'200₮

ТЭЭВЭР



- Авто тээвэр: 120 цаг, 228.0₮/кг

- Авто тээвэр: 120 цаг, 228.0₮/кг

- Агаарын тээвэр: 72 цаг, 19'900 ₮/кг

ТӨЛБӨР ХҮЛЭЭН АВАХ



- 120-240 цаг
- Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл: 7.71%
- Дундын банкны шимтгэл: 25-35\$

- 120-240 цаг
- Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл: 7.71%
- Дундын банкны шимтгэл: 25-35\$

- 120-240 цаг
- Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл: 7.71%
- Дундын банкны шимтгэл: 25-35\$

- Нэг тонн мах, махан бүтээгдэхүүнд ногдох экспортын үйл явцын зардал – 13'388₮ (БНХАУ руу)
- Нэг тонн өлөн гэдэсэнд ногдох экспортын үйл явцын зардал – 12'588₮ (Япон улс руу)
- Нэг тонн хагас боловсруулсан маханд ногдох экспортын үйл явцын ба тээврийн зардал – 241'388₮ (БНХАУ руу)
- Нэг тонн хагас боловсруулсан маханд ногдох экспортын үйл явцын ба тээврийн зардал – 241'388₮ (БНХАУ руу)

Импортлогчийн хашаа хүртэлх хил гааль дээрх үйл явц:

БНХАУ

Баримт бичгийн бүрдүүлэлт:
 - БНХАУ руу экспортлох эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа гэдгийг баталгаажуулсан гэрчилгээ
 - Үйлдвэрийн хянан магадалгаа
 - Мах, махан бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ
 - Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)
 - Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)
Хил дээрх үйл явц, хяналт шалгалт:
 - Экспортлогч БНХАУ-ын гаалийн байгууллага (GACC)-д бүртгүүлсэн байх
 - Үйлдвэрлэгч БНХАУ-ын гэрчилгээжүүлэлтийн газар (CNCA)-д бүртгүүлсэн байх
 - Импортлогч БНХАУ-ын гаалийн байгууллага (GACC)-д бүртгүүлсэн байх
 - Импортлогч хүнсний үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх
 - БНХАУ-ын ЧХШТЕГ-т бүртгүүлсэн гаалийн мэдүүлэг

Япон

Баримт бичгийн бүрдүүлэлт:
 - Мах, махан бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ
 - Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)
 - Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)
Хил дээрх үйл явц, хяналт шалгалт:
 - Гаалийн импортын мэдүүлэг болон хяналт шалгалт
 - Гаалийн татвар
 - Гаалийн бус байгууллагын хяналт, шалгалт

ОХУ

Баримт бичгийн бүрдүүлэлт:
 - Мах, махан бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ
 - Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)
 - Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)
Хил дээрх үйл явц, хяналт шалгалт:
 - Гаалийн импортын мэдүүлэг, хяналт шалгалт
 - Терминал дээрх холбогдох үйл явцууд
 - Ачааны бичиг баримт
 - Гаалийн татварын хувь
 - Дотоод тээврийн зардал



арга ашиглан үздэг учир ихэвчлэн 72 цагийг бүрэн шинжилгээнд, хариу авах болон бичиг цаасны ажилтай нийлэн 4-5 өдөр болдог байна.

Шинжилгээний хариуг хүлээн аваад МЭЕГ-т хүргүүлэн Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авах хүсэлтээ гаргадаг. Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ гарахад хуучин ажлын 4-5 өдөр зарцуулдаг байсан бол одоо 1-3 өдөр зарцуулдаг болсон байна. Гэвч Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авахад хариу өгөх хуулиар зөвшөөрөгдсөн хугацаа нь 30 хоногийн дотор гэж заасан. Үнийн хувьд 12,500₮ бөгөөд олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг МХЕГ-т хүргүүлж Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ авах хүсэлтээ гаргадаг бөгөөд Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ нь экспортын дагалдах бичиг баримт болдоггүй МХЕГ-т үлддэг тул ААН-үүд үүнд шүүмжлэлтэй хандаж байсан.

Мал эмнэлэг ариун цэврийн гэрчилгээг авахад дунджаар 4-5 өдөр зарцуулдаг боловч зөвшөөрөгдсөн хуулийн хугацаа нь 14 хоног бөгөөд гэрчилгээний үнэ 10,000₮ байна. Бодлогын гэрээний дагалдах бичгийн 3 дахь хувийг СХЗГ-т хүргүүлж Тохирлын гэрчилгээ авдаг бөгөөд тус үйл явцад дунджаар 2 цаг зарцуулдаг харин хураамжийн хувьд 79,000₮ байна.

Гарал үүслийн гэрчилгээг МҮХАҮТ-д цахимаар хүсэлтээ гаргаж биеэр очиж авдаг бөгөөд 40,000-45,000₮ хураамжтай байна. Ийнхүү холбогдох зөвшөөрлүүдийг авсны дараа гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчтэй холбогдож ачилтад бэлтгэх болон ачаа тээврийн бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүний дараа гаальд мэдүүлэн гаалийн хяналтын бүсэд ачилтыг хийж, шаардлагатай тохиолдолд гаалийн байцаагчийг ачилт хийх газарт хяналтаар ажиллуулдаг бөгөөд энэ тохиолдолд гаалийн байгууллагын цагийн үнэлгээгээр тооцон нэмэлт төлбөр төлдөг.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн хувьд гаалийн бүрдүүлэлт болон ачаа тээвэрлэлтийг гэрээт гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчид хариуцуулдаг байв. Дотоодын тээвэрлэлт буюу Улаанбаатараас Замын-Үүд хүртэл 25 тонн зориулалтын хөргүүртэй автомашинаар хагас өдөр буюу 10-14 цаг зарцуулдаг бөгөөд хил дээр гаалийн хяналт шалгалтад ачааллаас хамаарч дунджаар хагас өдөр буюу тухайн өдөртөө багтаан гаргадаг.

БНХАУ-ын хил дээр, гаалийн байгууллагын хяналт шалгалт нь нарийн явагддаг бөгөөд зарим тохиолдолд бичиг баримтын буруу бичилт, нэр үсэг алдах зэрэг жижиг зүйлсээс шалтгаалж ачааг саатуулах, буцаах тохиолдолд гардаг тухай судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд мэдээлсэн. Хоёр улсын хооронд байгуулсан гэрээ, хэлцэл, протоколуудын дагуу МХЕГ нь БНХАУ-ийн ЧХШХЦЕГ-д экспортлогчийн холбогдолтой мэдээллийг хүргүүлэх үүрэг хүлээдэг бөгөөд мэдээлэл нь буруу эсхүл дутуу байх зэрэг асуудлууд гарах тохиолдол бий. Импортлогч бичиг баримтаа бүрдүүлэлт хүлээн авах хүртэл барааг гаалийн хяналтын бүсэд байлгадаг бөгөөд тус хугацаанд тээвэрлэгчийн зардал, хөлс бодогдсоор байдаг.

Өлөн гэдэс экспортлох үйл явц стратегийн хүнсний ангилалд багтдаг махыг экспортлохтой харьцуулахад, харьцангуй бага хугацаа, зардал зарцуулдаг. Учир нь квот, бодлогын гэрээ, хүлээн авагч орны хянан магадалгаа зэрэг зүйлс шаардлагагүй байдаг. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн хувьд 2014 оноос эхлэн Япон улс руу хагас боловсруулан экспортолж эхэлсэн бөгөөд 2020 оны 07 дугаар сар хүртэл идэвхтэй байнга экспортолж байгаад цар тахал, хөл хорионоос шалтгаалан зогссон байна. Хамгийн сүүлд 2021 оны 04 дүгээр сард бага хэмжээгээр Япон улс руу экспортолсон. Өлөн гэдсийг экспортлох үйл явц ердийн үед худалдан авагч талын төлөөлөгч үйлдвэртэй танилцаж бараа бүтээгдэхүүнээс дээж авч Япон улсад шинжлүүлсний дараа эхэлж байсан бол 2020 оноос хойш цар тахлын нөлөөгөөр худалдан авагч тал ирж үйл явцад хяналт тавих боломжгүй болсон.

Өлөн гэдэсний экспортын бичиг баримт бүрдүүлэлт худалдах, худалдан авах гэрээг байгуулж үнийн нэхэмжлэхийг илгээнэ. Холбогдох зөвшөөрлүүд болон үйл явцын хувьд НМХГ-т байцаагч томилуулах, УМЭАЦТЛ-д дээж шинжлүүлэх, МЭЕГ-аас Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авах, СХЗГ-аас тохирлын гэрчилгээ авах, МҮХАҮТ-аас гарал үүслийн гэрчилгээ авах, МХЕГ-аас Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ буюу экспортын гэрчилгээ (үүнд дагалдах мэдээллийн бичиг мөн багтана)-г авах, ачаа тээвэрлэлт болон холбогдох бичиг баримтыг бэлтгэх үйл

явцууд дулааны аргаар боловсруулсан махны экспортын үйл явцтай ижил байх бөгөөд тээвэрлэлтийн хувьд судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж агаарын тээврээр ихэвчлэн экспорт хийдэг. Агаарын тээврийн 1 кг ачаа илгээх үнэ 4,100₮ байсан бол сүүлийн жилүүдэд өсөж 15-20 орчим мянган төгрөгт хүрсэн. Агаарын тээврээр хүргэгдэн очсон барааг худалдан авагч тал импортын гаалийн бүрдүүлэлт хийж хүлээж авдаг бөгөөд төлбөрийг ийнхүү хүлээн авсны дараа барагдуулдаг байна. Төлбөрийг ихэвчлэн банкны гадаад шилжүүлгээр хүлээж авдаг бөгөөд ямар нэг шимтгэл хураамж төлдөггүй, шилжүүлэгч болон дундын банкны төлбөрийг худалдан авагч хариуцдаг.

2.3.СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

2.3.4.Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц

Гадаад улс орнуудын импортын сүү, сүүн бүтээгдэхүүний импортод тавигдах стандарт шаардлага:

Япон улсад мониторинг шинжилгээ нь тухайн бүтээгдэхүүний сав баглаа боодол, бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн нөхцөл, хэлбэр дүрсээ алдсан эсэх, хадгалалтын горим зэргийг шалган дүгнэлт гаргана. Харин бүтээгдэхүүний зааварчилгаа, удирдамж болон анхан шатны туршилт явуулах бөгөөд шинжилгээгээр тухайн бүтээгдэхүүний хаяг дээр заасан үзүүлэлтүүд, орчны өөрчлөлт зэргийг шинжилнэ. Шинжилгээнд тэнцээгүй бүтээгдэхүүнд шууд хориг тавина. Тэнцсэн импортын бүтээгдэхүүнийг гарал үүслийн бичиг баримт бүрдүүлэн дараагийн шатны нарийвчилсан Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яаманд харьяалагддаг хорио цээрийн байгууллага руу явуулна. Хорио цээрийн газар бүтээгдэхүүний илчлэг чанар, бүтээгдэхүүнд агуулагдах органик болон эрдсийн нарийвчилсан шинжилгээ хийж, бүтээгдэхүүний шошго, бусад үзүүлэлттэй тулгана. Шинжилгээнд тэнцсэн бүтээгдэхүүнийг нэгж бүтээгдэхүүнд төлөх татварыг бүс нутгийн татварын хэлтэст төлж баталгаажуулж, баримтаа авснаар зарах эрх нээгдэнэ. Борлуулалтын сувгийг тухайн дистрибьютер компани сонгоно.

БНХАУ. Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан БНХАУ-д цэвэр сүүний хэрэглээ өссөн, дотоодын сүүний чанарт шүүмжлэлтэй ханддаг хэмээх судалгаа хийгдсэн байна. БНХАУ импортын сүү, сүүн бүтээгдэхүүнд дараах шаардлагуудыг тавьж байна.

- ✚ Малын гоц халдварт шүлхий өвчний улмаас хөл хорио тогтоосон бүс нутагт биш /хөл хорио тогтоож байсан бүс нутаг бол эрүүл бүс нутаг болсноос хойш багадаа 2 сар болсон байх/
- ✚ Сүүлийн 12 сарын хугацаанд фермд бог болон бод малын тахал, хонины цэцэг өвчин, ямааны цэцэг өвчин, Рифтийн хөндийн халууралт, үхрийн хатгаа өвчин тусаагүй байх
- ✚ Сүүлийн 12 сар фермд боом өвчин гараагүй байх.
- ✚ Вакцинд хамрагдсанаас хойш хамгийн багадаа 21 хоносон байх.
- ✚ Сүүний ферм дээр түүхий сүү цуглуулахад бруцеллэз, паратуберкулез (Жонын өвчин гэж нэрлэдэг), сүрьеэгийн эмнэл зүйн шинж тэмдэг илрээгүй байх.
- ✚ БНХАУ-д хориг тогтоогоогүй малын тэжээлээр тэжээсэн байх

Япон улсад сүүний экспорт хийхийн тулд тус улсын Засгийн газраас квот авна. Импортын сүүний асуудлыг зөвхөн Засгийн газарт харьяалагдах байгууллага, эсвэл итгэмжлэгдсэн байгууллага хийж гүйцэтгэнэ.

АНУ -д Хүнсний аюулгүй байдлын хяналтыг холбооны, муж, орон нутгийн түвшний олон тооны төрийн байгууллагууд гүйцэтгэдэг. Холбооны түвшинд 15 агентлаг 30 гаруй хүнсний аюулгүй байдлын хуулийн хэрэгжилтийг хангадаг. 2002 оны Биотерроризмын эсрэг холбооны хуулийн

дагуу бүх хүнс үйлдвэрлэгч, импортлогчид хоол хүнсээ АНУ-д оруулж ирэх үед FDA12 -д бүртгүүлж, мэдээлнэ.

Гадаад улс орнуудын шаардлагаас илүү нэмэлтээр Монголын талын шаардаж буй бичиг баримтууд байхгүй бөгөөд харин зарим улсуудын импортын шаардлага, зөвшөөрөл өгөх үйл ажиллагаа Монгол улсаас өөр байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 304 дүгээр тогтоолын хавсралтад “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт” MNTR 2:2011-д сүү, сүүн бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэлд тавигдах шаардлагуудыг бүрэн тусгасан байдаг.

“Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын хүрээнд сүү, сүүн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, боловсруулах, үйлдвэрийн барилга, сүүн бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрээр техникийн шаардлагыг иж бүрэн шинжтэй боловсруулсан байна.

Судалгааны объект болох “Глобал номадик продактс” компани нь Архангай аймагт үйлдвэрлэл эрхэлж, олон улсын эрүүл ахуй, чанарын стандартад нийцсэн үйлдвэрт сарлагийн сүүг боловсруулж цөцгийн тос, шар тос үйлдвэрлэж дэлхийн зах зээлд гаргадаг. АНУ-ын “Gold Nugget Ghee” компанитай хамтран ажиллаж сарлагийн шар тосыг амжилттай экспортолж байна. Сүү, сүүн бүтээгдэхүүний судалгааг дараах нэр төрлийн экспортын бараа бүтээгдэхүүнүүд дээр авч үзсэн. Үүнд:

- ✚ Шар тос
- ✚ Хатаасан бяслаг
- ✚ Шар сүүний уураг

Хүснэгт 42. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын бичиг баримтын жагсаалт

№	Бичиг баримтын жагсаалт	Бичиг баримтыг олгох газар	Улс орон	
			БНХАУ	ОХУ
1	Улсын бүртгэлийн гэрчилгээ	Экспортлогч байгууллага	+	+
2	Үнийн нэхэмжлэх	Экспортлогч байгууллага	+	+
3	Худалдах, худалдан авах гэрээ	Импортлогч болон экспортлогч байгууллага	+	+
4	Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч байгууллага	+	+
5	Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ	Бүс, нутгийн анхан шатны мал эмнэлгийн нэгж	+	+
6	Бүтээгдэхүүний дээжид итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори/ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	+	+
7	Тохирлын гэрчилгээ	Стандарт хэмжил зүйн газар	+	+
8	Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ	+	+
9	ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	Мал эмнэлгийн ерөнхий газар	+	+
10	Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээ, экспортын гэрчилгээ	МХЕГ	+	+
11	Тээврийн бичиг баримт	Тээвэрлэгч	+	+

Экспортлогч аж ахуйн нэгж УМЭАЦТЛ-ын шинжилгээний дүгнэлтийг МЭЕГ-т өгч ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ авах бөгөөд МХЕГ-т бусад шаардлагатай бичиг баримтын хамт өгч “Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ” буюу “Экспортын гэрчилгээ” авна.

Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газар (НМХГ)-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэст сүү экспортлоход хяналт тавих байцаагч томилуулах тухай болон экспортын бүтээгдэхүүний дээжид шинжилгээ хийлгүүлэх тухай хүсэлт гаргана.

Хүсэлтийг харгалзан газрын дарга зөвшөөрөл өгч байцаагч томилно. НМХГ-ын томилсон байцаагч бүтээгдэхүүнээс түүврийн аргаар дээж авч бүтээгдэхүүнд ямар үзүүлэлтүүдээр шинжилгээ хийлгүүлэх тухай мэдэгдэл бичиж өгөх бөгөөд дээжийн хамт итгэмжлэгдсэн

¹² The Food and Drug Administration


лаборатори буюу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид хүргэж өгнө. УМЭАЦТЛ-ын хүлээн авах дээр шинжээч дээжийг хүлээн авсан тухай тусгай журналд тэмдэглэл хийж дээжийн код болон тус лабораторид хийлгэсэн шинжилгээний төлбөрийн дүн, төлбөр хүлээн авах банк, дансны мэдээлэл, шинжилгээний хариу бэлэн болох хугацааг экспортлогч аж ахуйн нэгжийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

Бүх бичиг баримтын хамт Улаанбаатар хотод байрлах өөрийн бараа ачуулах терминал дээр очиж биет үзлэг хийлгэх бөгөөд үүнд бүх баримт бичиг бүрэн, зөрчилгүй тохиолдолд нэг ажлын өдөр болно. Барааг гаалийн байцаагчийн хамт лацдаж, баримт бичгийг экспортлогчид өгнө.

Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлт \Шар тос, хатаасан бяслаг\:

- ✚ Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ
- ✚ Бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлж дүгнэлт гаргуулах
- ✚ Тохирлын гэрчилгээ авах
- ✚ Гарал үүслийн гэрчилгээ авах
- ✚ Олон Улсын мал эмнэлгийн гэрчилгээ
- ✚ Мал эмнэлгийн эрүүл ахуйн гэрчилгээ
- ✚ Ачааны манифест, Тээврийн бичиг баримт, Баглаа боодлын жагсаалт

Зураг 22. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын үйл явц



Шар тос, хатаасан бяслаг экспортлоход ижил төрлийн гэрчилгээ, зөвшөөрөл авна. Бүтээгдэхүүний дээжийг экспортлох оронд илгээж шинжлүүлэх бөгөөд мөн дотооддоо зөвшөөрөл, гэрчилгээ авахын тулд шинжлүүлнэ. Бүх бичиг баримт бүрдүүлсний дараа Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт хүсэлт гаргаж байцаагч томилуулна. Хяналтын үзлэгийг гаалийн байцаагч, мэргэжлийн хяналтын байцаагч хамтдаа хийнэ. Экспортын бүтээгдэхүүнийг лацадсаны дараа гүний гаалиас тээвэрлэлт эхэлнэ.

Хүснэгт 43. Сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн хугацаа, зардал

Алхам	Байгууллага	Өдөр/ цаг							Зардал, ₮	
		1	2	3	4	5	6	7		
		24	48	72	96	120	144	168		
Худалдах, худалдан авах гэрээ	Экспортлогч, импортлогч	+								
Үнийн нэхэмжлэх	Экспортлогч	+								
Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч	+								
Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт МХЕГ гаргах	НМХГ		+							
Дээжид шинжилгээ хийх	УМЭАЦТЛ		+	+	+	+				124,000₮
Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ	Бүс нутгийн анхан шатны мал эмнэлгийн нэгж					+	+			12,500₮
Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ	МЭЕГ						+			12,500₮
Тохирлын гэрчилгээ	СХЗГ						2ц			79,000₮
Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ						2ц			40,000₮
Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ	МХЕГ						+	+		12,500₮
ГЕГ-ын цахим сүлжээнд экспортын хэмжээг бүртгүүлэх	ГЕГ							+		
Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч							+		320,000₮
Нийт								168 цаг		600'500₮

Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын бичиг баримтын бүрдүүлэх зардалд 168 цаг, 600'500 төгрөгийг зарцуулж байна.

Сүү, сүүн бүтээгдэхүүнийг экспортлоход шаардлагатай зөвшөөрөл, гэрчилгээний жагсаалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 44. Сүү, сүүн бүтээгдэхүүний гэрчилгээ, зөвшөөрлийн хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт

Зөвшөөрөл, гэрчилгээ	Бүрдүүлэх материал
Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ	Харьяалсан бүс нутгийн мал эмнэлгийн нэгжээс мал, түүхий эдэд дагалдуулж өгдөг.
Бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт	НМХГ-ын томилсон байцаагчийн авсан дээжид шинжилгээ хийж дүгнэлт гаргана.
Тохирлын гэрчилгээ	- УБГ-ний хуулбар (баталгаажсан) - Өргөдлийн маягт бөглөх (masm.gov.mn) - Худалдах, худалдан авах гэрээ - Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг - Бүтээгдэхүүний сорилт, туршилт хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн - Мэргэжлийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл (шаардлагатай тохиолдолд) - Үйлчилгээний төлбөр тушаасан баримтын хувь
Гарал үүслийн гэрчилгээ	- УБГ-ний хуулбар - Өргөдлийн маягт бөглөх - Гадаад худалдааны гэрээний хуулбар - Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт - Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл, чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар
ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	- УБГ-ний хуулбар - Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн

	хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа - Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил
Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээ, экспортын гэрчилгээ	- Албан хүсэлт бичгээр - УБГ-ний хуулбар - Стратегийн хүнс экспортлох бол ХХААХҮЯ-аас гаргасан экспортлох тоо хэмжээ /квот/ - Худалдах, худалдан авах гэрээ эсхүл түүнтэй адилтгах баримт - Сав, баглаа боодлын мэдээлэл, тоо хэмжээ /Англи хэлээр/ - Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн - Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл - Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ - ОХУ болон БНХАУ-д экспортлох бол тухайн улсад бүртгэсэн бүртгэлийн хуулбар /нэг удаа өгөх/ - Гуравдагч оронд экспортлох бол ОХУ болон БНХАУ-аас дамжуулан тээвэрлэх зөвшөөрлийн хуулбар - Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах тухай улсын байцаагчийн дүгнэлт /анх удаа экспорт эхэлж байгаа бол/ - Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

Улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаад худалдааны гэрээ зэрэг баримт бичиг нь гэрчилгээ олголтод давхардуулан шаардагддаг.

2.3.2.Хил, гааль дээрх үйл явц

Сав баглаа, боодлын гадаад улс орнуудын стандарт шаардлагууд:

Япон улс руу экспортлох зориулалттай бүтээгдэхүүн нь “Хүнсний шошгын тухай хууль” -ийг дагаж мөрдөх ёстой бөгөөд үүний дагуу бүтээгдэхүүний сав баглаа боодол дээр хугацааг нь зааж өгөх ёстой.

- ✚ Бүтээгдэхүүний орц, бүтэц, хадгалалт, баглаа боодлын стандартыг нарийн баримтлах бөгөөд нэгийг нь зөрчсөн тохиолдолд гэрээг цуцална. Үндсэн тайлбар нь япон хэл дээр бичигдсэн байх
- ✚ Япон худалдан авагчид сав баглаа боодол дээр заасан огноог дуусах хугацаа гэж ойлгодог тул үйлдвэрлэсэн огноог нь биш харин дуусах хугацааг нь тавина. Японы томоохон худалдааны сүлжээнүүд анхны сав баглаа боодлын өгөгдөл дээр нэмэлт наалт наахад сөрөг хандлагатай тул Японы талаас үл ойлголцол үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд үйлдвэрлэсэн огноог оруулна.
- ✚ Бүтээгдэхүүнийг тээврийн хайрцаг дээр үйлдвэрлэсэн оноог бичнэ.

БНХАУ руу экспортлох бүтээгдэхүүний сав баглаа, боодолд тавигддаг стандартууд:

- ✚ Бүтээгдэхүүнийг битүүмжилж лацадсан байна. Үйлдвэрлэсэн улс, өдөр, бүтээгдэхүүний бүтэц, үйлдвэрлэгч болон импортлогчийн талаарх мэдээлэл, худалдааны тэмдэг, бүтээгдэхүүний онцлог шошгод заавал байна.
- ✚ Хэрэв сүүний рН 7.0 -аас бага байвал 72 ° С -т 15 секунд турш ариутгах процедур (өндөр температур – богино HTST хугацаа) хийсэн байх. Хамгийн багадаа 132 ° С температурт ариутгах процедур (UHT) -ийг дор хаяж 1 секунд турш хэрэглэсэн байх

АНУ руу экспортлох бүтээгдэхүүний сав баглаа, боодолд тавигддаг стандартууд:

- ✚ Ариун цэвэр, хяналтын газраас зөвшөөрсөн материалаар хийгдсэн сав баглаа боодол ашиглана.
- ✚ АНУ-д бүтээгдэхүүний нэр; үйлдвэрлэгчийн нэр, байршил; орцын найрлага; цэвэр жин; шим тэжээлийн агууламж шошго дээр бичигдсэн байх шаардлагатай. Мөн шошгод бүтээгдэхүүний илчлэгийн хэмжээ, өөх тос, холестерол, натри, эслэгийн мэдээлэл байх ёстой.

Монгол Улсад гаалийн хилээр нэвтрүүлэх бүх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийнэ. Гаалийн бүрдүүлэлтийн зорилго нь гаалийн хяналтад байгаа барааг мэдүүлэгчийн сонгосон горимын дагуу гаалийн хилээр нэвтрүүлэхэд оршино. Гаалийн тухай хуульд зааснаар “гаалийн хилээр нэвтрэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс эхэлж, гаалийн бичиг баримтыг, шаардлагатай бол бараа, тээврийн хэрэгслийг шалгах, гаалийн болон бусад татварыг ногдуулан, барагдуулсны дараа эзэнд нь олгох, эсхүл гаалийн хилээр гаргахыг гаалийн байгууллага зөвшөөрөх хүртэл цогцолбор үйл ажиллагааг гаалийн

бүрдүүлэлт” гэж тодорхойлсон байна. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийснээр барааг эзэнд нь олгох, эсхүл гаалийн хилээр гаргах эсэхийг шийдвэрлэнэ. Энэхүү үйл ажиллагаа нь дараах үе шаттай явагдана.

1. мэдүүлэх;
2. бичиг баримтыг шалгах;
3. бараа, тээврийн хэрэгслийг шалгах;
4. гаалийн болон бусад татварыг ногдуулж барагдуулах;
5. хүлээн авагчид олгох, эсхүл гаалийн хилээр гаргахыг зөвшөөрөх.

Гаалийн улсын байцаагч гаалийн бүрдүүлэлтийн явцад гаалийн удирдах төв байгууллагаас баталсан маягыг нөхөн бичнэ. Үүнд:

- ✚ “Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас” /маягт 2/ - ыг зорчигчийн бараанд татвар, хураамжийг ногдуулж, барагдуулахад;
- ✚ “Татвар, хураамжийн орлогын хуудас” /маягт 1/-ыг банкны байгууллага ажилладаггүй хилийн боомтод гаалийн татвар, хураамжийг бэлнээр авах, захиалга дуудлагаар бүрдүүлэлт хийх, мэдээллийн дагуу шалгалт хийх, статистик, мэдээ, мэдээллээр үйлчлэхэд;
- ✚ “Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах хуудас” /маягт 5/ - барааг нягтлан шалгах зорилгоор саатуулахад;
- ✚ “Лабораторийн шинжилгээний хураамжийн хуудас” /маягт 3/ - улсын хилээр оруулж буй хими, биологийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг гаалийн лабораторид шилжүүлэн, шинжилгээ хийлгэхэд;

Зөрчил илрүүлсэн тохиолдолд:

- ✚ “Бараа, тээврийн хэрэгслийг хураах хуудас” /маягт 4/-зөрчилд холбогдсон барааг хураахад;
- ✚ “Зөрчлийн тухай тэмдэглэл” – Гаалийн тухай хуульд заасан зөрчлийг үйлдсэн бол;
- ✚ “Үзлэг хийсэн тухай акт” /маягт 6/ - эрүүгийн гэмт хэргийн шинжтэй зөрчил илрүүлсэн бол нөхөн бичнэ.

Гадаад бүрдүүлэлтэд шаардлагатай гадаад худалдааны бичиг баримт:

Олон улсын худалдааны бичиг баримтыг гүйцэтгэх үүргээс нь хамаарч дараах бүлгүүдэд хуваадаг.

Авто тээврийн хэрэгслээр:

- ✚ авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ;
- ✚ ачаа тээвэрлэлтийн бичиг баримт;
- ✚ худалдааны бичиг баримт; /Гадаад худалдааны гэрээ, төлбөрийн баримт, үнийн нэхэмжлэх, баглаа боодлын жагсаалт, даатгалын бичиг баримт, техникийн бичиг баримт болон бусад барааг тодорхойлсон шаардлагатай бичиг баримтууд/

Агаарын тээврийн хэрэгслээр:

- ✚ тээврийн хэрэгслийн гэрчилгээ;
- ✚ ерөнхий мэдүүлэг;
- ✚ ачааны жагсаалт /карго манифест/;
- ✚ ачаа тээвэрлэлтийн бичиг баримт;
- ✚ аяллын хугацаанд хэрэглэх зорчигчийн хүнс, хэрэгслийн жагсаалт;
- ✚ худалдааны бичиг баримт;

Төмөр замаар:

- ✚ дамжуулах хуудас;
- ✚ вагон хуудас;
- ✚ тээврийн бичиг баримт;
- ✚ худалдааны бичиг баримт.

Хүснэгт 45. Сүү, сүүн бүтээгдэхүүний хил, гааль дээрх үйл явц

Алхам	Байгууллага	Өдөр/ цаг			Зардал, ₮
		1	2	3	
		24	48	72	
Гаальд мэдүүлэх	Гаалийн зуучлагч	+			
Гаалийн бүрдүүлэлт хийлгэх: -Үнэлгээ хийлгэх -Бичиг баримт хянах -Татвар төлөх -R дугаар авах	Гааль	+			22'500₮
Гаалийн биет үзлэгт орох: - Бодит шалгалтад хамрагдах - Экспортлох зөвшөөрөл авах	Гааль	+	+		8'200₮
Гааль дээрх үзлэг, шалгалт	Гаалиас бусад байгууллага (МХЕГ, Хилийн шалган г.м)			+	7'000₮
Нийт				72 цаг	37'700₮

Экспортын үйл ажиллагааны гааль дээр ажиллах байцаагч ажлын 8 цагт багтааж үзлэг хийж дуусаагүй тохиолдолд илүү цаг 1,5-аар бодогдож төлбөрийг гаалийн байгууллагын дансанд хийнэ. Төмөр замаар тээвэрлэлт хийж буй тохиолдолд хаалга, нээлхийнээс шалтгаалж ломбо /лац/-ны тоо тодорхойлогдоно.

Япон улсын хилээр бүтээгдэхүүн оруулахдаа дистрибьютер компани болон Монголоос урьдчилан гаалийн бүрдүүлэлт онлайн эсвэл шуудангаар материал бүрдүүлэлт хийж болно. Тусгай хүснэгтийн дагуу бүтээгдэхүүний бүрэн мэдээлэл, хавсралт материалыг бүрдүүлэн гаалийн бүрдүүлэлт хийнэ. Япон улсын гааль дээр ирэх хүртэлх бүх асуудал, бичиг баримтыг экспортлогч компани, гаалийн бүрдүүлэлт хийх, шинжилгээнд оруулах, бүтээгдэхүүний ангилал зүй, татварын асуудал зэргийг дистрибьютер компани тус тус хариуцна.

Япон улс руу импортлох бүтээгдэхүүн нь бүтээгдэхүүний түүхий эдээс хамааран ангилагдах бөгөөд улсын харьяа магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудаар хэмжилт, судалгаанд орж, тэнцсэн тохиолдолд татварын албаны хяналтад орж нэгж бүтээгдэхүүний татвар тодорхойлуулна. Ингэхдээ хүнсний эрүүл ахуйн тухай хуулийн 29-р зүйлийг мөрдлөг болгоно. Япон улс нь хүнсний эрүүл ахуйн шаардлага дээд зэргийн хяналт тавьдаг тул импортын бүтээгдэхүүнд хүнсний эрүүл ахуйн болон гадаад худалдааны хуулийн хэрэгжилтээр хяналт тавьдаг. Монгол улс өөрийн түүхий эд бэлтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх MNS стандартууд байгаа боловч Япон улсын үйлдвэрлэлийн стандартуудыг давхар хангасан бүтээгдэхүүн экспортлох шаардлагатай болдог.

2.3.3.Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц

Сүү, сүүн бүтээгдэхүүн импортлогч орнуудын тээвэрлэлтийн нөхцөлд тавьдаг стандарт, шаардлагыг АНУ, ОХУ, Япон улсын жишээн дээр судаллаа.

АНУ:

- ✚ Хадгалах, тээвэрлэх үйл явцад бүтээгдэхүүн аюултай, хортой бодисоор бохирдохоос сэргийлж ариун цэврийн бүх стандартыг дагаж мөрдөх
- ✚ Бүтээгдэхүүнийг тээвэрлэх явцад битүүмжилсэн саванд тээвэрлэх

ОХУ-д импортлох сүү, сүүний хувьд, хэрэв бүтээгдэхүүн импортлох ажлыг Гаалийн холбооны хүрээнд хийсэн бол ачааны мэдүүлэг шаардлагагүй, НӨАТ -ын татвар төлөхгүй, зөвхөн тээвэрлэлт, тээвэрлэлтийн бичиг баримтыг үзүүлнэ. Гаалийн байгууллагаас барааны мэдүүлгийг гаргах стандарт хугацаа нь бүртгүүлснээс хойш 1-2 хоногийн дараа буюу урьдчилсан мэдүүлгээр ирснийг баталгаажуулдаг. Гаалийн хуулийн 81-р зүйлд хурдан мууддаг бараатай холбоотой гаалийн ажиллагааг (үүнд зарим төрлийн сүүн бүтээгдэхүүн орно) нэн тэргүүнд хийх ёстой.

Япон улсад импортлох сүү, сүүний тээвэрлэлтийн хувьд, Бүтээгдэхүүн бохирдохоос сэргийлж ариун цэврийн бүх стандартыг дагаж мөрдөн, битүүмжилсэн саванд тээвэрлэнэ. Японы зах зээлд бараа бүтээгдэхүүнээ нэвтрүүлэхийн тулд албан ёсны импортлогч компанитай худалдааны гэрээ байгуулна. Албан ёсны дистрибьютер компани Японы зах зээл дээр хэрхэн борлуулах оновчтой суваг олох, хэрэглэгч хүртэлх дэс дараалал, тээвэрлэлтийг хариуцан хууль дүрмийн дагуу ажиллах болно. Импортын бүтээгдэхүүний хаяг, шошгын загварыг “Guide to Food Import” hand book-ээс дэлгэрэнгүй мэдээлэл авч болно. Үүнд: хаяг, шошгын стандартын дагуу бэлтгэж Япон хэл дээр хөрвүүлэн бүтээгдэхүүний арын хэсэгт наана.

Гадаад улс орнуудын сүү, сүүн бүтээгдэхүүний **хадгалалтын нөхцөлд** тавигддаг стандарт, шаардлагууд:

АНУ:

- ✚ Хадгалах хэм+4 +8
- ✚ Гэрэлтүүлгийн стандарт баримтлах

ОХУ:

- ✚ Гэрэлтэй орчинд хэрэгцээт амин дэм устаж, түргэн муудах тул харанхуй орчинд тээвэрлэх
- ✚ Түүхий сүү 36 цаг
- ✚ Савласан сүү 10 өдрөөс илүүгүй
- ✚ Шилэн савлагаатай бол 2 сар хадгалах шаардлагатай тул энэ хугацаанд амжихгүй бол гэрээ цуцлагдана.

Япон:

- ✚ Хадгалах хэм+4 +8
- ✚ Гэрэлтүүлгийн стандарт баримтлах

Сүү, сүүн бүтээгдэхүүн нь хурдан мууддаг бүтээгдэхүүнд тооцогддог. Энэхүү тодорхой төрлийн ачааг тээвэрлэх норматив байдаг. Тээвэрлэлтэд температурын тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх, хадгалалт, баглаа боодол, ариун цэврийн шаардлагыг дагаж мөрдөх, мал эмнэлэг, ариун цэврийн байгууллагын шаардлага удирдлага болгох хэрэгтэй. Бүтээгдэхүүн хүргэсний дараа контейнерыг бүрэн цэвэрлэгээнд оруулах ёстой.

Гадаад улс орнууд руу экспорт хийх тээврийн зардлын тээврийн төрлөөс хамаарч ялгаатай байдлаар хүснэгтээр харуулав.

Хүснэгт 46. Экспортын тээврийн зардал (улс орноор, тээврийн хэрэгслээр)

	Гадаад улс орнууд	Зарцуулах хугацаа		Зардал, ₮
1	Япон: - Далайн тээвэр	28-35	672-840	8,550,000
2	БНХАУ: - Авто тээвэр - Төмөр замын тээвэр	10-12	240-224	5,700,000
		10-15	240-360	8,550,000
3	АНУ: - Агаарын тээвэр:	2-3	73	16,307,700

Агаарын тээвэр хугацааны хувьд хэмнэлттэй ч тээврийн өртөг өндөр байдаг. Гэхдээ сүү, сүүн бүтээгдэхүүн нь хурдан муудах эрсдэлтэй бүтээгдэхүүн тул хугацаа хожих нь чухал юм. Сүү сүүн бүтээгдэхүүн нь БНХАУ-аар дамжин АНУ хүрдэг тул энд БНХАУ хүрэх тээврийн зардлыг харууллаа.

Төлбөр хүлээн авах үйл явц

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн нөхцөлийг харахад, ихэвчлэн бараагаа тээвэрлэн бүрэн хүлээлгэж өгсний дараа төлбөрөө авдаг бөгөөд зарим тохиолдолд тодорхой хэмжээний урьдчилгаа авдаг байна.

Төлбөрөө ийнхүү барааг бүрэн хүлээлгэн өгсний дараа авч байгаа нь хамгийн өндөр эрсдэлтэй боловч дараах шалтгаануудын улмаас ийнхүү төлбөрийн нөхцөлтэй гэрээ байгуулдаг гэж дүгнэсэн. Үүнд:

- ✚ Тухайн худалдан авагч тал нь урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн буюу бүрэн итгэлцэлтэй байдаг.
- ✚ Худалдах, худалдан авах гэрээг байгуулахдаа төлбөрийн нөхцөлийг тохирох боломж бага буюу, худалдан авагч талын тавьсан нөхцөл, шаардлагын дагуу гүйцэтгэдэг. Энэ нь тухайн аж ахуйн нэгжийн гадаад худалдааны туршлага, нэр хүнд болон бизнесийн эрсдэлтэй холбоотой байна.

Хүснэгт 47. Экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явц

№	Үйл ажиллагааны жагсаалт	Байгууллагын нэр
1	Гэрээ байгуулах /Онлайн худалдаа- CIF, харилцагч- FCA нөхцөлөөр гэрээ хийгдэнэ/	Импортлогч тал
2	Нэхэмжлэл – холбогдох бичиг баримтыг харилцагчаас авах	Импортлогч тал
3	Шаардлагатай зөвшөөрөл материал бүрдүүлэх	Экспортлогч тал
4	Төлбөр шилжүүлэх	Шилжүүлэгч болон дундын банк
	- Шилжүүлгээр - Бэлнээр - Аккредитив	

Төлбөрийн даалгаварт төлбөр хүлээн авагчийн банкны мэдээлэл, дансны дугаар, дэлгэрэнгүй хаяг, утасны дугаар болон гүйлгээний утга зэргийг үнэн зөв, гаргацтай бөглөнө. Алдаатай, буруу эсхүл дутуу бөглөсний улмаас гуйвуулга саатах эсхүл буцаагдах магадлалтайг экспортлогчид анхаарах хэрэгтэй. Ам.долларын шилжүүлгийн хураамж 5,000.00 хүртэл хэмжээнд 8.5 ам. Доллар үйлчилгээний хөлс болгон авна. 5,000.01 – 50,000.00 хэмжээнд 12,5 ам.доллар¹³ байна. Дансны шилжүүлгээр харилцах дансанд төлбөр хүлээн авахад ямар нэг шимтгэл, төлбөр төлдөггүй бөгөөд шилжүүлэгч банк, дундын банкны аливаа шимтгэл төлбөрийг импортлогч тал хариуцдаг.

2.3.4. Экспортын замын зураглал

Бүтээгдэхүүний экспорт буюу олон улсын зах зээлд гаргах нь олон хүчин зүйлээс хамааралтай, олон төрлийн мэдлэг чадвар шаардсан өргөн хүрээтэй үйл ажиллагаа тул тухайн аж ахуйн нэгж, иргэд нь юуны өмнө экспортод бараа бүтээгдэхүүнээ гаргахад тухайн улсын болон олон улсын худалдаанд хэрэглэгддэг буюу ашиглагддаг маш олон хууль журам, гэрээ конвенц, хэлэлцээрүүдийг сайтар судалж танилцан, тээвэр логистикийн байгууллагаар дамжуулан экспортлох нь илүү үр дүнтэй, эрсдэлийг бууруулж байна.

Хүснэгт 48. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын үйл явцын шат дараалал

	Алхмууд	Олгох байгууллага	Тайлбар
Урьдчилсан шаардлага	Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ	Харьяалсан бүс, нутгийн анхан шатны мал эмнэлгийн нэгж	Тухайн нутгийн анхан шатны мал эмнэлгийн нэгжээс авсан байна.
Бичиг баримт бүрдүүлэлт	Шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	Экспортлогч нь НМХГ-т шинжилгээ хийлгүүлэх хүсэлт гаргасны дагуу хяналтын байцаагч томилогдон бүтээгдэхүүнээс дээж авч тэмдэглэл үйлдэн, ямар үзүүлэлтээр шинжилгээ хийлгүүлэх тухай мэдэгдэл бичиж өгнө.
	Бүтээгдэхүүний дээжид мал эмнэлэг ариун цэврийн шалгуур үзүүлэлтүүдээр шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори/ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	МХЕГ-ын байцаагчийн гаргасан мэдэгдлийн дагуу дээжид шинжилгээ хийн, шинжилгээний дүнг экспортлогчид өгнө.

¹³ <https://www.xacbank.mn/product/79>

	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ	Мал эмнэлгийн ерөнхий газар	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг МЭЕГ-аас авах бөгөөд тус гэрчилгээ нь МХЕГ-аас авах экспортын гэрчилгээнд шаардагддаг.
	Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ авах	Стандарт хэмжил зүйн газар	Тохирлын гэрчилгээ авахад холбогдох стандартын шаардлагыг бүрэн хангасан байх шаардлагатай.
	Бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ авах	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Гарал үүслийн гэрчилгээ нь тухайн бараа бүтээгдэхүүн бүхэлдээ болон хэсэгчлэн Монгол улсад үйлдвэрлэгдсэн болохыг албан ёсоор баталгаажуулсан үнэт цаас юм.
	Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ	МХЕГ	Экспортын бүтээгдэхүүнд "Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ буюу экспортын гэрчилгээ олгоно.
Гаалийн бүрдүүлэлт	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч байгууллага	Тээвэрлэгч байгууллагатай тохирон тээврийн бичиг баримтыг бүрдүүлнэ.
	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Тээвэрлэгч байгууллага, Гаалийн зуучлагч	Гаалийн цахим хуудас руу барааны мэдүүлгийг илгээнэ.
	Гаалийн хяналт шалгалт бараа, тээврийн хэрэгсэл	Улаанбаатар хот дахь гаалийн газар	Томилогдсон хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийг шалгах
	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Улаанбаатар хот дахь гаалийн газар	- Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, хураамжийг барагдуулах, - Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо	Гааль, Хилийн мэргэжлийн хяналт	Гааль болон Хилийн мэргэжлийн хяналт бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, хилийн мэргэжлийн хяналтын байцаагч экспортын мэдэгдэл өгөх
Тээвэрлэлт	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч	Тээвэрлэлт нь АНУ руу онгоцоор, Япон улс руу далайн замаар тээвэрлэгддэг.	
	Төлбөр хүлээн авах	Худалдан авагч	Барааг бүрэн хүлээн авсны дараа

Экспортын гэрчилгээ, зөвшөөрөл хөөцөлдөх үйл ажиллагаанаас гаалийн хяналт шалгалтын шат дараалал, тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц хүртэл хураангуйлан харуулсан болно.

Зураг 23. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын замын зураглал

ЭКСПОРТЫН ЗАМЫН ЗУРАГ
СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН



Хүснэгт 49. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортод импортлогч улсуудаас тавигдаж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал

Экспортын үйл явц	АНУ		Япон	
	Хугацаа \цагаар\	Зардал, ₮	Хугацаа \цагаар, өдрөөр\	Зардал, ₮
Баримт бичгийн бүрдүүлэлт				
Экспортлох эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа гэдгийг баталгаажуулсан гэрчилгээ	Урьдчилж тавигдах шаардлага бөгөөд нэг удаа явагдана			
Үйлдвэрийн хянан магадалгаа	Урьдчилж тавигдах шаардлага бөгөөд нэг удаа явагдана			
Сүү, сүүн бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ	120 цаг	104,000	120 цаг	104,000
Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)	120 цаг	10,000	120 цаг	10,000
Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)	2 цаг	40,000	2 цаг	40,000
Хил гааль дээрх үйл явц				
Экспортлогч гаалийн байгууллагад бүртгүүлсэн байх				
Үйлдвэрлэгч гэрчилгээжүүлэлтийн газарт бүртгүүлсэн байх				
Импортлогч гаалийн байгууллагад бүртгүүлсэн байх				
Импортлогч хүнсний үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх				
Гаалийн мэдүүлэг	48-168 цаг		48-120 цаг	
Төлбөр хүлээн авах үйл явц				
Гадаад улсын гаалийн хашаан дотор очих хүртэлх тээвэр, төлбөрийн шилжүүлгийн банкны шимтгэл	72-168 цаг төлбөр хүлээн авахад шимтгэл төлдөггүй		72-168 цаг төлбөр хүлээн авахад шимтгэл төлдөггүй	
Экспортын барааг ачуулсны дараах үйл явц	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч хариуцдаг			
Нэхэмжлэх явуулсны дараах төлбөр хүлээн авах хугацаа	336-480		336-480	
Нийт	698-1058		698-1010	

Дээрх хүснэгтэд дээжид шинжилгээ хийх, 5 төрлийн гэрчилгээ авах, тээврийн манифест, экспортын ачааг ачуулсны дараах үйл явцын хугацаа болон зардлыг Япон, АНУ улсаар харууллаа. Бичиг баримт бүрдүүлэх хугацаа экспортлогч хоёр орны хувьд адил, харин тээвэрлэлтийн хугацаа болон өртөг ялгаатай. Харилцагч банкны хувьд аж ахуйн нэгж нь ихэвчлэн зээл авсан банкттайгаа холбоотой санхүүгийн үйл ажиллагаагаа явуулдаг тул сонгож авсан компанийн хувьд “Голомт” болон “Хаан” банкаар дамжуулан гүйлгээ хийдэг.

Хүснэгт 50. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын үйл явц дахь зардлын тооцоо

	АНУ	Япон
Монгол дахь экспортын үйл явцад нийт зарцуулах зардал, ₮	600'500	600'500
Тээвэр, ₮	2 тн, 5500 ам.доллар	10 тн, 4500 ам.доллар
Нийт зардал, ₮	16,270,000	13,421,000
Нэгжид ногдох зардал (нэг тонн), ₮	8,135,000	1,342,100

Сүү, сүүн бүтээгдэхүүнийг экспортлох үйл явцад 600.5 мянган төгрөг 10 өдрийг зарцуулж байна. Харин гадаад улс орны шаардлагын дагуу нэмэгдэж байгаа зардал байхгүй. Харин АНУ руу тээвэрлэх тээврийн зардал харьцангуй өндөр байна. Нэг тонн сүүн бүтээгдэхүүнийг АНУ-д экспортлоход 8.1 сая төгрөг, Япон улс руу экспортлоход 1.3 сая төгрөгийн зардал зарцуулдаг.

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН



ЭКСПОРТЫН БИЧИГ БАРИМТ БҮРДҮҮЛЭЛТ

ХИЛ ГААЛЬ ДЭЭРХ ҮЙЛ ЯВЦ

ТЭЭВЭР

ТӨЛБӨР ХҮЛЭЭН АВАХ



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

- Худалдах, худалдан авах гэрээ
- Үнийн нэхэмжлэх
- Сав баглаа боодлын жагсаалт
- Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлтийг МХЕГ-т гаргах
- Дээжид шинжилгээ хийх
- Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ
- Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ
- Тохирлын гэрчилгээ
- Гарал үүслийн гэрчилгээ
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ
- ГЕГ-ын цахим сүлжээнд экспортын хэмжээг бүртгүүлэх
- Тээврийн бичиг баримт, Ачааны манифест

168 цаг, 600'500₮

- Гаальд мэдүүлэх
- Гаалийн бүрдүүлэлт хийлгэх:
 - Үнэлгээ хийлгэх
 - Бичиг баримт хянах
 - Татвар төлөх
 - R дугаар авах
- Гаалийн биет үзлэгт орох:
 - Бодит шалгалтад хамрагдах
 - Экспортлох зөвшөөрөл авах
- Гааль дээрх үзлэг, шалгалт

72 цаг, 37'700₮

- АНУ: 2750\$/тонн
- Япон: 450\$/тонн

- 120-240 цаг
- Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл: 7.71%
- Дундын банкны шимтгэл: 25-35\$

Импортлогчийн хашаа хүртэлх хил гааль дээрх үйл явц:

АНУ

Баримт бичгийн бүрдүүлэлт:

- Экспортлох эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа гэдгийг баталгаажуулсан гэрчилгээ
- Үйлдвэрийн хянан магадалгаа
- Сүү, сүүн бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)
- Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)

Хил дээрх үйл явц, хяналт шалгалт:

- Экспортлогч гаалийн байгууллагад бүртгүүлсэн байх
- Үйлдвэрлэгч гэрчилгээжүүлэлтийн газарт бүртгүүлсэн байх
- Импортлогч гаалийн байгууллагад бүртгүүлсэн байх
- Импортлогч хүнсний үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх
- Гаалийн мэдүүлэг

Япон

Баримт бичгийн бүрдүүлэлт:

- Экспортлох эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа гэдгийг баталгаажуулсан гэрчилгээ
- Үйлдвэрийн хянан магадалгаа
- Сүү, сүүн бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)
- Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)

Хил дээрх үйл явц, хяналт шалгалт:

- Экспортлогч гаалийн байгууллагад бүртгүүлсэн байх
- Үйлдвэрлэгч гэрчилгээжүүлэлтийн газарт бүртгүүлсэн байх
- Импортлогч гаалийн байгууллагад бүртгүүлсэн байх
- Импортлогч хүнсний үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх
- Гаалийн мэдүүлэг

- Нэг тонн сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын үйл явцын зардал - 60'050₮
- Нэг тонн сүү, сүүн бүтээгдэхүүнд ногдох экспортын үйл явцын ба тээврийн зардал - 8'135'000₮ (АНУ руу)
- Нэг тонн сүү, сүүн бүтээгдэхүүнд ногдох экспортын үйл явцын ба тээврийн зардал - 1'342'100₮ (Япон улс руу)

Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын замын зураглалыг бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль дээрх үйл явц, төлбөр хүлээн авах үйл явцыг тус бүрд нь судалж эцэст нь экспортын замын зураглалыг боловсруулж дүгнэлт хийлээ.

Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явцыг судлахдаа нэг талаас Монгол Улсаас экспортын бүтээгдэхүүнд шаардагдаж буй бичиг баримтын жагсаалтыг гаргаж тэдгээрт шаардагдах цаг хугацаа, зардлыг тооцсон. Нөгөө талаас, арьс ширэн бүтээгдэхүүнийг импортлогч гол улс орнууд болох АНУ, Япон улсад экспортлоход шаардагддаг чанар, стандарттай уялдуулан судаллаа.

Сүү, сүүн бүтээгдэхүүнийг экспортлоход Экспортын гаалийн мэдүүлэг, Үнийн нэхэмжлэл, Баглаа боодлын тодорхойлолт, Тээврийн бичиг баримт /ачааны манифест, тээвэр төлсөн баримт/, Тохирлын гэрчилгээ, Барааны гарал үүслийн гэрчилгээ, Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ, Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, Гадаад худалдааны гэрээ, Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ гэсэн бичиг баримтуудыг Монголын талаас шаардаж байна. Эдгээр бичиг баримтуудыг бүрдүүлэхэд тус бүрдээ 6-аас дээш бичиг баримтуудыг бүрдүүлдэг бөгөөд бичиг баримтуудын давхардлыг To Be шинжилгээнд нарийвчлан тооцсон болно.

Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын бичиг баримтууд нь “ХАА-н гаралтай түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн”-ий ангилалд багтдаг бөгөөд экспортын бичиг баримт бүрдүүлэлтэд 168 цаг, 600500₮ зарцуулж байгааг судалгаагаар тогтоов.

Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын хил гааль дээрх үйл явц нь Тээвэрлэгчид бараа тээвэрлүүлэх захиалга өгч тээвэрлэлтэд бэлдэх, тээврийн бичиг баримтыг бүрдүүлэх, Гааль мэдүүлэх, Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч гаалийн бүсэд нэвтрэх, Гааль бараа, тээврийн хэрэгслийг шалгах, Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, Гаалийн болон бусад татвар хураамжийг барагдуулах, Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах, Гааль болон Хилийн мэргэжлийн хяналтын алба бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, Хилийн мэргэжлийн хяналтын албанаас экспортын мэдэгдэл өгөх, Гаалийн хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх үйл явцаас бүрдэнэ. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын хил гааль дээрх үйл явцад дунджаар 48 цаг, зардалд 37,700 төгрөгийг зарцуулдаг. Эндээс бичиг баримт бүрдүүлэлт (168 цаг, 600,500₮), хил гаалийн хяналт шалгалт (48 цаг, 37,700₮)–ын зардлыг нэмбэл нийт 216 цаг, 638,200₮ зарцуулна.

Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын төлбөр төлөлт, тээвэрлэлтийн үйл явцыг судлахад, экспортод автозам, агаар, далайн тээвэр гэсэн бүх төрлийн тээврийн хэрэгслийг ашигладаг. Эдгээр тээврийн зардлыг улс орон болгоноор, тээврийн хэрэгслийн төрөл тус бүрээр судалж судалгааны тайланд оруулав. Төлбөрийн шилжүүлгийн шимтгэлд улс орон бүрээр ялгаатай боловч дунджаар 24-96 цаг (1-4 өдөр) зарцуулж 4.76% төлдөг бол Дундын банкны шимтгэлд 20-35\$ төлж байна.

Гадаад улс орнуудын импортын шаардлагыг хангахтай холбоотой болон гадаад улсын импортлогчийн хашаанд хүртэл зардлын шинжилгээг гүйцэтгэхэд, Япон улсын хувьд 244 цаг, 13421000 ₮ АНУ-ын хувьд 244цаг, 16307700 ₮ зарцуулдаг.

Сүү сүүн бүтээгдэхүүнийг экспортлоход Монголын талд зарцуулах зардал нь улс орон бүрээр ялгаатай бус, ижил бөгөөд энэ зардал дээр гадаад, дотоодын тээвэр, гадаад улс орнуудын импортын шаардлагыг хангахтай холбоотой нэмэгдэл зардлуудыг нэмж нэг тонн тутамд ногдох зардлыг тооцов. Нийтлэг ашиглаж буй тээврийн хэрэгслийг сонгож дундаж өртгийг тооцоход, нэг тонн сүү сүүн бүтээгдэхүүний экспортын үйл явцад зарцуулах дундаж өртөг АНУ руу экспорт хийхэд 8.1 сая төгрөг, Япон улс руу 1.3 сая төгрөг байна.

2.4. ГОО САЙХНЫ БҮТЭЭГДЭХҮҮН

2.4.1. Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц

MNS1910:2017 стандарт нь гоо сайхны бүтээгдэхүүнд чанар болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн микробиологийн шинжилгээний үндсэн үзүүлэлт, бүтээгдэхүүнд тавих шаардлага, дээж авах журам хамаарна.

MNS1595:2017 стандарт нь гоо сайхны бүтээгдэхүүнд чанар болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн нян судлалын шинжилгээ хийх, Эшерих коли нян илрүүлэх аргад хамаарах зэргээр олон стандарт нь бүтээгдэхүүн бүрээр өөр гарч ирэх бөгөөд энд нийтлэг заавал биелүүлэх хоёр стандартыг тайлбарлалаа.

Олон улсын стандартын байгууллагаас боловсруулсан ISO21148 стандартыг гоо сайхны бүтээгдэхүүний микробиологийн тодорхойлох ерөнхий дүрэм, туршилтын аргыг заавал хийсэн байх хэрэгтэй.

Европын холбооны Гоо сайхны бүтээгдэхүүний зохицуулалтын шаардлага EC1223/2009; Европын Холбооны Гишүүн орнуудын хэрэглэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг уялдуулах Зөвлөлийн 87/357/EE, Европын Холбооны Комиссын дүрэм EC 655/2013 Гоо сайхны бүтээгдэхүүн дээр тавих мэдээлэл; Европын Холбооны дүрэм EC 1272/2008 гоо сайхны бүтээгдэхүүнд хэрэглэх бодисын савлагаа, шошго, ангилал; EC 1069/2009 Амьтны гаралтай найрлага бодисын шаардлага; ISO2716:2007-Гоо сайхны бүтээгдэхүүн-Үйлдвэрлэлийн зохистой дадлын дүрэм; ISO 9235 Үнэрт байгалийн гаралтай түүхий эд ашиглах зэрэг шаардлагыг биелүүлсэн байх ёстой. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын бэлтгэл судалгаа, туршилтын ажил зардал ихтэй байдаг.

Европын Холбооны зах зээл дээр худалдаалагдах гоо сайхны бүтээгдэхүүний стандарт шаардлагыг тогтоосон. Тухайн ангилалд хамаарах гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ дээжийг тус улсад шинжлүүлж, ЕХ-ны гишүүн улс орнуудад худалдаалах эрхийг авна.

Үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) нь Европын шинэ Гоо заслын удирдамж боловсруулахад тулгуурладаг. Энэ заавар нь хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангахад маш өндөр шаардлага тавьдаг.

ISO 22716 Гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн шилдэг туршлагауд нь бүтээгдэхүүний чанарт нөлөөлдөг хүний, техникийн болон захиргааны хүчин зүйлсэд гол анхаарлаа хандуулж, үйл ажиллагааны дүрэм журам, үйл ажиллагааны дүрмийг багтаасан байдаг.

ISO 22716 стандартын зорилго нь хүлээгдэж буй техникийн шаардлагыг хангасан эцсийн бүтээгдэхүүн рүү чиглэсэн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах явдал юм. Энэхүү дүрэм, ISO 22716 стандартын дагуу, тухайлбал, гоо сайхны бүтээгдэхүүний найрлага хоруу чанар, бүтээгдэхүүний шошгололт, бүтээгдэхүүний дэлгэрэнгүй задаргааг бэлтгэх, шинэ бүтээгдэхүүний танилцуулгад Европын Комисст заавал мэдэгдэх, үйлдвэрлэгч, түгээгчдэд хариуцлага хүлээхэд хүргэдэг.

Гэсэн хэдий ч гоо сайхны зах зээл хөгжиж байгаа Европын холбооны гаднах бусад улс орнууд ISO 22716 Гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх практикийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай арга замыг мөн зааж өгдөг. Компаниуд нь ISO 22716 сертификатын ачаар дэлхий даяар худалдааны давуу талыг олж авдаг.

Монгол улсад гоо сайхны бүтээгдэхүүний экспортод доорх бичиг баримтуудыг бүрдүүлдэг.

Гоо сайхны бүтээгдэхүүн экспортлох үйл явц.

“Монос Косметик” ХХК 2018 онд монголын гоо сайхны үйлдвэрлэлийн салбарт шинэчлэл хийж, салбартаа анхдагч олон улсын ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоог үйл

ажиллагаандаа амжилттай нэвтрүүлж дэлхийн топ-5 баталгаажуулалтын байгууллага болох AFNOR группээс гэрчилгээ гардан авсан. 2021 онд Монос Косметик ХХК нь GMP стандарт бүхий гоо сайхны жишиг үйлдвэрийг ашиглалтад оруулна.

Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлт “Биомон халгай” шампунь, гарын тос, хонины сүүлтэй тос, гангын хандтай шампунь, биеийн шингэн саван, лосьон жишээн дээр\:

- ✚ Бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлэн дүгнэлт гаргуулах
- ✚ Тохирлын гэрчилгээ авах
- ✚ Гарал үүслийн гэрчилгээ авах
- ✚ Ачааны манифест, Тээврийн бичиг баримт, Баглаа боодлын жагсаалт

Хүснэгт 51. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортод шаардлагатай бичиг баримтын жагсаалт

№	Бичиг баримтын жагсаалт	Бичиг баримтыг олгох газар	Улс орон
			БНХАУ
1	Улсын бүртгэлийн гэрчилгээ	Экспортлогч байгууллага	+
2	Үнийн нэхэмжлэх	Экспортлогч байгууллага	+
3	Худалдах, худалдан авах гэрээ	Импортлогч болон экспортлогч байгууллага	+
4	Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч байгууллага	+
5	Бүтээгдэхүүний дээжид итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори/ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	+
6	Тохирлын гэрчилгээ	Стандарт хэмжил зүйн газар	+
7	Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ	+
8	Тээврийн бичиг баримт	Тээвэрлэгч	+

“Биомон халгай” шампунь, гарын тос, хонины сүүлтэй тос, гангын хандтай шампунь, биеийн шингэн саван, лосьон экспортлох үйл ажиллагаанд бүрдүүлэх бичиг баримт нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнтэй харьцуулахад харьцангуй цөөн. Харин стандарт, шаардлага, шинжилгээний гэрчилгээ шаардлагатай бөгөөд тухайн экспортлох орны гоо сайхны бүтээгдэхүүний чанарын шаардлага, стандартад заавал нийцүүлэх шаардлагатай. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас импортлогч талд илгээх дээжийн тээвэрлэлт хугацаа хоцрох явдал гарах магадлалтай. Дээрх бүтээгдэхүүнүүдийн БНХАУ-ын Эрээн хот орох тээвэрлэлтийг импортлогч тал даах бөгөөд хэрэглэгчид хүрэх хүргэлтийг импортлогч тал хариуцна.

Зураг 24. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын үйл явцын дараалал



Гоо сайхны бүтээгдэхүүнийг экспортлоход эрх бүхий байгууллагуудаас дараах тодорхойлолт, гэрчилгээг авах шаардлагатай.

Хүснэгт 52. Гоо сайхны бүтээгдэхүүнийг экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц, хугацаа, зардал

Алхам	Байгууллага	Зардал, ₮					
		1	2	3	4	5	
		24	48	72	96	120	
Худалдах, худалдан авах гэрээ	Экспортлогч, импортлогч	+					
Үнийн нэхэмжлэх	Экспортлогч	+					
Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч	+					
Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ		+				
Бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжүүлэн дүгнэлт гаргуулах	МХЕГ			+	+		Дээжийн тоо хэмжээнээс шалтгаалж үнэ ялгаатай
Тохирлын гэрчилгээ	СХЗГ				2ц		79,000₮
Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ				2ц		20,000₮
ГЕГ-ын цахим сүлжээнд экспортын хэмжээг бүртгүүлэх	ГЕГ				+		
Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч					+	
Нийт						100 цаг	99'000₮

Гоо сайхны бүтээгдэхүүний дээжийн шинжилгээ нь бүтээгдэхүүн бүрээр ялгаатай, мөн экспортлогч орон, Европын холбоо зэрэг нь тусдаа шаардлагатай тул шинжилгээний зардал өөр өөр гардаг.

Хүснэгт 53. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдийн хүсэлт гаргахад бүрдүүлэх материал

Зөвшөөрөл, гэрчилгээ	Бүрдүүлэх материал
Бүтээгдэхүүний дээж	
Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй болон өндөр эрсдэлтэй экспортын бараа бүтээгдэхүүнд эрүүл ахуйн дүгнэлт	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Экспорт, импорт, экспорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт хандсан “Эрүүл ахуйн дүгнэлт гаргуулах тухай” иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт - Иргэний үнэмлэхийн хуулбар - Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар - Үйлдвэрлэгчтэй эсвэл албан ёсны дистрибьютертэй хийсэн худалдааны гэрээ - Хилээр экспортолж буй биологийн халдвартай материал, шинжилгээний дээжийн хувьд холбогдох төрийн захиргааны байгууллагаас олгосон лиценз - Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимаас олгосон гарал үүслийн гэрчилгээ - Бараа, бүтээгдэхүүний чанарын болон тохирлын гэрчилгээ - Бараа, бүтээгдэхүүний шинжилгээний дүнгийн гэрчилгээ - Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн
Гарал үүслийн гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - УБГ-ний хуулбар - Өргөдлийн маягт бөглөх - Гадаад худалдааны гэрээний хуулбар - Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт - Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл, чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар
Тохирлын гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - УБГ-ний хуулбар (баталгаажсан) - Өргөдлийн маягт бөглөх (masm.gov.mn) - Худалдах, худалдан авах гэрээ - Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг - Бүтээгдэхүүний сорилт, туршилт хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн - Мэргэжлийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл (шаардлагатай тохиолдолд) - Үйлчилгээний төлбөр тушаасан баримтын хувь
Чанар, шинжилгээний бичиг	Шаардлагатай тохиолдолд нян судлал, хими, хүнд металл, цацрагийн

	шинжилгээнд хамруулна
Шошго	<p>Шошгод тавих шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> ○ Хариуцлагатай хүний нэр хаяг; ○ Анхдагч улс, (Гарал үүслийн улс нь зөвхөн импортын бүтээгдэхүүний хувьд шаардлагатай байна); Тайлбар; Хадгалах хугацаа, тагийг задалснаас хойш хадгалах хугацаа; ○ Анхааруулга; ○ Бүтээгдэхүүний дугаар; ○ Бүтээгдэхүүний зориулалт; ○ Орц, найрлага. <p>Экспортлох орны хэл дээр танилцуулгыг хийнэ. Австри, Болгар, Франц, Польш, Португал, Словак зэрэг улс нь шошго, сурталчилгааны мэдээлэл зэрэг бүтээгдэхүүний талаарх бүх мэдээллийн орчуулгыг заавал шаарддаг. Шошго дээрх тайлбарыг ойлгомжтой хэлбэрээр тодорхойлсон байна.</p>

Монгол улсаас гоо сайхны бүтээгдэхүүн экспортлоход тухайн бүтээгдэхүүний орц найрлага нь хүний биед сөрөг нөлөөгүй болохыг баталсан шинжилгээний дэлгэрэнгүй бичгийг хүлээн авагч талаас шаарддаг.

2.4.2.Хил, гааль дээрх үйл явц

Импортлогч орнуудын сав баглаа, боодолд тавигддаг стандарт, шаардлагууд:

БНХАУ:

- ✚ Бүтээгдэхүүний нэр
- ✚ Үйлдвэрлэгчийн хаяг
- ✚ Бүтцийн найрлага
- ✚ Ариун цэврийн гэрчилгээний код
- ✚ Үйлдвэрлэх лицензийн код
- ✚ Бүтээгдэхүүний орцод нэмсэн амтлагч
- ✚ Үйлдвэрлэсэн хугацаа, хүчинтэй хугацаа
- ✚ Бүтээгдэхүүн хэрэглэх заавар
- ✚ HS код

Япон улс:

- ✚ Бүтээгдэхүүний нэр төрлийн код
- ✚ Брэндийн нэр
- ✚ Анхдагч борлуулагчийн нэр, хаяг
- ✚ Агуулга (жин эсвэл багтаамж)
- ✚ Үйлдвэрлэсэн улсын нэр
- ✚ Үйлдвэрлэлийн дугаар эсвэл код
- ✚ Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдын гаргасан тушаалын дагуух найрлагын жагсаалт
- ✚ Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдын тушаалын дагуух гоо сайхны бүтээгдэхүүний хугацаа дуусах хугацааны горимд таарч буй эсэх
- ✚ Гоо сайхны бүтээгдэхүүний хэрэглээ, хадгалалтын талаарх санамж
- ✚ Холбоо барих хүний мэдээлэл, утас¹⁴

2017 оноос Биомон гурамсан хандтай шампунь, Биомон кидс-хонины сүүлтэй тос, Биомон барагшуун иж бүрдэл, Биомон гүүний саам иж бүрдэл, Биомон чацаргана иж бүрдлийг Хятад, Япон улс руу экспортоор гаргаж эхэлсэн.

Хүснэгт 54.Гоо сайхны бүтээгдэхүүний хил, гааль дээрх үйл явц

Алхам	Байгууллага	Өдөр/ цаг			Зардал, ₮
		1	2	3	
		24	48	72	
Гаальд мэдүүлэх	Гаалийн зуучлагч	+			

¹⁴ <https://www.cirs-reach.com/news-and-articles/regulatory-requirements-for-exporting-cosmetics-to-japan.html>

Гаалийн бүрдүүлэлт хийлгэх: -Үнэлгээ хийлгэх -Бичиг баримт хянах -Татвар төлөх -R дугаар авах	Гааль	+			22,500₮
Гаалийн биет үзлэгт орох: - Бодит шалгалтад хамрагдах - Экспортлох зөвшөөрөл авах	Гааль	+	+		8,200₮
Гааль дээрх үзлэг, шалгалт	Гаалиас бусад байгууллага (МХЕГ, Хилийн шалган г.м)			+	7,000₮
Нийт				72 цаг	37'700₮

Гоо сайхны бүтээгдэхүүний хил гааль дээр зарцуулагдах хугацаа болон зардлын дундаж хэмжээг дээрх хүснэгтээр харуулав. Биомон гурамсан хандтай шампунь, Биомон кидс-хонины сүүлтэй тос, Биомон барагшуун иж бүрдэл, Биомон гүүний саам иж бүрдэл, Биомон чацаргана иж бүрдлийн экспортын хил, гааль дээрх хяналт шалгалтад 72 цаг, 37.7 мянган төгрөгийг зарцуулдаг.

Хамтран ажиллах хүрээнд 3 улсад албан ёсны экспортын зөвшөөрөл 22 лабораторийн шинжилгээний бичиг, зөвшөөрөл өөрийн нэрийн бүтээгдэхүүнүүд дээрээ авсан байна. Цаашдаа БНСУ, Сингапур, Мьянмар, Малайз, АНУ улсад бүтээгдэхүүнээ бүртгүүлэх, албан ёсоор экспортлох ажлыг хийж байна. Малайз, Мьянмар улсад амжилттай нэвтэрсний дараа ASEAN-ын орнуудад гарахаар төлөвлөж байна.

2.4.3.Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц

Импортлогч орнуудын **гоо сайхны бүтээгдэхүүний тээвэрлэлтийн нөхцөлд** тавигддаг стандарт, шаардлагууд:

БНХАУ:

- ✚ Гоо сайхны бүтээгдэхүүн нь хэт бага эсвэл өндөр хэмд мууддаг тул тодорхой хэмийн горим, чийгшлийг хадгалах боломжтой тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг. Гоо сайхны бүтээгдэхүүнийг +1 -ээс +10 хэм хүртэл байдаг. Автомашин, төмөр зам, агаарын тээврээр хөргөлтийн төхөөрөмж ашиглан тээвэрлэх боломжтой¹⁵.
- ✚ Бүтээгдэхүүнийг атираат картон, полиэтиленээр хийсэн хайрцагт савлана. Шилэн саванд хийсэн гоо сайхны бүтээгдэхүүнийг нимгэн хальсан таглаагаар таглаж өгнө. Эмзэг, шатамхай ачаанд тэмдэглээ хийж өгнө.
- ✚ Хэрэв бүтээгдэхүүн нь алдартай брэнд бол үйлдвэрлэгчээс барааны тэмдгийг авах шаардлагатай. Барааны тэмдэг байхгүй тохиолдолд бүтээгдэхүүн импортлох, борлуулахыг хууль бус гэж үзнэ.

БНХАУ-д барааны дагалдах бичиг баримтын хуулбарыг гаалийн байгууллага гаргуулан авах бөгөөд бараа ирсний дараа бичиг баримтын эх хувийг хуулбартай нь тулган шалгана. Гаалийн тухай хуульд заасан бичиг баримтыг тулган барааг гаалийн хилээр нэвтрүүлнэ.

Барааны нэр төрлөөс хамааран бусад нэмэлтээр шаардагдах бичиг баримт: урьдчилж бүртгүүлж авсан зөвшөөрөл, шинжилгээний бичиг, эрүүл ахуйн шинжилгээний бичиг гэх мэт.

- ✚ Үнийн нэхэмжлэх: нэгж барааны үнэ, нийт үнэ, тоо хэмжээ, барааны тодорхойлолт, тээврийн мэдээллийг тусгасан байх.
- ✚ Гарал үүслийн гэрчилгээ: Үйлдвэрлэгчээс гарсан байж болох бөгөөд дараах мэдээллийг агуулсан байвал зохино. Үүнд:
 - Гэрчилгээг гаргагчийн албан ёсны нэр, хаяг
 - Импортлогчийн мэдээлэл
 - Экспортлогчийн мэдээлэл
 - Үйлдвэрлэгчийн мэдээлэл
 - Барааны тодорхойлолт болон БТКУС кодын ангилал

¹⁵ <https://sbcargo.ru/poleznaya-informatsiya/tamozhennoe-oformlenie-kosmetiki>

- Гэрчилгээний огноо
- ✚ Сав баглаа боодлын жагсаалт: Сав баглаа боодлын болон жин, хэмжээний мэдээлэл.
- ✚ Ачааны бичиг /манифест/: Тээвэрлэгчийн мэдээлэл, хүлээн авагчийн нэр, хаяг, эцсийн хүрэх боомт, ачааны тодорхойлолт, ачааны үнийн болон даатгалын мэдээлэл.
- ✚ Импортын деклараци: Ихэвчлэн импортлогч, хүлээн авагч этгээд англи хэл дээр бөглөн ирүүлдэг.

Импортлогч орнуудын **гоо сайхны бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөлд** тавигддаг стандарт шаардлагууд:

БНХАУ:

- ✚ AQSIQ¹⁶, CFDA¹⁷-д бүртгүүлэх
- ✚ GB 7916 1987: Гоо сайхны бүтээгдэхүүний ариун цэврийн стандарт
- ✚ GB 7917 1987 (1 – 5 заалт):
- ✚ GB 7918-1987 (1 – 5 заалт):
- ✚ GB 7919 1987:
- ✚ GB 5296.3 — 2008) эдгээр стандартуудыг экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байхдаа тусган ажиллах ёстой.

БНХАУ-ын гаалийн лаборатори нь хилээр нэвтрүүлэх бараа тээврийн хэрэгсэл болон тэдгээртэй холбоотой бичиг баримтад гаалийн хяналт хийх явцад мэргэжлийн тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах, гаалийн зорилгоор барааны ангиллын кодыг тодорхойлох тохиолдолд магадлан шинжилгээг хийх, мансууруулах, сэтгэц нөлөөт бодисыг таньж илрүүлэх зорилго бүхий гаалийн хяналт, шалгалтын явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх чиг үүрэгтэй.

Гадаад улс орнууд руу экспорт хийх тээврийн зардлын тээврийн төрлөөс хамаарч ялгаатай байдлаар хүснэгтээр харуулав.

Хүснэгт 55. Экспортын тээврийн зардал (улс орноор, тээврийн хэрэгслээр)

	Гадаад улс орнууд	Зарцуулах хугацаа		Зардал, ₮
1	БНХАУ:			
	- Авто тээвэр	10-12	240-224	5,700,000
	- Төмөр замын тээвэр	10-15	240-360	8,550,000
	- Агаарын тээвэр	3-5	72-120	34,200 төг/кг

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж гоо сайхны бүтээгдэхүүнийг БНХАУ руу автомашинаар тээвэрлэж байгаа бөгөөд 20 тонны чингэлэг бүхий ачааг 22.8 сая төгрөгөөр тээвэрлэж байна. Энэхүү тээвэрт нийт 720 цаг зарцуулж, нэг тонн бүтээгдэхүүний тээврийн зардал нь 1.1 сая төгрөг болно.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн нөхцөлийг харахад, ихэвчлэн бараагаа тээвэрлэн бүрэн хүлээлгэж өгсний дараа төлбөрөө авдаг бөгөөд зарим тохиолдолд тодорхой хэмжээний урьдчилгаа авдаг байна.

Төлбөрөө ийнхүү барааг бүрэн хүлээлгэн өгсний дараа авч байгаа нь хамгийн өндөр эрсдэлтэй боловч дараах шалтгаануудын улмаас ийнхүү төлбөрийн нөхцөлтэй гэрээ байгуулдаг гэж дүгнэсэн. Үүнд:

- ✚ Тухайн худалдан авагч тал нь урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн буюу бүрэн итгэлцэлтэй байдаг.
- ✚ Худалдах, худалдан авах гэрээг байгуулахдаа төлбөрийн нөхцөлийг тохирох боломж бага буюу, худалдан авагч талын тавьсан нөхцөл, шаардлагын дагуу гүйцэтгэдэг. Энэ нь тухайн аж ахуйн нэгжийн гадаад худалдааны туршлага, нэр хүнд болон бизнесийн эрсдэлтэй холбоотой.

¹⁶ General Administration of Quality Supervision, Inspection and Quarantine of the People's Republic of China (AQSIQ)

¹⁷ The China Food and Drug Administration (CFDA) (now NMPA)

Хүснэгт 56. Экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явц

№	Үйл ажиллагааны жагсаалт	Байгууллагын нэр
1	Гэрээ байгуулах /Онлайн худалдаа- CIF, харилцагч- FCA нөхцөлөөр гэрээ хийгдэнэ/	Импортлогч тал
2	Нэхэмжлэл - холбогдох бичиг баримтыг харилцагчаас авах	Импортлогч тал
3	Шаардлагатай зөвшөөрөл материал бүрдүүлэх	Экспортлогч тал
4	Төлбөр шилжүүлэх	Шилжүүлэгч болон дундын банк
	- Шилжүүлгээр - Бэлнээр - Аккредитив	

2.4.4. Экспортын замын зураглал

ГЕГ нь экспорт, импортын барааны мэдүүлгийг цахимаар авах¹⁸ боломжтой болсон нь иргэн, аж ахуйн нэгжийн цаг хугацаа, зардлыг хэмнэсэн алхам болсон. Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны хувьд нэн тэргүүнд импорт, экспорт, эсхүл дамжуулан өнгөрүүлэхэд шаардлагатай баримт бичиг, өгөгдлийг нэг цэгээр дамжуулах хил гаалийн хяналтын “Цахим нэг цонх”-ны системийг бий болгож, хөгжүүлэх нь чухал байна.

Дараах хүснэгтэд экспортын гэрчилгээ, зөвшөөрөл хөөцөлдөх үйл ажиллагаанаас гаалийн хяналт шалгалтын шат дараалал, тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц хүртэл хураангуйлан харууллаа.

Хүснэгт 57. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын үйл явцын шат дараалал


	Алхмууд	Олгох байгууллага	Тайлбар
Бичиг баримт бүрдүүлэлт	Шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	Экспортлогч нь НМХГ-т шинжилгээ хийлгүүлэх хүсэлт гаргасны дагуу хяналтын байцаагч томилогдон бүтээгдэхүүнээс дээж авч тэмдэглэл үйлдэн, ямар үзүүлэлтээр шинжилгээ хийлгүүлэх тухай мэдэгдэл бичиж өгнө.
	Бүтээгдэхүүний дээжид шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	МХЕГ-ын байцаагчийн гаргасан мэдэгдлийн дагуу дээжид шинжилгээ хийн, шинжилгээний дүнг экспортлогчид өгнө.
	Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ авах	Стандарт хэмжил зүйн газар	Тохирлын гэрчилгээ авахад холбогдох стандартын шаардлагыг бүрэн хангасан байх шаардлагатай.
	Бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ авах	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Гарал үүслийн гэрчилгээ нь тухайн бараа бүтээгдэхүүн бүхэлдээ болон хэсэгчлэн Монгол улсад үйлдвэрлэгдсэн болохыг албан ёсоор баталгаажуулсан үнэт цаас юм.
Гаалийн бүрдүүлэлт	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч байгууллага	Тээвэрлэгч байгууллагатай тохирон тээврийн бичиг баримтыг бүрдүүлнэ.
	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Тээвэрлэгч байгууллага, Гаалийн зуучлагч	Гаалийн цахим хуудас руу барааны мэдүүлгийг илгээнэ.
	Гаалийн хяналт шалгалт бараа, тээврийн хэрэгсэл	Улаанбаатар хот дахь гаалийн газар	Томилогдсон хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийг шалгах
	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Улаанбаатар хот дахь гаалийн газар	- Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, хураамжийг барагдуулах, - Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо	Гааль, Хилийн мэргэжлийн хяналт	Гааль болон Хилийн мэргэжлийн хяналт бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, хилийн мэргэжлийн хяналтын байцаагч экспортын мэдэгдэл өгөх
Тээвэрлэлт	Гаалийн итгэмжлэгдсэн	Тээвэрлэлт нь БНХАУ руу автомашинаар тээвэрлэгддэг.	

¹⁸https://customs.gov.mn/images/publishers/2018/8/%D0%A6%D0%90%D0%A5%D0%98%D0%9C_%D0%9B%D0%90%D0%92%D0%9B%D0%90%D0%93%D0%90%D0%90_%D0%90%D0%92%D0%90%D0%A5.pdf

		тээвэрлэгч	
	Төлбөр хүлээн авах	Худалдан авагч	Барааг бүрэн хүлээн авсны дараа

Зураг 25. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын замын зураглал

ЭКСПОРТЫН ЗАМЫН ЗУРАГ
Гоо сайхны бүтээгдэхүүн



Европын Холбооны зах зээлд гаргахаар зорьж буй мал амьтан, ургамлын орц, гаралтай 18 нэр төрлийн 70 гаруй бүтээгдэхүүний жагсаалтыг Европын Комисст хүргүүлж, эдгээр бүтээгдэхүүнийг зорилтот зах зээлийн стандартад нийцүүлэх зорилгоор “эрүүл ахуй, хорио цээр”-ийн асуудлыг хэлэлцэх Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны бүтэц бий болгохоор тохирсны дагуу гоо сайхны бүтээгдэхүүнийг энэхүү стандартад тааруулах нэг баримт бичиг болж байгаа нь сайшаалтай.

Хүснэгт 58. Гоо сайхны экспортод импортлогч улсуудаас тавигдаж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал

Экспортын үйл явц	БНХАУ	
	Хугацаа \цагаар\	Зардал, ₮
Баримт бичгийн бүрдүүлэлт		
БНХАУ руу экспортлох эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа гэдгийг баталгаажуулсан гэрчилгээ	Урьдчилж тавигдах шаардлага бөгөөд нэг удаа явагдана	
Үйлдвэрийн хянан магадалгаа	Урьдчилж тавигдах шаардлага бөгөөд нэг удаа явагдана	
Гоо сайхны бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ гэх мэт	120 цаг	104,000
Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)	2 цаг	40,000
Хил, гааль дээрх үйл явц		
Экспортлогч БНХАУ-ын гаалийн байгууллага (GACC)-д бүртгүүлсэн байх		
Үйлдвэрлэгч БНХАУ-ын гэрчилгээжүүлэлтийн газар (CNCA)-д бүртгүүлсэн байх		
Импортлогч БНХАУ-ын гаалийн байгууллага (GACC)-д бүртгүүлсэн байх		
БНХАУ-ын ЧХШТЕГ-т бүртгүүлсэн гаалийн мэдүүлэг	48-168 цаг	
Төлбөр хүлээн авах үйл явц		
Гадаад улсын гаалийн хашаан дотор очих хүртэлх тээвэр, төлбөрийн шилжүүлгийн банкны шимтгэл		
Экспортын барааг ачуулсны дараах үйл явц	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч хариуцдаг	

Нэхэмжлэх явуулсны дараах төлбөр хүлээн авах хугацаа	336-480 цаг	
Нийт	506-770 цаг	

Экспорт, импортын үйл ажиллагаа, хил гаалийн хяналтыг хялбаршуулж, оновчтой болгох, уялдаа холбоог сайжруулах нь экспортын зардлыг бууруулах гол хүчин зүйл болж байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

ГЕГ экспортын барааны мэдүүлгийг цахимаар авах боломжтой болсон нь иргэн, аж ахуйн нэгжийн цаг хугацаа, зардлыг хэмнэсэн ололтын эхлэл болж байна. Экспорт болон дамжуулан өнгөрүүлэхэд шаардлагатай баримт бичиг, өгөгдлийг нэг цэгээр дамжуулах хил гаалийн хяналтын “Цахим нэг цонх”-ны системийг хурдавчлах нь чухал болохыг хүснэгтээс харж болохоор байна.

Хүснэгт 59. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын үйл явц дахь зардлын тооцоо

	БНХАУ
Монгол дахь экспортын үйл явцад нийт зарцуулах зардал, ₮	136'700₮
Тээвэр, ₮	22,792,000 ₮
Гадаад орны импортын шаардлага хангахтай холбоотой нэмэгдсэн зардал, ₮	
Нийт зардал, ₮	22'928'700₮
Нэгжид ногдох зардал (нэг тонн), ₮	1'146'435₮

Гоо сайхны бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортлоход 136.7 мянган төгрөг, 5-6 өдөр зарцуулж тээвэрт 22.9 сая төгрөг зарцуулах ба үүн дээр шинжилгээний зардал нэмэгдэнэ. Харин импортлогч орны шаардлагыг хангахад зардал гарахгүй, харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, стандартыг хангахад зардал гарах нь тодорхой юм. Тээврийн зардлыг оролцуулан тооцвол, нэг тонн гоо сайхны бүтээгдэхүүнд ногдох экспортын зардал 1.1 сая төгрөг байна.

ДҮГНЭЛТ

Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын замын зураглалыг бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль дээрх үйл явц, төлбөр хүлээн авах үйл явцыг тус бүрд нь судалж эцэст нь экспортын замын зураглалыг боловсруулж дүгнэлт хийлээ. Гоо сайхны бүтээгдэхүүнийг экспортлоход Экспортын гаалийн мэдүүлэг, Үнийн нэхэмжлэл, Баглаа боодлын тодорхойлолт, Тээврийн бичиг баримт /ачааны манифест, тээвэр төлсөн баримт/, Тохирлын гэрчилгээ, Барааны гарал үүслийн гэрчилгээ, Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ, Гадаад худалдааны гэрээ, Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ гэсэн бичиг баримтуудыг Монголын талаас шаардаж байна. Эдгээр бичиг баримтуудыг бүрдүүлэхэд тус бүрдээ 6-аас дээш бичиг баримтуудыг бүрдүүлдэг бөгөөд бичиг баримтуудын давхардлыг To Be шинжилгээнд нарийвчлан тооцсон болно.

Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын бичиг баримтууд нь бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлтэд 100 цаг, 99000+₮ зарцуулж байгааг судалгаагаар тогтоов.

Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын хил гааль дээрх үйл явц нь Тээвэрлэгчид бараа тээвэрлүүлэх захиалга өгч тээвэрлэлтэд бэлдэх, тээврийн бичиг баримтыг бүрдүүлэх, Гаальд мэдүүлэх, Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч гаалийн бүсэд нэвтрэх, Гааль бараа, тээврийн хэрэгслийг шалгах, Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, Гаалийн болон бусад татвар хураамжийг барагдуулах, Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах, Гааль болон Хилийн мэргэжлийн хяналтын алба бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, Хилийн мэргэжлийн хяналтын албанаас экспортын мэдэгдэл өгөх, Гаалийн хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх үйл явцаас бүрдэнэ. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын хил гааль дээрх үйл явцад дунджаар 48 цаг, зардалд 37,700 төгрөгийг зарцуулдаг. Эндээс, бичиг баримт бүрдүүлэлт (100 цаг, 99.000+₮), хил гаалийн хяналт шалгалт (48 цаг, 37,700₮)–ын зардлыг нэмбэл нийт 148 цаг, 136,700₮ зарцуулна.

ГОО САЙХНЫ БҮТЭЭГДЭХҮҮН



Гоо сайхны бүтээгдэхүүн



- Худалдах, худалдан авах гэрээ
- Үнийн нэхэмжлэх
- Сав баглаа боодлын жагсаалт
- Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт
- Бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжүүлэн дүгнэлт гаргуулах
- Тохирлын гэрчилгээ
- Гарал үүслийн гэрчилгээ
- ГЕГ-ын цахим сүлжээнд экспортын хэмжээг бүртгүүлэх
- Тээврийн бичиг баримт, Ачааны манифест

100 цаг, 99'000₮



ХИЛ ГААЛЬ ДЭЭРХ ҮЙЛ ЯВЦ

- Гаальд мэдүүлэх
- Гаалийн бүрдүүлэлт хийлгэх:
 - Үнэлгээ хийлгэх
 - Бичиг баримт хянах
 - Татвар төлөх
 - R дугаар авах
- Гаалийн биет үзлэгт орох:
 - Бодит шалгалтад хамрагдах
 - Экспортлох зөвшөөрөл авах
- Гааль дээрх үзлэг, шалгалт

72 цаг, 37'700₮



ТЭЭВЭР

- БНХАУ: 1'139'600₮/тонн



ТӨЛБӨР ХҮЛЭЭН АВАХ

- 120-240 цаг
- Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл: 7.71%
- Дундын банкны шимтгэл: 25-35\$

Импортологчийн хашаа хүртэлх хил гааль дээрх үйл явц:

БНХАУ

Баримт бичгийн бүрдүүлэлт:

- БНХАУ руу экспортлох эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа гэдгийг баталгаажуулсан гэрчилгээ
- Үйлдвэрийн хянан магадалгаа
- ЧГоо сайхны бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ гэх мэт
- Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)

Хил дээрх үйл явц, хяналт шалгалт:

- Экспортологч БНХАУ-ын гаалийн байгууллага (GACC)-д бүртгүүлсэн байх
- Үйлдвэрлэгч БНХАУ-ын гэрчилгээжүүлэлтийн газар (CNCA)-д бүртгүүлсэн байх
- Импортологч БНХАУ-ын гаалийн байгууллага (GACC)-д бүртгүүлсэн байх
- БНХАУ-ын ЧХШТЕГ-т бүртгүүлсэн гаалийн мэдүүлэг.

- Нэг тонн гоо сайхны бүтээгдэхүүнд ногдох экспортын үйл явцын зардал – 6'835₮
- Нэг тонн гоо сайхны бүтээгдэхүүнд ногдох экспортын үйл явцын болон тээврийн зардал – 1'146'435₮ (БНХАУ руу)



Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын төлбөр төлөлт, тээвэрлэлтийн үйл явцыг судлахад, экспортод автозам, агаар, далайн тээвэр гэсэн бүх төрлийн тээврийн хэрэгслийг ашигладаг. Эдгээр тээврийн зардлыг улс орон болгоноор, тээврийн хэрэгслийн төрөл тус бүрээр судалж

судалгааны тайланд оруулав. Төлбөрийн шилжүүлгийн шимтгэлд улс орон бүрээр ялгаатай боловч дунджаар 24-96 цаг (1-4 өдөр) зарцуулж 4.76% төлдөг бол Дундын банкны шимтгэлд 20-35\$ төлж байна.

Гадаад улс орнуудын импортын шаардлагыг хангахтай холбоотой болон гадаад улсын импортлогчийн хашаанд хүртэл зардлын шинжилгээг гүйцэтгэхэд, БНХАУ-ын хувьд 23,197,300 ₮ зарцуулдаг.




Гоо сайхны бүтээгдэхүүнийг экспортлоход Монголын талд зарцуулах зардал нь улс орон бүрээр ялгаатай бус, ижил бөгөөд энэ зардал дээр гадаад, дотоодын тээвэр, гадаад улс орнуудын импортын шаардлагыг хангахтай холбоотой нэмэгдэл зардлуудыг нэмж нэг тонн тутамд ногдох зардлыг тооцов. Нийтлэг ашиглаж буй тээврийн хэрэгслийг сонгож дундаж өртгийг тооцоход, нэг тонн гоо сайхны бүтээгдэхүүний экспортын үйл явцад зарцуулах дундаж өртөг БНХАУ руу экспорт хийхэд 1.2 сая төгрөг байна.

2.5.МОНГОЛ ГЭР

2.5.1. Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц

Монгол гэр экспортлоход нэгдүгээрт, ургамал хамгааллын мэргэжлийн байгууллагаар ургамлын хортон шавж устгал, ариутгал халдваргүйтгэлийг хийлгэж акт үйлдүүлж авна. Хоёрдугаарт, МҮХАҮТ-аас гарал үүслийн гэрчилгээ авах бөгөөд тус бичиг баримтууд дээр нэмж бусад шаардлагатай баримт бичгүүдийг (тээврийн) бүрдүүлэн МХЕГ-т хүсэлтээ гаргаж Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ авна.

Монгол гэр экспортлоход дараах гэрчилгээ, зөвшөөрлийг бүрдүүлдэг. Үүнд:

-  Ургамлын хортон шавж устгах ариутгал хийсэн акт
-  Гарал үүслийн гэрчилгээ
-  Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, экспортын гэрчилгээ

Хүснэгт 60. Импортлогч орнуудын Монгол гэрт тавигддаг стандарт, шаардлагууд

ХБНГУ	Франц	Итали
DIN B1: Germany	NFP 92 – 503: France	CSR RF 1/75 A: Italy
EN 12520: Модон эдлэлийн бат бөх байдал, аюулгүй байдал /EX/		
(EU) 2019/2125 модон эдлэлийн импортод тавигдах шаардлага		
(EU) 2019/2072 ургамлын ариун цэврийн гэрчилгээ		

Эх үүсвэр: Access to European Union law

Зураг 26. Монгол гэрийн экспортын гэрчилгээ, зөвшөөрөл бүрдүүлэлт



Монгол гэр экспортлоход Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ шаарддаг бөгөөд энэ нь гэрийн материал нь модоор хийгддэгтэй холбоотой. Тус гэрчилгээ нь мөн импортлогч орны хил дээр гаалийн бүрдүүлэлт хийхэд зайлшгүй шаардлагатай байна.

Хүснэгт 61. Монгол гэрийн экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдийн хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт

Зөвшөөрөл, гэрчилгээ	Бүрдүүлэх материал
Ургамлын хортон шавж устгах ариутгал хийсэн акт	Ургамал хамгааллын мэргэжлийн байгууллагад хандан хүсэлт гаргах
Гарал үүслийн гэрчилгээ	- УБГ-ний хуулбар - Өргөдлийн маягт бөглөх - Гадаад худалдааны гэрээний хуулбар - Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт - Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл, чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар
Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, экспортын гэрчилгээ	- Албан хүсэлт бичгээр - УБГ-ний хуулбар - Худалдах, худалдан авах гэрээ эсхүл түүнтэй адилтгах баримт - Сав, баглаа боодлын мэдээлэл, тоо хэмжээ

- Ургамлын хортон шавж устгах ариутгал хийсэн акт
- Гарал үүслийн гэрчилгээ
- Гэрчилгээний үнэ тушаасан баримт

Хүснэгт 62. Монгол гэрийн экспортын баримт бүрдүүлэлтийн үйл явцын хугацаа, зардал

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг					Зардал, ₮
			1	2	3	4	5	
			24	48	72	96	120	
1	Худалдах, худалдан авах гэрээ	Экспортлогч, импортлогч	+					
2	Үнийн нэхэмжлэл	Экспортлогч	+					
3	Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч	+					
4	Ариутгал, халдваргүйтгэл хийлгэх	Ариутгалын компани	+					50,000₮
5	Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ		+				40,000₮
6	Ургамлын ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ	МХЕГ		+	+	+	+	10,000₮
7	Тээврийн бичиг баримт, ачааны манифест	Тээвэрлэгч					+	
	Нийт						120 цаг	100'000₮

Монгол гэр экспортлох бичиг баримт бүрдүүлэхэд нийт зарцуулах хугацаа 120 цаг ба зардал 100,000₮ байна.

2.5.2.Хил, гааль дээрх үйл явц

ХБНГУ, Франц, Итали улсууд сав, баглаа боодлын “Directive 94/62/EC: Сав баглаа боодлын шаардлага”-ыг баримталж Монгол гэрийг импортолдог.

Монгол гэрийн мод, иж бүрдэл экспортлоход гаалийн байгууллагаас гадна хилийн мэргэжлийн хяналтын байцаагч бараа бүтээгдэхүүний бичиг баримт хийгээд биет байдлыг шалгадаг. Гаалийн бүрдүүлэлтийн хувьд бичиг баримт бүрдүүлэлт бүрэн гүйцэд, зохих журмаар бүрдүүлсэн байхад процесс харьцангуй хялбар явагддаг байна.

Монгол гэр экспортлоход ямар нэг татвар ногдуулдаггүй буюу татварыг тэглэсэн байдаг бөгөөд зөвхөн гаалийн хураамж төлдөг байна.

Монгол гэр экспортлоход дараах бичиг баримтуудыг бүрдүүлдэг. Үүнд:

- ✚ Экспортын гаалийн мэдүүлэг
- ✚ Үнийн нэхэмжлэл
- ✚ Баглаа боодлын тодорхойлолт
- ✚ Тээврийн бичиг баримт /ачааны манифест, тээвэр төлсөн баримт г.м./
- ✚ Барааны гарал үүслийн гэрчилгээ
- ✚ Экспортын гэрчилгээ /ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ/
- ✚ Гадаад худалдааны гэрээ
- ✚ Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ

Хүснэгт 63. Монгол гэрийн экспортын хил, гааль дээрх үйл явц

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг			Зардал ₮
			1	2	3	
			12	36	60	
1	Ачаа тээшний зохицуулалт	Тээвэрлэгч	+			
2	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Гаалийн зуучлагч		+		20,000
3	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гааль		+		8200
4	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, лац, ломбо	Гааль		+		1000
5	Дотоод тээвэрлэлт	Тээвэрлэгч			+	

6	Хил дээрх гаалийн хяналт шалгалт	Гааль			+	
	Нийт				60 цаг	38'200₮

Тээврийн төрөл: Төмөр зам /Франц улс руу/

Монгол гэр экспортлох хил гааль дээрх үйл явцад 3 өдөр, 38,200₮ төгрөг зарцуулах бөгөөд хийгдэх алхмууд нь ачаа тээшний зохицуулалт, гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг, гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт, гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, лац, ломбо шалгах юм.

2.5.3.Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц

Монгол гэр импортлогч улс орнуудыг төлөөлүүлж **ХБНГУ, Франц, Итали улсуудын тээвэрлэлтийн нөхцөлд тавигддаг шаардлагыг судлахад, “Шууд тээвэрлэлтийн нөхцөлийн шаардлага (EU) 2015/2446”**-ыг баримталдаг.

Гадаад улс орнууд руу экспорт хийх тээврийн зардлын тээврийн төрлөөс хамаарч ялгаатай байдлаар хүснэгтээр харуулав.

Хүснэгт 64. Монгол гэрийн экспортын тээврийн зардал (улс орноор, тээврийн хэрэгслээр)

	Гадаад улс орнууд	Зарцуулах хугацаа		Зардал, ₮
1	Итали:			
	- Авто тээвэр	20-25	240-600	16,200,000
	- Төмөр замын тээвэр	30-35	720-840	16,200,000
2	Герман:			
	- Авто тээвэр	20-25	240-600	17,100,000
	- Төмөр замын тээвэр	30-35	720-840	13,500,000
3	Их Британи:			
	- Авто тээвэр	30-35	720-840	22,800,000
	- Төмөр замын тээвэр	-	-	-
4	Франц:			
	- Авто тээвэр	20-25	240-600	17,100,000
	- Төмөр замын тээвэр	30-35	720-840	17,100,000

Монгол гэрийг ихэвчлэн Европын холбооны орнууд руу авто тээвэр болон, төмөр зам ашиглан тээвэрлэж экспортолсон байна. Зарим тохиолдолд тээвэрлэлтийн өмнө тээврийн даатгал хийлгэдэг бөгөөд харин төлбөрийг дараа эсхүл, урьдчилгаа авах, мөн зарим тохиолдолд бүх төлбөрийг урьдчилж аван худалдан авагч нь өөрөө гаалийн бүрдүүлэлтэд байлцан илгээдэг байна.

Төмөр замын тээвэрлэлт нь их хэмжээний бүтээгдэхүүн экспортлоход ашигтай боловч сүүлийн үед цар тахал, үүсээд буй нөхцөл байдлын улмаас их хэмжээгээр экспортлох боломж төдийлөн байхгүй байна. Монгол гэрийг ихэвчлэн Европын холбооны улс орнуудад экспортолж байгаа бөгөөд төмөр зам, авто тээвэр ашиглаж байна.

Төлбөр хүлээн авах үйл явц

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн нөхцөлийг харахад, ихэвчлэн бараагаа тээвэрлэн бүрэн хүлээлгэж өгсний дараа төлбөрөө авдаг бөгөөд зарим тохиолдолд тодорхой хэмжээний урьдчилгаа авдаг байна.

Төлбөрөө ийнхүү барааг бүрэн хүлээлгэн өгсний дараа авч байгаа нь хамгийн өндөр эрсдэлтэй боловч дараах шалтгаануудын улмаас ийнхүү төлбөрийн нөхцөлтэй гэрээ байгуулдаг гэж дүгнэсэн. Үүнд:

- ✚ Тухайн худалдан авагч тал нь урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн буюу бүрэн итгэлцэлтэй байдаг.
- ✚ Худалдах, худалдан авах гэрээг байгуулахдаа төлбөрийн нөхцөлийг тохирох боломж бага буюу, худалдан авагч талын тавьсан нөхцөл, шаардлагын дагуу гүйцэтгэдэг. Энэ нь

тухайн аж ахуйн нэгжийн гадаад худалдааны туршлага, нэр хүнд болон бизнесийн эрсдэлтэй холбоотой байна.

Хүснэгт 65. Монгол гэрийн экспортын бүтээгдэхүүний төлбөрийг хүлээн авах үйл явц

№	Үйл ажиллагааны жагсаалт	Байгууллагын нэр
1	Худалдааны гэрээ байгуулах	Экспортлогч/ Импортлогч
2	Үнийн нэхэмжлэх	Экспортлогч
3	Бичиг баримт бүрдүүлэлт болон гаалийн хяналт шалгалт, тээвэрлэлт	Экспортлогч
4	Төлбөр тооцоо /урьдчилж, шууд, аккредитив, инкасс, эскроу данс/	Импортлогч, Шилжүүлэгч банк, дундын банк
	- Шилжүүлгээр - Бэлнээр - Аккредитив	

Дансны шилжүүлгээр харилцах дансанд төлбөр хүлээн авахад ямар нэг шимтгэл, төлбөр төлдөггүй бөгөөд шилжүүлэгч банк, дундын банкны аливаа шимтгэл төлбөрийг импортлогч тал хариуцдаг байна. Харин хугацааны хувьд барааг импортлогч орны хил дээр хүлээлгэн өгснөөс хойш дунджаар 7-14 хоног хүлээдэг байна.

2.5.4.Экспортын замын зураглал

Монгол гэр нь Европын холбооны улс орнуудад экспортлогдсон байна. Тээврийн төрлийн хувьд авто тээвэр болон төмөр замаар тээвэрлэгджээ. Энэхүү судалгааны хүрээнд, төмөр замаар тээвэрлэсэн хувилбарыг авч үзсэн бөгөөд тээвэрлэлтийн мэдээлэл, хугацаа болон үнийг тээвэр зуучийн байгууллагаас авч орууллаа.

Хүснэгт 66. Монгол гэрийн экспортын үйл явцын шат дараалал

	Алхмууд	Олгох байгууллага	Тайлбар
Бичиг баримт бүрдүүлэлт	Ургамлын хортон шавж устгах ариутгал, халдваргүйтгэл хийлгэх	Ургамал хамгааллын мэргэжлийн байгууллага	Ургамал хамгааллын мэргэжлийн хувийн ААН-тэй холбогдож, ариутгал халдваргүйтгэл хийлгэнэ.
	Гарал үүслийн гэрчилгээ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Гарал үүслийн гэрчилгээ нь аль улс оронд экспорт хийгдэхээс шалтгаалан өөр формоор гарна.
	Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, экспортын гэрчилгээ	МХЕГ	Экспортын бүтээгдэхүүнд Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ буюу экспортын гэрчилгээ олгоно.
Гаалийн бүрдүүлэлт	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч байгууллага	Тээвэрлэгч байгууллагатай тохирон тээврийн бичиг баримтыг бүрдүүлнэ.
	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Тээвэрлэгч байгууллага, Гаалийн зуучлагч	Гаалийн цахим сүлжээнд барааны мэдүүлгийг шивж оруулан илгээнэ.
	Гаалийн хяналт шалгалт бараа, тээврийн хэрэгсэл	Улаанбаатар хот дахь гаалийн газар	Томилогдсон хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийг шалгах
	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гааль	- Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, хураамжийг барагдуулах, - Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо	Гааль, Хилийн мэргэжлийн хяналт	- Гааль болон Хилийн мэргэжлийн хяналт бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, хилийн мэргэжлийн хяналтын байцаагч экспортын мэдэгдэл өгөх
Тээвэрлэлт	Тээвэрлэгч байгууллага	Тээвэр автомашин, агаарын тээвэр	
Төлбөр хүлээн авах	Худалдан авагч	Барааг бүрэн хүлээн авсны дараа	

Монгол гэр нь модон хийцээс бүрддэг тул ургамлын хортон шавжийн ариутгал, ургамлын гаралтай харшил болон элдэв халдах боломжит өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэргэжлийн байгууллагаар ариутгал заавал хийлгэх шаардлагатай болдог. Энэхүү шаардлага

нь зөвхөн экспортлогч орны зүгээс бус импортлогч орны зүгээс тавьдаг гол шаардлага болдог байна.

Зураг 27. Монгол гэрийн экспортын замын зураглал



Хүснэгт 67. Монгол гэр экспортод импортлогч улсуудаас тавигдаж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал

	ХБНГУ		Франц		Итали	
	Хугацаа \цагаар, өдрөөр\	Зардал, ₮	Хугацаа \цагаар, өдрөөр\	Зардал, ₮	Хугацаа \цагаар, өдрөөр\	Зардал, ₮
Баримт бичгийн бүрдүүлэлт						
Гарал үүслийн гэрчилгээ	2 цаг	45,000	2 цаг	45,000	2 цаг	45,000
Ургамлын ариун цэврийн гэрчилгээ	4 өдөр / 96 цаг	10,000	4 өдөр / 96 цаг	10,000	4 өдөр / 96 цаг	10,000
Хил, гааль дээрх үйл явц						
Single Administrative Document (SAD) гаалийн мэдүүлэг	1-2 өдөр / 48 цаг					
Төлбөр хүлээн авах үйл явц						
Гадаад улсын гаалийн хашаан дотор очих хүртэлх тээвэр, төлбөрийн шилжүүлгийн банкны шимтгэл	27-40 өдөр / 648-960 цаг		27-40 өдөр / 648-960 цаг		27-40 өдөр / 648-960 цаг	
Нийт	30-44 өдөр / 720-1,056 цаг	55,000	30-44 өдөр / 720-1,056 цаг	55,000	30-44 өдөр / 720-1,056 цаг	55,000

Хүснэгт 68. Монгол гэрийн экспортын үйл явц дахь зардлын тооцоо

	ХБНГУ	Франц	Итали
Монгол дахь экспортын үйл явцад нийт зарцуулах зардал, ₮	129,200₮	129,200₮	129,200₮
Тээвэр, ₮	17,100,000₮	17,100,000₮	16,200,000₮
Гадаад орны импортын шаардлага хангахтай холбоотой нэмэгдсэн зардал, ₮			
Нийт зардал, ₮	17,229,200₮	17,229,200₮	16,329,200₮
Нэг гэрт ногдох зардал ₮	3,445,840₮	3,445,840₮	3,265,840₮

Экспортын үйл явцад зарцуулах зардал нь 129.2 мянган төгрөг бөгөөд харин тээврийн зардал харьцангуй өндөр байна. Тухайлбал, 20 тонны чингэлэгт тавилгагүй 5 ханатай 15 гэр, тавилгатай гэр 4-5 багтдаг. Дээрх тооцоог тавилгатай гэрээр тооцож үзэхэд, экспортын үйл явцтай холбоотой зардал 1 гэрт 25'840₮ төгрөг бөгөөд тээврийн зардлыг оролцуулан тооцвол, 3.3-3.4 сая төгрөг болно. Монгол гэрийн экспортын бүх үйл явцад нийтдээ 30-44 өдөр болдог. Харин Монгол гэрийг экспортлоход гадаад улс орнуудын импортын шаардлагыг хангахад тусгайлсан зардал гардаггүй.

ДҮГНЭЛТ

Монгол гэр экспортлоход Ургамлын хортон шавж устгах ариутгал хийсэн акт, Гарал үүслийн гэрчилгээ, Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, экспортын гэрчилгээг бүрдүүлдэг. Монгол гэр экспортлох бичиг баримт бүрдүүлэхэд нийт зарцуулах хугацаа 120 цаг ба зардал 100,000₮ байна.

Хил гааль дээрх үйл явцад Экспортын гаалийн мэдүүлэг, Үнийн нэхэмжлэл, Баглаа боодлын тодорхойлолт, Тээврийн бичиг баримт /ачааны манифест, тээвэр төлсөн баримт/, Барааны гарал үүслийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ /ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ/, Гадаад худалдааны гэрээ, Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ гэсэн бичиг баримтуудыг бүрдүүлдэг. Хил гааль дээрх үйл явцад 3 өдөр, 38,200₮ төгрөг зарцуулна.

Монгол гэрийн экспорт нь ихэвчлэн Европын холбооны орнууд руу хийгдэж байгаа бөгөөд модон хийц гэдэг утгаараа ургамлын хорио цээрийн стандарт шаардлагыг ханган гэрчилгээжсэн байдаг. Цөөнгүй тооны тээврийн болон тээвэр зуучийн компаниуд экспортын бичиг баримтын бүрдүүлэлт, гаалийн мэдүүлэг, тээвэрлэлтийг хариуцан экспортыг гүйцэтгэж байна.

Экспортын үйл явц мэргэжлийн халдваргүйтгэл, ариутгалын компанид захиалга өгч ариутгал, халдваргүйтгэл хийлгэхээс эхэлдэг бөгөөд тус үйл явц нэг гэрийн мод, материалд дунджаар 1-2 цаг зарцуулдаг, үнийн хувьд 40-50 мянган төгрөг байна. Ийнхүү халдваргүйтгэл хийгдсэний дараа МХЕГ-т экспортын гэрчилгээ авах хүсэлтээ хүргүүлдэг бөгөөд тус гэрчилгээ дундаар 5 хоногт гардаг. Энэ хугацаанд гарал үүслийн гэрчилгээг МҮХАҮТ-аас авдаг бөгөөд 1-2 цаг зарцуулдаг.

Экспортын гэрчилгээ буюу ургамлын хорио цээрийн гэрчилгээг авсны дараа ачилт болон тээврийн бичиг баримтыг бүрдүүлдэг. Тээвэр хийх хугацаа дунджаар 35-55 хоног байдаг бөгөөд Европын холбооны “Шууд тээвэрлэлтийн нөхцөлийн шаардлага (EU) 2015/2446”-ийн дагуу замдаа задралгүй, шууд хүлээн авах орны хил дээр очиж буулгадаг.

МОНГОЛ ГЭР



Монгол гэр


**ЭКСПОРТЫН
БИЧИГ БАРИМТ
БҮРДҮҮЛЭЛТ**

- Худалдах, худалдан авах гэрээ
- Үнийн нэхэмжлэх
- Сав баглаа боодлын жагсаалт
- Ариутгал, халдваргүйтгэл хийлгэх
- Гарал үүслийн гэрчилгээ
- Ургамлын ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ
- Тээврийн бичиг баримт, ачааны манифест

120 цаг, 100,000₮



**ХИЛ ГААЛЬ
ДЭЭРХ ҮЙЛ
ЯВЦ**

- Ачаа тээшний зохицуулалт
- Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг
- Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт
- Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, лац, ломбо
- Дотоод тээвэрлэлт
- Хил дээрх гаалийн хяналт шалгалт

60 цаг, 38'200₮

 **ТЭЭВЭР**

- Тээвэрлэлтийн үйл явц Иж бүрэн тавилгатай Монгол гэр: 3'420'000₮ (ХБНГУ, Франц)
- Иж бүрэн тавилгатай Монгол гэр: 3'240'000₮ (Итали)

 **ТӨЛБӨР
ХҮЛЭЭН АВАХ**

- 120-240 цаг
- Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл: 7.71%
- Дундын банкны шимтгэл: 25-35\$

25840₮

Иж бүрэн тавилгатай нэг Монгол гэрт ногдох экспортын үйл явцын зардал .

Импортлогчийн хашаа хүртэлх хил гааль дээрх үйл явц:

ХБНГУ, Франц, Итали

Баримт бичгийн бүрдүүлэлт:

- Гарал үүслийн гэрчилгээ
- Ургамлын ариун цэврийн гэрчилгээ

Хил дээрх үйл явц, хяналт шалгалт:

- Single Administrative Document (SAD) гаалийн мэдүүлэг.



Иж бүрэн тавилгатай нэг Монгол гэрийн ХБНГУ руу экспортлох үйл явцын болон тээврийн зардал.

3,445,840₮

2.6.АРЬС ШИРЭН БҮТЭЭГДЭХҮҮН

2.6.1.Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц

Арьс ширэн бүтээгдэхүүн импортлогч орнуудын сав баглаа, боодолд тавигддаг стандартууд:

БНХАУ:

- ✚ БНХАУ-д импортын болон худалдаж байгаа бараа бүтээгдэхүүн нь CCC гэрчилгээг /China Compulsory Certification гэрчилгээг заавал авах ёстой.
- ✚ Сав баглаа боодлын материал нь хортой, аюултай байж болохгүй
- ✚ Амархан задарч, дахин боловсруулах боломжтой байх
- ✚ Модон сав баглаа боодол нь заавал IPPC тэмдэгтэй байх
- ✚ Шошгын мэдээллийг Хятад хэл дээр бичих
- ✚ Бүтээгдэхүүний нэр
- ✚ Хэмжээ
- ✚ Бүтээгдэхүүний найрлага, орц
- ✚ Үйлдвэрлэсэн огноо
- ✚ Үйлдвэрлэгчийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл
- ✚ Хадгалах заавар
- ✚ Бүтээгдэхүүний стандартын код
- ✚ Хадгалах нөхцөл
- ✚ Үндэсний стандартад заасан нэмэлт бүтээгдэхүүний ерөнхий нэр бичих
- ✚ Үйлдвэрлэлийн лицензийн дугаар

Европын холбооны улс:

- ✚ Шошго эсвэл тэмдэг нь удаан эдэлгээтэй, уншихад хялбар, харагдахуйц, хүртээмжтэй, шошгын хувьд найдвартай бэхлэгдсэн байх ёстой
- ✚ Бүтээгдэхүүнийг хэрэглэгчид санал болгож буй гишүүн улсын албан ёсны хэлээр бичнэ.
- ✚ Шошго дээрх мэдээлэл нь олон улсын стандартад заасан товчлолыг эс тооцвол товчлол агуулаагүй байх ёстой.
- ✚ Арьс ширэн бүтээгдэхүүнд төрөл бүрийн хориотой химийн бодис хэрэглэсэн бол хилээр оруулахыг хориглодог.
- ✚ Зөвшөөрөл аваагүй тохиолдолд биоцидын бүтээгдэхүүнийг нэхмэл болон арьс ширэн эдлэлд оруулахыг хориглоно.
- ✚ ЕХ-ны эко шошго эсвэл 'Цэцгийн лого' нь бүтээгдэхүүний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар хэрэглэгчдэд энгийн бөгөөд үнэн зөв зааварчилгаа өгөх зорилготой. Эко шошгын шалгуурыг бүтээгдэхүүний бүрийн бүлгүүд (жишээлбэл нэхмэл эдлэл, гутал, цэвэрлэгээний бүтээгдэхүүн, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, цаасан бүтээгдэхүүн гэх мэт) байдлаар тусгайлан тогтоодог.

Япон улс:

- ✚ Шошгод тухайн бүтээгдэхүүний орц найрлага, шинж чанар, хэрэглээ, хадгалалтын нөхцөл болон чанарын талаар бусад үзүүлэлтийг тусгана.
- ✚ Шошгод тусгах дээрх зүйлсийг, үйлдвэрлэгч, худалдагч, шошгын гэрээлэгчид бүгд анхаарч биелүүлэх ёстой.
- ✚ Арчилж цэвэрлэх зааврыг заавал оруулах
- ✚ Худалдааны тэмдэг
- ✚ Бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн улсын нэр бичих
- ✚ Шошгыг хэрэглэгчдэд харахад хялбар газарт байрлуулна
- ✚ Ойлгоход хялбар, оёдол доор оруулахгүй болохгүй байх ёстой
- ✚ Японы ачаа тээшний холбоо нь гадаргуугийнхаа 60% ба түүнээс дээш хэсгийг арьсаар хийсэн ачаа тээшний хаяг шошгыг Өрхийн барааны чанарын шошгын тухай хуулийн дагуу боловсруулдаг
- ✚ Шошгын урд талд
- ✚ нь арьсан эдлэлийн стандарт тэмдэг, ар талд нь арчилгааны зааварчилгааг тусгана.

- ✚ Японы гар цүнхний холбоо нь дээрх заалттай ижил мөрдөхийн зэрэгцээ гарал үүсэл улсын нэр байж болно гэж үздэг.
- ✚ Бүтээгдэхүүний аюулгүй байдлын SG /Safe Goods/ тэмдгийг авч бүтээгдэхүүнээ баталгаажуулах боломжтой ч заавал шаардахгүй.
- ✚ Япон эко арьсыг Японы Эко Арьс Стандарт (JES- *Japan Eco Leather Standard*) тэмдгийг авах боломжтой. /Заавал биш/ Япон эко арьс нь дараах шаардлагыг хангана.
- ✚ Цэвэр 100 хувь арьс байх
- ✚ Бохир ус болон хатуу хог хаягдлыг хууль ёсны дагуу зохицуулдаг үйлдвэрт үйлдвэрлэсэн
- ✚ Эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодис оруулахгүй байх
- ✚ Арьсны будаг үрэлтийн явцад бөх бат, стандартад нийцсэн байх

Арьс ширэн бүтээгдэхүүний хувьд импортлогч орнууд бүтээгдэхүүний чанар болон үйлдвэрлэлтийн боловсруулалтын явцад орсон будаг, химийн бодис, урвалж нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор аюулгүй байх, боловсруулалтын технологи нь эко байхыг онцгой анхаардаг байна. Тиймээс олон улсын арьс ширний зөвлөл /LWG/ Японы Эко Арьсны Стандарт (JES), Европын холбооны эко шошго (Flower logo) зэрэг стандартын шаардлагыг хангах нь экспортын үйл явцыг хөнгөвчлөхөөс гадна Монгол улсын гадаад зах зээлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх стратегийн ач холбогдолтой.

Арьс ширний боловсруулалтын түвшнээс хамаарч импортлогч орнуудад ХАА-н биржийн утга агуулга бүхий бичиг баримт шаарддаггүй байна.

Судалгааны объект болох “Мон-Ирээдүй” ХХК нь 2005 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд жилд 1.2 сая ширхэг бог, 300 мянган ширхэг бод малын арьс ширийг хагас боловсруулах, 180 мянган квадрат/метр гүн боловсруулсан арьс шир, 120 мянган квадрат/метр гүйцэд боловсруулсан шир савхи үйлдвэрлэх хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компани нь 2013 оноос эко-арьс шир, байгаль орчинд сөрөг нөлөөл багатай үйлдвэрлэлийн хамтарсан туршилтаар ургамлын гаралтай болон органик бүтэцтэй идээлэгчээр арьс гүн боловсруулах технологийг Монгол малын арьс ширний онцлогт тохируулан боловсруулах аргачлалыг гаргаж массын үйлдвэрлэлдээ нэвтрүүлсэн. Одоогоор Япон улсад гүн боловсруулалт хийсэн савхи, БНХАУ болон Итали улсад хагас боловсруулсан бүтээгдэхүүн экспортолж байна.

Монгол Улсад арьс ширэн бүтээгдэхүүний экспортын бүрдүүлэлтэд дараах бичиг баримтыг шаарддаг. Үүнд:

- ✚ Экспортын гаалийн мэдүүлэг
- ✚ Үнийн нэхэмжлэл
- ✚ Баглаа боодлын тодорхойлолт
- ✚ Тээврийн бичиг баримт /ачааны манифест, тээвэр төлсөн баримт/
- ✚ Тохирлын гэрчилгээ
- ✚ Барааны гарал үүслийн гэрчилгээ
- ✚ ХАА-н биржийн тодорхойлох бичиг
- ✚ Экспортын гэрчилгээ /мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ/
- ✚ Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ
- ✚ Гадаад худалдааны гэрээ
- ✚ Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ

Хүснэгт 69. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортод бүрдүүлж буй бичиг баримт

№	Бичиг баримтын жагсаалт	Бичиг баримтыг гаргах газар	Экспортлох улс орон		
			Япон	БНХАУ	Итали
1	Үнийн нэхэмжлэх	Импортлогч байгууллага	+	+	+
2	Худалдах, худалдах авах гэрээ	Импортлогч болон экспортлогч байгууллага	+	+	+
3	Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч байгууллага	+	+	+
4	Бүтээгдэхүүний дээжийн шинжилгээний бичиг	МХЕГ	+	+	+

5	Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээ	МХЕГ	+	+	+
6	ХАА-н биржийн бичиг	ХАА-н бирж	+	+	+
7	ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	МЭЕГ	+	+	+
8	Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ	+	+	+
9	Тохирлын гэрчилгээ	СХЗГ	+	+	+
10	Гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалт	ГЕГ	+	+	+
11	Ачааны манифест, Тээврийн бичиг баримт, TIR	Тээврийн болон Гаалийн зуучлагч байгууллага	+	+	+

Хүснэгт 70. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортлоход шаардлагатай гэрчилгээ, зөвшөөрлүүдийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт

Зөвшөөрөл, гэрчилгээ	Бүрдүүлэх материал
Бүтээгдэхүүний дээжийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт авах	<ul style="list-style-type: none"> - УБГ-ний хуулбар - Албан бичиг - Гарал үүслийн гэрчилгээ - Гадаад худалдааны гэрээ, гэрээний хавсралт - Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт - Бүтээгдэхүүний дээж / өнгө тус бүрээс 50 грамм / - Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
Тохирлын гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - УБГ-ний хуулбар - Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа - Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил
Гарал үүслийн гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - Албан хүсэлт бичгээр - УБГ-ний хуулбар - Худалдах, худалдан авах гэрээ эсхүл түүнтэй адилтгах баримт - Сав, баглаа боодлын мэдээлэл, тоо хэмжээ /Англи хэлээр/ - Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн - Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл - Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ - Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
ХАА-н биржийн тодорхойлолт	<ul style="list-style-type: none"> -Тодорхойлолт хүсэгчийн бичгээр гаргасан хүсэлт -Үйлчилгээний төлбөр төлсөн баримт
ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - УБГ-ний хуулбар - Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа - Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил
Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээ /Экспортын гэрчилгээ/	<ul style="list-style-type: none"> - Албан хүсэлт бичгээр - УБГ-ний хуулбар - Худалдах, худалдан авах гэрээ эсхүл түүнтэй адилтгах баримт - Сав, баглаа боодлын мэдээлэл, тоо хэмжээ /Англи хэлээр/ - Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн - Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл - Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ - Арьс шир боловсруулсан газрын тодорхойлолт, стандартын шинжилгээний дүн /шаардлагатай тохиолдолд/ - Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

“Мон-Ирээдүй” ХК нь арьс ширэн бүтээгдэхүүний онцлогоос хамаарч ХАА-н гарал үүсэлтэй хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортод холбогдох бүх бичиг баримтыг бүрдүүлэх шаардлагатай байдаг.

Хүснэгт 71. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын баримт, бичиг бүрдүүлэлтийн хугацаа, зардал

№	Алхам	Байгууллага	Өдөр							Зардал,₮
			1	2	3	4	5	6	7	
			24	48	72	96	120	144	168	
1	Худалдах, худалдан авах гэрээ	Экспортлогч, импортлогч	+							
2	Үнийн нэхэмжлэх	Экспортлогч	+							
3	Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч	+							
4	Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	+							
5	Дээжид шинжилгээ хийх	УМЭАЦТЛ	+	+						142,500₮
6	ХАА-н биржийн тодорхойлох бичиг	ХАА-н бирж		+						5,000-10,000₮
7	ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	МЭЕГ			+					12,500
8	Тохирлын гэрчилгээ	СХЗГ				5 цаг				79,000₮
9	Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ					4 цаг			47,500₮
10	Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, экспортын гэрчилгээ	МХЕГ					20 цаг			10,000₮
11	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч							3цаг	7,000
	Нийт								168 цаг	306'000₮

Хагас болон гүн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн хугацаа 168 цаг, зардалд нь 306,000₮ зарцуулсан байна. Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг авахад ХАА-н биржээр түүхий эд, бүтээгдэхүүн арилжаалагдсан тухай тодорхойлолт бичгийг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд тус бичгийг авахад гэрээний үнийн дүнгийн 0,2%-ийг төлдөг. Иймээс тухайн экспортлогч бүр гэрээний үнээс шалтгаалж ялгаатай төлбөрийг төлдөг бөгөөд тус зардал нь бичиг баримт бүрдүүлэлтийн зардалд зайлшгүй нэмэгдэж тооцогдох шаардлагатай.

Хагас боловсруулсан болон гүн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүнүүд нь ХАА-н гаралтай түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүний шаардлагатай бүх шинжилгээг хийлгэдэг тул хугацаа, зардлын хувьд ялгаагүй ижил байна.

Арьс ширэн бүтээгдэхүүнийг экспортлоход импортлогч орнуудын зүгээс “Хөдөө аж ахуйн биржийн тодорхойлолт” гэсэн бичиг баримт шаарддаггүй байна.

2.6.2.Хил, гааль дээрх үйл явц

Арьс ширэн бүтээгдэхүүний хадгалалтын ОУ-ын шаардлага:

Хагас болон гүн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүнийг ихэвчлэн тавиур дээр эсвэл өлгүүрт дүүжлэн хадгалдаг. Арьсны уян хатан чанар, зөөлөн байдал нь тодорхой чийгшилтэй холбоотой байдаг. Тиймээс арьсыг агааржуулалт сайтай, хэт хуурай биш, жигд 15-20 хэмийн температурт, харьцангуй чийгшил 50-70 хувьтай орчинд хадгална. Өндөр температураас зайлсхийх хэрэгтэй. Арьсны хөгшрөлтийг дэмждэг тул температурын хэлбэлзэл, чийгшлийн тогтмол өөрчлөлтөөс аль болох зайлсхийх хэрэгтэй. Хэрэв чийгшил хэт бага байвал арьс нь хэврэг болж, цаг хугацаа өнгөрөх тусам хатуурдаг. Хэрэв агаарын чийгшил хэт өндөр эсвэл агаарын солилцоо хангалтгүйгээс хөгц үүсэх эрсдэлтэй. Нарны шууд тусгалаас зайлсхийх нь арьсны өнгө будаг гандахаас хамгаална. Арьсыг цементэн шалан дээр шууд хадгалах, битүүмжилж болохгүй учир нь конденсац үүсэх эрсдэлтэй. Энэ нь толбо болон хөгц ургахад

хүргэдэг. Арьсыг тавиур дээр хадгалах үед хамгийн доод тавиур нь шалнаас дор хаяж 10 см байх ёстой бөгөөд арьсыг давхарлаж тавихдаа дээд тал нь 50-60 см хүртэл өндөртэй байх ёстой. Хэрэв овоолго хэт өндөр байвал доод талын арьс хүндийн даралтаас болж гэмтэх магадлалтай. Арьсыг үрчийж хэлбэрээ алдахаас хамгаалж хавтгай тэгш талбайд хадгална. Арьс ширний агуулахыг цэвэр байлгаж, хортон шавжгүй байх ёстой. Төрөл бүрийн өнгийн арьс ширийг хамтад нь хадгалахгүй өнгө шилжүүлэхгүйн тулд тус тусад нь хадгална.

Европын холбооны улсын хил, гааль дээрх бараа бүтээгдэхүүний хадгалалт:

Гаалийн агуулах: Холбооны бус орны барааг импортын татвар, бараа импортлохтой холбоотой бусад төлбөр, арилжааны бодлогыг ногдуулахгүйгээр гаалийн байгууллагын зөвшөөрлийн дагуу гаалийн агуулахын байранд хадгалж болно.

Чөлөөт бүс: Гишүүн орнууд гаалийн талбарын зарим хэсгийг чөлөөт бүс болгон ашиглаж болдог. Эдгээр нь Холбооны гаалийн нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлтэй бараа бүтээгдэхүүнийг импортын татвар, бусад хураамж (өөрөөр хэлбэл дотоод татвар), арилжааны бодлогын арга хэмжээнээс чөлөөлж, гаалийн шинэ эрх зүйн зохицуулалт гарах эсвэл дахин экспортлох хүртэл тусгайлсан үйл ажиллагааны талбар болгон ашиглах боломжтой. Энд барааг боловсруулах, дахин савлах гэх мэт энгийн үйлдлүүдийг хийх боломжтой.

Монгол Улсын арьс ширэн бүтээгдэхүүний экспортын хил гааль дээрх үйл явц дараах үе шаттай явагдана. Үүнд:

- ✚ Тээвэрлэгчид бараа тээвэрлүүлэх захиалга өгч тээвэрлэлтэд бэлдэх, тээврийн бичиг баримтыг бүрдүүлэх
- ✚ Гаальд мэдүүлэх
- ✚ Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч гаалийн бүсэд нэвтрэх
- ✚ Гааль бараа, тээврийн хэрэгслийг шалгах
- ✚ Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах
- ✚ Гаалийн болон бусад татвар хураамжийг барагдуулах
- ✚ Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
- ✚ Гааль болон Хилийн мэргэжлийн хяналтын алба бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, Хилийн мэргэжлийн хяналтын албанаас экспортын мэдэгдэл өгөх
- ✚ Гаалийн хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх

Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын хил, гааль дээрх үйл явцын хугацаа, зардлыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 72. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын хил, гааль дээрх үйл явцын дараалал, хугацаа, зардал

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг		Зардал ₮
			1	2	
			24	48	
1	Ачаа тээшний зохицуулалт	Тээвэрлэгч	1 цаг		15,000
2	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Гаалийн зуучлагч	1 цаг		
3	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гаалийн зуучлагч	5 цаг		7,000
4	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо, хил гаалийн шалгалт	Гааль, ХМХГ		5 цаг	7,000 1,000
	Нийт			48 цаг	30'000₮

Одоогоор “Мон-Ирээдүй” ХХК нь хагас боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүнийг БНХАУ болон Итали улс руу, гүн боловсруулалт хийсэн савхин бүтээгдэхүүнийг Япон улс руу тус тус экспортолж байна. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын хил гааль дээрх үйл явцад дунджаар 48 цаг, зардалд 30,000 төгрөг тус тус зарцуулдаг.

Өмнөх дэд бүлэгт тооцсончлон, бичиг баримт бүрдүүлэлтэд 168 цаг, 306,000₮ зарцуулдаг бөгөөд үүн дээр хил гаалийн хяналт шалгалтын цаг, зардлыг нэмбэл нийт 216 цаг, 336,000₮ зарцуулна.

2.6.3.Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц

Арьс ширэн бүтээгдэхүүний овор хэмжээ, шинж чанараас хамааран ихэнх тохиолдолд далайн болон төмөр замын чингэлгээр улс хооронд тээвэрлэгддэг байна. Дэлхийн хэмжээнд тээвэрлэлт, чингэлгийн салбарын аюулгүй байдлыг хангах зорилго бүхий Олон улсын CINC /Cargo Incident Notification System/ ашгийн бус байгууллагаас 2017 онд боловсруулсан “Арьс ширэн бүтээгдэхүүнийг чингэлэгт тээвэрлэх удирдамж” /Guidelines for the Carriage of Hides & Skins in Containers/-ийг дэлхийн хамгийн том тээвэрлэгч компаниуд мөрдөн ажиллаж байна. Энэ байгууллагын гишүүнээр дэлхийн тээврийн үйлчилгээний хамгийн том компаниуд болох COSCO shipping, CMA CGM, EMIRATES shipping line, MAERSK line, Evergreen зэрэг 16 компани гишүүнээр нэгдэж тус байгууллагын заавар зөвлөмжийг хэрэгжүүлдэг байна. Тус байгууллагаас арьс ширэн бүтээгдэхүүнийг чингэлгээр тээвэрлэх шаардлагыг дор дурдав.

Арьс ширэн бүтээгдэхүүнийг чингэлгээр тээвэрлэхэд тавигдах шаардлага:

Арьс ширэн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнээс хамаарч тээвэрлэлтийн төрлийг сонгоно. ОУ-ын түвшинд арьс ширэн бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд дараах шаардлагыг тавьдаг.

Боловсруулаагүй арьс:

1. Контейнер сонгох
 - Энгийн стандарт контейнер
 - Хөргүүртэй контейнер
2. Контейнерын бэлтгэл ажил
 - Доторлогоо хийх
 - Шалны аюулгүй байдлыг хангах
 - Үрдэс дэвсэх

Нойтон хөх арьс:

Зориулалтын тусгай саванд ороож тавиур дээр ачих тул тусгай тоноглол шаардахгүй.

Хатааж давсалсан арьс:

Далайн тээврээр тээвэрлэх нөхцөлд конденсаци үүсэх эрсдэлтэй тул чийгээс хамгаалах доторлогоог 30 см хийж, картон эсвэл чийг шингээгч сайн чанарын үрдсээр шалыг нийтэд нь жигд хучих шаардлагатай.

Өрөлт дүүргэлт:

Ачилтын үед ачаа хооронд үлдэх зайнаас хамаарч буулгах, хаалга онгойлгоход нурах болон бусад эрсдэлээс урьдчилан сэргийлж тохирох хаалганы хэсэгт хамгаалалтын бэхэлгээ тоноглолыг хийх

Захиалга өгөх, мэдэгдэх:

Тухайн усан онгоцны тээвэрлэлтэд бүтээгдэхүүний нэр төрөл, шинж чанарыг урьдчилан мэдэгдэх шаардлагатай. Энэ нь тухайн ачаатай контейнерыг хаана байршуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан зэрэг асуудлыг тээвэрлэгч анхаарахад чухал үүрэгтэй байдаг.

Гадаад улс орнууд руу экспорт хийх тээврийн зардлын тээврийн төрлөөс хамаарч ялгаатай байдлаар хүснэгтээр харуулав.

Хүснэгт 73. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын тээврийн зардал /улс орноор, тээврийн хэрэгслээр/

	Гадаад улс орнууд	Зарцуулах хугацаа		Зардал, ₮
1	Итали*:			
	- Авто тээвэр	20-25	240-600	16,200,000
	- Төмөр замын тээвэр	30-35	720-840	16,200,000
	- Агаарын тээвэр	9	216	25,650 төг/кг
- Далайн тээвэр	50-60	1200-1440	24,300,000	
2	Япон:			
	- Агаарын тээвэр	5-9	120-216	39,900 төг/кг
	- Далайн тээвэр	28-35	672-840	8,550,000

3	БНХАУ:			
	- Авто тээвэр	10-12	240-224	5,700,000
	- Төмөр замын тээвэр	10-15	240-360	8,550,000
	- Агаарын тээвэр	3-5	72-120	34,200 төг/кг

*- Агаарын тээврийг Инчэны транзит ашиглах нөхцөл

Төлбөр хүлээн авах үйл явц

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн нөхцөлийг харахад, ихэвчлэн бараагаа тээвэрлэн бүрэн хүлээлгэж өгсний дараа төлбөрөө авдаг бөгөөд зарим тохиолдолд тодорхой хэмжээний урьдчилгаа авдаг байна.

Төлбөрөө ийнхүү барааг бүрэн хүлээлгэн өгсний дараа авч байгаа нь хамгийн өндөр эрсдэлтэй боловч дараах шалтгаануудын улмаас ийнхүү төлбөрийн нөхцөлтэй гэрээ байгуулдаг гэж дүгнэсэн. Үүнд:

- ✚ Тухайн худалдан авагч тал нь урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн буюу бүрэн итгэлцэлтэй байдаг.
- ✚ Худалдах, худалдан авах гэрээг байгуулахдаа төлбөрийн нөхцөлийг тохирох боломж бага буюу, худалдан авагч талын тавьсан нөхцөл, шаардлагын дагуу гүйцэтгэдэг. Энэ нь тухайн аж ахуйн нэгжийн гадаад худалдааны туршлага, нэр хүнд болон бизнесийн эрсдэлтэй холбоотой байна.

Хүснэгт 74. Экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явц

№	Үйл ажиллагааны жагсаалт	Байгууллагын нэр
1	Гэрээ байгуулах /Онлайн худалдаа- CIF, харилцагч- FCA нөхцөлөөр гэрээ хийгдэнэ/	Импортлогч тал
2	Нэхэмжлэл - холбогдох бичиг баримтыг харилцагчаас авах	Импортлогч тал
3	Шаардлагатай зөвшөөрөл материал бүрдүүлэх	Экспортлогч тал
4	Төлбөр шилжүүлэх	Шилжүүлэгч болон дундын банк
	- Шилжүүлгээр - Бэлнээр - Аккредитив	
	Онлайн-CIF Харилцагч-FCA	

2.6.4. Экспортын замын зураглал

Монгол улсын арьс ширний экспортын бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль дээрх хяналт, шалгалт, тээвэр, төлбөр хүлээн авах үйл явцыг судалж арьс ширний экспортын үйл явцын шат дарааллыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 75. Хагас болон гүн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүний экспортын үйл явцын шат дараалал

	Алхмууд	Олгох байгууллага	Тайлбар
Бичиг баримт бүрдүүлэлт	Шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	Экспортлогч нь НМХГ-т шинжилгээ хийлгүүлэх хүсэлт гаргана. НМХГ-аас хяналтын байцаагч томилох бөгөөд тус байцаагч ямар үзүүлэлтээр шинжилгээ хийлгүүлэх тухай мэдэгдэл бичиж өгнө.
	Шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори/ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	МХЕГ-ын байцаагчийн гаргасан мэдэгдлийн дагуу дээжид шинжилгээ хийн, шинжилгээний дүнг экспортлогчид өгнө. Шинжилгээний төрлөөс хамаарна, төрөл бүр өөр өөр тарифтай,
	Тохирлын гэрчилгээ	Стандарт хэмжил зүйн газар	Бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ авах хүсэлтийг СХЗГ-т өгөх бөгөөд энэхүү гэрчилгээ нь экспортын бүтээгдэхүүн холбогдох стандартыг хангасан болохыг баталгаажуулна.
	Бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ авах	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Гарал үүслийн гэрчилгээ нь аль улс оронд экспорт хийгдэхээс шалтгаалан өөр формоор гарна.
	Мал эмнэлэг, ариун	МХЕГ	Экспортын бүтээгдэхүүнд "Мал эмнэлэг, ариун цэврийн

	цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ		гэрчилгээ буюу экспортын гэрчилгээ олгоно.
	ХАА-н биржийн тодорхойлох бичиг	ХАА-н биржийн газар	Биржийн арилжаагаар арилжигдсан бараа, бүтээгдэхүүний ангилал, нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт үнийн дүнг илэрхийлсэн биржийн албан ёсны тодорхойлолт
	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ	МЭЕГ	Мал, амьтны эрүүл мэнд, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийг ОУ-д баталгаажуулсан гэрчилгээ
Гаалийн бүрдүүлэлт	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч байгууллага	Тээвэрлэгч байгууллагатай тохирон тээврийн бичиг баримтыг бүрдүүлнэ.
	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Тээвэрлэгч байгууллага, Гаалийн зуучлагч	Гаалийн цахим сүлжээнд барааны мэдүүлгийг шивж оруулан илгээнэ.
	Гаалийн хяналт шалгалт бараа, тээврийн хэрэгсэл	Улаанбаатар хот дахь гаалийн газар	Томилогдсон хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийг шалгах
	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Улаанбаатар хот дахь гаалийн газар	- Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, хураамжийг барагдуулах, - Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо	Гааль, Хилийн мэргэжлийн хяналт	- Гааль болон Хилийн мэргэжлийн хяналт бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, хилийн мэргэжлийн хяналтын байцаагч экспортын мэдэгдэл өгөх
	Тээвэрлэлт	Тээвэрлэгч байгууллага	Тээвэр автомашин, агаарын тээвэр
	Төлбөр хүлээн авах	Худалдан авагч	Барааг бүрэн хүлээн авсны дараа

Хүснэгт 76. Япон улсаас арьс ширэн бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал

	Хугацаа \цагаар\	Зардал, \$
Баримт бичгийн бүрдүүлэлт		
Худалдан авалтын гэрээ		
Төлбөрийн нэхэмжлэл		
Сав баглаа боодлын жагсаалт		
Ачааны бичиг баримт эх хувь	60	90
Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ /SOLAS certificate/		
Бусад байгууллагын хяналт, шалгалт бичиг баримт бүрдүүлэлт	0	0
Хил дээрх үйл явц, хяналт шалгалт		
Гаалийн импортын мэдүүлэг болон хяналт шалгалт	68.5	185
Гаалийн татвар /ЕРА-ийн хүрээнд татваргүй/		
Бусад байгууллагын бичиг баримтын хяналт, шалгалт		
Төлбөр хүлээн авах үйл явц		
Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл /1 JPY = 0.00907 USD/		68.04 (10.5%)
Дундын банкны шимтгэл		
• 5 сая хүртэл – 5,000 иен		
• 5 саяас дээш – 0.10%		
Дотоод тээврийн зардал /from Yokohama port to Tokyo/	93	380
Нийт	221.5	655\$

Эх үүсвэр: <https://remittanceprices.worldbank.org/>

Эх үүсвэр: <https://www.doingbusiness.org/>

Япон болон Монгол улсын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд Монгол улсаас экспортолж буй гүн боловсруулсан савхин бүтээгдэхүүнд импортын татвар тэглэж тарифын хөнгөлөлтөд хамрагдаж байгаа давуу тал байна. Харин Азийн орнуудтай худалдан авалтын гэрээг DAP нөхцөлөөр хийж тухайн барааны холбогдох даатгал тээврийн зардлыг экспортлогч тал хариуцахаас гадна импортлогч нь бараагаа хүлээн авсны дараа төлбөрийг экспортлогч талд шилжүүлж байна. Мөн Япон улсын хувьд улс хоорондын шилжүүлгийн шимтгэл өндөр, хугацаа урт болох нь судалгаанаас харагдлаа.

Хүснэгт 77. БНХАУ-аас арьс ширэн бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал

	Хугацаа \цагаар\	Зардал, \$
Баримт бичгийн бүрдүүлэлт		
Худалдан авалтын гэрээ	48	35
Төлбөрийн нэхэмжлэх		
Сав баглаа боодлын жагсаалт		
Ачааны бичиг баримт эх хувь		
Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ		
Ачааны бичиг баримт, мэдээллийн электрон хувилбар		
Хил, гааль дээрх үйл явц		
Гаалийн импортын мэдүүлэг, хяналт шалгалт	33	220
Терминал дээрх холбогдох үйл явцууд		
Ачааны бичиг баримт, мэдээллийн электрон хувилбар		
Гаалийн татварын хувь (MFN ангиллаар 6 хувь)		
Дотоод тээврийн зардал /Tianjin port/	40	395
Төлбөр хүлээн авах үйл явц		
Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл /1 CNY = 0.154250 USD/		7.71%
Дундын банкны шимтгэл		25-35\$
Нийт	121	650\$

Эх үүсвэр: <https://www.doingbusiness.org/>

<https://medium.com/@sticpay/international-money-transfer-policy-china>

БНХАУ-импортлогдож буй бүх төрлийн бараа бүтээгдэхүүн 3 төрлийн татвар төлдөг. Үүнд:

1. Гаалийн татвар
2. Нэмүү өртгийн татвар
3. Хэрэглээний татвар

БНХАУ-ын импортын бараа бүтээгдэхүүнд ногдуулдаг татварын 6 ангилал байдаг бөгөөд Монгол улсын хувьд MFN ангилалд багтаж хагас боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүний импортын татварт 6 хувь, НӨАТ-д 13 хувийг тус тус төлдөг.

Харин Азийн орнуудтай DAP нөхцөлөөр гэрээг хийж тухайн барааны даатгал тээврийн зардлыг экспортлогч тал хариуцахаас гадна импортлогч тал бараагаа хүлээн авсны дараа төлбөрийг экспортлогч талд төлбөрөө шилжүүлдэг. Хятад улсыг хувьд газар зүйн байршил ойр давуу талтайгаас тээвэр болон төлбөрийн шилжүүлгийн хугацаа бусад орноос бага байна.

Хүснэгт 78. Итали улсаас арьс ширэн бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал

	Хугацаа \цагаар\	Зардал, ₮
Баримт бичгийн бүрдүүлэлт		
Төлбөрийн нэхэмжлэх	1	0
Европын холбооны нутаг дэвсгэрт хийгдэх буй бараа, бүтээгдэхүүний урсгалын гаалийн мэдүүлгийг системд бүртгүүлэх /Intrastat/		
Сав баглаа боодлын жагсаалт		
Улс хоорондын <i>авто замаар</i> ачаа тээвэрлэх <i>гэрээний тухай Конвенц</i> /CMR/-ийн шаардлага бүхий тээврийн бичиг баримт		
Хил, гааль дээрх үйл явц		
Гаалийн импортын мэдүүлэг, хяналт шалгалт	0	0
Терминал дээрх холбогдох үйл явцууд		
Гаалийн татвар /GSP+ нөхцөлөөр импортын татвар 0% /		
Ачаа тээврийн бичиг баримт шалгах		
Дотоод тээврийн зардал /Italy-Austria port/	12	1225
Төлбөр хүлээн авах үйл явц		
Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл	24-96 цаг (1-4 өдөр)	4.76%
Дундын банкны шимтгэл		20-35\$
Нийт	73	1225\$

Эх үүсвэр: <https://remittanceprices.worldbank.org>

Европын холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем буюу /GSP+/- ийн хүрээнд Монгол Улсаас гарал үүсэлтэй 7200 бараа бүтээгдэхүүнд гаалийн тарифын хөнгөлөлт эдлэх бүтээгдэхүүний жагсаалтад хагас боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүн багтсан байна.

Хүснэгт 79. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын үйл явц дахь зардлын харьцуулсан тооцоо

Үзүүлэлт	БНХАУ	Япон	Итали
Монгол дахь экспортын үйл явцад нийт зарцуулах зардал, ₮	336,000	336,000	336,000
Гадаад тээвэр, ₮	Төмөр зам 8,550,000	Далайн тээвэр 8,550,000	Авто тээвэр 17,100,000
Дотоод тээвэр, ₮	1,125,750	1,083,000	3,491,250
Гадаад орны импортын шаардлага хангахтай холбоотой нэмэгдсэн зардал, ₮	726,750	783,750	0
Нийт зардал, ₮	10,738,500	10,752,750	20,927,250
Нэгжид ногдох зардал (нэг тонн), ₮	429,540	430,110	837,090

Дээрх харьцуулсан судалгаанд импортын төлбөрийг шилжүүлэхтэй холбогдон гарах төлбөрийн зардлыг оруулаагүй. Учир нь тухайн улс хоорондын шилжүүлэг хийхэд оролцож буй дамжуулагч банкны тоо болон төлбөрийн дүнгээс хамаарч шимтгэлийн хувиар тооцсон үнийн дүн ялгаатай.

Дэлхийн банкнаас 2008 оноос эхлэн дэлхий даяар улс хоорондын мөнгөн гуйвуулгын үнийг (RPW) газарзүйн бүх бүс нутгуудын хянадаг судалгааны улирал тутмын тайланг гаргадаг болсон. 2021 оны 1 дүгээр улирлын тайлангаар дэлхийн дундаж шимтгэлийн хувь 6.38 хувь байгааг бөгөөд энэхүү зардлыг 5 хувь хүртэл бууруулахаар G20 улсуудын оролцоо бүхий Засгийн газар, үйлчилгээ үзүүлэгчид болон бусад оролцогч талууд түншлэлийн хүрээнд хамтран ажилладаг.

Дэлхийн мөнгөн урсгалын шилжүүлэгч орнуудын ихэнх нь G8-ын орнууд байдаг бөгөөд шилжүүлгийн шимтгэлийн хамгийн бага 1 хувьтай ОХУ, дараагийнх нь 4.76 хувьтай Итали улс байхад хамгийн өндөр буюу 10.5 хувьтай нь Япон улс байна.

Зураг 28. Арьс ширний экспортын замын зураглал



Хагас болон гүн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүний экспортын үйл явцад төрийн болон хувийн хэвшлийн 9 байгууллага оролцож, үйл явцад 168 цаг, зардалд 336,000 төгрөг тус тус зарцуулж байна. Арьс ширэн хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг ихэвчлэн авто машин, галт тэргээр тээвэрлэж байгаа бөгөөд Европ руу олон улсын TIR горимтой авто машинаар тээвэрлэн экспортлох нь хугацаа хэмнэх давуу талтай.

АРЬС ШИРЭН БҮТЭЭГДЭХҮҮН



**ЭКСПОРТЫН
БИЧИГ БАРИМТ
БҮРДҮҮЛЭЛТ**

**ХИЛ ГААЛЬ
ДЭЭРХ ҮЙЛ
ЯВЦ**

ТЭЭВЭР

**ТӨЛБӨР
ХҮЛЭЭН АВАХ**

**Арьс ширэн
бүтээгдэхүүн**

- Худалдах, худалдан авах гэрээ
- Үнийн нэхэмжлэх
- Сав баглаа боодлын жагсаалт
- Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт
- Дээжид шинжилгээ хийх
- ХАА-н биржийн тодорхойлох бичиг
- ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ
- Тохирлын гэрчилгээ
- Гарал үүслийн гэрчилгээ
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, экспортын гэрчилгээ
- Тээврийн бичиг баримт, Ачааны манифест

168 цаг, 306'000₮

- Ачаа тээшний зохицуулалт
- Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг
- Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт
- Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо, хил гаалийн шалгалт
- Ачаа тээшний зохицуулалт

48 цаг, 30,000₮

- Төмөр зам, далайн тээвэр: 342'000₮ /тонн (БНХАУ, Япон)
- Авто тээвэр: 684'000₮ /тонн (Итали)

- 120-240 цаг
- Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл: 7.71%
- Дундын банкны шимтгэл: 25-35\$

13440₮/тн

Нэг тонн арьс ширэн бүтээгдэхүүнд ногдох экспортын үйл явцын зардал.

Импортлогчийн хашаа хүртэлх хил гааль дээрх үйл явц:

Япон


Баримт бичгийн бүрдүүлэлт:
 - Худалдан авалтын гэрээ
 - Төлбөрийн нэхэмжлэл
 - Сав баглаа боодлын жагсаалт
 - Ачааны бичиг баримт эх хувь
 - Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ /SOLAS certificate/
 - Бичиг баримт бүрдүүлэлтийн хяналт, шалгалт
Хил дээрх үйл явц, хяналт шалгалт:
 - Гаалийн импортын мэдүүлэг болон хяналт шалгалт
 - Гаалийн татвар /EPA-ийн хүрээнд татваргүй/
 - Бичиг баримтын хяналт, шалгалт

БНХАУ

Баримт бичгийн бүрдүүлэлт:
 - Худалдан авалтын гэрээ
 - Төлбөрийн нэхэмжлэх
 - Сав баглаа боодлын жагсаалт
 - Ачааны бичиг баримт эх хувь
 - Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ
 - Ачааны бичиг баримт, мэдээллийн электрон хувилбар
Хил дээрх үйл явц, хяналт шалгалт:
 - Гаалийн импортын мэдүүлэг, хяналт шалгалт
 - Терминал дээрх холбогдох үйл явцууд
 - Ачааны бичиг баримт, мэдээллийн электрон хувилбар
 - Гаалийн татварын хувь (MFN ангиллаар 6 хувь)
 - Дотоод тээврийн зардал / Tianjin port/

Итали

Баримт бичгийн бүрдүүлэлт:
 - Төлбөрийн нэхэмжлэх
 - Европын холбооны нутаг дэвсгэрт хийгдэх буй бараа, бүтээгдэхүүний урсгалын гаалийн мэдүүлгийг системд бүртгүүлэх /Intrastat/
 - Сав баглаа боодлын жагсаалт
 - Улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай Конвенц /CMR/-ийн шаардлага бүхий тээврийн бичиг баримт
Хил дээрх үйл явц, хяналт шалгалт:
 - Гаалийн импортын мэдүүлэг, хяналт шалгалт
 - Терминал дээрх холбогдох үйл явцууд
 - Гаалийн татвар /GSP+ нөхцөлөөр импортын татвар 0% /
 - Ачаа тээврийн бичиг баримт шалгах
 - Дотоод тээврийн зардал / Italy-Austria port/



● Нэг тонн арьс ширэн бүтээгдэхүүнд ногдох экспортын үйл явцын болон тээврийн зардал (төг)

Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын замын зураглалыг хагас боловсруулсан, гүн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүн гэсэн ангиллаар бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль дээрх үйл явц, төлбөр хүлээн авах үйл явцыг тус бүрд нь судалж эцэст нь экспортын замын зураглалыг боловсруулж нэгтгэн дүгнэв.

Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явцыг судлахдаа нэг талаас Монгол Улсаас экспортын бүтээгдэхүүнд шаардагдаж буй бичиг баримтын жагсаалтыг гаргаж тэдгээрт шаардагдах цаг хугацаа, зардлыг тооцсон. Нөгөө талаас, арьс ширэн бүтээгдэхүүний импортлогч гол улс орнууд болох БНХАУ, Итали, Япон улсад экспортлоход шаардагддаг чанар, стандарттай уялдуулан судаллаа.

Арьс ширэн бүтээгдэхүүнийг экспортлоход Экспортын гаалийн мэдүүлэг, Үнийн нэхэмжлэл, Баглаа боодлын тодорхойлолт, Тээврийн бичиг баримт /ачааны манифест, тээвэр төлсөн баримт/, Тохирлын гэрчилгээ, Барааны гарал үүслийн гэрчилгээ, ХАА-н биржийн тодорхойлох бичиг, Экспортын гэрчилгээ /мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ/, Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, Гадаад худалдааны гэрээ, Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ гэсэн бичиг баримтуудыг Монголын талаас шаардаж байна. Эдгээр бичиг баримтуудыг бүрдүүлэхэд тус бүрдээ 6-аас дээш бичиг баримтуудыг бүрдүүлдэг бөгөөд бичиг баримтуудын давхардлыг To Be шинжилгээнд нарийвчлан тооцсон болно.

Хагас боловсруулсан болон гүн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүний экспортын бичиг баримтууд нь “ХАА-н гаралтай түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн”-ий ангилалд багтаж ижил төрлийн шинжилгээ шаардлагатай тул эдгээр хоёр бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлт, шаардагдах цаг хугацаа, зардал нь адил байна. Хагас болон гүн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлтэд 168 цаг, 306,000₮ зарцуулж байгааг судалгаагаар тогтоов. Уг үнийн дүн нь Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг авахад “ХАА-н биржээр түүхий эд, бүтээгдэхүүн арилжаалагдсан тухай тодорхойлолт”-ыг авахад төлдөг төлбөрөөс хамаарч ялгаатай байж болно. Учир нь уг тодорхойлолтыг авахад гэрээний үнийн дүнгийн 0,2%-ийн төлбөрийг төлдөг юм.

Япон, БНХАУ, Итали улсуудын импортын шаардлагаас харахад, “Хөдөө аж ахуйн биржийн тодорхойлолт” гэсэн бичиг баримт шаарддаггүй байна.

Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын хил гааль дээрх үйл явц нь Тээвэрлэгчид бараа тээвэрлүүлэх захиалга өгч тээвэрлэлтэд бэлдэх, тээврийн бичиг баримтыг бүрдүүлэх, Гаальд мэдүүлэх, Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч гаалийн бүсэд нэвтрэх, Гааль бараа, тээврийн хэрэгслийг шалгах, Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, Гаалийн болон бусад татвар хураамжийг барагдуулах, Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах, Гааль болон Хилийн мэргэжлийн хяналтын алба бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, Хилийн мэргэжлийн хяналтын албанаас экспортын мэдэгдэл өгөх, Гаалийн хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх үйл явцаас бүрдэнэ. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын хил гааль дээрх үйл явцад дунджаар 48 цаг, зардалд 30,000 төгрөгийг зарцуулдаг. Эндээс, бичиг баримт бүрдүүлэлт (168 цаг, 306,000₮), хил гаалийн хяналт шалгалт (48 цаг, 30,000₮)-ын зардлыг нэмбэл нийт 216 цаг, 336,000₮ зарцуулна.

Арьс ширний экспортын төлбөр төлөлт, тээвэрлэлтийн үйл явцыг судлахад, арьс ширний экспортод төмөр зам, автозам, агаар, далайн тээвэр гэсэн бүх төрлийн тээврийн хэрэгслийг ашигладаг. Эдгээр тээврийн зардлыг улс орон болгоноор, тээврийн хэрэгслийн төрөл тус бүрээр судалж судалгааны тайланд оруулав. Төлбөрийн шилжүүлгийн шимтгэлд улс орон бүрээр ялгаатай боловч дунджаар 24-96 цаг (1-4 өдөр) зарцуулж 4.76% төлдөг бол Дундын банкны шимтгэлд 20-35\$ төлж байна.

Гадаад улс орнуудын импортын шаардлагыг хангахтай холбоотой болон гадаад улсын импортлогчийн хашаанд хүртэл зардлын шинжилгээг гүйцэтгэхэд, Япон улсын хувьд 221.5 цаг, 655\$, БНХАУ-ын хувьд 121 цаг, 650\$, Итали улсын хувьд 73 цаг, 1225\$ зарцуулдаг.

Арьс ширэн бүтээгдэхүүнийг экспортлоход Монголын талд зарцуулах зардал нь улс орон бүрээр ялгаатай бус, ижил бөгөөд энэ зардал дээр гадаад, дотоодын тээвэр, гадаад улс орнуудын импортын шаардлагыг хангахтай холбоотой нэмэгдэл зардлуудыг нэмж нэг тонн тутамд ногдох зардлыг тооцов. Нийтлэг ашиглаж буй тээврийн хэрэгслийг сонгож дундаж өртгийг тооцоход, нэг тонн арьс ширэн бүтээгдэхүүний экспортын үйл явцад зарцуулах дундаж өртөг БНХАУ руу экспорт хийхэд 429.5 мянган төгрөг, Япон улс руу 430.1 мянган төгрөг, Итали улс руу 871.0 мянган төгрөг байна.

2.7.НООС, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН

2.7.1.Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц

Дэлхийн органик нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний стандарт **“Global Organic Textile Standard (GOTS)”** Герман улсаас гаралтай бөгөөд сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн олон улсын чанарын гэрчилгээ болдог. Тэрээр зөвхөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл төдийгүй, түүхий эдийн нийлүүлэлтийг мөн багтаан авч үздэг байна. Гэвч тус гэрчилгээжилт нь зөвхөн биологийн хяналт бүхий баталгаажсан мал, амьтны гаралтай түүхий эдэд хамаарна (GGC4 2017).

Швейцар улсад Блюсайн (Bluesign), **ОЕКО-ТЕХ** зэрэг сертификатуудыг олгодог бөгөөд ялангуяа, ОЕКО-ТЕХ100 сертификатыг Монголын нөхцөлд тохируулан нэвтрүүлэх боломжтой байна. “ОЕКО-ТЕХ” гэрчилгээжилт нь фермерийн үйлдвэрлэсэн түүхий эд материалаас эхлээд угаасан болон самнасан ноос, ноолуур, эцсийн бүтээгдэхүүн хүртэлх бүх шат дамжлагад чанарын баталгаа олгодог.

Organización Internacional Agropecuaria S.A. (OIA) нь фермерийн аж ахуйн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн ба нийлүүлэлтийн сүлжээнд чанарын баталгаа өгдөг.

ASTM буюу **“American Society for Testing and Materials”** нь олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, хувцас хэрэгсэл, бөс даавуу, нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүн болон мөн бусад төрлийн бараа бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэл, үйлчилгээ, түүхий эдэд стандарт тогтоодог байгууллага юм. Тус байгууллагын стандартууд нь АНУ-ын хувцас хэрэгсэл, размер, хэмжээ зэрэг бүхий л хүрээнд нарийн тусгагдсан байдаг.

IVN буюу **“International Association of Natural Textile Industry”** нь ХБНГУ-аас гаралтай 2001 оноос хойш тогтвортой арьс ширний стандартыг боловсруулахад оролцож ирсэн. Чанарын тамга **NATURLEDER IVN ZERTIFIZIERT** нь шошготой бүтээгдэхүүний экологи, чанарын өндөр түвшинг баталгаажуулдаг.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний салбарын тухайд энэ салбарт Монгол улсын хэмжээнд 130-аад техникийн зохицуулалт, стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр стандартууд нь тухайн түүхий эд бүрийн онцлог шинжид тохируулан гаргасан техникийн шаардлагын дагуу зохицуулагдсан.

Хаан ширхэгт. Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн олон улсын төслийн хүрээнд “Монголын хаан ширхэгт” тэмдгийг гаргаж хэрэгжүүлж эхлээд байна.

Судалгааны объект болох “Говь” ХК нь ямааны ноолуурт цогц боловсруулалт хийдэг үндэсний хамгийн том үйлдвэрлэгч бөгөөд жилд 1,100 тонн түүхий ноолуур боловсруулах, 820 тонн ээрмэл болон нарийн ээрмэл утас хийх 1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн 1,000,000 метр нэхмэл бүтээгдэхүүн 162,000 ширхэг ноолууран пальто болон пиджак үйлдвэрлэх хүчин чадалтай үйл ажиллагаа явуулж байна. Одоогоор Улаанбаатар хотод 3, Дархан хотод 1 гадаад цахим дэлгүүр 8, салбар дэлгүүр 1, 41 франчайз дэлгүүртэй дотоод, гадаадын зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулж байна.

Тус компани 2019 онд 210 тэрбум төгрөгийн борлуулалт хийж үүнээс гадаад борлуулалт 75 тэрбум төгрөг, дотоод борлуулалт 135 тэрбум төгрөг, 2020 онд нийт 117,1 тэрбум төгрөгийн

борлуулалт хийж үүнээс гадаад борлуулалт 36 тэрбум төгрөг, дотоод борлуулалт 49,5 тэрбум төгрөг байна. Энд цар тахлын хүчин зүйлийн нөлөөлөл бага үе буюу 2019 оны байдлаар “Говь” ХК нь Монгол улсын ноолууран бэлэн бүтээгдэхүүний экспортын орлогын 68 хувийг (28,1/41,2 сая доллар) дангаар эзэлж байгаа нь ноос, ноолуурын салбарын гадаад худалдааны үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал болон цаашдын хөгжлийн төлөв байдлыг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэж үзэн судалгааны объектоор сонгосон болно.

“Говь” ХК нь ноолуурыг гүн боловсруулалт хийж нэхмэл, сүлжмэл, оёмол эцсийн бүтээгдэхүүн болон топс экспортолж байна. Экспортолж буй бүтээгдэхүүний судалгааг ноолууран эцсийн бүтээгдэхүүн, топс гэсэн 2 төрөл дээр авч үзсэн.

Хүснэгт 80. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын бичиг баримтын бүрдүүлэлт

№	Бичиг баримтын жагсаалт	Бичиг баримтыг олгох газар	Экспортлох улс орон				
			ОХУ	БНХАУ	Европын орнууд	Азийн орнууд	АНУ
1	Үнийн нэхэмжлэх	Импортлогч байгууллага	+	+	+	+	+
2	Худалдах, худалдах авах гэрээ	Импортлогч болон экспортлогч байгууллага	+	+	+	+	+
3	Сав баглаа, боодлын жагсаалт	Экспортлогч байгууллага	+	+	+	+	+
4	Бүтээгдэхүүний дээжийн шинжилгээний дүгнэлт	МХЕГ	+	+	+	+	+
5	Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ	МХЕГ	+	+	+	+	+
6	Биржийн тодорхойлолт	ХАА-н бирж	+	+	+	+	+
7	ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	МЭЭГ /2020.04.01/	+	+	+	+	+
8	Гарал үүслийн гэрчилгээ	МХАУТ	+	+	+	+	+
9	Тохирлын гэрчилгээ	СХЗГ	+	+	+	+	+
10	Гаалийн бүрдүүлэлт хийлгэх	ГЕГ	+	+	+	+	+
11	Ачааны манифест, Тээврийн бичиг баримт	Тээвэр, гаалийн зуучлагч байгууллага	+	+	+	+	+

Тайлбар: БТКУС код: 51 бүлэг -Бөмбөгөн ноолуур, 61, 62, 65-бүлэг ямааны ноолууран бүтээгдэхүүн

Хүснэгт 81. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортлоход шаардлагатай зөвшөөрөл, гэрчилгээг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт

Зөвшөөрөл, гэрчилгээ	Бүрдүүлэх материал
Итгэмжлэгдсэн лабораторийн бүтээгдэхүүний дээжийн шинжилгээний дүгнэлт авах	<ul style="list-style-type: none"> - УБГ-ний хуулбар - Албан бичиг - Гарал үүслийн гэрчилгээ - Гадаад худалдааны гэрээ, гэрээний хавсралт - Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт - Бүтээгдэхүүний дээж / өнгө тус бүрээс 50 грамм / - Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
Тохирлын гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - УБГ-ний хуулбар - Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилгах баримт бичиг - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа - Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил

Гарал үүслийн гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - Албан хүсэлт бичгээр - УБГ-ний хуулбар - Худалдах, худалдан авах гэрээ эсхүл түүнтэй адилтгах баримт - Сав, баглаа боодлын мэдээлэл, тоо хэмжээ /Англи хэлээр/ - Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн - Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл - Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ - Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
ХАА-н биржийн тодорхойлолт	<ul style="list-style-type: none"> -Тодорхойлолт хүсэгчийн бичгээр гаргасан хүсэлт -Үйлчилгээний төлбөр төлсөн баримт
ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> - УБГ-ний хуулбар - Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт - Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа - Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил
Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээ / Экспортын гэрчилгээ/	<ul style="list-style-type: none"> - Албан хүсэлт бичгээр - УБГ-ний хуулбар - Худалдах, худалдан авах гэрээ эсхүл түүнтэй адилтгах баримт - Сав, баглаа боодлын мэдээлэл, тоо хэмжээ /Англи хэлээр/ - Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн - Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл - Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ - Ноос, ноолуурыг боловсруулсан газрын тодорхойлолт, стандартын шинжилгээний дүн /шаардлагатай тохиолдолд/ - Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

Хүснэгт 82. Ноолууран эцсийн бүтээгдэхүүн экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн хугацаа, зардал

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг							Зардал, ₮	
			1	2	3	4	5	6	7		
			24	48	72	96	120	144	168		
1	Худалдах, худалдан авах гэрээ	Экспортлогч, импортлогч	+								
2	Үнийн нэхэмжлэх	Экспортлогч	+								
3	Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч	+								
4	Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	+								
5	Дээжид шинжилгээ хийх	УМЭАЦТЛ	+	+	+						37,500₮
6	Тохирлын гэрчилгээ	СХЗГ				2 цаг					79,000₮
7	Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ				2 цаг					162,500₮
8	Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, экспортын гэрчилгээ	МХЕГ					+	+	+		10,000₮
9	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч								3цаг	7,000
	Нийт									168 цаг	296,000₮

Тайлбар: Дээрх тооцоонд бичиг баримтын бүрдүүлэлтэд шаардагдах өдрийг Дэлхийн банкны судалгааны аргачлалаар нэв өдрийг 24 цагт шилжүүлэн тооцсон болно.

Ноолууран эцсийн бүтээгдэхүүн экспортлох бичиг баримт бүрдүүлэхэд нийт зарцуулах хугацаа 168 цаг, зардал нь 296,000₮ байна.

Монгол улс 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн (ЕХ)-ны REX буюу “Бүртгэгдсэн экспортлогчдын систем”-ийг нэвтрүүлсэнтэй холбогдуулан аж ахуйн нэгжүүдийг бүртгүүлэх, бүртгэлийн санг хөтлөх үйл ажиллагааг МҮХАҮТ гүйцэтгэж байна. Харин ЕХ-ны гааль, татварын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу хийгдэх, хяналт шалгалттай холбоотой үйл ажиллагааг

Гаалийн ерөнхий газар, REX буюу бүртгэгдсэн экспортлогчдын бүртгэлтэй холбоотой мэдээллээ ГХЯ, ГЕГ, МҮХАҮТ хооронд харилцан солилцож REX буюу бүртгэгдсэн экспортлогчдын системийг ашиглан экспортлогч, хувь хүн, аж ахуйн нэгж, тээвэр зуучийн байгууллагууд бараа бүтээгдэхүүний гарал үүслийг бие даан мэдүүлэх боломжтой.

“Говь” ХК-ны хувьд Европын орнуудад бүтээгдэхүүн экспортлохдоо гарал үүслийн бичгийг REX-ийн дугаарыг ашиглаж байгаа нь гарал үүслийн гэрчилгээний авахад зарцуулдаг бичиг баримт бүрдүүлэлтийн зардал болон хугацааг хэмнэх давуу талтай.

Зураг 29. Ноолууран эцсийн бүтээгдэхүүний экспортын үйл явц

Үйл явцын үе шат:



Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаалаар, “Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”-ыг шинэчлэн баталснаар хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд болох ямааны ноолуур, хонь, тэмээний болон завод ноосыг экспортод гаргахдаа заавал биржийн

арилжаанд оролцсон тодорхойлолтыг үндэслэн олон улсын мал эмнэлгийн цахим гэрчилгээг олгох зааврыг 2021 оны 4-р сарын 1-ний өдрөөс эхлэн шинээр мөрдөж байна.

Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг авахад ХАА-н биржээр түүхий эд, бүтээгдэхүүн арилжаалагдсан тухай тодорхойлолт бичгийг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд тус бичгийг авахад гэрээний үнийн дүнгийн 0,2%- ийг төлдөг байна. Иймээс тус зардал нь бичиг баримт бүрдүүлэлтийн зардалд зайлшгүй нэмэгдэж тооцогдоно.

Олон улсын мал эмнэлгийн цахим гэрчилгээ нь МХЕГ-аас олгодог экспортын гэрчилгээг авахад шаардлагатай бүрдүүлэх материалын жагсаалтад ордог.

Хүснэгт 83. Хагас боловсруулсан /ноолууран топс/ бүтээгдэхүүн экспортлох бичиг баримт бүрдүүлэлтийн хугацаа, зардал

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг									Зардал, ₮		
			1	2	3	4	5	6	7	8	9			
			24	48	72	96	120	144	168	192	216			
1	Худалдах, худалдан авах гэрээ	Экспортлогч, импортлогч	+											
2	Үнийн нэхэмжлэх	Экспортлогч	+											
3	Сав баглаа боодлын жагсаалт	Экспортлогч	+											
4	Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	+											
5	Дээжид шинжилгээ хийх	УМЭАЦТЛ	+	+	+									37,500₮
6	ХАА-н биржийн тодорхойлох бичиг	ХАА-н бирж				+								5,000-10,000₮
7	ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	МЗЭГ					+							12,500
8	Тохирлын гэрчилгээ	СХЗГ								2 цаг				79,000₮
9	Гарал үүслийн гэрчилгээ	МҮХАҮТ								2 цаг				162,500₮
10	Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, экспортын гэрчилгээ	МХЕГ								+	+	+		10,000₮
11	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч											3 цаг	7,000
	Нийт												216 цаг	316'000₮

Ноолууран топс бүтээгдэхүүн экспортлох бичиг баримтын бүрдүүлэлтэд нийт зарцуулах хугацаа 216 цаг, 316,000₮ зарцуулсан байна.

Дээрх хагас боловсруулсан топс болон эцсийн бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн зардал хугацааг харьцуулахад эцсийн бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлтэд 168 цаг, 296.0 мянган төгрөг, топс буюу хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлтэд 216 цаг, 316.0 мянган төгрөг тус тус зарцуулсан.

Зураг 30. Ноолууран топс бүтээгдэхүүний экспортын үйл явц



Ноолууран топс бүтээгдэхүүний экспортын үйл явц нь эцсийн бүтээгдэхүүний экспортын үйл явцаас 2 өдөр буюу 48 цагийн илүү хугацаа зарцуулж байна.

Ноос, ноолууран эцсийн бүтээгдэхүүн экспортлоход зарцуулж буй хугацаа нь хагас боловсруулсан бүтээгдэхүүнд зарцуулж буй хугацаанаас 48 цагаар бага буюу 22%-иар бага зарцуулсан бол нийт бичиг баримтын хураамж, төлбөрт зарцуулах зардал харьцангуй бага

буюу 6% байна. Эндээс дүгнэхэд, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдээр үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнд гүн боловсруулалт хийж эцсийн бэлэн бүтээгдэхүүн экспортод гаргах нь экспортын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт бүрдүүлэлтийн шат дамжлага, цаг хугацаа буурах зүй тогтолтой байгааг харуулна.

Ноолууран бүтээгдэхүүний экспортод импортлогч орнуудын зүгээс “Хөдөө аж ахуйн биржийн тодорхойлолт” болон “Мал эмнэлгийн гэрчилгээ” гэсэн бичиг баримтыг шаарддаггүй байна.

2.7.2.Хил, гааль дээрх үйл явц

Ноос, ноолууран бүтээгдэхүүний шошго, сав баглаа, боодолд тавигддаг гадаад улс орнуудын стандарт шаардлагууд:

БНХАУ. БНХАУ-д импортын болон худалдаж байгаа бараа бүтээгдэхүүн нь CCC гэрчилгээг /China Compulsory Certification заавал дагаж авах гэрчилгээ, тэмдгийг шаарддаг.

Ерөнхий шаардлага:

- ✚ Шошгын мэдээллийг Хятад хэл дээр бичих
- ✚ Сав баглаа боодлын материал нь хортой, аюултай байж болохгүй
- ✚ Амархан задарч, дахин боловсруулах боломжтой байх
- ✚ Модон сав баглаа боодол нь заавал IPPC тэмдэгтэй байх

Шошгын мэдээллийн шаардлага:

- ✚ Бүтээгдэхүүний нэр
- ✚ Бүтээгдэхүүний найрлага, хольц
- ✚ Хэмжээ, өнгө
- ✚ Үйлдвэрлэсэн огноо
- ✚ Үйлдвэрлэгчийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл
- ✚ Хадгалах хугацаа
- ✚ Бүтээгдэхүүний стандартын код
- ✚ Хадгалах нөхцөл
- ✚ Үндэсний стандартад заасан нэмэлт бүтээгдэхүүний ерөнхий нэр бичих
- ✚ Үйлдвэрлэлийн лицензийн дугаар

Европын холбооны улс: Бүтээгдэхүүний сав баглаа боодлыг хүрээлэн буй орчинд ээлтэй дахин боловсруулах материалаар үйлдвэрлэх, Аюултай бодис, материалын агууламжийг бууруулах, Дахин ашиглах боломжтой эсвэл сэргээх боломжтой сав баглаа боодлыг ашиглах, Био задрах боломжтой сав баглаа боодол хэрэглэх, ЕХ-ны нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, импортолсон бараа бүтээгдэхүүнд хориотой химийн бодис, хүнд металль болон бусад аюултай бодисын талаарх хязгаарлалт, хориглолт, анхааруулгыг (REACH) /The Registration, Evaluation, Authorization and Restriction of Chemicals/-ийн журмаар зохицуулдаг.

Ерөнхий шаардлага:

- ✚ Текстиль бүтээгдэхүүнийг зах зээлд гаргахдаа үйлдвэрлэгч, борлуулагч, импортлогч нь бүтээгдэхүүний ширхгийн агууламжийг харуулсан шошго эсвэл тэмдэглэгээг нийлүүлэх ёстой. Мэдээлэл нь үнэн зөв, төөрөгдүүлэхгүй, ойлгомжтой байх ёстой.
- ✚ Шошго эсвэл тэмдэг нь удаан эдэлгээтэй, уншихад хялбар, харагдахуйц, хүртээмжтэй, шошгын хувьд найдвартай бэхлэгдсэн байх ёстой.
- ✚ Холбогдох гишүүн улсад өөрөөр заагаагүй бол бүтээгдэхүүнийг хэрэглэгчид санал болгож буй гишүүн улсын албан ёсны хэлээр өгнө.
- ✚ Шошго дээрх мэдээлэл нь код болон бусад олон улсын стандартад заасан товчлолыг эс тооцвол товчлол агуулаагүй байх ёстой.
- ✚ Текстиль бүтээгдэхүүний найрлага нь шошго дээр заасан мэдээлэлтэй нийцэж байгаа эсэхийг хянах ажлыг борлуулалтын сүлжээний аль ч үе шатанд хийж болно. (гаалийн бүрдүүлэлт, дистрибьютерийн агуулах, бөөний болон жижиглэнгийн худалдааны цэгүүд гэх мэт).

Тусгай шаардлага:

- Зөвхөн нэг төрлийн ширхэгтээс бүрдсэн текстил бүтээгдэхүүнийг "100 %", "цэвэр" эсвэл "бүгд" гэж тэмдэглэж болно.
- Олон төрлийн ширхэгтээс бүрдсэн текстил бүтээгдэхүүнийг бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн нэр, жингийн хувиар буурах дарааллаар шошголж эсвэл тэмдэглэнэ.
- ЕХ-ны журмын хавсралтад хараахан оруулаагүй байгаа утас нь нийт жингийн 5% -иас бага хувийг эзэлбэл бусад утас гэж нэрлэж болно.
- Текстилийн бүтээгдэхүүн хоёр ба түүнээс дээш текстилийн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн тохиолдолд бүрэлдэхүүн тус бүрийн ширхэгтийн агууламжийн шошго, тэмдэглэгээтэй байна.
- Бүтээгдэхүүний гоёлын утасны ширхэгтийн цахилгаанжилтын нөлөө 7%-иас хэтрээгүй бол 2% -ийг ширхэгтийн агууламжийн үзүүлэлтээс хасна.
- Текстилийн бусад эд анги нь амьтны гаралтай биш бол хаяг шошго дээр амьтны гаралтай гэж тэмдэглэх

ЕХ-ны эко шошго (Flower logo)

ЕХ-ны Текстилийн бүтээгдэхүүнд Эко-шошгыг сайн дурын үндсэн дээр авах боломжтой.

Шаардлага:

- ✚ Текстилийн ширхгийн үзүүлэлт
- ✚ Бүрэлдэхүүн болон дагалдах бүрдэл хэсэг
- ✚ Химийн бодис болон боловсруулалт
 - Хэрэглэхэд тааламжтай байдал
 - Компанийн нийгмийн хариуцлага
 - Дэмжих бичиг баримтууд

Текстилийн бүтээгдэхүүний Эко шошгын шалгуур үзүүлэлтийн хүчинтэй хугацаа нь 2025 оны 12 сарын 31 хүртэл байна. "Global Organic Textile Standard (GOTS)" Герман улсаас гаралтай сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн олон улсын чанарын гэрчилгээ байдаг. Энэ бүтээгдэхүүний үйлдвэрлэл төдийгүй, түүхий эдийн нийлүүлэлтийг асуудлыг хамардаг байна.

БНСУ. БНСУ-ын зах зээлд ноос, ноолуур, даавуун бүтээгдэхүүн нийлүүлэх бүх компани "КС" маркийг урьдчилан заавал авах ёстой

Ерөнхий шаардлага:

- ✚ Шошгын мэдээллийг англи хэл дээр оруулбал Солонгос хэлний хамт оруулна
- ✚ Материал, арчилгааны холбогдолтой бүх мэдээлэл заавал оруулах
- ✚ Үйлдвэрлэсэн улсын нэрийг бичих

Шошгын мэдээллийн шаардлага:

- ✚ Бүтээгдэхүүний нэр
- ✚ Хэмжээ
- ✚ Ширхэгтийн агууламж
- ✚ Импортын бүтээгдэхүүн дистрибьютерээр дамжсан бол түүний нэр, хаяг
- ✚ Арчилгааны заавар, тэмдэглэгээ
- ✚ КС марк заавал оруулах
- ✚ Үйлдвэрлэсэн орны нэр

Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын хил гааль дээрх үйл явц дараах үе шаттай явагдана.

- ✚ Тээвэрлэгчид бараа тээвэрлүүлэх захиалга өгөн тээвэрлэлтэд бэлдэх, тээврийн бичиг баримтыг бүрдүүлэх
- ✚ Гаальд мэдүүлэх
- ✚ Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч гаалийн бүсэд нэвтрэх
- ✚ Гааль бараа, тээврийн хэрэгслийг шалгах
- ✚ Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах

- ✚ Гаалийн болон бусад татвар хураамжийг барагдуулах
- ✚ Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
- ✚ Гааль болон Хилийн мэргэжлийн хяналтын алба бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, Хилийн мэргэжлийн хяналтын албанаас экспортын мэдэгдэл өгөх
- ✚ Гаалийн хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх

Хүснэгт 84. Ноос, ноолууран бүтээгдэхүүний хил, гааль дээрх үйл явцын дараалал, хугацаа, зардал

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг	Зардал ₮
			1 24	
1	Ачаа тээшний зохицуулалт	Тээвэрлэгч	+	15,000
2	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Гаалийн зуучлагч	+	
3	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гааль	+	7,000
4	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо, хил гаалийн хяналт шалгалт	Гааль, ХМХГ	+	7,000 1,000
	Нийт			30,000

Ноос, ноолууран бүтээгдэхүүнийг экспортын хил гаалийн үйл явцад нийт 24 цаг, 30000 төгрөгийн зардал зарцуулсан байна.

Экспортын үйл ажиллагааны хил гааль дээрх үйл явцын дэс дараалал болон гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалтад зарцуулах цаг хугацаа нь эцсийн болон хагас боловсруулсан ноос, ноолууран бүтээгдэхүүний хувьд ижил тул тухайн экспортлогчийн мэдүүлж буй барааны нэр төрлийн тоо, гааль дээр биетээр хийх хяналт шалгалтад зарцуулж буй хугацаанаас шалтгаалан зарцуулах хугацаа, зардал нь харилцан адилгүй ялгаатай байдаг ч ноолууран бүтээгдэхүүн нь гаалийн хилээр нэвтрүүлэх барааны ногоон төлөвт хамаардаг тул экспортын бичиг баримт, барааны шалгалтад цаг хугацаа бага зарцуулдаг давуу талтай.

2.7.3.Тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц

Гадаад улс орнуудын ноос, ноолуурын хадгалалтад тавих шаардлага:

Ноос, ноолуурыг агуулахад зөвхөн баглаж хадгах бөгөөд задгай, баглаагүй хадгалахыг хориглоно. Ноос, ноолуурыг баглахдаа төрөл, өнгөөр ангилж баглана. Баглааг багласан металл төмөр утсаар прэссэлж бүслүүрдэнэ. Ноос, ноолуурыг хир зэрэг нягт баглан боосноос шалтгаалж контейнерт орох хэмжээ багтаамж шалтгаална. Жишээ нь: Нэг вагонд 12-13 тн угаасан ноос, ноолуур орох боломжтой.

Гадаад улс орнуудын түүхий эдийн агуулахад тавигдах шаардлага:

- ✚ Агаарын харьцангуй чийг 75%-с ихгүй температур нь 25⁰С-с ихгүй байна.
- ✚ Агуулахын агаарын чийглэгийг хэмжих багаж термограф, гигрографт шалнаас 15- 20см өндөрт хаалганаас зайтай гол орчинд байрлуулна.
- ✚ Агуулахын температурыг гаднын температуртай харьцуулан тохируулна.
- ✚ Ноос, ноолуурын чанар чийгийг байнга шалган үзэж байх
- ✚ Ноос, ноолуурын шалгах явцад норсон, эрвээхэйд идэгдсэн бол (Сольж) гаргах ноосыг чанар зэргийг стандартын дагуу шалгана.

Агуулахын өрөө байр нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, Үйлдвэрлэлийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага”, стандартын шаардлагыг хангасан агааржуулалтын системтэй байна.

Гадаад улс орнууд руу экспорт хийх тээврийн зардлын тээврийн төрлөөс хамаарч ялгаатай байдлаар хүснэгтээр харуулав.

Хүснэгт 85. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын тээврийн зардал /улс орноор, тээврийн хэрэгслээр

	Гадаад улс орнууд	Зарцуулах хугацаа		Зардал, ₮
1	Герман*:			
	- Авто тээвэр	20-25	240-600	17,100,000
	- Төмөр замын тээвэр	30-35	720-840	13,500,000
	- Агаарын тээвэр	5-9	120-216	82,650 төг/кг
	- Далайн тээвэр	50-60	1200-1440	22,800,000
2	БНСУ:			
	- Агаарын тээвэр	2-4	48-96	28,500 төг/кг
	- Далайн тээвэр	28-35	672-840	8,550,000
3	БНХАУ:			
	- Авто тээвэр	10-12	240-224	5,700,000
	- Төмөр замын тээвэр	10-15	240-360	8,550,000
	- Агаарын тээвэр	3-5	72-120	34,200 төг/кг

*- Агаарын тээврийг Инчёны транзит ашиглах нөхцөл

Төлбөр хүлээн авах үйл явц

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн нөхцөлийг харахад, ихэвчлэн бараагаа тээвэрлэн бүрэн хүлээлгэж өгсний дараа төлбөрөө авдаг бөгөөд зарим тохиолдолд тодорхой хэмжээний урьдчилгаа авдаг байна.

Төлбөрөө ийнхүү барааг бүрэн хүлээлгэн өгсний дараа авч байгаа нь хамгийн өндөр эрсдэлтэй боловч дараах шалтгаануудын улмаас ийнхүү төлбөрийн нөхцөлтэй гэрээ байгуулдаг гэж дүгнэсэн. Үүнд:

- ✚ Тухайн худалдан авагч тал нь урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн буюу бүрэн итгэлцэлтэй байдаг.
- ✚ Худалдах, худалдан авах гэрээг байгуулахдаа төлбөрийн нөхцөлийг тохирох боломж бага буюу, худалдан авагч талын тавьсан нөхцөл, шаардлагын дагуу гүйцэтгэдэг. Энэ нь тухайн аж ахуйн нэгжийн гадаад худалдааны туршлага, нэр хүнд болон бизнесийн эрсдэлтэй холбоотой байна.

Хүснэгт 86. Экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явц

№	Үйл ажиллагааны жагсаалт	Байгууллагын нэр
1	Гэрээ байгуулах /Онлайн худалдаа- CIF, харилцагч- FCA нөхцөлөөр гэрээ хийгдэнэ/	Импортлогч тал
2	Нэхэмжлэл - холбогдох бичиг баримтыг харилцагчаас авах	Импортлогч тал
3	Шаардлагатай зөвшөөрөл материал бүрдүүлэх	Экспортлогч тал
4	Төлбөр шилжүүлэх	Шилжүүлэгч болон дундын банк
	- Шилжүүлгээр - Бэлнээр - Аккредитив	
	Онлайн-CIF Харилцагч-FCA	

2.7.4.Экспортын замын зураглал

Ноос, ноолууран бүтээгдэхүүнийг экспортлоход бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг доорх хүснэгтээр нэгтгэн харуулав.

Хүснэгт 87. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын үйл явцын шат дараалал

	Алхмууд	Олгох байгууллага	Тайлбар
Бичиг баримт бүрдүүлэ	Шинжилгээ хийлгүүлэх хүсэлт	НМХГ	Экспортлогч нь НМХГ-т шинжилгээ хийлгүүлэх хүсэлт гаргана. НМХГ-аас хяналтын байцаагч томилох бөгөөд тус байцаагч ямар үзүүлэлтээр шинжилгээ хийлгүүлэх тухай мэдэгдэл бичиж өгнө.

	Шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори/ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	МХЕГ-ын байцаагчийн гаргасан мэдэгдлийн дагуу дээжид шинжилгээ хийн, шинжилгээний дүнг экспортлогчид өгнө. Шинжилгээний төрлөөс хамаарна, төрөл бүр өөр өөр тарифтай.
	Тохирлын гэрчилгээ	Стандарт хэмжил зүйн газар	Бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ авах хүсэлтийг СХЗГ-г өгөх бөгөөд энэхүү гэрчилгээ нь экспортын бүтээгдэхүүн холбогдох стандартыг хангасан болохыг баталгаажуулна.
	Бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ авах	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Гарал үүслийн гэрчилгээ нь аль улс оронд экспорт хийгдэхээс шалтгаалан өөр формоор гарна.
	Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ	МХЕГ	Экспортын бүтээгдэхүүнд "Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ буюу экспортын гэрчилгээ олгоно.
	ХАА-н биржийн тодорхойлох бичиг	ХАА-н биржийн газар	Биржийн арилжаагаар арилжигдсан бараа, бүтээгдэхүүний ангилал, нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт үнийн дүнг илэрхийлсэн биржийн албан ёсны тодорхойлолт
	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ	МЭЕГ	Мал, амьтны эрүүл мэнд, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийг ОУ-д баталгаажуулсан гэрчилгээ
Гаалийн бүрдүүлэлт	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч байгууллага	Тээвэрлэгч байгууллагатай тохирон тээврийн бичиг баримтыг бүрдүүлнэ.
	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Тээвэрлэгч байгууллага, Гаалийн зуучлагч	Гаалийн цахим сүлжээнд барааны мэдүүлгийг шивж оруулан илгээнэ.
	Гаалийн хяналт шалгалт бараа, тээврийн хэрэгсэл	Улаанбаатар хот дахь гаалийн газар	Томилогдсон хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийг шалгах
	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Улаанбаатар хот дахь гаалийн газар	- Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, хураамжийг барагдуулах, - Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо	Гааль, Хилийн мэргэжлийн хяналт	- Гааль болон Хилийн мэргэжлийн хяналт бараа, тээврийн хэрэгслийг шалгах, лацдах, хилийн мэргэжлийн хяналтын байцаагч экспортын мэдэгдэл өгөх
	Тээвэрлэлт	Тээвэрлэгч байгууллага	Тээвэр автомашин, агаарын тээвэр
	Төлбөр хүлээн авах	Худалдан авагч	Барааг бүрэн хүлээн авсны дараа

Ноолууран эцсийн бүтээгдэхүүний экспорт нь хагас боловсруулсан ноолууран бүтээгдэхүүний экспортод гаргах бичиг баримтын бүрдүүлэлтээс хугацаа болон зардлын хувьд харьцангуй бага байна. Ноолууран эцсийн бүтээгдэхүүний экспортын үйл явцад нийт 8 байгууллагатай харьцаж холбогдох бичиг баримтын бүрдүүлэлтийг хийдэг.

Хагас боловсруулсан ноолууран бүтээгдэхүүний хувьд, Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг 2021 оны 04 сарын 01-ээс эхлэн экспортын бичиг баримтын бүрдүүлэлтэд шаардаж байгаа бөгөөд тус гэрчилгээг авахын тулд ХАА-н биржийн газраас тодорхойлолт бичиг авах шаардлагатай болж улмаар эцсийн бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлтээс 2 бичгийг нэмэлтээр бүрдүүлэх шаардлагатай болсон.

Хүснэгт 88. ХБНГУ-ын ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал

	Хугацаа \цагаар, өдрөөр\	Зардал, \$
Баримт бичгийн бүрдүүлэлт		
Төлбөрийн нэхэмжлэх	1	0
Европын холбооны нутаг дэвсгэрт хийгдэх буй бараа, бүтээгдэхүүний урсгалын гаалийн мэдүүлгийг системд бүртгүүлэх /Intrastat/		
Сав баглаа боодлын жагсаалт		
Улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай Конвенц"/CMR/-ийн		

шаардлага бүхий тээврийн бичиг баримт		
Гаалийн бус байгууллагын бичиг баримтын хяналт, шалгалт	0	0
Хил дээрх үйл явц, хяналт шалгалт		
Гаалийн импортын мэдүүлэг болон хяналт шалгалт	0	0
Гаалийн татвар /GSP+ нөхцөлөөр импортын татвар 0% /		
Бусад байгууллагын бичиг баримтын хяналт, шалгалт		
Төлбөр хүлээн авах үйл явц		
Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл / 1.00 EUR = 1.171814 USD/		7.26%
Дундын банкны шимтгэл		15-20\$
Дотоод тээврийн зардал /Germany- Czech Republic border crossing/	5	520\$
Нийт	174	520\$

Эх үүсвэр: <https://remittanceprices.worldbank.org/>

Эх үүсвэр: <https://www.doingbusiness.org/>

Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем буюу /GSP+/- ийн хүрээнд Монгол Улсаас гарал үүсэлтэй 7200 бараа бүтээгдэхүүнд гаалийн тарифын хөнгөлөлт эдлэх бүтээгдэхүүний жагсаалтад хагас боловсруулсан ноолууран бүтээгдэхүүн багтсан.

ХБНГУ нь Дэлхийн банкны LPI-ийн үзүүлэлтээр дэлхийд нэгдүгээрт орсон тул импортын бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулсан цаг, зардал тэг гэж судалгаагаар гарсан байна.

Хүснэгт 89. БНСУ-ын ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал

	Хугацаа \цагаар, өдрөөр\	Зардал, \$
Баримт бичгийн бүрдүүлэлт		
Худалдан авалтын гэрээ	1	36.9
Хүргэлтийн захиалга		
Сав баглаа боодлын жагсаалт		
Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ /SOLAS certificate/		
Гаалийн бус байгууллагын бичиг баримт бүрдүүлэлт		
Хил дээрх үйл явц, хяналт шалгалт		
Гаалийн импортын мэдүүлэг болон хяналт шалгалт	6	277.8
Гаалийн татвар		
Гаалийн бус байгууллагын хяналт, шалгалт		
Төлбөр хүлээн авах үйл явц		
Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл / 1 KRW = 0.00087 USD/		4.61%
Дундын банкны шимтгэл		15-20\$
Дотоод тээврийн зардал /Busan port/	7	568
Нийт	79	882.7 \$

БНСУ-д ноолууран бүтээгдэхүүн экспортлоход урьдчилан БНСУ-ын Технологи, Стандартын Агентлаг буюу KATS (Korean Agency for Technology and Standards)-с үндэсний хэмжээний "KC" маркийг заавал авах ёстой. Тус маркийг 2009.07.01-нд олон нийтэд танилцуулан 2010.01.01-ний өдрөөс албан ёсоор ашиглаж эхэлсэн бөгөөд энэ нь 13 төрлийн сертификатыг нэгтгэн нэг болгосон шинэ марк юм. Монголын ноолууран бүтээгдэхүүний импортын татварын хувь 13 хувь байна.

Хүснэгт 90. БНХАУ-ын ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортод тавьж буй шаардлага, түүнд зарцуулах хугацаа, зардал

	Хугацаа \цагаар, өдрөөр\	Зардал, \$
Баримт бичгийн бүрдүүлэлт		
Худалдан авалтын гэрээ	8	35
Төлбөрийн нэхэмжлэх		
Сав баглаа боодлын жагсаалт		
Ачааны бичиг баримт эх хувь		
Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ		
Ачааны бичиг баримт, мэдээллийн электрон хувилбар		
Хил, гааль дээрх үйл явц		
Гаалийн импортын мэдүүлэг, хяналт шалгалт	33	220
Терминал дээрх холбогдох үйл явцууд		
Ачааны бичиг баримт, мэдээллийн электрон хувилбар		

Гаалийн татварын хувь (MFN ангиллаар 6 хувь)		
Дотоод тээврийн зардал /Tianjin port/	8	395
Төлбөр хүлээн авах үйл явц		
Нэхэмжлэл хүлээн авах	(24-120 цаг) (1-5 өдөр)	
Төлбөрийн шилжүүлгийн шимтгэл /1 CNY = 0.154250 USD/ (Telegram fee -23\$, remittance handling fee 8-40\$)		(7.71%)
Дундын банкны шимтгэл		25-35\$
Нийт	121	650\$

Эх үүсвэр: <https://www.transcustoms.com/tariff/>

БНХАУ-ын импортын бараа бүтээгдэхүүнд ногдуулдаг татварын 6 ангилал байдаг бөгөөд Монгол улсын хувьд MFN ангилалд багтаж хагас боловсруулсан ноолууран бүтээгдэхүүний импортын татварт 6 хувь, НӨАТ 13 хувийг тус тус төлдөг.

БНХАУ-ын Non-MNF ангиллын орнуудад ноолууран бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнээс хамаарч импортын ерөнхий татвар 50%-130% байгаа нь тус улсын дотоод зах зээлээ хамгаалж, үйлдвэрлэгчдээ дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааны илрэл юм.

Хүснэгт 91. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын үйл явц дахь зардлын тооцоо

Үзүүлэлт	БНХАУ	БНСУ	ХБНГУ
Монгол дахь экспортын үйл явцад нийт зарцуулах зардал, ₮	326,000	326,000	343,500
Дотоодын тээвэр, ₮	1,125,750	896,895	1,482,000
Гадаад тээвэр, ₮	Төмөр замын тээвэр 8,550,000	Далайн тээвэр 8,550,000	Авто тээвэр 22,800,000
Гадаад орны импортын шаардлага хангахтай холбоотой нэмэгдсэн зардал, ₮	726,750	1,618,800	0
Нийт зардал, ₮	10,728,500	11,391,695	24,625,500
Нэгжид ногдох зардал (тонн), ₮	429,140	455,668	985,020

Дээрх 3 орны харьцуулсан судалгаанд импортын төлбөрийн шилжүүлгийн зардал, болон дамжуулагч банкны шимтгэлийн төлбөрийн оруулж тооцоогүй. Учир нь тухайн импортын бүтээгдэхүүний нийт үнийн дүнгээс хамаарч шилжүүлгийн төлбөр ялгаатай гарах тул тус тооцоололд тооцоогүй болно.

Дэлхийн банкнаас улс хоорондын мөнгөн гуйвуулгын үнийн өөрчлөлтийг хянадаг улирал тутмын тайлангийн 2021 оны 3 дугаар улирлын судалгаагаар G8 улсын бүлэгт багтдаг БНСУ 4.61%, ХБНГУ 7.26 %, БНХАУ-7.71% гэсэн шимтгэлийн хувь төлдөг болохыг гаргасан байна. ХБНГУ болон БНХАУ-ын улс хоорондын мөнгөн гуйвуулгын шимтгэлийн хувь дэлхийн дундаж үзүүлэлтээс 0.88-1.33%-иар илүү байгаа нь тухайн орнуудад импортын нэгж бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлж буй бас нэг хүчин зүйл гэж дүгнэж байна.

Зураг 31. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын замын зураглал

ЭКСПОРТЫН ЗАМЫН ЗУРАГ
НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН



Одоогоор Монгол Улсаас Ази, Европын орнууд болон АНУ, БНХАУ, ОХУ зэрэг хамгийн олон оронд экспортолж буй бүтээгдэхүүн болох ноолууран эцсийн бүтээгдэхүүнийг бүх төрлийн тээврийн хэрэгслийг ашиглан экспортолж байна.

Хэрэв Европын холбооны улс руу бүтээгдэхүүнээ экспортлох аж ахуйн нэгж Европын холбооны REX-ийн системд бүртгүүлэн бүртгэлтэй экспортлогчийн REX дугаар авснаар тухайн хүчинтэй хугацаандаа гарал үүслийн гэрчилгээ авахад зарцуулдаг хугацаа, зардлыг хэмнэх боломжтой.

Ноолууран топс бүтээгдэхүүнийг маш бага хэмжээгээр гадаад улс орнууд руу экспортод гаргадаг бөгөөд холбогдох бичиг баримтыг бүрдүүлэхэд эцсийн бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэхэд оролцож буй байгууллагын тоо 2-оор, нийт зарцуулж буй цаг 48 цагаар, зардал 20,000 төгрөгөөр илүү байна.

НООС, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН



ЭКСПОРТЫН БИЧИГ БАРИМТ БҮРДҮҮЛЭЛТ



ХИЛ ГААЛЬ ДЭЭРХ ҮЙЛ ЯВЦ



ТЭЭВЭР



ТӨЛБӨР ХҮЛЭЭН АВАХ



Хагас боловсруулсан ноолуур



- Худалдах, худалдан авах гэрээ
- Үнийн нэхэмжлэх
- Сав баглаа боодлын жагсаалт
- Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт
- Дээжид шинжилгээ хийх
- ХАА-н биржийн тодорхойлох бичиг
- ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ
- Тохирлын гэрчилгээ
- Гарал үүслийн гэрчилгээ
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, экспортын гэрчилгээ
- Тээврийн бичиг баримт, Ачааны манифест

216 цаг, 316'000₮

- Ачаа тээшний зохицуулалт
- Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг
- Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт
- Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо, хил гаалийн хяналт шалгалт

24 цаг, 30'000₮

- Төмөр замын тээвэр: 342'000₮/тонн (БНХАУ)
- Далайн тээвэр: 342'000₮/тонн (БНСУ)
- Авто тээвэр: 912'000₮/тонн (ХБНГУ)

- 120-240 цаг
- Төлбөрийн шимтгэл: 7.71%
- Дундын банкны шимтгэл: 25-35\$

Ноолууран эцсийн бүтээгдэхүүн



- Худалдах, худалдан авах гэрээ
- Үнийн нэхэмжлэх
- Сав баглаа боодлын жагсаалт
- Дээжид шинжилгээ хийлгүүлэх хүсэлт
- Дээжид шинжилгээ хийх
- Тохирлын гэрчилгээ
- Гарал үүслийн гэрчилгээ
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, экспортын гэрчилгээ
- Тээврийн бичиг баримт, Ачааны манифест

168 цаг, 296'000₮

- Ачаа тээшний зохицуулалт
- Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг
- Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт
- Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт, экспортын мэдэгдэл, лац, ломбо, хил гаалийн хяналт шалгалт

24 цаг, 30'000₮

- Төмөр замын тээвэр: 342'000₮/тонн (БНХАУ)
- Далайн тээвэр: 342'000₮/тонн (БНСУ)
- Авто тээвэр: 912'000₮/тонн (ХБНГУ)


- 120-240 цаг
- Төлбөрийн шимтгэл: 7.71%
- Дундын банкны шимтгэл: 25-35\$

13840₮/ТН Нэг тонн хагас боловсруулсан ноолуурт ногдох экспортын үйл явцын зардал.

Нэг тонн ноолууран эцсийн бүтээгдэхүүнд ногдох экспортын үйл явцын зардал. **13040₮/ТН**

Импортлогчийн хашаа хүртэлх хил гааль дээрх үйл явц:

ХБНГУ	БНСУ	БНХАУ
Баримт бичгийн бүрдүүлэлт: - Төлбөрийн нэхэмжлэх - Европын холбооны нутаг дэвсгэрт хийгдэх буй бараа, бүтээгдэхүүний урсгалын гаалийн мэдүүлгийг системд бүртгүүлэх /Intrastat/ - Сав баглаа боодлын жагсаалт - Улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай Конвенц/CMR/-ийн шаардлага бүхий тээврийн бичиг баримт - Гаалийн бус байгууллагын бичиг баримтын хяналт, шалгалт Хил дээрх үйл явц, хяналт шалгалт: - Гаалийн импортын мэдүүлэг болон хяналт шалгалт - Гаалийн татвар /GSP+ нөхцөлөөр импортын татвар 0% / - Бичиг баримтын хяналт, шалгалт	Баримт бичгийн бүрдүүлэлт: - Худалдан авалтын гэрээ - Хүргэлтийн захиалга - Сав баглаа боодлын жагсаалт - Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ /SOLAS certificate/ - Гаалийн бус байгууллагын бичиг баримт бүрдүүлэлт Хил дээрх үйл явц, хяналт шалгалт: - Гаалийн импортын мэдүүлэг болон хяналт шалгалт - Гаалийн татвар - Гаалийн бус байгууллагын хяналт, шалгалт	Баримт бичгийн бүрдүүлэлт: - Худалдан авалтын гэрээ - Төлбөрийн нэхэмжлэх - Сав баглаа боодлын жагсаалт - Ачааны бичиг баримт эх хувь - Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ - Ачааны бичиг баримт, мэдээллийн электрон хувилбар Хил дээрх үйл явц, хяналт шалгалт: - Гаалийн импортын мэдүүлэг, хяналт шалгалт - Терминал дээрх холбогдох үйл явцууд - Ачааны бичиг баримт, мэдээллийн электрон хувилбар - Гаалийн татварын хувь (MFN ангиллаар 6 хувь) - Дотоод тээврийн зардал / Tianjin port/



Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын замын зураглалыг хагас боловсруулсан, эцсийн бүтээгдэхүүн гэсэн ангиллаар бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль дээрх үйл явц, төлбөр хүлээн авах үйл явцыг тус бүрд нь судалж эцэст нь экспортын замын зураглалыг боловсруулж нэгтгэн дүгнэв.

Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явцыг судлахдаа нэг талаас Монгол Улсаас экспортын бүтээгдэхүүнд шаардагдаж буй бичиг баримтын жагсаалтыг гаргаж тэдгээрт шаардагдах цаг хугацаа, зардлыг тооцсон. Нөгөө талаас, арьс ширэн бүтээгдэхүүнийг импортлогч гол улс орнууд болох БНХАУ, БНСУ, Европын холбооны улсуудад экспортлоход шаардагддаг чанар, стандарттай уялдуулан судаллаа.

Ноос, ноолууран бүтээгдэхүүнийг экспортлоход Худалдах, худалдан авах гэрээ, Үнийн нэхэмжлэл, Баглаа боодлын тодорхойлолт, Бүтээгдэхүүний дээжийн шинжилгээний дүгнэлт, Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, ХАА-н биржийн тодорхойлох бичиг, Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, Тохирлын гэрчилгээ, Барааны гарал үүслийн гэрчилгээ, Гаалийн бүрдүүлэлт хийлгэх, Ачааны манифест, Тээврийн бичиг баримтыг Монголын талаас шаардаж байна. Эдгээрийг авахдаа тус бүрдээ 6-аас дээш бичиг баримтуудыг бүрдүүлдэг бөгөөд бичиг баримтуудын давхардлыг To Be шинжилгээнд нарийвчлан тооцсон болно.

Хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын бичиг баримтууд нь “ХАА-н гаралтай түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн”-ий ангилалд багтаж байгаа бол ноолууран эцсийн бүтээгдэхүүнд ХАА-н биржээс тодорхойлолт авах шаардлагагүй. Хагас боловсруулсан ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлтэд 216 цаг, зардал 316,000₮ зарцуулж байгаа бол ноолууран эцсийн бүтээгдэхүүнд 168 цаг, зардал 296,000₮ зарцуулдаг судалгаагаар тогтоов.

БНХАУ, БНСУ, ХБНГУ-ын импортын шаардлагаас харахад, “Хөдөө аж ахуйн биржийн тодорхойлолт” гэсэн бичиг баримт шаарддаггүй байна.

Экспортын үйл ажиллагааны хил гааль дээрх үйл явцын дэс дараалал болон гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын цагийн үнэлгээ нь эцсийн болон хагас боловсруулсан ноос, ноолууран бүтээгдэхүүний хувьд ижил тул тухайн экспортлогчийн мэдүүлж буй барааны нэр төрлийн тоо, гааль дээр биетээр хийх хяналт шалгалтад зарцуулж буй хугацаанаас шалтгаалан зарцуулах хугацаа, зардал нь харилцан адилгүй ялгаатай байдаг ч ноолууран бүтээгдэхүүн нь гаалийн хилээр нэвтрүүлэх барааны ногоон төлөвт хамаардаг тул экспортын бичиг баримт, барааны шалгалтад цаг хугацаа бага зарцуулдаг давуу талтай. Ноос, ноолууран бүтээгдэхүүнийг экспортын хил гаалийн үйл явцад нийт 24 цаг, 30,000 төгрөгийн зардал зарцуулдаг.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын төлбөр төлөлт, тээвэрлэлтийн үйл явцыг судлахад, арьс ширний экспортод төмөр зам, автозам, агаар, далайн тээвэр гэсэн бүх төрлийн тээврийн хэрэгслийг ашигладаг. Эдгээр тээврийн зардлыг улс орон болгоноор, тээврийн хэрэгслийн төрөл тус бүрээр судалж судалгааны тайланд оруулав. Төлбөрийн шилжүүлгийн шимтгэлд улс орон бүрээр ялгаатай боловч дунджаар 24-96 цаг (1-4 өдөр) зарцуулж 4.76% төлдөг бол Дундын банкны шимтгэлд 20-35\$ төлж байна.

Гадаад улс орнуудын импортын шаардлагыг хангахтай холбоотой болон гадаад улсын импортлогчийн хашаанд хүртэл зардлын шинжилгээг гүйцэтгэхэд, БНХАУ-ын хувьд 650\$, БНСУ-ын хувьд 79 цаг, 882.7, ХБНГУ-ын хувьд импортын шаардлагыг хангахтай холбоотой зардал гарахгүй боловч Чех улсаар дамжин өнгөрөх тээвэрт 174 цаг, 520\$ зарцуулдаг.

Ноос, ноолууран бүтээгдэхүүнийг экспортлоход Монголын талд зарцуулах зардал нь улс орон бүрээр ялгаатай бус, ижил бөгөөд энэ зардал дээр гадаад, дотоодын тээвэр, гадаад улс орнуудын импортын шаардлагыг хангахтай холбоотой нэмэгдэл зардлуудыг нэмж нэг тонн тутамд ногдох зардлыг тооцов. Хамгийн хямд тээврийн хэрэгслийг сонгож дундаж өртгийг тооцоход, нэг тонн ноос, ноолууран экспортын үйл явцад зарцуулах дундаж өртөг БНХАУ руу

экспорт хийхэд 429.4 мянган төгрөг, БНСУ руу 455.7 мянган төгрөг, ХБНГУ руу 985.0 мянган төгрөг байна.

2.8.САМРЫН ИДЭЭНИЙ ЭКСПОРТЫН ЗАМЫН ТОЙМ СУДАЛГАА

Самрын идээний экспортыг дэмжих бодлогын эхлэл тавигдаж байгаа ч тогтворгүй байдаг, мөн хэрэгжүүлэх стратеги, арга хэрэгсэл нь тодорхойгүй байдаг учраас хэрэгжилтийн түвшин хангалтгүй байна.

БОАЖ-ын сайдын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/577 тоот тушаалын дагуу ойн сан бүхий орон нутагтай гэрээ байгуулан зохих хураамжийг төлж бэлтгэн боловсруулсан ойн дагалт баялгийг хамгаалах ашиглах тусгай зөвшөөрөлтэй ААН байгууллагуудад БОАЖЯ-аас 2020 оны 10 дугаар сарын 14-өөс экспортын тусгай зөвшөөрлийг олгож эхэлсэн. Уг экспортын тусгай зөвшөөрөл нь 30 хоногоор олгогддог. Мөн гадаад худалдан авагч байгууллагуудтай богино хугацаат хатуу нөхцөлтэй худалдааны гэрээтэй зарим дотоодын аж ахуйн нэгжүүд гадаадын компаниар алданги тооцуулах асуудал тавигддаг зэрэг асуудал самрын экспортод сөргөөр нөлөөлж байна.

Самрын идээг экспортлоход шаарддаг зөвшөөрөл, гэрчилгээнүүдийн жагсаалтыг дараах хүснэгтэд харууллаа.

Самрын идээний экспортын бичиг баримтын бүрдүүлэлтийн жагсаалт:

- ✚ Байгалийн ургамал, ойн дагалт баялаг тэдгээрийн гаралтай түүхий эдийг бэлтгэх, зөвшөөрөл
- ✚ Ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйл, ойн дагалт баялгийг гадаадад гаргах зөвшөөрөл
- ✚ Бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжүүлэн дүгнэлт гаргуулах
- ✚ Тохирлын гэрчилгээ авах
- ✚ Гарал үүслийн гэрчилгээ авах
- ✚ Ачааны манифест, Тээврийн бичиг баримт, Баглаа боодлын жагсаалт

Зураг 32. Самрын идээний экспортын үйл явцын үе шат



Дээрх зурагт, самрын идээний экспортын үйл явцын үе шатыг зураглан харууллаа. Үйлдвэрлэл, түншлэл, зөвшөөрөл авах, шинжилгээнд хамруулах, бичиг баримтын бүрдүүлэлт, төлбөр шилжүүлэх, гааль, тээвэрлэлт гэсэн үйл ажиллагааны явцыг дамжих бөгөөд экспортын үйл явцыг дэлгэрүүлэн дор тайлбарлаж бичив.

Гэрчилгээ авах алхам:

1. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах тухай улсын байцаагчийн дүгнэлт /анх удаа экспорт эхэлж байгаа бол/ “Иргэн, хуулийн этгээдээс МХЕГ-т ирүүлсэн хүсэлтийг

тус газрын "Зөвлөгөө, мэдээллийн төв"-д ажил үүрэг гүйцэтгэж байгаа Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын (ахлах) байцаагч шалгах хуудас ашиглан хүсэлт гаргагчийн дэргэд нягтлан шалгаж, хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ.

2. Хүсэлт шалгах хуудасны шаардлагыг хангаж буй бол хүлээн авч, хүсэлт гаргагчид тасалбар өгнө.
3. Хүсэлтийг хянан хүлээж авсан улсын байцаагч нь МХЕГ-ын албан бичиг хариуцсан ажилтанд нэн даруй хүлээлгэн өгнө.
4. МХЕГ-ын албан бичиг хариуцсан ажилтан хүсэлтийг цахим системд бүртгэж, даргын туслахад хүлээлгэн өгнө.
5. Даргын туслах хүсэлтийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж, МХЕГ-ын дарга (дэд дарга)-аар цохуулан Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын албан хэрэг хариуцсан улсын байцаагчид өгнө.
6. МХЕГ-ын дарга (дэд дарга) хүсэлтийг нэн даруй буюу 24 цагийн дотор цохно.
7. Экспорт, импорт хилийн хорио цээрийн хяналтын газрын албан хэрэг хариуцсан улсын байцаагч даргын туслахаас хүсэлтийг хүлээн авч "бүртгэх дэвтэр"-т бүртгэн хяналтын газрын дарга, түүний түр эзгүйд хэлтсийн дарга, газар, хэлтсийн даргын түр эзгүйд ажил үүргийг нь түр орлож байгаа улсын ахлах байцаагчид танилцуулна.
8. Хүсэлттэй танилцсан газрын/хэлтсийн дарга ажлын нэг өдөрт багтаан цохолт хийж, цахимаар холбогдох улсын байцаагчид шилжүүлнэ.
9. Уг цохолтын дагуу албан хэрэг хариуцсан улсын байцаагч хүсэлтийг цаасаар шилжүүлэн өгч, "бүртгэх дэвтэр"-т хүлээн авсан тухай тэмдэглэл хийж, гарын үсэг зуруулна.
10. Хүсэлтийг хүлээн авсан улсын байцаагч нь хууль, журмын дагуу шалгаж гэрчилгээ мэдэгдэл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Хэрвээ олгох боломжгүй бол энэ тухай хүсэлт гаргагчид ажлын 1 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ. Албан бичигт олгоогүй үндэслэлийг тодорхой бичнэ. Гэрчилгээ мэдэгдэл олгох боломжтой бол хуулийн хугацаанд шуурхай олгоно.
11. Хэвлэгдсэн мэдэгдлийг эрх бүхий албан тушаалтанд танилцуулан гарын үсэг зуруулна. Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг зурсан гэрчилгээ, мэдэгдэлд байгууллагын тэмдэг даруулж баталгаажуулна. Баталгаажсан гэрчилгээ, мэдэгдлийг холбогдох бүртгэлийн дэвтэрт бүртгэн дугаар олгож Зөвлөгөө мэдээллийн төвд ажил үүрэг гүйцэтгэж байгаа холбогдох улсын байцаагчид өгнө.
12. Зөвлөгөө мэдээллийн төвд ажиллаж байгаа улсын байцаагч гэрчилгээ, мэдэгдлийг хүсэлт гаргагчид өгнө. Шалгах хуудсанд заасан баримт бичгээс өөр материал шаардахыг хориглоно".

Экспортлогч дээрх алхмуудын дагуу зохих хяналт шалгалтыг хийлгэж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах бөгөөд экспортын дараагийн шатны үйл ажиллагаанд хүндрэл учрахаас сэргийлж чадна.

Төлбөрийг хүлээн авах үйл явц:

Худалдагч, худалдан авагч талууд гэрээнд заасан барааны үнэ, торгууль, алданги, хөнгөлөлт, урамшуулал, хорогдуулсан үнэ зэргийг тооцож төлбөр тооцоог гэрээнд заасан нөхцөлөөр хийж дуусгаснаар гэрээ хүчин төгөлдөр хэрэгжинэ. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн төлбөрийн нөхцөлийг харахад, ихэвчлэн бараагаа тээвэрлэн бүрэн хүлээлгэж өгсний дараа төлбөрийг авдаг бөгөөд зарим тохиолдолд тодорхой хэмжээний урьдчилгаа авдаг. Төлбөр хоёр талын тохирсон дагуу 50/50 хувиар төлдөг. Тухайн худалдан авагч тал нь урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн буюу бүрэн итгэлцэлтэй байдаг тул барааг хүлээн авсны дараа үлдсэн 50 хувь шилжүүлдэг байна.

Зураг 33. Голомт банкны аккредитив



Банкны аккредитив нь барааг тохиролцсон нөхцөлийн дагуу нийлүүлсэн тохиолдолд барааны төлбөрийг цаг тухайд нь найдвартай шилжүүлэх тухай банкнаас төлбөрийн үүрэг хүлээсэн баталгаа юм. Анх удаа бизнес хийж байгаа тохиолдолд илүү тохиромжтой. Аккредитив нээсэн банк импортлогчийн төлбөрийн эрсдэлээс үл хамааран төлбөр хийх үүрэг хүлээдэг. Экспортлогч аккредитивын төлбөрийг хүлээн авах хугацаанаас өмнө санхүүжилт авах боломжтой. Төлбөрийн хэлбэр нь:

- At sight payment: Шууд төлбөртэй аккредитив
- Deferred payment: Дараа төлбөртэй аккредитив
- Mixed payment: Холимог төлбөртэй аккредитив

Төрийн банкны Гадаад инкасс (Documentary collection) нь гадаад худалдааны уламжлалт төлбөр тооцооны хэлбэрүүдийн нэг бөгөөд банк худалдагчийн өмнөөс худалдан авагчид ачилтын баримтуудыг хүргүүлж, төлбөр нэхэмжлэх ажиллагаа юм. Инкассын үйлчилгээг бизнесийн харилцаатай түншүүд хэрэглэхэд тохиромжтой бөгөөд доорх дүрслэн харууллаа. Давуу талууд:

- DOCUMENTARY: Импортлогч барааны төлбөрийг ачилт хийснийг нотлох баримтуудыг үндэслэн хийнэ;
- LOW COST: Барааны төлбөрийг хямд зардлаар шилжүүлэх боломжтой;
- FLEXIBILITY: Талууд инкассын төлбөрийн нөхцөлийг харилцан уян хатан тогтоох боломжтой гэж тодорхойлсон байна²⁰.

²⁰ <https://www.statebank.mn/product/714>


Зураг 34. Төрийн банкны гадаад инкасс



Хүснэгт 92. Самрын идээний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдийн хүсэлт гаргахад зарцуулах хугацаа, зардал

	Алхмууд	Холбогдох байгууллага	Хугацаа	Зардал
1	Бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжүүлэн дүгнэлт гаргуулах	МХЕГ	Ажлын 7 хоног	124000
2	Экспортын тусгай зөвшөөрөл	БОАЖЯ	Ажлын 10 хоног	12500
3	Тохирлын гэрчилгээ авах	СХЗГ	2 цаг	51370
	Гарал үүслийн гэрчилгээ авах	МҮХАҮТ	2 цаг	25000
4	Ургамал хорио цээрийн гэрчилгээ	МХЕГ	15 хоног	10000
5	Ачааны манифест, Тээврийн бичиг баримт, Баглаа боодлын жагсаалт	Тээврийн компани, Гаалийн зуучлагч	Ажлын 1 хоног	320000
6	<ul style="list-style-type: none"> Гаалийн бүрдүүлэлт хийлгэх Гаальд мэдүүлэх Үнэлгээ хийлгэх Бичиг баримт хянах Татвар төлөх R дугаар авах/мэдүүлгийн дугаар/ 	Гааль	Ажлын 1 хоног	Ажлын цагаас илүү цаг тутамд 1,5 цагаар илүү цаг тооцно.
7	Гаалийн биет үзлэгт орох: <ul style="list-style-type: none"> Бодит шалгалтад хамрагдах Экспортлох зөвшөөрөл авах 	Гааль	1 цаг	7000
8	Гааль дээрх бусад үзлэг, шалгалт	Гаалиас бусад байгууллага (МХЕГ, Хилийн шалган г.м)	Ажлын нэг өдөр /зөрчилтэй, бичиг баримт дутуу үед ажлын 3-7 өдөр/	
9	Төмөр замын тээвэр	Төмөр зам, Гаалийн зуучлагч	10-14 хоног	Нэг вагон 1500000 төг Ачаа тээврийн зуучлалаар Нэг вагон 2500000-3500000 төг

Зураг 35. Самрын идээний экспортод зарцуулах цаг хугацаа ба зардал



Импортлогч орон руу гаргах боловсруулсан бүтээгдэхүүнийг олон улсын ариун цэврийн стандартыг хангасан шинэ материалаар боож баглана. Гадна баглаан дээр монгол, хятад, англи хэлээр стандартын дагуу үйлдвэрлэгдсэн газар, очих газар бүтээгдэхүүний нэр, жин үйлдвэрлэгчийн нэр, бүртгэлийн дугаар, үйлдвэрлэлийн цувааны дугаар, хадгалах нөхцөл, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа, хоёр талаас тэмдэглэсний дагуу хяналт шалгалт, хорио цээрийн нөхцөлийг хангасан тэмдэглэгээг заасан байна. Дотор талын баглаан дээр үйлдвэрлэгч орны нэр бүтээгдэхүүний нэр, аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаар, үйлдвэрлэлийн цувааны дугаарыг заасан байна. Дотор, гадна баглаан дээр мөн зөвхөн импортлогч оронд борлуулахыг заасан тэмдэглэгээг заавал хийнэ.

Зураг 36. Самрын идээний экспортын тээвэрлэлтийн ба бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц



Самрын идээний экспортод ачааны вагоны тээврийг ашиглаж байна. Бичиг баримтын бүрдүүлэлтийн хугацааг бусад орнуудтай харьцуулан үзэхэд дундаж түвшинд байгаа ч тээвэр зуучлалын компаниар зуучлуулан тээвэрлэлт хийхэд экспортын өртөг хоёр дахин өсөж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ОРЦУУДЫН ИМПОРТЫН ЗАМЫН ЗУРАГЛАЛ

3.1. Хүнсний орцын импорт

Импортын бараа бүтээгдэхүүн хилээр нэвтрүүлэхэд тухайн барааны төрөл, ангиллаас хамаарч урьдчилан бүрдүүлэх бичиг баримтын төрлүүд тодорхойлогдоно. Жишээ нь: хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн орц нь химийн гаралтай, эсхүл хүнсний бүтээгдэхүүний шууд орц найрлагад ордог бол Гарал үүслийн гэрчилгээ, Шинжилгээний бичиг (Certificate of Origin), Хор аюулын лавлах мэдээлэл (MSDS), Чанар стандартын гэрчилгээнүүд (ISO, HACCP, GMP гэх мэт) үйлдвэрлэгч буюу гадаадын экспортлогч талаас авах шаардлагатай. Мөн зарим төрлийн бараа, бүтээгдэхүүнийг импортлоход тусгай зөвшөөрөл, лиценз шаардагддаг.

Импортын бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн үйл явц

Импортын барааны гаалийн бүрдүүлэлт нь барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс гаалийн бичиг баримтыг, шаардлагатай тохиолдолд барааг шалгах, ногдуулсан татварыг төлсний дараа барааг хүлээн авахыг зөвшөөрөх хүртэлх цогц үйл ажиллагаа юм.

Импортын бараанд экспортын барааны нэгэн адил гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хяналт хийх гурван төлөв байдаг бөгөөд эдгээр нь гаалийн эрсдэлийн удирдлагын программд урьдчилан оруулсан шалгуурт тулгуурлан улаан, улбар шар, ногоон гэсэн гурван өнгөөр илэрхийлэгдэнэ.

Импортын барааг хилээр нэвтрүүлэхэд гүний гаалийн байгууллага болон хилийн гаалийн байгууллагад давхар, эсхүл дан хилийн гаалийн байгууллагад хяналт шалгалт хийгдэнэ.

Импортын гаалийн бүрдүүлэлт дараах үе шаттай явагдана. Үүнд:

1. Тээвэрлэгч барааг гаалийн хяналтын бүсэд оруулан бүртгэл хийлгээд дагалдах бичиг баримтыг гаалийн байгууллагад өгнө.
2. Хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийг шалган, бичиг баримтыг бүртгэж дугаарлан, тамга тэмдэг дарж тээвэрлэгчид шилжүүлэн өгнө.
3. Хэрэв мэргэжлийн хяналтын шалгалт, импортын мэдэгдэл, зөвшөөрөл шаардлагатай бол хилийн мэргэжлийн хяналтын холбогдох байцаагчид мэдэгдэн барааг задлан шалгуулж, бичиг баримтыг мөн шалгуулна.
4. Гаальд мэдүүлэх
5. Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах
6. Гаалийн болон бусад татвар хураамжийг барагдуулах
7. Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
8. Гааль биет үзлэг шалгалт хийн хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх

Хүнсний орцын материалын импорт

Хүнсний болон химийн гаралтай бүтээгдэхүүнд шаардлагатай бол итгэмжлэгдсэн лабораторид дээж өгч шинжлүүлдэг.

Хүснэгт 93. Хүнсний орцын материалын импорт

№	Алхам	Байгууллага	Өдөр													Зардал ₮	
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13		
1	Худалдах, худалдан авах гэрээ	Нийлүүлэгч, импортлогч	+														
2	Үнийн нэхэмжлэх	Нийлүүлэгч	+														
3	Төлбөр тооцоо	Импортлогч	+	+	+												
4	Сав баглаа боодлын жагсаалт, тээврийн бичиг баримт	Нийлүүлэгч			+												
5	Гадаад тээвэр	Тээвэрлэгч				+	+	+	+	+	+	+	+				

✚ Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ

Хүснэгт 94. Хүнсний орцын материалын импортын үйл явцын шат дараалал

№	Алхмууд	Олгох байгууллага	Тайлбар
1	Нийлүүлэгч талд төлбөрийг шилжүүлэх	Импортлогч	
2	Ачилтын урьдчилсан мэдээлэл, дагалдах бичиг баримт	Үйлдвэрлэгч, экспортлогч	Шинжилгээний бичиг, Бүтээгдэхүүний ОУ-ын чанар стандартын гэрчилгээ, Хор аюулын лавлах мэдээлэл, Үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээ зэргийг цахимаар хүлээн авах
3	Гадаад тээвэр	Тээвэрлэгч	Экспортлогч орноос Монгол Улсын хил хүртэлх тээвэр
4	Хил дээрх гаалийн үзлэг	Гааль	Хил дээр ирсэн барааг хилийн гаалийн газар хяналт, шалгалт хийн, лац ломбо зүүн гүний гаальд илгээнэ
5	Тээврийн бичиг баримт, авах	Тээвэрлэгч	Тээвэрлэгч байгууллагаас тээврийн бичиг баримт, ачааны манифест авна.
6	Импортын мэдэгдэл, зөвшөөрөл олгох	Хилийн мэргэжлийн хяналт	Хилийн мэргэжлийн хяналт бараа, бичиг баримтыг шалгаж импортын мэдэгдэл, зөвшөөрөл олгох
7	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Тээвэрлэгч, Гаалийн зуучлагч	Гаалийн цахим сүлжээнд барааны мэдүүлгийг шивж оруулан илгээнэ.
8	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гааль	- Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, хураамжийг барагдуулах, - Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
9	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт	Гааль	- Гааль барааг шалгах, гаалийн бүсээс авч гарах зөвшөөрөл өгөх

Хүснэгтээс харахад, нийлүүлэгч буюу экспортлогч талаас авах бичиг баримтууд гаалийн импортын бүрдүүлэлтэд гааль болон хилийн мэргэжлийн хяналтын газрын зүгээс шаардагддаг байна.

Хүнсний гаралтай, мөн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд орох материалын импорт нь гааль дээр Хилийн мэргэжлийн хяналтын газраар шалгуулж импортын зөвшөөрөл авдаг байна. Иймд үйлдвэрлэгчээс гарал үүслийн гэрчилгээ, чанарын сертификатууд болон тухайн бүтээгдэхүүнд хийгдсэн шинжилгээ, сорилтуудын хариу зэрэг нь гаалийн бүрдүүлэлтэд зайлшгүй шаардагддаг байна.

Зарим барааны импортод гаалийн хяналтын байцаагч тухайн бараанаас дээж авч гаалийн лабораторид шинжлүүлэх эсэхийг шийддэг. Гаалийн лабораторид шинжлүүлэх шаардлагатай гэж үзсэн үед гаалийн лабораторийн шинжилгээ 7 хоног үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд, гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримт, хяналт шалгалт, бусад шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх үйл явц гүйцэтгэгддэг.

Хүнсний орцын материал нь аль улсаас, ямар тээврийн төрлөөр оруулж ирж байгаагаас хамаарч цаг хугацаа болон зардлын хувьд харилцан адилгүй байна. Доорх замын зураглалд судалгаанд хамрагдсан тээвэр зуучийн байгууллагын мэдээлснээр, БНХАУ-аас авто тээврээр 7-10 хоног зарцуулна.

Судалгаанд хамрагдсан тээвэр зуучийн байгууллагын мэдээлснээр, 2021 оны 5 сард бүтээгдэхүүн ачигдахад 5-7 хоног зарцуулдаг байсан бол 2021 оны 7 сард 10-20 хоног зарцуулдаг болсон. Мөн нэг метр куб ачаа 300-400 юань байсан бол одоо 1200-1450 юань болсон. Тээвэрлэлтийн компаниуд зардлаа нэмж 400-650 мянган төгрөгөөр²¹ тээвэрлэдэг болжээ.

Хүнсний орцын импортод нийт зарцуулагдах хугацаа 13 өдөр буюу 312 цаг, үүний ихэнх буюу 200 орчим цаг нь тээвэрт зарцуулагдаж байна. Зардлын хувьд, БНХАУ-аас 40 тонны чингэлэг тээвэрлэхэд ойролцоогоор 10 орчим сая төгрөг болж байгаа нь нийт зардлын дийлэнх хэсгийг эзэлж байна.

²¹ <https://news.mn/r/2457367/>

Гэрээнд тусгасан байдлаас шалтгаалан төлбөр 70/30, 50/50, 100 хувь шилжүүлнэ. Баримт бичиг бүрэн, холбогдох зөвшөөрөл, гэрчилгээ бэлэн үед импортын асуудал хил, гааль дээр асуудал үүсэхгүй. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас тээвэрлэлт өмнөх жилтэй харьцуулахад хугацаа болон өртгийн хувьд нэмэгдсэн.

3.2.Сав баглаа, боодлын импорт

Үйлдвэрлэлийн орцод сав баглаа боодлын импортыг судаллаа. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд сав баглаа, боодлыг бараг 100 хувь БНХАУ-аас импортолж байна.

Хүснэгт 95. Сав баглаа, боодлын импортын үйл явцын шат дараалал

№	Алхмууд	Олгох байгууллага	Тайлбар
1	Нийлүүлэгч талд төлбөрийг шилжүүлэх	Импортлогч	
2	Ачилтын урьдчилсан мэдээлэл, дагалдах бичиг баримтыг цахимаар хүлээн авах	Үйлдвэрлэгч, экспортлогч	
3	Тээвэрлэлт	Тээвэрлэгч байгууллага	
4	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч байгууллага	Тээвэрлэгч байгууллагаас тээврийн бичиг баримтыг авна.
5	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Тээвэрлэгч байгууллага, Гаалийн зуучлагч	Гаалийн цахим сүлжээнд барааны мэдүүлгийг шивж оруулан илгээнэ.
6	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гааль	- Гааль бичиг баримтыг шалгах, татвар хураамж ногдуулах, хураамжийг барагдуулах, - Барагдуулсан татвар хураамжийн баримтыг шалгах, баталгаажуулах
7	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт	Гааль	Гааль барааг шалгах, гаалийн бүсээс авч гарах зөвшөөрөл өгөх

Сав баглаа, боодлын импортын хил, гааль дээрх үйл явц харьцангуй хялбар байх бөгөөд татварын хувь хэмжээ, барааны үнэлгээ зэргийг голлон анхаардаг байна.

Сав баглаа, боодлын импорт хийхэд шаарддаг бичиг баримтууд:

- ✚ Импортын гаалийн мэдүүлэг
- ✚ Үнийн нэхэмжлэх
- ✚ Баглаа боодлын тодорхойлолт
- ✚ Тээврийн бичиг баримт /ачааны манифест, тээвэр төлсөн баримт г.м./
- ✚ Чанарын гэрчилгээ /тохирлын гэрчилгээ г.м./
- ✚ Барааны гарал үүслийн гэрчилгээ
- ✚ Гадаад худалдааны гэрээ
- ✚ Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ

Сав баглаа, боодлын импорт нь гааль дээр Хилийн мэргэжлийн хяналтын газраар шалгуулах, импортын мэдэгдэл авах шаардлагагүй боловч тухайн бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, чанарын гэрчилгээ зэргийг гаалийн бүрдүүлэлтэд, гаальд мэдүүлэхэд шаарддаг.

Хүснэгт 96. Үйлдвэрлэлийн энгийн орцын импортын хугацаа ба зардал

№	Алхам	Байгууллага	Өдөр/ цаг						Зардал ₮	
			1	2	3	4	5	6		
			24	48	72	96	120	144		
1	Худалдах, худалдан авах гэрээ	Нийлүүлэгч, импортлогч	+							
2	Үнийн нэхэмжлэх	Нийлүүлэгч	+							
3	Төлбөр тооцоо	Импортлогч	+	+	+					
4	Сав баглаа боодлын жагсаалт, тээврийн бичиг баримт	Нийлүүлэгч			+					
5	Тээвэрлэлт	Тээвэрлэгч				+	+			16,540/кг

6	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч						+		
7	Гаалийн мэдүүлэг импорт	Гаалийн зуучлагч							+	60,000
8	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гааль							+	8,200
9	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт	Гааль							+	
11	Гаалийн гарах зөвшөөрөл	Гааль							+	
12	Төлбөр тооцоо	Импортлогч							+	

Тээврийн төрөл: Агаарын тээвэр /БНСУ/

Сав баглаа, боодлыг импортлоход ердөө 6 хоног буюу 144 цаг зарцуулж байгаа нь тээврийн төрөл болон төлбөрийн нөхцөлтэй шууд хамааралтай.

Сав баглаа, боодлыг агаарын тээврээр хүлээн авах тохиолдолд импортын орцын гаалийн хяналт болон бүрдүүлэлт нь Чингэс хаан гааль дээр явагддаг бөгөөд зарцуулагдах цаг хугацааны хувьд бага боловч тээврийн зардал өндөр байдаг байна.

2021 оны 7 сарын 25-ны байдлаар, Замын-Үүд боомтын хил дээр 1000 гаруй тээврийн хэрэгсэл байгаа бөгөөд өмнө нь 8000 юань байсан тээврийн зардал 13 м-тэй автомашин 25000 юань улмаар 30000 юань, 17м-тэй машин 40000-45000 юань болж өссөн. Эрээн-УБ хүртэлх тээвэрлэлтийн хугацаа өмнө нь 6 хоног байсан бол дунджаар 20 хоног болсон²² бөгөөд энэхүү байдлыг өөрчлөгдөнө хэмээн тооцож 2021 оны эхэн үеийн тарифаар дундажлан гаргалаа.

Цар тахлын улмаас үүссэн хил дээр болон далайн боомтуудад үүссэн ачаа чингэлгийн бөөгнөрөл, тээвэр логистикийн зардлын өсөлт зэрэг нь Монгол төдийгүй дэлхий даяар нийлүүлэлтийн найдвартай сүлжээг байгуулах, зам тээврийн шинэ хонгил, алтернатив чиглэлүүдийг сонгох, өрсөлдөх чадвараа сайжруулж, мэдээллийн шинэ технологи ашиглах хэрэгтэйг харуулж байна.

Худалдан авагчийн хүсэлтээр буюу өөрийн нэрийн өмнөөс Худалдагч тал аккредитивын нөхцөлийг хангасан баримтуудыг Худалдан авагчийн банканд бүрдүүлж өгсөн нөхцөлд тохиролцсон валютаар тодорхой хэмжээний мөнгийг түүнд төлөх банкны үүрэг болох талаар ХАС банкны импортын аккредитив дээр жишээ болгон орууллаа.

²² <https://www.facebook.com/FMFFs>

Хүснэгт 97. Импортын аккредитив

Импортын аккредитив нээх	0.1 хувь
доод хэмжээ	75 ам.доллар
дээд хэмжээ	250 ам.доллар
Импортын аккредитивийн нөхцөлд өөрчлөлт оруулах (1 удаа өөрчлөлт оруулахад)	40 ам.доллар
Импортын аккредитивийн дүнг нэмэгдүүлэх (нэмэгдүүлсэн дүнгээс)	0.2 хувь
доод хэмжээ	25 ам.доллар
дээд хэмжээ	150 ам.доллар
Импортын аккредитивийг цуцлах	30 ам.доллар
Эх үүсвэргүй аккредитивийн эрсдэлийн шимтгэл	Зээлийн Хорооны хурлаас тогтоосон хэмжээгээр
Импортын зөрчилтэй аккредитивийн баримт (багц баримтаас)	50 ам.доллар
Импортын аккредитивийн баримт шалгах	50 ам.доллар
Аккредитивтэй холбоотой лавлагаа явуулах болон лавлагаанд хариу өгөх	20 ам.доллар

Эх үүсвэргүй аккредитив судалсны үйлчилгээний хураамж нь тухайн үед мөрдөгдөж буй Бизнесийн зээлийн үйлчилгээний шимтгэлтэй ижил байна.

Аккредитивийн үйл ажиллагаатай холбогдон гарах шуудан, харилцаа холбоо, гадаад банкны үйлчилгээний шимтгэл зэрэг зардал гарсан тохиолдолд тэдгээр зардлыг харилцагч хариуцана.

Эх үүсвэр: https://www.xacbank.mn/product/84?fbclid=IwAR2fFzTOVFcit6hnTz1kYFv5CvsDu6FTBnz9JQ_U5fajs8LNRoB1zBav1CY

Аккредитив нь импортлогчийн банкнаас экспортлогчид гаргаж буй төлбөр гүйцэтгэх баталгаа болдог тул импортлогчийн хувьд худалдааны гэрээ хийхдээ урьдчилгаа төлбөр төлөхгүйгээр тохиролцох, барааг хүлээн авмагц, эсхүл бараа хүлээн авснаас хойш тодорхой хугацааны дараа төлбөр шилжүүлэх, бараа үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчтэй барааны үнэ тохиролцох зэрэг худалдан авагчийн талд ашигтай байх төлбөрийн хувилбаруудаар гэрээний нөхцөлүүдээ тохиролцох давуу талуудыг үүсдэг.

Импортлогчид аккредитив ашигласан үед Төлбөр төлөх нөхцөлийг аккредитивт заах боломжтой. Бараа хэзээ, хаана, хэрхэн ачигдсаныг хянана. Зохих бичиг баримтыг өгөөгүй тохиолдолд банкнууд төлбөр хийхгүй. Банкнаас санхүүжилт авах боломжтой - Бусад аргуудтай харьцуулахад өртөг өндөр - Журмын талаар нарийн мэдлэг шаардлагатай - Банкны зээлийн эрхийг ашиглана - Бичиг баримт нээлттэй дансны арга хэрэглэснээс удаан шилжиж ирнэ.

Зураг 38. Сае баглаа, боодлын импортын гаалийн бүрдүүлэлт хугацаа болон зардал



Дээрх зургаас харахад, ихэнх цагийг гаалийн бичиг баримт бүрдүүлэлтэд зарцуулж байгаа мэт боловч энэ нь импортлогчийн нийлүүлэгчид төлж буй төлбөрийн нөхцөлөөс шалтгаалж байна.

3.3.Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт

Импортын бичиг баримтын бүрдүүлэлтэд тавигдах шаардлагаас хамаарч боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай импортын орцыг тусгай орц буюу химийн бодис, будаг, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт гэж ангилж судаллаа.

Үйлдвэрлэлд ашиглах тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг БНХАУ-аас ихэвчлэн импортолдог бол харин арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүд Итали, Герман улсаас импортолдог. Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт нь химийн бодис, будагтай харьцуулахад харьцангуй хялбар, богино хугацаанд бичиг баримт, гаалийн үйл явц шийдэгддэг.

Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импортод шаардагдах бичиг баримтууд:

- ✚ Импортын гаалийн мэдүүлэг
- ✚ Үнийн нэхэмжлэх
- ✚ Баглаа боодлын тодорхойлолт
- ✚ Тээврийн бичиг баримт /ачааны манифест, тээвэр төлсөн баримт г.м./
- ✚ Чанарын гэрчилгээ /тохирлын гэрчилгээ г.м./
- ✚ Барааны гарал үүслийн гэрчилгээ
- ✚ Гадаад худалдааны гэрээ
- ✚ Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ

Хүснэгт 98. Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импортын үйл явцад зарцуулах цаг, зардал

№	Алхам	Байгууллага	Өдөр					Зардал, ₮
			1	2	3	4	5	
			24	48	72	96	120	
1	Худалдах, худалдан авах гэрээ	Нийлүүлэгч, импортлогч	+					
2	Үнийн нэхэмжлэх	Нийлүүлэгч	+					
3	Төлбөр тооцоо	Импортлогч	+	+	+			50,000-150,000₮
4	Сав баглаа боодлын жагсаалт, тээврийн бичиг баримт	Нийлүүлэгч			+			
6	Хил дээр гаалийн үзлэг, хяналт, лац ломбо	Гааль			+			
7	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч			+			
8	ХМХГ-ын хяналт шалгалт, биет үзлэг	ХМХГ				+		34,000₮
9	Импортын мэдэгдэл, зөвшөөрөл	ХМХГ				+		
10	Гаалийн мэдүүлэг импорт	Гаалийн зуучлагч				+		
11	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гааль				+		
12	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт	Гааль				+		
13	Гаалийн гарах зөвшөөрөл	Гааль				+		
14	Үйлдвэр рүү тээвэрлэх	Импортлогч					+	300,000₮

Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортлох үйл явцын бичиг баримт бүрдүүлэлтэд 120 цаг, 409,000 төгрөг зарцуулж байна. Нийт зардалд хамгийн өндөр хувийг гааль дээрээс үйлдвэрийн агуулах руу хүргүүлэх дотоод тээврийн зардал эзэлж байна.

Хүснэгт 99. Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импортын хугацаа, зардал

№	Үйл ажиллагаа	Олгох байгууллага	Зарцуулах хугацаа		Зардал, ₮	Тайлбар
			Өдрөөр	Цагаар		
1	Мөнгө шилжүүлэх нэхэмжлэл авах	экспортлогч				
2	Шилжүүлэгч банк руу төлбөр шилжүүлнэ - Шилжүүлэг - Бэлэн мөнгө - LC (90-180 хоног)	импортлогч	3	72	50,000-100,000	

3	Шаардлагатай нөхцөлд дамжуулагч банкаар дамжуулан нийлүүлэгчийн данс руу төлбөр шилжүүлнэ	Шилжүүлэгч болон дундын банк				
4	Ачилтын урьдчилсан мэдээлэл, дагалдах бичиг баримтыг цахимаар хүлээн авах	импортлогч				
5	Шинжилгээний бичиг, Бүтээгдэхүүний ОУ-ын чанар стандартын гэрчилгээ, Хор аюулын лавлах мэдээлэл, Үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээ	импортлогч				
6	Тээвэрлэлт Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэр, зуучлалын байгууллага				
7	Гаалийн бүрдүүлэлт хийнэ	ГЕГ	1	24	20,000	Гаалийн мэдүүлэг
8	МХ-н байцаагчид шалгуулна				7,000	Хураамж
9	Гаалийн үнэлгээ хийнэ				7,000	Нэг цагийн үнэлгээ
10	Гаалийн хяналт шалгалт					
11	Үйлдвэр рүү тээвэрлэх	Тээвэрлэгч		24	300,000	
	Нийт			120	409.000	

Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл импортлоход төлбөрийн 70-100 хувь урьдчилан шилжүүлдэг бөгөөд банкны шимтгэлийн хувь нийт импортын бичиг баримт бүрдүүлэлтийн зардалд хамгийн өндөр хувийг эзэлж байна.


Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь овор хэмжээ, онцлог шинж чанараас хамааран экспортлогч нар агаарын тээврээс бусад төрлийн тээврийг түлхүү ашигладаг тул тээвэрлэлтийн хугацаа нэлээд урт байна.

Хүснэгт 100. Тоног төхөөрөмжийн импортын тээврийн зардал /улс орнуудаар/

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Итали /Тоног, төхөөрөмж /		Герман /Сэлбэг хэрэгсэл/	
		Хугацаа \цагаар\	Хугацаа \цагаар\	Хугацаа \цагаар\	Зардал /сая.төг/
1	Автомашин	384-432	360-408	360-408	27,2-28,9
2	Вагон	720-840	720-840	720-840	11,5-15,6
3	Онгоц	120-168	120-168	120-168	14.8\$/kg
4	Усан онгоц	1200-1440			

Тайлбар: Дээрх тээврийн үнэ нь цар тахлын хүчин зүйлээс шалтгаалсан үнийн өсөлтийг тооцоогүй хэвийн үеийн үнэ ханшийн судалгааг ашигласан болно.

Зураг 39. Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импортын үйл явцын бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль, хүлээн авах үйл явцад зарцуулах хугацаа, зардал



3.4.Химийн бодис, будгийн импорт

Дэлхийн жишгээр 240 гаруй нэр төрлийн химийн материал хэрэглэдэг бол Монгол улсад 30-60 орчмыг хэрэглэдэг байна. Одоогоор үндсэн химийн материал БНХАУ-аас нийлүүлэгдэж байгаа бөгөөд Япон, Швейцар, Туркийн Sarchem, Италийн Biokimical, Испанийн Chromogina,

Голландын Stall, Германы Lanxess, ОХУ-ын Шебекинская химия зэрэг компаниудын химийн материалын дистрибуитерууд орж ирээд байгаа боловч үйл ажиллагаа нь сайн жигдрээгүй, химийн материал хугацаандаа орж ирэхгүй саатах, тасалдах, үнэ нэмэгдэх зэрэг бэрхшээлүүд байна. Харин ноос, ноолуурын үйлдвэрүүд үйлдвэрлэлд ашиглах химийн бодис, будгийг ихэвчлэн Япон улсаас импортолдог.

Химийн бодис, будгийн импортод шаардагдах бичиг баримтууд:

- ✚ Импортын гаалийн мэдүүлэг
- ✚ Үнийн нэхэмжлэх
- ✚ Баглаа боодлын тодорхойлолт
- ✚ Тээврийн бичиг баримт /ачааны манифест, тээвэр төлсөн баримт/
- ✚ Чанарын гэрчилгээ /тохирлын гэрчилгээ/
- ✚ Барааны гарал үүслийн гэрчилгээ
- ✚ Чанар, стандартын шаардлага хангасан тухай баримт бичгийн бүрдэл лабораторийн шинжилгээ хийж баталгаажсан байдал
- ✚ Тусгай зөвшөөрөл
- ✚ Импортын мэдэгдэл
- ✚ Гадаад худалдааны гэрээ
- ✚ Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ

Хүснэгт 101. Химийн бодис, будгийн импортын бичиг баримт бүрдүүлэлтэд зарцуулах цаг, зардал

№	Алхам	Байгууллага	Өдөр											Зардал ₮	
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11		
1	Худалдах, худалдан авах гэрээ	Нийлүүлэгч, импортлогч	+												50,000-100,000
2	Үнийн нэхэмжлэх	Нийлүүлэгч	+												
3	Төлбөр тооцоо	Импортлогч	+	+	+										
4	Сав баглаа боодлын жагсаалт, тээврийн бичиг баримт	Нийлүүлэгч			+										
6	Хил дээр гаалийн үзлэг, хяналт, лац ломбо	Гааль			+										
7	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	Тээвэрлэгч			+										
8	ХМХГ-ын хяналт шалгалт, биет үзлэг	ХМХГ			+										
9	Импортын мэдэгдэл, зөвшөөрөл	ХМХГ			+										
10	Гаалийн мэдүүлэг импорт	Гаалийн зуучлагч			+										20,000
11	Гаалийн бичиг баримтын хяналт, шалгалт	Гааль			+										7,000
12	Гаалийн биет үзлэг, хяналт шалгалт	Гааль			+										7,000

13	Гаалийн лабораторийн шинжилгээ	Гааль				+	+	+	+	+	+	+	20,000
14	Үйлдвэр рүү тээвэрлэх	Импортлогч										+	300,000

Химийн бодис, будаг гэсэн нэр төрлийн бүтээгдэхүүнийг импортлоход тусгай зөвшөөрөл, дээжийн шинжилгээ, хор аюулын байдлын заавар гэсэн мэдээлэл, бичиг баримтыг нэмэлтээр заавал бүрдүүлэх шаардлагатай болдог. Импортоор химийн бодис, будаг оруулахад дээжийн шинжилгээнд 7 хоног буюу 168 цагийг зарцуулж байгаа нь импортын нийт бичиг баримт, хил гаалийн хяналт шалгалтад зарцуулж буй цагийн 60 гаруй хувь болох нь судалгаанаас харагдаж байна.

Хүснэгт 102. Химийн бодис, будгийн импортын хугацаа, зардал

№	Үйл ажиллагаа	Олгох байгууллага	Зарцуулах хугацаа		Зардал, ₮	Тайлбар
			Өдрөөр	Цагаар		
1	Мөнгө шилжүүлэх нэхэмжлэл авах	экспортлогч				
2	Шилжүүлэгч банк руу төлбөр шилжүүлнэ - Шилжүүлэг - Бэлэн мөнгө - LC (90-180 хоног)	импортлогч	3	72	50,000-100,000	
3	Шаардлагатай нөхцөлд дамжуулагч банкаар дамжуулан нийлүүлэгчийн данс руу төлбөр шилжүүлнэ	Шилжүүлэгч болон дундын банк				
4	Ачилтын урьдчилсан мэдээлэл, дагалдах бичиг баримтыг цахимаар хүлээн авах	импортлогч				
5	Шинжилгээний бичиг, Бүтээгдэхүүний ОУ-ын чанар стандартын гэрчилгээ, Хор аюулын лавлах мэдээлэл, Үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээ	импортлогч				
6	Тээвэрлэлт	Тээвэр, зуучлалын байгууллага				
7	Тээврийн бичиг баримт, Ачааны манифест	ГЕГ	7	168		
8	Гаалийн бүрдүүлэлт хийнэ					
9	МХ-н байцаагчид шалгуулна				20,000	Гаалийн мэдүүлэг
10	Гаалийн үнэлгээ хийнэ				7,000	Хураамж
11	Хяналт шалгалтад орно				7,000	Нэг цагийн үнэлгээ
12	Гаалийн лабораторид дээжийн шинжилгээ хийлгэх			20,000		
13	Үйлдвэр рүү тээвэрлэх		1	24	300,000	
	Нийт			264	429.000	

Тайлбар:

БТКУС код: 2833.29.00, 2830.10.00, 2915.11.00, 3402.90.00, 3202.90.00, 2827.10.00- Хятадын химийн бодис

БТКУС код: 34029000, 32021000, 34039100, 32021000, 34031100, 39095090, 32041200, 38099300- Европын химийн бодис

БТКУС код: 84219990, 8453.10.00- Тоног төхөөрөмж

Химийн бодис, будгийг импортлох үйл явцын бичиг баримт бүрдүүлэлтэд 264 цаг, 429,000 төгрөг зарцуулж байна. Нийт зардалд хамгийн өндөр хувийг гааль дээрээс үйлдвэрийн агуулах руу барааг тээвэрлэх дотоод тээврийн зардал эзэлж байна.


Хүснэгт 103. Химийн бодис, будгийн тээврийн зардал /улс орнуудаар/

№	Тээврийн хэрэгслийн төрөл	БНХАУ		БНСУ	
		Хугацаа \цагаар\	Зардал /сая.төг/	Хугацаа \цагаар\	Зардал /сая.төг/
1	Автомашин	240-336	8,6-11,4		
2	Вагон	22-26	5,7-8,0		
3	Онгоц	24-48	6,4\$/kg	24-48	5.8 \$/kg
4	Усан онгоц	840-960	5,71-9,99	840-960	5,7-9,9

Тайлбар: Дээрх тээврийн үнэ нь цар тахлын хүчин зүйлээс шалтгаалсан үнийн өсөлтийг тооцоогүй хэвийн үеийн үнэ ханшийн судалгааг ашигласан болно.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд химийн бодис, будгийг Швейцар, Япон улсуудаас импортлоход 264 цаг, 182.25 мянган төгрөгийг зарцуулдаг.

Зураг 40. Химийн бодис, будгийн импортын үйл явцын бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль, хүлээн авах үйл явцад зарцуулах хугацаа, зардал



Химийн бодис, будгийн импортын үйл явц нь гаалийн лабораторийн шинжилгээний хугацаа, улс хооронд төлбөр шилжүүлэх хугацаа хамгийн урт байна. Түүнчлэн судалгаагаар, улс хоорондын төлбөрийн шилжүүлгийн шимтгэл маш өндөр байгааг судалгаанд оролцогчид онцолсон.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭКСПОРТЫН “ТО ВЕ” ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

4.1. ЭКСПОРТОД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Монгол Улсаас бүтээгдэхүүн экспортлоход тулгарч буй бэрхшээлийг бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц, хил, гааль дээрх үйл явц, тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явц гэж ангилж тодрууллаа. Тулгамдаж буй асуудлыг төрийн байгууллагын төлөөлөл, экспортлогч компаниуд, тээвэр зуучийн компани, эрдэмтэн судлаач бүхий 20 хүнээс асуулгын аргаар авч 1-9 оноогоор үнэлгээ өгсөн.

АНР шинжилгээг тоогоор үл илэрхийлэгдэх шинжтэй үзүүлэлтүүдийг тоон утгад шилжүүлж, тэдгээрийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд хэрэглэдэг. АНР шинжилгээ нь SWOT шинжилгээг тоон үнэлгээгээр нарийвчлан гүйцэтгэдэг судалгааны арга юм. Судалгаанд оролцогчдын SWOT шинжилгээний үзүүлэлт тус бүрд өгсөн үнэлгээний агуулгыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 104. АНР шинжилгээний үнэлгээний арга

Үнэлгээ	Агуулга	Тайлбар
1	Ижил	А болон Б хүчин зүйлс ижил ач холбогдолтой.
3	Бага зэрэг	А хүчин зүйл нь Б хүчин зүйлээс бага зэрэг илүү ач холбогдолтой.
5	Илүү	А хүчин зүйл нь Б хүчин зүйлээс илүү ач холбогдолтой.
7	Маш их	А хүчин зүйл нь Б хүчин зүйлээс маш их ач холбогдолтой.
9	Маш их давуу	А хүчин зүйл нь Б хүчин зүйлээс маш их давуу ач холбогдолтой.
2,4,6,8	Дундаж	Дээрх үзүүлэлтийн дундаж ач холбогдолтой илэрхийлнэ.

Эх сурвалж: (Saaty, 1991)

Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц дахь тулгамдаж буй асуудлын эрэмбэ, шинжилгээний үр дүнгийн үзүүлэлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 105. Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц дахь тулгамдаж буй асуудлууд

AHP Analytic Hierarchy Process (EVM multiple inputs)
 K. D. Goepel Version 26.07.2014 Free web based AHP software on: <http://bpmsg.com>
Only input data in the light green fields and worksheets!

n= 8 Number of criteria (3 to 10) Scale: 1 Linear
 N= 2 Number of Participants (1 to 20) α: 0.1 Consensus: 75.2%
 p= 1 selected Participant (0=consol.) 13 7 Participant 1

Objective Бичиг баримт бүрдүүлэлтийн үйл явц
 Author BSH
 Date 20-Jul-21 Thresh: 1E-07 Iterations: 9 EVM check: 4.2E-08

Table	Criterion	Comment	Weights	Rk
1	Цахим	Төрийн байгууллагын гэрчилгээ олгох үйл явц цахимж	21.3%	2
2	МХЕГ	МХЕГ-аас экспортын гэрчилгээ авах шат дараалал, з	23.8%	1
3	ГЕГ	ГЕГ-т квотын хэмжээг бус бодлогын гэрээгээр заасан	4.1%	8
4	Цар тахал	Цар тахалтай холбоотой төрийн байгууллагын ажилтн	11.4%	4
5	Бодлого төлөөлөл	Бичиг баримт бүрдүүлэлтийн хуулийн хугацаа урт бол	14.4%	3
6	Гадаад зах зээл	Экспортын барааны дамжин өнгөрөх, хүрэх газрын та	7.8%	6
7	МХЕГ	МХЕГ-аас гаргасан мэдэгдэл, гэрчилгээ нь алдаатай	7.3%	7
8	Нэмэлт зүйлс	Нотариатаар баталгаажуулах, орчуулгын товчооны та	9.8%	5
9		for 9&10 unprotect the input sheets and expand the	0.0%	
10		question section ("+" in row 66)	0.0%	

Result
 Eigenvalue lambda: 16.112
 Consistency Ratio 0.09 GCI: 2.33 CR: 82.7%

Matrix											normalized principal Eigenvector
	МХЕГ	ГЕГ	Цар тахал	Бодлого төлөвлөлт	Гадаад зах зээл	МХЕГ	Нэмэлт зүйлс	0	0	#N/A	
	1	2	3	4	5	6	7	8	9	10	
МХЕГ	1	9	7	5	1/5	1/3	1	1	-	-	21.33%
ГЕГ	1/9	1	7	3	9	5	5	9	-	-	23.76%
Цар тахал	1/7	1/7	1	1/3	1/9	5	1/7	1	-	-	4.10%
Бодлого төлөвлөлт	1/5	1/3	3	1	7	1	5	1/3	-	-	11.43%
Гадаад зах зээл	5	1/9	9	1/7	1	1	7	1	-	-	14.35%
МХЕГ	3	1/5	1/5	1	1	1	3	1/9	-	-	7.84%
Нэмэлт зүйлс	1	1/5	7	1/5	1/7	1/3	1	5	-	-	7.34%
0	1	1/9	1	3	1	9	1/5	1	-	-	9.84%
0	-	-	-	-	-	-	-	-	1	-	0.00%
#N/A	-	-	-	-	-	-	-	-	-	1	0.00%

Судалгаанд оролцогчид Экспортын бичиг баримт бүрдүүлэлтэд МХЕГ-аас экспортын гэрчилгээ авах шат дараалал, зарцуулах хугацаа их (23.8%), Төрийн байгууллагын гэрчилгээ олгох үйл явц цахимжаагүй (21.3%), Бичиг баримт бүрдүүлэлтийн хуулийн хугацаа урт боловч дээжийн шинжилгээний хариу 30 хоногийн хугацаатай хүчинтэй байх (14.4%), Цар тахалтай холбоотой төрийн байгууллагын ажилтнууд ажлын байран дээрээ байхгүй байх (11.4%), Нотариатаар баталгаажуулах, орчуулгын товчооны тамга гэх мэт бүрдүүлэх материалын жагсаалтад байхгүй материалуудыг нэхэх (9.8%), экспортын барааны дамжин өнгөрөх, хүрэх газрын талаар мэдээлэл хомс (7.8%), МХЕГ-аас гаргасан мэдэгдэл, гэрчилгээ нь алдаатай байх үүнээс шалтгаалж БНХАУ-ын хил дээрээс бараа буцаж ирдэг (7.3%), ГЕГ-т квотын хэмжээг бус бодлогын гэрээгээр заасан хэмжээг бүртгүүлдэг нь дахин дахин бүрдүүлэлт хийх шалтгаан болдог (4.1%) гэж эрэмбэлжээ.

Экспортын хил, гааль дээрх үйл явцад тулгамдаж буй асуудлын эрэмбэ, шинжилгээний үр дүнгийн үзүүлэлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 106. Хил, гааль дээрх үйл явцад тулгамдаж буй асуудлууд

AHP Analytic Hierarchy Process (EVM multiple inputs)
 K. D. Goepel Version 26.07.2014 Free web based AHP software on: <http://bpmsg.com>
 Only input data in the light green fields and worksheets!

n= 7 Number of criteria (3 to 10) Scale: 1 Linear
 N= 2 Number of Participants (1 to 20) α: 0.1 Consensus: 71.5%
 p= 1 selected Participant (0=consol.) 13 7 Participant 1

Objective Хил, гааль дээрх үйл явц

Author BSH
 Date 20-Jul-21 Thresh: 1E-07 Iterations: 10 EVM check: 7.4E-08

Table	Criterion	Comment	Weights	Rk
1	МХЕГ	Мэргэжлийн хяналтын байцаагч гаалийн бүрдүүлэлт	21.3%	2
2	ГЕГ-ын норм, стан	Гаалийн байцаагчийн хяналт шалгалт хийх норм, стан	14.0%	4
3	ГЕГ-ын дараалал	Гаалийн бүрдүүлэлт нь бичиг баримт бүрдүүлэлтийн	33.0%	1
4	Хүнд суртал	Төрийн байгууллагын ажилтнуудын хүнд суртал их	14.9%	3
5	Сав баглаа боодол	Сав баглаа боодлын стандарт шаардлага хангахгүй б	4.0%	6
6	ОХУ	Монголын гаалийн систем болон ОХУ-ын системийн	9.4%	5
7	Гацсан бараа	Хил дээр гацсан барааны талаар мэдээлэл авах бол	3.3%	7
8			0.0%	
9		for 9&10 unprotect the input sheets and expand the	0.0%	
10		question section ("*" in row 66)	0.0%	

Result
 Eigenvalue lambda: 11.859
 Consistency Ratio 0.07 GCI: 1.82 CR: 60.5%

Matrix	ГЕГ-ын норм, стандарт	ГЕГ-ын дараалал	Хүнд суртал	Сав баглаа боодол	ОХУ	Гацсан бараа	0	0	0	#N/A	normalized principal Eigenvector
	1	2	3	4	5	6	7	8	9	10	
ГЕГ-ын норм, ГЕГ-ын дараалал	1	9	1/7	5	5	1/3	1	-	-	-	21.35%
Хүнд суртал	1/9	1	1/7	3	9	5	5	-	-	-	13.97%
Сав баглаа боодол	7	7	1	1/3	9	5	7	-	-	-	33.02%
ОХУ	1/5	1/3	3	1	7	1	5	-	-	-	14.93%
Гацсан бараа	1/5	1/9	1/9	1/7	1	1	7	-	-	-	4.05%
0	3	1/5	1/5	1	1	1	3	-	-	-	9.41%
0	7	1/5	1/7	1/5	1/7	1/3	1	-	-	-	3.27%
0	-	-	-	-	-	-	-	1	-	-	0.00%
0	-	-	-	-	-	-	-	-	1	-	0.00%
#N/A	-	-	-	-	-	-	-	-	-	1	0.00%

Хил, гааль дээрх үйл явцад тулгамдаж буй асуудлуудыг эрэмбэлэхэд, Гаалийн бүрдүүлэлт нь бичиг баримт бүрдүүлэлтийн байцаагч, хяналтын байцаагч, ахлах байцаагч гэх мэт дараалалд хугацаа их шаардагддаг (33.0%), Мэргэжлийн хяналтын байцаагч гаалийн бүрдүүлэлтийн өмнө эсвэл дараа нь үзэж шалгах эсэх нь тодорхой бус байх (21.3%), Төрийн байгууллагын ажилтнуудын хүнд суртал их (14.9%), Гаалийн байцаагчийн хяналт шалгалт хийх норм, стандарт байхгүй (14.0%), Монголын гаалийн систем болон ОХУ-ын системийн уялдаагүй байдал (9.4%), Сав баглаа боодлын стандарт шаардлага хангахгүй байх (4.0%), Хил дээр гацсан барааны талаар мэдээлэл авах боломжгүй байдаг (3.3%) асуудлууд тулгамдаж байна.

Төрийн байгууллагын гэрчилгээ гаргаж өгөх хугацаа удаан, шат дамжлага их, ойлгомжгүй зүйл тайлбарлах тайлбарлалт муу, хүнд сурталтай, цахимжилт хангалтгүй байна.

Экспортын тээвэрлэлт, төлбөрийг хүлээн үйл явцад тулгамдаж буй асуудлын эрэмбэ, шинжилгээний үр дүнгийн үзүүлэлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 107. Экспортын тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явцад тулгамдаж буй асуудлууд

AHP Analytic Hierarchy Process (EVM multiple inputs)
 © D. Goepel Version 26.07.2014 Free web based AHP software on: <http://bpmsg.com>
Only input data in the light green fields and worksheets!

n= 6 Number of criteria (3 to 10) Scale: 1 Linear
 N= 2 Number of Participants (1 to 20) α: 0.1 Consensus: 71.3%
 p= 1 selected Participant (0=consol.) 13 7 Participant 1

Objective Тээвэрлэлт, төлбөрийг хүлээн авах үйл явц
 Author BSH
 Date 20-Jul-21 Thresh: 1E-07 Iterations: 11 EVM check: 4.4E-08

Table	Criterion	Comment	Weights	Rk
1	Гадаад зах зээл	Дамжин өнгөрөх болон хүрэх орнуудын бараанд тавиг	23.1%	2
2	Тээвэрлэгчид	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчид хангалттай бус	13.4%	4
3	Цар тахал	Цар тахалтай холбоотой хүндрэлүүд тээврийн хэрэг	35.5%	1
4	Тээвэрлэгчид	Барааг ачихаас өмнө төлбөрийг авах нөхцөлтэй байх	15.2%	3
5	Банк	Арилжааны банкны шимтгэл өндөр	2.4%	6
6	Гадаад төлбөр тоо	Олон улсын төлбөр тооцоонд зарцуулах хугацаа их, о	10.3%	5
7			0.0%	
8			0.0%	
9		for 9&10 unprotect the input sheets and expand the	0.0%	
10		question section ("+" in row 66)	0.0%	

Result
 Eigenvalue lambda: 10.399
 Consistency Ratio 0.09 GCI: 2.15 CR: 70.2%

Matrix											normalized principal Eigenvector
	Тээвэрлэгчид 1	Цар тахал 2	Тээвэрлэгчид 3	Банк 4	Гадаад төлбөр тооцоо 5	0 6	0 7	0 8	0 9	#N/A 10	
Тээвэрлэгчид 1	1	9	1/7	5	5	1/3	-	-	-	-	23.13%
Цар тахал 2	1/9	1	1/7	3	9	5	-	-	-	-	13.43%
Тээвэрлэгчид 3	7	7	1	1/3	9	5	-	-	-	-	35.55%
Банк 4	1/5	1/3	3	1	7	1	-	-	-	-	15.19%
Гадаад төлбөр 5	1/5	1/9	1/9	1/7	1	1	-	-	-	-	2.40%
0 6	3	1/5	1/5	1	1	1	-	-	-	-	10.30%
0 7	-	-	-	-	-	-	1	-	-	-	0.00%
0 8	-	-	-	-	-	-	-	1	-	-	0.00%
0 9	-	-	-	-	-	-	-	-	1	-	0.00%
#N/A 10	-	-	-	-	-	-	-	-	-	1	0.00%

Экспортын тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явцад тулгамдаж буй асуудлуудыг эрэмбэлэхэд, Цар тахалтай холбоотой хүндрэлүүд тээврийн хэрэгслийн тоо, олдоц муу, ариутгал хугацаа их шаарддаг (35.5%), Дамжин өнгөрөх болон хүрэх орнуудын бараанд тавигдах шаардлага тодорхой бус. Мэргэжлийн байгууллагуудын ажилтнууд ийм төрлийн мэдээлэлгүй (23.1%), Барааг ачихаас өмнө төлбөрийг авах нөхцөлтэй байх (15.2%), Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчид хангалттай бус (13.4%), Олон улсын төлбөр тооцоонд зарцуулах хугацаа их, олон банк дамждаг (10.3%), Арилжааны банкны шимтгэл өндөр (2.4%) гэжээ.

Одоогоор шинээр гадаад зах зээлд гарч буй жижиг экспортлогч нарын хувьд тэдгээрийн санхүүгийн гүйлгээ тооцоог хийхэд шимтгэлийн хувь өндөр байгаа тул төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд өрсөлдөхүйц хямд үнэтэй түргэн шуурхай санхүүгийн үйлчилгээг бий болгох нь чухал ач холбогдолтой байна.

Ачаа барааны замын мэдээлэл талаар мэдээлэл авах, мөшгөлт хийж дараа дараагийн үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаагаа төлөвлөх боломжгүйгээс эрсдэл ихтэй.

Экспорт, импорт бүрдүүлэх бичиг баримтын бүрдүүлэлт бүрэн цахимжаагүй, олон байгууллагаас бүрдүүлдэг, нэг төрлийн бичиг баримтыг 5 хувь үйлдэж холбогдох байгууллагуудад хүргэж 2-168 цагийн дотор шийдвэрлүүлж байгаа нь дүрэм журмын нийцэл муу, давхардал, шийдвэрлэгдэх цаг хугацаа, хүнд суртал хэтэрхий их болохыг Монгол улсын гадаад худалдааны хөгжилд хамгийн нөлөөлж буй хүчин зүйл юм.

Дээрх экспортын үйл явц дахь тулгамдсан асуудлуудыг судалгаанд оролцогчдоор эрэмбэлүүлснээс гадна орцуудын импортын төлбөр шилжүүлэх, бичиг баримт бүрдүүлэх, бүтээгдэхүүнийг хүлээн авах үйл явцад тулгамдсан асуудлуудыг эрэмбэлсэн АНР шинжилгээний үр дүнг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 108. Орцуудын импортын төлбөр шилжүүлэх, бичиг баримт бүрдүүлэх, бүтээгдэхүүнийг хүлээн авах үйл явцад тулгамдаж буй асуудлууд

AHP Analytic Hierarchy Process (EVM multiple inputs)

© D. Goepel Version 26.07.2014 Free web based AHP software on: <http://bpmsg.com>

Only input data in the light green fields and worksheets!

n= Number of criteria (3 to 10) Scale:

N= Number of Participants (1 to 20) α: Consensus:

p= selected Participant (0=consol.) 13 7

Objective

Author

Date Thresh: Iterations: 10 EVM check: 7.9E-08

Table	Criterion	Comment	Weights	Rk
1	Давхар шалгада	Мэргэжлийн хяналтын байцаагчийн шалгасан бар	11.9%	5
2	Бүрэн төлбөр ша	Төлбөрийг бүрэн төлж байж худалдагч тал барааг	23.6%	1
3	Норм, стандарт	Гаалийн хяналт шалгалтад тогтсон норм, стандар	21.6%	2
4	Лаборатори	Лабораторийн шинжилгээ их хугацаа шаарддаг	12.9%	4
5	Арилжааны банк	Арилжааны банкны шимтгэл өндөр	4.5%	8
6	Хүнд суртал	Гаалийн байгууллагын хүнд суртал, гаалийн талб	5.2%	7
7	Тээврийн зардал	Тээврийн зардал байдаг	6.0%	6
8	Олон шат дамжл	Гаалийн бүрдүүлэлт нь бичиг баримтын улсын ба	14.1%	3
9		for 9&10 unprotect the input sheets and expand the	0.0%	
10		question section ("+" in row 66)	0.0%	

Result Eigenvalue lambda:

Consistency Ratio 0.07 GCI: CR:

Matrix	Criteria										normalized principal Eigenvector
	Бүрэн төлбөр шаардах	Норм, стандарт	Лаборатори	Арилжааны банкны шимтгэл өндөр	Хүнд суртал	Тээврийн зардал өндөр	Олон шат дамжлагатай	0	0	#N/A	
Бүрэн төлбөр шаардах	1	1/3	7	1/5	5	1/3	1	1/9	-	-	11.94%
Норм, стандарт	9	1	1/9	3	9	5	5	9	-	-	23.61%
Лаборатори	1/7	9	1	1/3	9	5	7	1	-	-	21.64%
Арилжааны банкны	5	1/3	3	1	7	1	5	1/3	-	-	12.93%
Хүнд суртал	1/5	1/9	1/9	1/7	1	1	7	1	-	-	4.49%
Тээврийн зардал өндөр	3	1/5	1/5	1	1	1	3	1/9	-	-	5.20%
Олон шат дамжлагатай	1	1/5	1/7	1/5	1/7	1/3	1	5	-	-	6.05%
0	9	1/9	1	3	1	9	1/5	1	-	-	14.14%
0	-	-	-	-	-	-	-	-	1	-	0.00%
#N/A	-	-	-	-	-	-	-	-	-	1	0.00%

Орцуудын импортын төлбөр шилжүүлэх, бичиг баримт бүрдүүлэх, бүтээгдэхүүнийг хүлээн авах үйл явцад тулгамдсан асуудлуудыг эрэмбэлсэн шинжилгээний дүнгээс харахад, төлбөрийг бүрэн төлсөн нөхцөлд барааг ачуулдаг (23.6%), гаалийн хяналт, шалгалтад тогтсон норм, стандарт байхгүй (21.6%), гаалийн бүрдүүлэлт нь бичиг баримтын гаалийн улсын байцаагч, хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч зөвшөөрсний дараа гаалийн улсын ахлах байцаагчаар зөвшөөрлийг баталгаажуулах олон шат дамжлага дамждаг (14.1%), лабораторийн шинжилгээ хийхэд их хугацаа зарцуулдаг (12.9%), Хилийн мэргэжлийн хяналтын байцаагчийн мэргэжлийн онцлогтой шалгасан баримт бичгийг гаалийн улсын байцаагч давхар шалгах тохиолдол гардаг (11.9%), дотоодын тээврийн зардал өндөр (6.1%), гаалийн байгууллагын хүнд

суртал, гаалийн талбайн ашиглалтын зохион байгуулалт муу (5.2%), арилжааны банкны шимтгэл өндөр (4.5%) байна.

Судалгаанд оролцогчдоос экспортын бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль дээрх үйл явц, тээвэр, төлбөр хүлээн авах явцыг сайжруулах санал авч чухал гэж үнэлсэн дарааллыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 109. Экспортын бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль дээрх үйл явц, тээвэр, төлбөр хүлээн авах явцыг сайжруулах санал

AHP Analytic Hierarchy Process (EVM multiple inputs)
 K. D. Goepel Version 26.07.2014 Free web based AHP software on: <http://bpmsg.com>
 Only input data in the light green fields and worksheets!

n= 8 Number of criteria (3 to 10) Scale: 1 Linear
 N= 2 Number of Participants (1 to 20) α: 0.1 Consensus: 93.1%
 p= 1 selected Participant (0=consol.) 13 7 Participant 1

Objective Экспортын бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль дээрх үйл явц, тээвэр, төлбөр хүлээн авах явцыг сайжруулах санал

Author BSH
Date 20-Jul-21 Thresh: 1E-07 Iterations: 10 EVM check: 7.9E-08

Table	Criterion	Comment	Weights	Rk
1	Чиг үүргийн давхардлыг	Гааль, мэргэжлийн хяналтын чиг үүргийн давхардлыг	11.9%	5
2	Цахимд зурган мэдээллийг солилцох	Цахим сүлжээнд зурган мэдээллийг солилцох	23.6%	1
3	Цар тахлын сөрөг нөлөөг бууруулах \тээвэр, ариутгал	Цар тахлын сөрөг нөлөөг бууруулах \тээвэр, ариутгал	21.6%	2
4	Олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллах	Далайд гарцгүй орны хувьд олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллах	12.9%	4
5	Платформ үүсгэх	Арилжааны платформ бий болгох, худалдааны олон суваг бий болгох	4.5%	8
6	Гадаад түнштэй хамтран ажиллах	Гадаад зах зээлд бүтээгдэхүүнийг борлуулах дистрибьютер, түнш, харилцагчтай байх	5.2%	7
7	Мэргэшсэн зөвлөх	Олон улсын худалдааны талаар мэргэшсэн сайн зөвлөх	6.0%	6
8	Лаборатори	Экспортын бүтээгдэхүүний шинжилгээ хийх лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, тоог өсгөх	14.1%	3
9			0.0%	
10			0.0%	

Result
 Eigenvalue lambda: 16.780
 Consistency Ratio 0.07 GCI: 2.42 CR: 89.5%

Matrix	Цахимд зурган мэдээллийг солилцох	Цар тахлын сөрөг нөлөөг бууруулах \тээвэр, ариутгал	Олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллах	Платформ үүсгэх	Гадаад түнштэй хамтран ажиллах	Мэргэшсэн зөвлөх	Лаборатори	0	0	#N/A	normalized principal Eigenvector
	1	2	3	4	5	6	7	8	9	10	
Цахимд зурган мэдээллийг солилцох	1	1/9	7	1/5	5	1/3	1	1/9	-	-	11.94%
Цар тахлын сөрөг нөлөөг бууруулах \тээвэр, ариутгал	9	1	1/9	3	9	5	5	9	-	-	23.61%
Олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллах	1/7	9	1	1/3	9	5	7	1	-	-	21.64%
Платформ үүсгэх	5	1/3	3	1	7	1	5	1/3	-	-	12.93%
Гадаад түнштэй хамтран ажиллах	1/5	1/9	1/9	1/7	1	1	7	1	-	-	4.49%
Мэргэшсэн зөвлөх	3	1/5	1/5	1	1	1	3	1/9	-	-	5.20%
Лаборатори	1	1/5	1/7	1/5	1/7	1/3	1	5	-	-	6.05%
0	9	1/9	1	3	1	9	1/5	1	-	-	14.14%
0	-	-	-	-	-	-	-	-	1	-	0.00%
#N/A	-	-	-	-	-	-	-	-	-	1	0.00%

Экспортын бичиг баримт бүрдүүлэлт, хил гааль дээрх үйл явц, тээвэр, төлбөр хүлээн авах явцыг сайжруулах саналыг эрэмбэлэхэд, Цахим сүлжээнд зурган мэдээллийг солилцох (23.6%), Цар тахлын сөрөг нөлөөг бууруулах \тээвэр, ариутгал, төлбөрийн хугацааг зохицуулах\ (21.6%), Экспортын бүтээгдэхүүний шинжилгээ хийх лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, тоог өсгөх (14.1%), Далайд гарцгүй орны хувьд олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллах, өмнө нь шийдэгдсэн өндөр ач холбогдолтой ажлуудыг урагшлуулах (12.9%), Гааль, мэргэжлийн хяналтын чиг үүргийн давхардлыг арилгах (11.9%), Олон улсын худалдааны талаар мэргэшсэн сайн зөвлөх, эксперттэй ажиллуулах (6.0%), Гадаад зах зээлд бүтээгдэхүүнийг борлуулах дистрибьютер, түнш, харилцагчтай байх (5.2%), Арилжааны платформ бий болгох, худалдааны олон суваг бий болгох (4.5%) байна.

Судалгаанд оролцогчдоос өгсөн Импортын бүтээгдэхүүний төлбөр шилжүүлэх, бичиг баримт бүрдүүлэх, бүтээгдэхүүнийг хүлээн авах үйл явцыг сайжруулах саналууд болон тэдгээрийн эрэмбийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 110. Импортын бүтээгдэхүүний төлбөр шилжүүлэх, бичиг баримт бүрдүүлэх, бүтээгдэхүүнийг хүлээн авах үйл явцыг сайжруулах санал

AHP Analytic Hierarchy Process (EVM multiple inputs)
 K. D. Goepel Version 26.07.2014 | Free web based AHP software on: <http://bpmsg.com>
Only input data in the light green fields and worksheets!

n= 5 Number of criteria (3 to 10) Scale: 1 Linear
 N= 2 Number of Participants (1 to 20) α: 0.1 Consensus: 61.8%
 p= 1 selected Participant (0=consol.) 13 7 Participant 1

Objective Импортын бүтээгдэхүүний төлбөр шилжүүлэх, бичиг баримт бүрдүүлэх, бүтээгдэхүүнийг хүлээн авах үйл явцыг сайжруулах санал

Author BSH
Date 20-Jul-21 Thresh: 1E-07 Iterations: 12 EVM check: 7.7E-08

Table	Criterion	Comment	Weights	Rk
1	Мэргэжилтнүүдийн	Бүтээгдэхүүний орц нарийн, тодорхой бичих сургалт	37.5%	1
2	Гарын авлага	Гадаад худалдааны гарын авлага боловсруулах	7.5%	5
3	Гадаад логистикийн	Хөрш орнуудын болон олон улсын логистикийн тогтолцоог бодлогын түвшинд судлах	33.2%	2
4	Цахимжуулах	Цахим шилжилтийг хийх	8.9%	4
5	Урьдчилсан бүрдүүлэлт	Урьдчилсан бүрдүүлэлтийн горимыг хөнгөвчлөх	13.0%	3
6			0.0%	
7			0.0%	
8			0.0%	
9			0.0%	
10		for 9&10 unprotect the input sheets and expand the question section (* in row 66)	0.0%	

Result
 Eigenvalue lambda: 7.527
 Consistency Ratio 0.09 GCI: 1.81 CR: 56.2%

Matrix

	Гарын авлага	Гадаад логистикийн судалгаа	Цахимжуулах	Урьдчилсан бүрдүүлэлт	0	0	0	0	0	#N/A	normalized principal Eigenvector
Гарын авлага	1	9	1/5	9	7	-	-	-	-	-	37.47%
Гадаад логистикийн	1/9	1	1	1	1/5	-	-	-	-	-	7.48%
Цахимжуулах	5	1	1	1	1	-	-	-	-	-	33.21%
Урьдчилсан бүрдүүлэлт	1/9	1	1	1	1	-	-	-	-	-	8.86%
0	1/7	5	1	1	1	-	-	-	-	-	12.99%
0	-	-	-	-	-	1	-	-	-	-	0.00%
0	-	-	-	-	-	-	1	-	-	-	0.00%
0	-	-	-	-	-	-	-	1	-	-	0.00%
0	-	-	-	-	-	-	-	-	1	-	0.00%
#N/A	-	-	-	-	-	-	-	-	-	1	0.00%

Импортын бүтээгдэхүүний төлбөр шилжүүлэх, бичиг баримт бүрдүүлэх, бүтээгдэхүүнийг хүлээн авах үйл явцыг сайжруулах саналуудыг эрэмбэлсэн шинжилгээний дүнгээс нэгтгэхэд, Бүтээгдэхүүний орц нарийн, тодорхой бичих сургалт зохион байгуулах (37.5%), Хөрш орнуудын болон олон улсын логистикийн тогтолцоог бодлогын түвшинд судлах (33.2%), Урьдчилсан бүрдүүлэлтийн горимыг хөнгөвчлөх (13.0%), Цахим шилжилтийг хийх (8.9%), Гадаад худалдааны гарын авлага боловсруулах (7.5%) санал өгсөн байна.

Монгол улсын гадаад худалдааны үйл ажиллагаанд хамгийн их нөлөөтэй гадаад хүчин зүйл нь олон улсын тээвэр логистик бөгөөд тэр дундаа дэлхий худалдааны 90 орчим хувийг тээвэрлэдэг далайн тээврийн эрэлт хэрэгцээ түүхэнд байгаагүйгээр нэмэгдсэнээс болж бусад төмөр замын өртөө боомтуудаа ачаалснаас үүдэн вагоны хүрэлцээгүй болж, автомашинууд нь

ачаатайгаа хил гааль дээр дараалал үүсгэн хорио цээрт орсон зэрэг шалтгаанаас үүдэн экспортын тээврийн зардал, нийлүүлэлтийн хугацаа, экспортын орлого зэрэг бие биеэсээ үүсмэл шинж бүхий эрсдэл хоёр хөршийн тээвэр логистикийн системээс ихээхэн хамааралтай, далайд гарцгүй манай орны хувьд маш том тулгамдсан асуудал болж байна. Түүнчлэн БНХАУ-д чингэлэг худалдаж авах үнэ өсөж энгийн үед Шанхайн боомт дээр шинэ чингэлэг 2300-2600 ам долларт, хуучин нь 1000 ам.доллар хавьд байсан бол өнөөдөр хуучин нь 3400 ам.долларт хүрээд байна. Монголд ч мөн адил 20 футийн чингэлэг 5 сая, 40 футийн чингэлэг 10 сая төгрөгт хүрсэн нь тээвэр, логистикийн салбарт маш том эрсдэл үүсэж байна.

4.2.ГАДААД УЛС ОРНУУДЫН САЙН ТУРШЛАГА

4.2.1.Экспорт, импортын замын зураглал

Монгол, БНХАУ, ОХУ-ын экспорт, импортод зарцуулах цаг хугацаа болон экспорт, импортын зарим үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд зэрэгцүүлэн харуулав.

Хүснэгт 111. Монгол, ОХУ, БНХАУ-ын логистикийн гүйцэтгэлийн индексийн харьцуулалт, 2018

Үзүүлэлт	Монгол	Хятад	ОХУ
Боомт нисэх, буудлын нийлүүлэлтийн хэлхээ /Экспортын хугацаа, зай/			
Зай (км)	N/A	337км	306 км
Үргэлжлэх хугацаа (өдөр)	N/A	2 өдөр	3 өдөр
Хуурай газрын нийлүүлэлтийн хэлхээ /Экспортын хугацаа, зай /			
Зай (км)	1250км	707км	3500км
Үргэлжлэх хугацаа (өдөр)	14 өдөр	6 өдөр	3 өдөр
Боомт нисэх буудлын нийлүүлэлтийн хэлхээ /Импортын хугацаа, зай			
Зай (км)	N/A	328км	2646км
Үргэлжлэх хугацаа (өдөр)	N/A	6 days	5 days
Хуурай газрын нийлүүлэлтийн хэлхээ /Импортын хугацаа, зай/			
Зай (км)	1250км	784км	2092км
Үргэлжлэх хугацаа (өдөр)	14 өдөр	4 өдөр	9 өдөр
Шаардлага хангасан тээвэрлэлт (%)			
Экспортын үйл ажиллагаатай холбоотой агентлагуудын тоо	88%	81%	69%
Импортын үйл ажиллагаатай холбоотой агентлагуудын тоо	2	3	3
Экспортын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтын тоо	N/A	3	3
Импортын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтын тоо	11	4	2
Биет үзлэг хийгдэхгүй гаалийн бүрдүүлэлт (өдрөөр)	11	4	2
Биет үзлэг хийгдэх гаалийн бүрдүүлэлт (өдрөөр)	1 өдөр	1 өдөр	2 өдөр
Биет үзлэг хийгдэх гаалийн бүрдүүлэлт (өдрөөр)	1 өдөр	2 өдөр	4 өдөр
Олон төрөлт (%)	75%	3%	22%
Электрон болон онлайннар мэдүүлсэн болон боловсруулсан мэдүүлэг (%)	75%	1%	4%
Зөвшөөрөлтэй гаалийн зуучлагч ашигласан импортлогч(%)	92%	71%	43%
Эцсийн бүрдүүлэлт хийх газраа сонгох боломжтой байдал (%)	100%	71%	88%
Гаалийн бүрдүүлэлт хүлээгдэж буй нөхцөлд бараагаа авах (%)	33%	83%	88%

Эх үүсвэр: (WB, 2020), <https://lpi.worldbank.org/international/scorecard/>

Монгол улсын LPI-ийн үзүүлэлтийг хөрш зэргэлдээ 2 улсын үзүүлэлттэй харьцуулахад гаалийн байгууллагын үйл ажиллагаа, ачаа тээвэрлэлтийн мэдээлэл болон цаг хугацааны үзүүлэлтүүд доогуур түвшинд үнэлэгдсэн байна. Энэ нь Монгол улсын хувьд гадаад зах зээл рүү гарах хилийн боомт цөөн, гадаад худалдаанд шаардлагатай бичиг баримтын тоо их, тэдгээрийг олгох эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоо сул, дэд бүтцийн сул хөгжил, ачаа барааг хянаж шалгах системийн хөгжил сул болохыг илтгэнэ.

Хүснэгт 112. Гадаад улс орнуудын экспортын бичиг баримт бүрдүүлэлт

Баримт бичиг	ОХУ	БНХАУ	АНУ	БНСУ	Хонконг	Беларусь	ЕХ	тайвань
Экспортын гэрээний бүртгэл	48 цаг	+	+	+	+	+	+	+
Экспортын гэрээ	72 цаг	+	+	+	+	+	+	+
Жимс, ногоо экспортлох гэрээ	72 цаг	+	+	+	+	+	+	+
Биржийн гэрээ	72 цаг	+	+	+	+	+	+	+
Барааны гаалийн шалгалт хийх \Хэрэв мэдүүлэг гаргагч нь гаалийн мэдүүлэг өгөх, шаардлагатай баримт бичиг, мэдээллийг барааг гаргасан өдрөөс хойш 45 хоногоос хэтрэхгүй хугацаанд өгөх үүргээ бичгээр гаргаснаар ийм хувилбар гаргахыг зөвшөөрнө\	72 цаг	+	+	+	+	+	+	+
Дамжин өнгөрөх тээврийн бичиг баримт	+	+	+	+	+	+	+	+
Экспортын гаалийн мэдүүлэг	+	+	+	+	+	+	+	+
Гаалийн хураамж төлсөн баримт	+	+	+	+	+	+	+	+
Гарал үүслийн бичиг	+	+	+	+	+	+	+	+
Баглаа боодлын жагсаалт	+	+	+	+	+	+	+	+
Чөлөөт худалдааны баримт бичиг	+	+	+	+	+	+	+	+

Эх үүсвэр: Как экспортировать кспортировать на рынки а рынки стран СНГ.
https://chamber.uz/uploads/posts/files/kak_eksp.pdf

Дээрх хүснэгтээс харахад, гадаад улс орнуудын экспортод шаарддаг бичиг баримт үндсэндээ ижил байна.

Итали улс:

Дэлхийн банкны 2020 оны Doingbusiness-ийн судалгаагаар, Итали улс дэлхийн 190 гаруй улсаас экспорт, импортын худалдааны үйл явцад зарцуулах хугацаа, зардлын үзүүлэлтүүдийн үнэлгээгээр хамгийн өндөр оноо авч тэргүүн байранд орсон байна.

Итали улсын экспорт, импортын үйл ажиллагаанд шаардлагатай бичиг баримтын бүрдүүлэлтэд шаардлагатай материалуудыг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 113. Итали улсын экспорт, импортод шаардагддаг бичиг баримтууд

Экспорт	Импорт
<ul style="list-style-type: none"> Улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай Конвенц"/CMR/-ийн шаардлага бүхий тээврийн бичиг баримт 	<ul style="list-style-type: none"> Улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай Конвенц"/CMR/-ийн шаардлага бүхий тээврийн бичиг баримт
<ul style="list-style-type: none"> Нэхэмжлэх 	<ul style="list-style-type: none"> Нэхэмжлэх
<ul style="list-style-type: none"> Сав баглаа боодлын жагсаалт 	<ul style="list-style-type: none"> Сав баглаа боодлын жагсаалт
<ul style="list-style-type: none"> Intrastat- Европын холбооны нутаг дэвсгэр хийгдэх буй бараа, бүтээгдэхүүний урсгалын гаалийн мэдүүлгийн систем 	<ul style="list-style-type: none"> Intrastat- Европын холбооны нутаг дэвсгэрт хийгдэх буй бараа, бүтээгдэхүүний урсгалын гаалийн мэдүүлгийн систем

БНЭУ:

БНЭУ-ын экспорт, импортын үйл ажиллагаанд шаардлагатай бичиг баримтын бүрдүүлэлтэд шаардлагатай материалуудыг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 114. БНЭУ-ын экспорт, импортод шаардагддаг бичиг баримтууд

Экспорт	Импорт
<ul style="list-style-type: none"> Ачаа тээврийн баримт 	<ul style="list-style-type: none"> Үнийн нэхэмжлэх
<ul style="list-style-type: none"> Үнийн нэхэмжлэх 	<ul style="list-style-type: none"> Баглаа боодлын жагсаалт
<ul style="list-style-type: none"> Баглаа боодлын жагсаалт 	<ul style="list-style-type: none"> Импортын манифест
<ul style="list-style-type: none"> Гаалийн мэдүүлэг 	<ul style="list-style-type: none"> Нэвтрэх хуудас
<ul style="list-style-type: none"> Ачааны терминалын баримт 	<ul style="list-style-type: none"> Гарал үүслийн гэрчилгээ
<ul style="list-style-type: none"> Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ 	<ul style="list-style-type: none"> Ачаа тээврийн баримт
	<ul style="list-style-type: none"> Ачааны зөвшөөрлийн бичиг
	<ul style="list-style-type: none"> Цахим хүргэлтийн баримт
	<ul style="list-style-type: none"> Ачааны терминалын баримт
	<ul style="list-style-type: none"> Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ

Эх үүсвэр: (WB, 2020), Doingbusiness.org

Бразил улс:

Бразил улсын экспорт, импортын үйл ажиллагаанд шаардлагатай бичиг баримтын бүрдүүлэлтэд шаардлагатай материалуудыг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 115. Бразил улсын экспорт, импортод шаардагддаг бичиг баримтууд

Экспорт	Импорт
• Ачаа тээврийн баримт	• Үнийн нэхэмжлэх
• Үнийн нэхэмжлэх	• Баглаа боодлын жагсаалт
• Гаалийн мэдүүлэг	• Ачааны манифест
• Экспортын нэхэмжлэх	• Банкны бичиг баримт
• Баглаа боодлын жагсаалт	• Гарал үүслийн гэрчилгээ
• Эрүүл ахуйн гэрчилгээ	• Төлбөрийн баримт
• Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ	• Гаалийн импортын мэдүүлэг

Эх үүсвэр: (WB, 2020), *Doingbusiness.org*

БНХАУ:

БНХАУ-д бүтээгдэхүүнээ экспортлоход нийтлэг дараах бичиг баримтыг шаарддаг байна. Үүнд:

- ✚ Худалдааны нэхэмжлэх
- ✚ Сав баглаа боодлын жагсаалт
- ✚ Ачааны тооцооны хуудас
- ✚ Экспортын мэдүүлэг
- ✚ Терминалын үйлчилгээний төлбөр
- ✚ SOLAS –гэрчилгээ / SOLAS олон улсын конвенцын стандарт бүхий далайн тээврийн аюулгүй байдалтай холбоотой гэрчилгээнүүд /

БНХАУ-д экспортлох бүтээгдэхүүний нэр төрлөөс хамаарч бүтээгдэхүүн тус бүрд ялгаатай байгаа бөгөөд сүүн бүтээгдэхүүн нийлүүлэхэд дараах баримт бичиг шаарддаг. Үүнд:

1. Гарал үүслийн гэрчилгээ. Уг гэрчилгээнд бараа нь экспортлогч улсаас гаралтай бөгөөд түүнд агуулагдах мэдээлэл бодит байдалд нийцэж байх ёстой.
2. Шалгалт, хорио цээрийн дэглэмийн гэрчилгээ. Энд чанарын гэрчилгээ, хорио цээр, аюулгүй байдлын шалгалт хамаарна. БНХАУ-ын Чанарын хяналт, хяналт, хорио цээрийн ерөнхий газрын харьяанд (Чанарын хяналт, хяналт, хорио цээрийн ерөнхий газар)-аас гэрчилгээг авахын тулд экспортлогч системд бүртгүүлсэн байна.
3. Сав баглаа боодол, шошгын тохирлын гэрчилгээ (БНХАУ-д хоол, хүнс импортлоход Шошгын баталгаажуулалтын гэрчилгээ авах шаардлагатай);
4. Хүнсний бүтээгдэхүүний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл;
5. Импорт-экспортын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (<http://www.sinoconsult.ru/cases/license>, 2020)²³

БНХАУ руу экспорт хийж эхлэхэд дараах алхмуудыг хийж гүйцэтгэсэн байвал зохино. Үүнд:


- ✚ Чанарын хяналт, шалгалтын ерөнхий захиргаанд бүртгүүлэх
- ✚ БНХАУ-ын хорио цээрийн дэглэм, бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтад тэнцэх
- ✚ Хятадад хүнсний бүтээгдэхүүний барааны тэмдгийн бүртгэлд хамрагдах.

БНХАУ-д хуурай сүү экспортлох ОХУ-ын талд дараах материалуудыг бүрдүүлэхийг шаарддаг байна.

- ✚ Мал эмнэлэг, фитосанитарийн тандалтын холбооны албаны зөвшөөрөл \үүний тулд БНХАУ руу бараа бүтээгдэхүүнийг туршилтаар хүргэх\
- ✚ Экспортын барааг БНХАУ-ын мал эмнэлгийн шаардлагатай нийцүүлэх (РосСельхозНадзор)
- ✚ Экспортлогч компани шалгалт өгөх ёстой
- ✚ Хүнсний аюулгүй байдлын гэрчилгээ
- ✚ Манифест
- ✚ Техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн гэрчилгээ
- ✚ Галын аюулгүй байдлын гэрчилгээ
- ✚ Улсын бүртгэлийн гэрчилгээ

²³ <http://www.sinoconsult.ru/cases/license>

Зураг 42. ОХУ-д бараа, бүтээгдэхүүнийг экспортлох үйл явцын дараалал



- Алхам 1: Борлуулалтын харилцагчтай холбоо тогтоох
 Алхам 2: Худалдагч багцыг БНХАУ дахь агуулахад илгээх
 Алхам 3: Нислэгийн өдөр хүртэл агуулахад хадгалах
 Алхам 4: Гаалийн баримт бичгийн бүрдүүлэлт хийх
 Алхам 5: Бүтээгдэхүүнийг БНХАУ нисэх онгоцны буудал руу илгээх
 Алхам 6: Нисэх онгоцны буудлаас үзлэг хийсний дараа ачааг онгоцонд ачих
 Алхам 7: БНХАУ-аас ОХУ руу дамжин өнгөрөх хугацаа 1-3 хоног үргэлжилнэ
 Алхам 8: ОХУ дахь үйлчлүүлэгчдэдээ гаалийн бүрдүүлэлт хийх
 Алхам 9: ОХУ-д гаалийн бүрдүүлэлт хийсний дараа хэрэглэгчийн багцыг түүний хаягаар ОХУ-д илгээнэ

ОХУ-д 2010 оноос хойш хушны самрыг экспортлох лицензийг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд түүхий эд экспортлох тусгай зөвшөөрөл авах шаардлагатай. Лиценз авахын тулд түрээсийн гэрээний үндсэн дээр хуш модны түүхий эд бэлтгэснийг баталгаажуулсан баримт бичиг бүрдүүлнэ.

ОХУ-аас хушны самрыг экспортлох үйл явцыг судаллаа. ОХУ хушны самрыг гаалийн бүрдүүлэлт хийх явцад бэрхшээл гарахгүй байх, экспортын үйл ажиллагааг түргэсгэхийн тулд гэрчилгээжүүлэх дээжийг ОХУ-аас урьдчилан экспортлох нь зүйтэй. Худалдааны гол багцыг экспортлохын тулд э 5-7 килограмм жинтэй бүтээгдэхүүний дээжийг экспортолно. Дээжийг баталгаажуулах замаар эрхийг олгоно. Эрх авсны дараа арилжааны багцыг импортлох дараалсан үйл ажиллагааг зохион байгуулна:

- ✚ Хушны самар (CIS) ST-1 гэрчилгээ
- ✚ Хушны самар ST-1 гэрчилгээг бүртгүүлэх баримт бичиг
- ✚ Өргөдөл \и-мэйлээр бөглөсөн\
- ✚ Гадаад худалдааны гэрээ
- ✚ Найрлагын талаарх үйлдвэрлэгчийн мэдээллийн захидал
- ✚ Нэхэмжлэх
- ✚ Ачаа тээшний загвар;
- ✚ "Гаргахыг зөвшөөрсөн" гэж тэмдэглэсэн барааны мэдүүлэг

Тэмдэглэгээг тухайн орны хэлээр бичиж байрлуулж, жижиглэнгийн борлуулалтад зориулж хувийн багц тус бүр дээр байрлуулна. Энд дараах мэдээллүүдийг агуулсан байх ёстой.

- + Бүтээгдэхүүний нэр
- + Цэвэр жин
- + Үйлдвэрлэсэн огноо
- + Хадгалах нөхцөл
- + Хадгалах хугацаа
- + Үйлдвэрлэгч
- + Үйлдвэрлэгчийн хаяг
- + Импортлогч
- + Импортлогчийн хаяг

Энэхүү тэмдэглэгээг барааны ханган нийлүүлэгч бүтээгдэхүүний сав баглаа боодол дээр тавьдаг.

Австрали улс:

Австрали улс нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн тэр дундаа мах, махан бүтээгдэхүүний экспортоор дэлхийд эхний 5-д ордог. Дараах төрлийн бүтээгдэхүүний экспортыг Австралийн Засгийн газраас хяналт тавьж зохицуулдаг байна. Үүнд:

- Сүүн бүтээгдэхүүн
- Өндөг, өндгөн бүтээгдэхүүн
- Загас, загасан бүтээгдэхүүн
- Амьд амьтан
- Мах, махан бүтээгдэхүүн
- Органик болон биодинамик бүтээгдэхүүн
- Ургамал, ургамлын бүтээгдэхүүн

Хөдөө аж ахуйн гаралтай Засгийн газрын хяналттай бүтээгдэхүүнүүд нь аль улс руу экспортлохоос хамаарч квоттой байдаг. Жишээ нь Европын холбооны улсууд руу экспортлох өндөр чанарын үхрийн махны жилийн квотын хэмжээ 7150 тонн байдаг. Квот авсан аж ахуйн нэгж нь өөр этгээдэд квотоо шилжүүлж болдог байна.

Busting Congestion for Agricultural Exporters 2020-2021

Австралийн Засгийн газар хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын ачааллыг бууруулах, хөнгөвчлөх зорилгоор 2020-2021 оноос эхлүүлэн 4 жилийн хугацаанд үргэлжлэх “Busting Congestion for Agricultural Exporters” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон бөгөөд тус хөтөлбөрийн нийт төсөв нь 328.4 сая австрали доллар. Тус хөтөлбөрийн хүрээнд хүнд суртлыг бууруулах, хөдөө аж ахуйн салбарт ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох хугацаа болон зардлыг бууруулахад цахим системийг сайжруулах ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөн байна.

Австралид мах экспортлоход “Махны экспортын лиценз” шаардлагатай бөгөөд Австрали улсын 2020 оны Экспортын хяналтын тухай хуулиар зохицуулагддаг байна. Тус зөвшөөрлийг Австралийн Засгийн газрын Хөдөө аж ахуй, ус, байгаль орчин хариуцсан салбар нэгж нь олгодог бөгөөд харин экспортлогчдын хувьд “AUS-MEAT” хэмээх (эсхүл түүнтэй адилтгах) магадлан итгэмжлэлийг хангасан байх шаардлагатай болдог. Үнийн хувьд лицензийн жилийн хураамж нь 500.00 Австрали доллар байдаг байна. Махны экспортын лиценз авахыг хүссэн этгээд AUS-MEAT магадлан итгэмжлэлийг хангасны дараа цахимаар өргөдлийн маягт бөглөн хүсэлтээ гаргадаг. Лицензтэй байгууллага нь экспорт хийхдээ EXDOC цахим программ ашиглан шаардлагатай бүх бичиг баримтаа бүрдүүлдэг.

AUS-MEAT магадлан итгэмжлэл

AUS-MEAT болон AUS-QUAL нь Австрали болон Шинэ Зеланд улсад хөдөө аж ахуйн бизнесийн хяналт шалгалт, гэрчилгээжүүлэлт, сургалт явуулдаг байгууллага бөгөөд 70 гаруй төрлийн магадлан итгэмжлэлийн хөтөлбөртэй. Тус байгууллага нь ашгийн бус байгууллага бөгөөд олон улсын түвшинд чанар баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа явуулдаг байна.

Үйлчилгээ, хөтөлбөрүүд нь амьд амьтан, мал, мах, боловсруулсан бүтээгдэхүүн, газар тариалан, шувууны аж ахуй, өндөг, болон бусад гэсэн бүтээгдэхүүний ангилалтай байна.

Мах экспортлоход зориулагдсан боловсруулах үйлдвэр, агуулах зэрэг байгууламжууд Хөдөө аж ахуй, ус, байгаль орчны яаманд бүртгэгдсэн байх шаардлагатай. Ийнхүү бүртгүүлэхэд Яамны нарийн бичгийн даргад EX26 маягтын дагуу хүсэлт илгээх бөгөөд зөвхөн нарийн бичгийн дарга бүртгэдэг байна. Бүртгэл нь гурван үндсэн үзүүлэлтийг баримталдаг. Үүнд:

- “Export Control Act 1982”-ын дагуу тухайн байгууламжийн удирдах шатны ажилтнуудын үнэлгээ
- Татварын өр төлбөргүй байх
- Техникийн чадамж, шаардлага хангасан байдал

Бүртгэлийг хүсэлт хүлээн авснаас хойш шийдвэрлэх хугацаа бүтээгдэхүүний ангиллаас хамаарч өөр өөр байдаг бөгөөд харин махны хувьд 60 хоног дотор шийдвэрлэдэг байна. Тус бүртгэл нь мах, махан бүтээгдэхүүн экспортлох үед экспортын зөвшөөрөл болон эрүүл ахуйн гэрчилгээг EXDOC цахим системээр авахад давхар шалгагддаг байна.

Экспортын зөвшөөрөл

Экспортын хяналтын 2005 оны тогтоолын дагуу Австралиас экспортлох мах, махан бүтээгдэхүүнд экспортын зөвшөөрөл заавал авна. Экспортын зөвшөөрлийн гол үүрэг нь бүтээгдэхүүнийг экспортод гаргах боломжтой эсэхийг баталгаажуулах явдал бөгөөд экспортын бүрдүүлэлт хийхээс өмнө Австралийн гааль, хил хамгаалах алба шаарддаг. Экспортын зөвшөөрөл нь 28 хоногийн хугацаанд хүчинтэй бөгөөд барааг гаргахаас өмнө авсан байх шаардлагатай.

Засгийн газрын гэрчилгээ

Засгийн газрын гэрчилгээ нь тухайн газраас экспортолж буй бүтээгдэхүүний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан, импортлогч орны шаардлагыг хангасан болохыг баталгаажуулсан албан ёсны баримт бичиг юм. Засгийн газрын гэрчилгээнд импортын улсын шаардлагаас хамааран мал эмнэлгийн ажилтан эсвэл эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурдаг. Засгийн газрын гэрчилгээг авах хүсэлт гэж тусдаа байдаггүй буюу экспортын зөвшөөрөл хүссэн өргөдөл нь давхар тус гэрчилгээг олгоход шалгагддаг.

Экспортын зөвшөөрөл болон Засгийн газрын гэрчилгээ хүсэгч нь EXDOC цахим системийг ашиглан хүсэлтээ илгээдэг. Австрали улсын махны экспортын үйл явцын зураглалыг дараах зургаар харуулав.

Зураг 43. Австрали улсын махны экспортын үйл явцын дараалал



Эх үүсвэр: (WB, 2020), Doingbusiness.org

Дээрх зургаас харахад, Австрали улсын махны экспортын үйл явц олон төрлийн гэрчилгээ шаарддаггүй буюу Экспортын зөвшөөрөл, ариун цэврийн гэрчилгээ (тохирлын гэрчилгээ), гарал үүслийн гэрчилгээ гэсэн гурван бичиг баримтыг цахим нэг цонхны үйлчилгээгээр авдаг байна.

Австрали улсын экспорт, импортод шаардагддаг бичиг баримтын жагсаалтыг дараах хүснэгтээр харуулав.


Хүснэгт 116. Австрали улсын экспорт, импортод шаардагддаг бичиг баримтууд

Экспорт	Импорт
• Ачаа тээврийн баримт	• Ачаа тээврийн баримт
• Экспортын мэдүүлэг	• Баглаа боодлын жагсаалт
• Үнийн нэхэмжлэх	• Импортын мэдүүлэг
• Эрүүл ахуйн зөвшөөрөл	• Гарал үүслийн гэрчилгээ
• Баглаа боодлын жагсаалт	• Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ
• Гарал үүслийн гэрчилгээ	• Ариутгалын гэрчилгээ
• Далайн орчны аюулгүй байдлын гэрчилгээ	•

Эх үүсвэр: (WB, 2020), *Doingbusiness.org*

Дээрх бичиг баримтуудыг бүрдүүлэхэд: -бичиг баримтын бүрдүүлэлт 7 цаг, -хил гааль дээрх хяналт шалгалт 5.5 цаг (гааль 1 цаг, хил дээрх гаалиас бусад байгууллагын шалгалт 4.5 цаг) байгаа бол хил дээрх ачаа тээшний зохицуулалт буюу ачилтад 30 цаг зарцуулдаг гэсэн байна. Эндээс үзэхэд экспортын зөвшөөрөл, Засгийн газрын гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ зэрэг нь өдөртөө гардаг буюу цахим хэлбэрээр шууд хүлээж авах боломжтой. Мөн цахим хэлбэрээр хүлээж авсан гэрчилгээ нь хуулийн хүчин төгөлдөр үйлчилдэг.

Зураг 44. Австрали, Энэтхэг, Бразил, Монгол улсуудын экспортод зарцуулагдах хугацаа, зардлын харьцуулалт 2019 он



Эх үүсвэр: (WB, 2020), *Doingbusiness.org*

Дэлхийн банкны 2019 онд гаргасан дээрх харьцуулалтаас харахад, Монгол улс бичиг баримт бүрдүүлэх, хил дээрх хяналт шалгалтад хамгийн их цаг хугацаа зарцуулдаг. Гэтэл зардлын хувьд авч үзэхэд хамгийн бага зардалтай байна.

АНУ:

АНУ нь экспортын бүтээгдэхүүнийг олон байгууллагатай хамтран ажиллан зорьсон газарт нь хүргэдэг. Уг үйл явцад экспортлогчоос гадна худалдан авагч, гүйлгээний хоёр талын банк, даатгалын компани, экспортын тээвэр зууч, гаалийн газрын агентлаг, гаалийн хэлтэс, боомтын удирдлага, дамжин өнгөрөх тээврийн үйлчилгээ үзүүлэгчид, тээврийн компаниуд оролцдог.

Зураг 45. АНУ-ын логистикийн үйл явц



Эх үүсвэр: <https://www.dripcapital.com/resources/blog/export-logistics-process#3>

АНУ-д логистикийн үйлчилгээнд дараах баримт бичиг бүрдүүлдэг. Үүнд:

- ✚ Худалдааны нэхэмжлэл
- ✚ Далайн тээврийн баримт
- ✚ Ачаа тээврийн баримт
- ✚ Гарал үүслийн гэрчилгээ
- ✚ Агуулахын баримт
- ✚ Хяналт шалгалтын гэрчилгээ
- ✚ Экспортын лиценз
- ✚ Баглаа боодлын жагсаалт
- ✚ Эрүүл мэндийн гэрчилгээ
- ✚ Даатгалын гэрчилгээ
- ✚ Консулын бичиг баримт
- ✚ Чөлөөт худалдааны баримт бичиг
- ✚ Ачаа илгээгчийн заавар
- ✚ Зориулалтын хяналтын мэдэгдэл (<https://www.dripcapital.com/resources/blog/export-logistics-process#3>, 2020)²⁴

Экспортын логистикийн хяналтын явцыг нарийвчлан авч үзэхэд:

- ✚ Барааг үйлдвэрлэж, ачилтын өмнөх хяналт, чанарын шалгалтыг хийсний дараа экспортлогч эсвэл гаалийн байгууллагын төлөөлөгч сав, баглаа боодол, шошго, тэмдэглэгээг хийж, ачилтын стандартад нийцүүлэн тэмдэглэнэ.
- ✚ Экспортлогч нь чингэлэгт хүргэлтийн захиалга авч, дүүргэх, битүүмжлэх ажлыг зохион байгуулна.
- ✚ Экспортлогчийн байрнаас ачих цэг хүртэл барааг тээвэрлэх тээвэрлэлтийг зохион байгуулна.

²⁴ <https://www.dripcapital.com/resources/blog/export-logistics-process#3>

- ✚ Бараа боомт дээр ирсний дараа экспортлогч эсвэл тэдгээрийн төлөөлөгч гаалийн бүрдүүлэлт, баримт бичиг, бодит шалгалт хийх ажлыг зохион байгуулан боомтын хураамжийг төлнө.
- ✚ Баримт бичгийг ачилтын шугамд хүлээлгэн өгдөг. Экспортлогч нь ачааны баримт болон бусад баримт бичгийн эх хувийг худалдан авагч эсвэл тэдгээрийн ачаа хүлээн авагч / төлөөлөгчдөд илгээнэ.
- ✚ Энэ хооронд барааг тээвэрлэгч рүү ачилт хийж эхний боомтоос хөдөлнө.

Хил, гааль дээрх үйл явц

Экспортын хил, гааль дээрх үйл явцыг ОХУ, БНХАУ, АНУ, Казакстан улсуудын жишээн дээр судалж дараах хүснэгтээр нэгтгэв.

Хүснэгт 117. Гадаад улс орнуудын хил, гааль дээрх үйл явц

Баримт бичиг	ОХУ	БНХАУ	АНУ	Казакстан
Барааны гэрчилгээ	+	+	+	+
Хорио цээр, ариун цэврийн хяналт	+	+	+	+
Мал эмнэлгийн хяналт	+	+	+	+
Ариун цэврийн болон эпидемиологийн хяналт	+	+	+	+
Лиценз, квот	+	+	+	+
Шошгын тодорхой шаардлага	+	+	+	+
Нэмэгдсэн өртгийн албан татвар	10%, 18%	17%	+	12%
Онцгой албан татвар	Засгийн газар тогтооно.			Үнэмлэхүй байдлаар тогтооно.
Гаалийн бүрдүүлэлтийн гаалийн хураамж	+	+	+	ачааны гаалийн мэдүүлгийн үндсэн хуудсанд-50 евро, ачааны гаалийн мэдүүлгийн нэмэлт хуудас бүрт 20 евро
Гааль дагалдан явах үеийн гаалийн хураамж ²⁵	Тээврийн хэрэгсэл дагалдах зай: -50 км зайд 2000 рубль -51-100 км зайд 3000 рубль -101-200 км зайд 4000 рубль -200 км зайнаас дээш 100 км зам тус бүрд 1000 рубль. Гэхдээ 6000 рублиэс багагүй байна. -Далай, гол, онгоц тус бүрд дагалдан явахад-20 000 рубль			Тээврийн хэрэгсэл дагалдах зай: -50 км зайд 9 евро -51-100 км зайд 11 евро -101-200 км зайд 18 евро -200-400 км 134 евро, 200 0 км-ээс дээш 599 евро
Гаалийн агуулах	-Өдөрт 100 кг жин тутамд-1 рубль -Өдөрт 100 кг жин тутамд (тоноглогдсон байр)-2 рубль			-Өдөрт 1 кв.м тутамд 0.17 евро төлдөг. Өдөрт метр (задгай талбай), 1 квадрат тутамд 0.48 евро харин хаалттай байранд 1 кв.м тутамд 0.86 евро


Эх үүсвэр: Как экспортировать кспортировать на рынки а рынки стран СНГ.
https://chamber.uz/uploads/posts/files/kak_eksp.pdf

БНХАУ-ын татвар 10 хувь , 18 хувь мэтээр барааны ангиллаас шалтгаалан ялгаатай тавигдсан бол бусад орон ерөнхийдөө адил хэмжээнд байна. Бидний судалгаагаар, БНХАУ гаалийн боловсон хүчний асуудалд цогцоор ханддаг нь ажиглагдсан. Гаалийн байцаагч нарын ажлын байрыг 2 жил тутамд сэлгэж байрлуулдаг бөгөөд давхар ахуйн асуудлыг нь шийдвэрлэж өгдөг. Мөн гаалийн байцаагч авилгийн хэргээр шалгагдаад буруутай болох, авилгийн хэргээр

²⁵ Илгээгч, хүлээн авагч тал нь хүсэлт гаргаж, гаалийн байгууллагаас зөвшөөрсөн тохиолдолд импортын бараа бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийг хүлээлгэн өгөх газарт нь буюу гаалийн байгууллага байгаа газарт, экспортолж буй бараа бүтээгдэхүүнийг гаалийн байгууллага байгаа ачааны газарт хийж болно. Ийм бараа бүтээгдэхүүнийг гаалийн байгууллагатай нэг газраас нөгөө рүү тээвэрлэхдээ гаалийн хяналтын шаардлагад нийцүүлсэн байна. Шаардлагатай бол гаалийн байгууллагын ажилтнууд нь бараа тээвэрлэлтийн үед дагалдаж явна.

сэжиглэгдсэн боловч гэм буруутай нь тогтоогдоогүй үед түүнийг байцаагчийн албан тушаалд эргүүлэн ажиллуулдаггүй байна.

Зураг 46. БНХАУ-ын Хил, гаалийн үйл явц




Эх үүсвэр: <https://www.dfhfreight.com/customs-clearance/>

Дээрх зургаас харахад, БНХАУ-д бараа импортлосон ч БНХАУ-аас бараа экспортолсон ч заавал дагаж мөрдөх журмууд байдаг нь тодорхой харагдаж байна. Зөвшөөрөгдсөн журмын дагуу явахад хүндрэл гарахгүй бөгөөд гаалийн үйл явцын хурдыг ихэсгэх болно.

Нэгдүгээрт, хориотой барааны жагсаалтад бүтээгдэхүүн байгаа эсэхийг сайн шалгана. Ачааны ангиллын HS кодыг тодотгож өгнө. Бүрдүүлэх жагсаалтын дагуу баримт бичиг, төлбөрийн хуудасны хамт бэлтгэнэ.

"eTIR олон улсын систем"- Олон улсын авто тээвэр (цахим)

Зураг 47. eTIR систем




Эх үүсвэр: <https://unece.org/about-etir>

НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комисс (ЕНЕС) нь 1959 онд байгуулагдсан бөгөөд 1975 онд шинэчлэн найруулсан TIR конвенцыг баталсан бөгөөд одоогоор 68 талуудыг багтаасан байна. TIR конвенцод олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гаалийн баримт бичиг болох TIR Carnet-ийг ашиглан дамжин өнгөрөх тээврийн үйл ажиллагааг хөнгөвчлөх олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн журмыг тусгасан бөгөөд энэ нь олон улсад хүчин төгөлдөр юм.

Олон жилийн туршид TIR конвенц нь үр дүнтэй ашиглагдаж ирсэн хэдий ч технологийн дэвшилтэй уялдан TIR Carnet цаасыг ашиглах нь улам бүр хоцрогдон гаалийн байгууллагуудын хэрэгжүүлж буй цахим журамтай холбогдоход хүндрэлтэй болж байна. Хилийн боомт бүр дээр гаалийн ажилтнууд үндэсний цахим гаалийн системдээ 50 хүртэлх өгөгдлийн элементийг оруулах шаардлагатай нэмэлт ажил тулгардаг. Өнөөгийн нөхцөл байдал нь гаалийн байгууллагуудаас аюулгүй байдлын талаарх өргөн мэдлэгтэй орчин шаардаж байгаа тул ачааны урьдчилсан мэдээлэлд үндэслэн эрсдэлийн менежментийн журмыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг хязгаарлагдмал болгож байна.

Зураг 48. Хил, гааль дээрх хяналт шалгалтын зохион байгуулалт



Эх үүсвэр: Передовая практика на пунктах пересечения границы: действие торговли и транспорту
Справочник ОБСЕ - ЕЭК ООН. https://unece.org/DAM/trans/bcf/publications/OSCE-UNECE_Handbook_russian.pdf

Дээрх зурагт, хил гааль дээр машины хяналт шалгалтын зохион байгуулалтын талаар тодорхой дүрслэн үзүүлсэн. Анхан шатны хяналтад дугаарлан буй жолооч нэг бол “ногоон” эсвэл “улаан” коридор сонгоно. Тээврийн цувааны нийт хурд өндөр байж болох бөгөөд энэ нь “ногоон” коридорын хөдөлгөөнд нөлөөлөхгүй. Замын цагдаа болон гаалийн ажилтнуудын тусламжтайгаар машинуудыг өөр зурвасаар явуулах боломжтой. Замын үндсэн урсгалд саад болохгүйгээр булан хэсэг “карман” хэсэгт хяналт хийж байхад, хөдөлгөөн тасралтгүй үргэлжилсээр гаалийн бүсээс гарах болно. Ийм замаар худалдааны чиглэлийн зөвшөөрөлтэй машинуудыг үзлэг, хяналтад оруулах нь үр дүнтэй.

Хүснэгт 118. Гадаад улс орнуудын хил, гаалийн үйл явцыг хялбарчлахаар хэрэгжүүлж буй ажлын туршлага

Үзүүлэлтүүд	Литва	Швед	БНСУ
Гаалийн бүрдүүлэлт хийх газрыг сонгох журам	Гаалийн бүрдүүлэлтийн байршлыг гаалийн байгууллага бизнес эрхлэгчидтэй яриа хэлэлцээр хийсний дараа тодорхойлдог бөгөөд тэдгээрийг олон нийтийн гаалийн вэбсайт дээр нийтэлдэг.	Гаалийн бүрдүүлэлтийн байршлыг гаалийн байгууллага бизнес эрхлэгчидтэй яриа хэлэлцээр хийж тодорхойлдог.	<ul style="list-style-type: none"> Экспортлогчид бараагаа агуулахад нь байх үед бараагаа мэдүүлж болно, дүрмийн дагуу экспортын бараанд гаалийн татвар ногдуулдаггүй тул гаалийн байгууллагаас импортын барааг хянах нь импортын барааны зохицуулалт шиг хатуу биш. Шинэчилсэн Киотогийн конвенцын (ГАК) заалтыг үндэслэдэг.
Барааг шалгах газар	Гаалийн шалгалтыг хил дээр хийдэг боловч логистикийг хөнгөвчлөх үүднээс эдийн засгийн операторын байранд шалгалт хийж болно.	Гааль шалгалтыг хил дээр хийдэг.	<ul style="list-style-type: none"> Импортлогчид импортын мэдүүлгийг хил дээрх гаалийн пост эсвэл тухайн улсын гаалийн пост дээр байрлуулах эсэхээ шийднэ. Экспортлогч нь барааг шалгах гаалийн газрыг сонгох боломжтой. Гаалийн байгууллагын хяналтад байгаа газарт гаалийн байгууллага шалгалт хийх газруудыг зааж өгч болно. Үүнээс гадна ачааг экспортлогчийн агуулахад шалгаж болно.
Хяналтын талбайн сонголт		Барааг гаалийн байгууллагад биет байдлаар	Хяналт шалгалтыг урьдчилан хийх боломжтой (экспортлогчийн агуулах эсвэл үйлдвэр), эсвэл хил дээр хийж болно.

		танилцуулна.	
Гаалийн бүрдүүлэлт хийгдээгүй барааны хөдөлгөөнийг хянах	Европын холбооны дамжин өнгөрөх горимыг ашиглаж байна.	<ul style="list-style-type: none"> • Европын холбооны дамжин өнгөрөх горимыг ашиглаж байна. • Хялбаршуулсан журмын дагуу эхний шатны гаалийн мэдүүлгийг баталсны дараа барааг гаалийн агуулахад шилжүүлэх боломжтой. 	<ul style="list-style-type: none"> • Транзит менежмент нь барааны дотоод дамжин өнгөрөлтийг удирдахад хэрэглэгддэг бөгөөд үүнд дамжин өнгөрөх үйл явцад дараах нөхцөлүүд шаардагдана. ✓ Аюулгүй тээврийн хэрэгсэл (жишээлбэл, чингэлэг) ба лац ✓ Тооцоолсон ирэх цагийг удирдана. • Дамжин өнгөрөх дэглэмийг ашиглана. • Киотогийн шинэчилсэн конвенц (КШК)-ыг мөрдөнө.

Эх үүсвэр: Список примеров наилучшей таможенной практики (подготовлен секретариатом ЕЭК ООН в ответ на запрос от российского бизнеса). Женев, 28.09.2012

Дээрх хүснэгтэд Литва, Швед, БНСУ-ын гаалийн бүрдүүлэлт хийх, хяналтын талбайг сонгох, хөдөлгөөн хянах шилдэг туршлагаудаас орууллаа. Европт хил гаалийн хувьд хамгийн боломжтой хувилбарт улсаар Швед улс гэж үздэг бөгөөд олон орон тэр системийг нь хэрэгжүүлдэг.

Экспортын тээвэрлэлт, төлбөр хүлээн авах үйл явц

Монгол Улсын газар зүйн байршлын онцлогоос хамаарч гадаад худалдааны хөгжилд хамгийн чухал нөлөөлж буй хүчин зүйл нь худалдааны логистик юм.

Дэлхийн банкнаас анх 2007 онд улс орнуудын өөрсдийн худалдааны логистикийн гүйцэтгэлд нөлөөлж буй бэрхшээл, боломжийн талаар юу хийж болохыг тодорхойлох зорилго бүхий харилцан нөлөөлөл бүхий бенчмаркийн харьцуулалтын арга болох логистикийн гүйцэтгэлийн индексийн /Logistic Performance Index/ боловсруулсан. Тус үзүүлэлтийг дараах 6 хүчин зүйлсээр үнэлж тооцдог. Үүнд:

1. Гааль- /Гаалийн мэдүүлгийн үйл явц, хурд, түргэн шуурхай байдал, дүрэм журмыг урьдчилан мэдэх боломж, хил гаалийн хяналт шалгалт гэх мэт/
2. Дэд бүтэц: /Худалдааны чанар, холбогдох дэд бүтэц-мэдээллийн технологи, төмөр зам, хилийн боомт, зам тээвэр/
3. Олон улсын тээвэр /хямд үнэтэй ОУ-ын тээвэр, зуучлал ашиглахад хялбар эсэх /
4. Логистикийн үйлчилгээний чанар болон чадавч: /Чадвартай гаалийн зуучлагч, тээвэр гүйцэтгэгч/
5. Ачааны замын мэдээлэл шалгах боломжтой эсэх /Тухай ачааны хаана явж байгааг мөшгөх/
6. Цаг хугацаа: /Төлөвлөсөн хугацаанд ачаа барааг хүрэх газраа ирдэг эсэх байдал/

Тус үнэлгээг дэлхийн хамгийн шилдэг үзүүлэлтэй орон, бүс нутаг болон орлогын түвшнээр харьцуулах боломжтой. Монгол улсын LPI-ийн үнэлгээг 2018 оны байдлаар дараах 4 хэлбэрээр харьцуулан харуулав.

Дэлхийн LPI –ийн үзүүлэлтээр эхний байранд байгаа Герман улстай харьцуулсан үзүүлэлт

Country	Year	LPI Rank	LPI Score	Customs	Infrastructure	International shipments	Logistics competence	Tracking & tracing	Timeliness
Germany	2018	1	4.20	4.09	4.37	3.86	4.31	4.24	4.39
Mongolia	2018	130	2.37	2.22	2.10	2.49	2.21	2.10	3.06

Зүүн Ази Номхон далайн бүсийн орнуудын дундажтай харьцуулсан үзүүлэлт:

Country	Year	LPI Rank	LPI Score	Customs	Infrastructure	International shipments	Logistics competence	Tracking & tracing	Timeliness
Region: East Asia & Pacific	2018		3.15	3.01	3.05	3.03	3.13	3.18	3.49
Mongolia	2018	130	2.37	2.22	2.10	2.49	2.21	2.10	3.06

Бүсийн орнуудаас LPI-ийн үзүүлэлтээр тэргүүлэгч Япон улстай харьцуулсан судалгаа:

Country	Year	LPI Rank	LPI Score	Customs	Infrastructure	International shipments	Logistics competence	Tracking & tracing	Timeliness
Japan	2018	5	4.03	3.99	4.25	3.59	4.09	4.05	4.25
Mongolia	2018	130	2.37	2.22	2.10	2.49	2.21	2.10	3.06

Орлогын түвшингээр нэг бүлэгт ангилагдсан Вьетнам улстай харьцуулсан үзүүлэлт:


Country	Year	LPI Rank	LPI Score	Customs	Infrastructure	International shipments	Logistics competence	Tracking & tracing	Timeliness
Vietnam	2018	39	3.27	2.95	3.01	3.16	3.40	3.45	3.67
Mongolia	2018	130	2.37	2.22	2.10	2.49	2.21	2.10	3.06

Эх үүсвэр: (WB, <https://lpi.worldbank.org>, 2019)


Монгол улс логистикийн гүйцэтгэлийн индексийн бүх үзүүлэлтээр БНХАУ, ОХУ болон Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн дунджаас доогуур, бага түвшинд байна.

Логистикийн систем нь авто зам, төмөр зам, далайн боомт, нисэх онгоцны буудал, агуулах, түгээлтийн төв гэх мэт салбарыг хамардаг. Монгол улсын LPI-ийн үнэлгээний үзүүлэлтийн зураглалыг доорх зургаар харуулав.

Зураг 49. Монгол улсын логистикийн гүйцэтгэлийн индекс /2007-2018/



Зураг 50. Турк улсын логистикийн үйл явцын зураглал



Эх үүсвэр: <http://sim.sagepub.com/cgi/content/abstract/79/2/94>

Цогцолбор бүтцийг аналитик аргаар бус симуляцийн техникээр судалж үзсэнийг зураг 20-д үзүүлсэн. Боомтын системийг загварчлах нь порт төлөвлөлт, төлөвлөлт, хүчин чадал нэмэгдэх, бүтээмж гэх мэт олон зорилгод нийцтэй бөгөөд энэхүү судалгаагаар түгжрэл үүссэн цэгүүдийн хэт ачаалалтай үеийн зохицуулалтыг харуулсан. Загварчлалын туршилтаар тээврийн хэрэгслийг ачиж буулгах үед түгжрэл үүсдэг болохыг тогтоожээ. Энэ цэг дээр боомтын

ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын стратегийг ашиглана. Эдийн засгийн хязгаарлалтын хүрээнд нөөцийг нэмж сайжруулалтыг судлахад симуляцийг ашиглана.

Төлбөр тооцоо

Олон улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд экспортлогч, импортлогч нь төлбөрийг цаг тухайд нь хүлээн авч, чанартай бараа нийлүүлэхтэй холбоотой гэрээний үүргээ биелүүлэх ёстой. Гадаад худалдааны гэрээ өөрөө цаг тухайд нь баталгаа өгч чадахгүй гадаадад хүргэгдсэн бараа, үйлчилгээний төлбөрийг бүрэн төлөх, ялангуяа дотоодын экспортлогчтой төдийлөн мэддэггүй гадаадын импортлогчтой холбоотой.

4.2.2.Экспортыг хөнгөвчлөх бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээний туршлага

Электрон хэлбэрээр гаалийн мэдүүлэг, бүрдүүлэлтийг хийх:

Гаалийн мэдээллийг бүрдүүлэх, дамжуулах, боловсруулах, солилцох цахим системүүд нь орчин үеийн гадаад худалдааны төвөгтэй орчинд мэдээллийн урсгалыг удирдах чухал хэрэгсэл юм. Веб-д суурилсан дэвшилтэт системүүд нь худалдаа эрхлэгчдэд холбогдох бичиг баримтаа бүрдүүлж, татвараа онлайнгаар төлөх боломжийг олгодог. Ийм системүүдийг үр дүнтэй хэрэгжүүлснээр урт хугацааны ашиг тустай буюу дүрэм журмыг боловсронгуй болгохын зэрэгцээ цаг хугацаа, мөнгө хэмнэх, төрийн албан хаагчидтай шууд харилцах харилцааг хязгаарлах, хээл хахуулийг бууруулдаг. Цаашилбал, гадаад худалдааг дэмжих, залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх, гадаад худалдааны гүйлгээний статистик мэдээллийг хянахад туслалцаа үзүүлэх замаар гаалийн цахим мэдээлэл солилцох системийг бусад төр захиргааны байгууллагууд ашиглах, мэдээлэл солилцох боломжтой.

Гаальтай холбоотой баримт бичгийг цахим хэлбэрээр бүрдүүлэх, боловсруулах боломжийг олгох нь арилжааны явцад гарах саатлыг бууруулах хамгийн түгээмэл бөгөөд үр дүнтэй арга замуудын нэг хэмээн олон улсад үзэх болсон. ЭЗХАХБ-ын улс орнуудын талаас илүү хувь нь арилжааны бүх баримт бичгийг цахим хэлбэрээр бүрдүүлж өгөх боломжтой болсон байна. Жишээлбэл, Литва улс 2017 оны 9-р сард гаалийн мэдээллийн менежментийн автоматжуулсан систем болох Гаалийн бүрдүүлэлт боловсруулах систем (MDAS)-ийг сайжруулж экспортын гаалийн бүрдүүлэлтийг хийх хугацааг багасгасан. Сайжруулсан платформ нь экспортын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргаж, автоматаар бүрдүүлэлт хийх, экспортлогчид цаасан хэлбэрээр материал бүрдүүлэх шаардлагагүй болсон.

Гэсэн хэдий ч цахим систем нэвтрүүлэх, хэрэгжүүлэх нь багагүй бэрхшээлтэй тулгардаг бөгөөд Засгийн газраас цахим гарын үсгийн болон цахим гүйлгээний тухай хууль тогтоомж батлах шаардлагатай болдог. Учир нь хууль зүйн зохицуулалтгүйгээр шинэ цахим систем нэвтрүүлэх нь ажлын ачаалал, зарцуулагдах хугацааг уртасгах, ажлыг давхардуулах (жишээлбэл, гарын үсэг зурсан баримт бичгийг цахим хэлбэрээр хүргүүлсний дараа цаасан хэлбэрээр ирүүлэхийг шаардах гэх мэт) зэрэг хүндрэлүүдийг бий болгох эрсдэлтэй.

Нэг цонхны цахим үйлчилгээг нэвтрүүлэх:

Зөвхөн гадаад худалдаа эрхлэгчид, гаалийн ажилтнууд төдийгүй олон улсын худалдаанд оролцдог бүх агентлагуудыг цахим нэг цонхны систем дээр холбох нь гадаад худалдааг хөнгөвчлөхөд өндөр ач холбогдолтой байна. Нэг цонхны цахим систем нь импорт, экспорт, транзиттай холбоотой бүхий л зохицуулалтын шаардлага, стандарт, баримт бичгийг нэг цахим үйлчилгээний цэгээр дамжуулах боломжийг олгодог буюу цахим цонх нь холбогдох бүх төрийн байгууллагууд цаашлаад банк, даатгалын компани, тээврийн компани зэрэг хувийн байгууллагуудыг хооронд нь холбож шаардлагатай мэдээллүүдийг солилцох гүүр болдог. Жишээлбэл, Энэтхэг улсын гааль 2018 оны 11-р сард Худалдааны нэг цонхны интерфэйсийн хүрээнд ажилладаг e-Sanchit онлайн программын системд Засгийн газрын хэд хэдэн байгууллагыг нэгтгэсэн. Энэхүү санаачилгын ачаар экспортын бүх баримт бичиг бүрдүүлэлтийг бүрэн цахимжуулсан.

БНЭУ-ын гадаад худалдааг хөнгөвчлөх нэг цонхны үйлчилгээ (ICEGATE)

Энэтхэг улсын гаалийн цахим гарц (ICEGATE) нь Онцгой албан татвар, гаалийн төв зөвлөлийн (CBIC) харьяа гаалийн байгууллагын үндэсний портал бөгөөд Худалдаа, ачааны тээвэрлэгч болон бусад худалдааны түншүүдэд цахим бүртгэлийн үйлчилгээ үзүүлдэг. Өнөөдрийн байдлаар 1.3 сая гаруй импортлогч / экспортлогчдод үйлчилж буй 43,542 орчим хэрэглэгч ICEGATE-д бүртгэлтэй байна. Энэ байгууллагаар дамжуулан Энэтхэгийн Гаалийн байгууллага олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд үүнд бүртгэлийн баримт (импортын барааны мэдүүлэг), ачилтын үнэт цаас (экспортын барааны мэдүүлэг), гаалийн татварын цахим төлбөр, гаалийн бүх баримт бичигт гарын үсэг зурах, e-Sanchit-ээр дамжуулан онлайн баримт бичгийг бүрдүүлэх, IGST-ийн цахим буцаан олголт гэх мэт цахим хэлбэрээр бүртгүүлэх үйлчилгээ багтдаг.

ICEGATE-ийн платформд “Бизнес эрхлэлтийг хялбарчлах” санаачилгын хүрээнд Энэтхэгийн Засгийн газрын Онцгой албан татвар, гаалийн төв зөвлөлөөс Энэтхэгийн гадаад худалдааг хөнгөвчлөх зорилгоор “Нэг Цонхны үйлчилгээ” төслийг хэрэгжүүлсэн. Тус нэг цонхны үйлчилгээ нь экспортлогч, импортлогчдыг гаальд мэдүүлэх шаардлагатай бүх бичиг баримтыг нэг дороос авах боломжийг бүрдүүлсэн. Тодруулбал өөр байгууллагаас авах шаардлагатай бичиг баримтуудыг экспортлогч, импортлогч нь заавал биеэр тус байгууллагад очилгүйгээр цахимаар авах боломжтой бөгөөд ингэснээр Засгийн газрын агентлагуудтай харилцах шууд харилцахыг багасгаж, цаг хугацаа, бизнес эрхлэх зардлыг бууруулсан. SWIFT-ийн зорилго нь Засгийн газрын ‘Make in India’, ‘Digital India’ гэсэн гол хөтөлбөрүүдтэй нийцэж байгаа юм.


Эх сурвалж: (<https://www.icegate.gov.in/eSANCHIT.html>, 2021)

Бразил улсын нэг цонхны үйлчилгээ - SISCOMEX

Бразил улсын экспортын зохицуулалтад нэг цонхны цахим үйлчилгээ буюу SISCOMEX нь өндөр ач холбогдолтой байна. Siscomex нь Бразилын Ерөнхийлөгчийн 1192 оны 660-р зарлигаар байгуулагдсан бөгөөд хожим нь 2014 онд Ерөнхийлөгчийн 8229-р зарлигаар шинэчлэгдсэн. Нэг цонхны үйлчилгээг бүртгэлтэй худалдаа эрхлэгчид болон гаалийн зуучлагчид www.siscomex.gov.br вэбсайтаас тоон гэрчилгээ ашиглан авах боломжтой.

Нэг цонхны Siscomex-ийг Сангийн яамны дэд сайд, Аж үйлдвэр, гадаад худалдаа, үйлчилгээний яамны дэд сайд, Холбооны орлого, гаалийн нарийн бичгийн дарга, гадаад худалдааны нарийн бичгийн даргаас бүрдсэн хороо удирддаг. Нэг цонхны үйлчилгээ үзүүлэхэд Засгийн газрын 22 агентлагууд ажиллаж нэгдэн байна. Гадаад худалдаа, импорт, экспортод тавигддаг тарифын бус хязгаарлалтууд, бичиг баримтын шаардлага, зөвшөөрлүүдийн бүх зохицуулалтыг нэг цонхоор хэрэгжүүлдэг. Нэг цонх нь оролцогч агентлагуудын импортлогч, экспортлогчдоос шаардсан бүх мэдээллийг цахим хэлбэрээр оруулах боломжийг олгодог. Худалдааны нэмэлт баримт бичиг шаардагдах тохиолдолд систем нь дижитал гарын үсэг бүхий дижитал хуулбарыг илгээх боломжийг мөн олгодог.

Зураг 51. Бразил улсын Siscomex интерфэйс



Эх үүсвэр: (siscomex, n.d.)

Бразил улсын Siscomex нь аль улсад ямар бараа бүтээгдэхүүн экспортлох эсхүл импортлох гэдгээс хамаарч экспорт, импорт хийхэд бэлтгэх, шаардлагатай баримт бичиг, татвар хураамж, холбогдох дүрэм журмыг таниулахад зориулсан туршилтын симулятор хөтөчтэй.

Швед улсын “The Virtual Customs Office” нэг цонхны систем

Шведийн нэг цонхны систем нь “The Virtual Customs Office” гэсэн нэртэй бөгөөд цахимаар экспорт, импортын мэдүүлэг, зөвшөөрлүүдийг олгохын зэрэгцээ бизнес эрхлэгчдийн мэдээллийг системтэй холбох, гадаад валютын ханш, гаалийн тариф, бүтээгдэхүүнийг кодын өөрчлөлтүүд автоматаар шинэчлэгдэхийн зэрэгцээ тус систем нь бизнес эрхлэгч нарт худалдаа бизнесийн холбоотой хууль, дүрэм, журмын талаар шинэ мэдээ, мэдээллийг интернэт болон SMS-ээр хүргүүлдэг үйлчилгээг нэгтгэсэн байна. Түүнчлэн VCO системийн хэрэглэгч нарт интерактив сургалтын модулийг санал болгохоос гадна хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн холбогдох мэдээлэл, процессыг агуулсан хувийн виртуал гаалийн газруудыг байгуулах боломжийг санал болгодог. Энэ нь гаалийн үйлчилгээний ачааллыг бууруулах гадаад худалдааг хөнгөвчлөхөд чухал ач тустай гэж үздэг байна. Энэхүү систем нь одоогоор 150 орчим электрон үйлчилгээг нийлүүлэхээс гадна холбогдох дүрэм журмыг 10 улсын хэл дээр хүргэж байгаа онцлогтой.

Зураг 52. Швед улсын нэг цонхны үйлчилгээ



Эх үүсвэр: https://en.wikipedia.org/wiki/Single-window_system

Нэг цонхны систем нь ойлголт нь худалдааг хөнгөвчлөх чиглэлээр оролцогчдод боломж олгох хил дамнасан худалдаа баримт бичгийг нэг дор бүрдүүлж өгөх газар юм. Ирүүлсэн баримт бичигт ихэвчлэн гаалийн мэдүүлэг, зөвшөөрөл хүсэх өргөдөл багтдаг экспорт / импорт эсвэл бусад дагалдах баримт бичиг, гарал үүслийн гэрчилгээ, борлуулалтын падаан зэрэг орно.

Гадаад худалдааны нэг цонхны үйлчилгээний цахим системийг Монголд хөгжүүлэхэд дотоодын холбогдох оролцогч талуудаас гадна, олон улсын чухал ач холбогдол бүхий системүүдтэй тодорхой нөхцөлөөр нэгтгэн, ашиглах боломжийг давхар авч үзэх шаардлага чухал юм.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг ашиглах

Импорт, экспортыг татвар, байгаль орчин, хилийн хяналт, эрүүл ахуй, аюулгүй байдлын үүднээс хяналт шалгалт хийх нь ихэвчлэн зайлшгүй шаардлагатай байдаг. Эдгээр хяналт шалгалт хэрхэн хийгддэг, үүнд ачааг хэрхэн шалгахаар сонгодог зэрэг нь улс орнуудын хувьд харилцан адилгүй байдаг. Хяналт шалгалтыг хэт чангатгах нь гадаад худалдаанд саад тотгор учруулж болзошгүй юм. Олон улс орнуудад гаалийн байгууллагууд нь хилийн бусад хяналтын байгууллагуудтай уялдаатай ажиллаж, ачааны болзошгүй эрсдэлтэй пропорциональ хяналт шалгалт хийх боломжийг олгодог эрсдэлийн мэдээллийн сан бий болгох системийг боловсруулсан байна.

Хувийн байгууллагуудын оролцоог хөнгөвчлөх замаар өрсөлдөөнийг бий болгох

Гаалийн албан ёсны үйл ажиллагаанаас гадна гаалийн брокерууд, тээврийн компаниуд, боомтын үйлчилгээ үзүүлэгчид гэх мэт хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчид бүгд хил дамнасан худалдааны цаг хугацаа, зардалд нөлөөлдөг. Өрсөлдөөн их байх нь төлбөр буурч, үйлчилгээний чанар сайжрах ач тустай.

Бүтээгдэхүүний онцлогт тулгуурласан хяналт шалгалтыг сайжруулах

Гол экспортын бараа нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн байдаг улс орнууд хөдөө аж ахуйн бус бүтээгдэхүүн голлон экспортолдог орнуудтай харьцуулахад хил гааль дээрх хяналт шалгалт удаан үргэлжилдэг. Үүний гол шалтгаан нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн экспортлоход тухайн бүтээгдэхүүний онцлогт тохирсон хяналт шалгалт, журам (утах, фитосанитарийн хяналт гэх мэт) шаарддагтай холбоотой байна. Хэдий тийм ч хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн голлон экспортолдог улс орнуудын бичиг баримт бүрдүүлэлт болон гаалийн хяналтад зарцуулагдах хугацаа нь өөр хоорондоо багагүй ялгаатай байдаг буюу хамгийн хурдан нь 2 цаг харин хамгийн удаан нь 168 цаг байна. Ийнхүү хэлбэлзэлтэй байдгаас харахад экспортлох бүтээгдэхүүний төрөл, ангиллаас үл хамаарч гадаад худалдааг хөнгөвчлөх боломжтой байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортолдог улс орнууд бүх бүс нутаг, орлогын түвшинг хамардаг. Жишээлбэл, Намибиа, Австрали улс хоёулаа экспортын бүтээгдэхүүнийхээ хувьд ариун цэврийн хяналт, гэрчилгээ шаарддаг. Гэсэн хэдий ч хил гааль дээрх үйл явц Намибиад (загас экспортлогчдод) 120 цаг зарцуулдаг бол Австралид (мах экспортлогч) ердөө 36 цаг зарцуулдаг. Бичиг баримтын бүрдүүлэлт нь Намибиад 90 цаг байхад Австралид 7 цаг зарцуулдаг байна. Намибиа дахь экспортлогч нь төрийн өөр өөр байгууллагуудаас баримт бичгийг цаасан хэлбэрээр авч дараагийн байгууллагад өгөх шаардлагатай болдог. Австралид эсрэгээрээ хорио цээрийн байгууллагууд үйл явцын туршид үйлдвэрлэгчид болон гаалийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг бөгөөд ихэнх баримт бичгийг цахим хэлбэрээр өгөх боломжтой байдаг. Хамгийн гол нь хяналт шалгалтыг нэмэгдүүлэх биш үр дүнтэй хяналт шалгалт чухал юм.

АНУ-ын International Trade Data System (ITDS)

АНУ экспорт, импортын үйл ажиллагааг оновчтой болгох ажлын хүрээнд 2014 оноос эхлэн ОУ-ын худалдааны өгөгдлийн систем (**ITDS**) нэг цонхны систем өргөн хэмжээнд ашиглах болсон. Тус системийн зорилго нь төрийн байгууллагуудын олон төрлийн системүүдийг нэгтгэж хувийн болон холбооны байгууллагуудын хэрэгцээ, шаардлагыг хангаж стандарт худалдааг дэмжих зорилго бүхий мэдээллийг цуглуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий систем юм. Тус системийг дараах үүрэгтэй гэж тодорхойлдог. Үүнд:

1. Олон улсын бизнес, худалдааны нэгтгэл, тайлангийн гаргах зардлыг бууруулах
2. Төрийн байгууллагын олон улсын бизнестэй холбоотой үйл ажиллагааны зардлыг бууруулах
3. Төрийн байгууллагын худалдааны шаардлага, бичиг баримт бүрдүүлэлтийг хөнгөвчлөх
4. Төрийн байгууллагын худалдааны дүрэм журмын хэрэгжилтийг хангах
5. Төрийн эрх бүхий байгууллагууд хооронд мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоог сайжруулахад дэмжлэг болох
6. ОУ-ын худалдааны талаарх үнэн зөв, найдвартай, бодит мэдээллээр хангагдах боломжуудыг олгодог байна.

Европын холбооны CDS - Customs Decisions System

Европын Холбооны гишүүн орнууд 2017 оны 10 сард Гаалийн шийдвэрийн систем буюу CDS (Customs Decisions System)-системийн эхний хувилбарыг анх боловсруулсан. Энэ систем цахимжуулах аргаар гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцогч талуудын үйл ажиллагааг хөнгөвчлөх, хурдан шуурхай болгох зорилготой. 2020 оны 7 сараас энэхүү системийг гишүүн орнуудтай зөвшилцөн хамтран ажилласны үр дүнд боловсруулсан хууль эрх зүйн шаардлага, шинэ функцуудыг нэмж өргөжүүлэн хөгжүүлсэн. Тус системийг хоёр бүрэлдэхүүнтэй байна.

1. Тодорхой нэг гишүүн орны хүрээнд үндэсний хэмжээний гаалийн шийдвэрийг удирдах
2. ЕХ-ны бүх гишүүн орны түвшинд системийг ашиглах гэсэн 2 бүтэцтэй хийгдсэн байна.

Европын холбооны REX систем-Бүртгэгдсэн экспортлогчийн систем

Европын Холбооны “GSP”+ Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн хүрээнд “Бүртгэгдсэн экспортлогчдын систем” REX системийг ашиглан экспортлогч, хувь хүн, аж ахуйн нэгж, тээвэр зуучлагч байгууллагууд бараа бүтээгдэхүүний гарал үүслийг бие даан мэдүүлэх боломжтой болсон. Энэ системд бүртгүүлж REX дугаар авснаар Европын холбооны орнууд руу бүтээгдэхүүн экспортлогч нарт бичиг баримтын бүрдүүлэлтийн цаг хугацаа, зардал хэмнэх давуу боломж байна. Монгол улсад тус системийн хэрэглээг илүү өргөжүүлэх шаардлагатай.

Европын холбооны SAD /Single administrative document/

Европын холбооны гишүүн орнууд гаалийн мэдүүлгийг “SAD” /Нэг захиргааны бичиг/ загварыг ашиглаж мэдүүлдэг байна. Тус мэдүүлгийг Европын холбооны гишүүн орнуудаас гадна Switzerland, Norway, Iceland, Turkey, the Republic of North Macedonia and Serbia орнууд ашиглаж байна.

Энэхүү бичиг нь тус бүрдээ өөр өөр үүрэг бүхий 8 багц үзүүлэлтээс бүрдэх бөгөөд энэ нь захиргааны хүнд суртал бууруулах, худалдааны мэдээллийг стандартчилах, бичиг баримт, мэдээллийн нийцлийг хангахад чухал ач тустай гэж үздэг байна. ЕХ-ны гишүүн орнуудын гаалийн байгууллага, худалдаачдад SAD-ийн хэрэгжилттэй холбоотой холбогдох хууль эрх зүй, аргачлалын талаарх нэгдсэн ойлголт өгөх зорилго тусгайлсан гарын авлага, заавар хамт гарган ашиглаж байна.

Европын холбооны Access2Markets веб-д суурилсан платформ

ЕХ-ны Access2Markets платформ нь экспорт импортын үйл ажиллагаатай холбоотой цогц мэдээллийг агуулсан, гадаад худалдаа, бизнес эрхлэгч нарын үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн ОУ-ын жишиг платформ юм.

Access2Markets платформ нь ЕХ болон дэлхийн 120 гаруй орны зах зээлийн талаар гаалийн татвар, хураамж, бүтээгдэхүүний шаардлага, дүрэм журмын талаарх мэдээллийг агуулсан байдаг. Тухайлбал, боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүнийг Итали улс руу экспортлох хайлтаар Европын холбоо Монгол улс хоорондын гэрээний дагуу тарифын хөнгөлөлттэй нөхцөлд хамрагдах боломжтой болох мэдээллийг харуулж байна.

The screenshot shows the Access2Markets platform interface. At the top, there is a navigation bar with 'Home', 'Goods', 'Services', 'Investment', 'Markets', 'Toolbox', and 'Contact'. Below this is a search bar with 'EN English' and a 'Search' button. The main content area is titled 'My Trade Assistant' and includes a search form with fields for 'Product name or HS code' (4112), 'Country from' (Mongolia), and 'Country to' (Italy). Below the search form, it says 'Showing search results for 4112 from Mongolia to Italy' and 'Product successfully identified'. A list of goods is shown, including 'Raw hides and skins (other than furskins) and leather' and 'Leather further prepared after tanning or crusting, including parchment-dressed leather, of sheep or lamb, without wool on, whether or not split, other than leather of heading 4114'. Below this is a section titled 'Import to EU' and 'Results for product code 4112 from Mongolia to Italy'. The 'Rules of origin' section is highlighted, showing the latest update on 01 January 2018. It states that the product classified in HS 4112 must originate in the EU or Mongolia. A table below provides details on the working or processing required for non-originating materials.

HS heading	Description of product	Working or processing, carried out on non-originating materials, which confers originating status
ex Chapter 41	Raw hides and skins (other than furskins) and leather, except for:	Manufacture from materials of any heading, except that of the product

EXDOC буюу Экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн цахим систем

EXDOC нь анхдагч бүтээгдэхүүний экспортын баримт бичгийг зохицуулах зорилгоор Хөдөө аж ахуй, ус, байгаль орчны газраас боловсруулсан программ юм. Тус программ нь экспортод шаардлагатай олон төрлийн баримт бичгийг цахимаар олгодог бөгөөд экспортын дараах үндсэн шаардлагуудыг хангадаг. Үүнд:

- ✚ Экспортын хяналтын тухай хуулийн хүрээнд шаардагддаг зөвшөөрлүүд
- ✚ Импорт хийж буй орны холбогдох хяналтын байгууллагаас гаргасан шаардлагын дагуу гэрчилгээнүүд

EXDOC нь үйлчлүүлэгчийн өмнөөс Австралийн гаалийн албанаас Экспортын мэдүүлгийн дугаар (EDN) -ийг нэг цонхны цахим сүлжээ (SEW) сонголтыг ашиглан авах боломжтой.

Экспортын зөвшөөрөл авахын тулд Экспортын хяналтын тухай хуульд заасан мэдээлэл, импортлогч орны шаардлагыг хангахад шаардагдах бүх мэдээллийг өгөх шаардлагатай. Жишээлбэл: ачаа, бүтээгдэхүүн, тээвэрлэлт, бүтээгдэхүүний боловсруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл гэх мэт.

EXDOC нь дараах бараа, бүтээгдэхүүнийг хамардаг. Үүнд:

- ✚ Хүнсний мах
- ✚ Сүүн бүтээгдэхүүн

- ✚ Далайн бүтээгдэхүүн
- ✚ Үр тариа
- ✚ Өндөг
- ✚ Цэцэрлэгжүүлэлт
- ✚ Арьс
- ✚ Ноос
- ✚ Хүнсний бус махан бүтээгдэхүүн

Next Export Documentation System (NEXDOC)

Австрали улс EXDOC цахим программыг сайжруулсан NEXDOC вебд суурилсан цахим сүлжээг 2021 оны 5 дугаар сард нэвтрүүлсэн бөгөөд одоогийн байдлаар сүүн бүтээгдэхүүний бичиг баримт бүрдүүлэлт явагдаж байгаа бөгөөд нэвтрүүлж дууссаны дараа EXDOC программд явагддаг бүх төрлийн бүтээгдэхүүний экспортын бичиг баримтын бүрдүүлэлтийг гүйцэтгэх боломжтой болно.

Хүснэгт 120. Экспортын үйл явцыг хөнгөвчилсөн гадаад улс орнуудын туршлагаас Монгол Улсад хэрэглэх боломжууд

Монгол Улсын экспортын үйл явцын дутагдалтай тал	Ашиглах боломжтой гадаад улс орны туршлага	Монгол Улсад ашиглах боломж
Гадаад худалдааны бодлогын чиглэлээр:		
Гадаадын улсуудтай хийсэн гэрээ, хэлэлцээрийн мэдээлэл хүртээмжтэй биш	Швед улсын нэг цонхны VCO системийн SMS үйлчилгээг хөгжүүлэх	ДХБ-ын Худалдааг Хөнгөвчлөх Хэлэлцээрийн хүрээнд нэг цонхны системд шилжүүлэх ажлын хүрээнд параллель шийдэх
ОУ-ын байгууллагын санхүүжилтээр Төрийн байгууллагуудад тодорхой түвшинд хийгдсэн цахим системүүд нь хэрэглээний шаардлага хангахгүй, уялдаа холбоо, ашиглалтын түвшин муу	АНУ, БНХАУ, БНЭУ гэх мэт улсуудын нэгдсэн цахим системийн туршлага	ДХБ-ын Худалдааг Хөнгөвчлөх Хэлэлцээрийн зорилтын хүрээнд гадаад худалдааны цахим нэг цонхны системийн хэрэгжилтийг сайжруулах
Экспортын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр:		
Итгэмжлэгдсэн лаборатори хангалттай олон биш, шинжилгээнд их хугацаа зарцуулдаг.	Австрали улсын хөндлөнгийн байгууллагын магадлан итгэмжлэл	Хөндлөнгийн байгууллагын магадлан итгэмжлэлийг нэвтрүүлэхэд эхний ээлжид гадаадын нэр хүндтэй байгууллагаас туршлага судалж хамтран ажиллах, хувийн хэвшлийн дэмжих
Мэдээлэл хангалтгүй, хугацаа их шаарддаг	Сингапур улсад TradeNet системийг ажиллуулж эхэлсэн. Эхлээд Засгийн газрын цөөн агентлагуудыг нэгтгэдэг байсан бол цаашдаа гадаад эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогчдын бичиг баримтыг шаардлагатай бүх эрх бүхий байгууллагад (35 агентлаг, газар) цахим хэлбэрээр нэг цонхоор илгээх боломжийг олгосон. TradeNet бол олон үйлдэлт систем бөгөөд оруулсан баримт бичгүүдийг уялдуулсан системийн кодын дагуу автоматаар шалгаж, зохицуулалтын хуулиудын үндсэн дээр синтактик шалгалт, дүн шинжилгээ хийдэг.	АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн үйл ажиллагаа уг туршлагыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах тул дэмжих, одоо байгаа нэг цонхны үйлчилгээг хөгжүүлэх
Экспортын санхүүжилт, даатгалын чиглэлээр:		
Экспортын даатгалд хамрагддаггүй	БНСУ-ын Экспортыг дэмжих байгууллага (KOTRA) нь дотоодын экспортлогчдыг дэмжих, бүтээгдэхүүнээ борлуулах гадаадын зах зээлийг тогтооход хэрэгцээт мэдээллээр хангах, гадаадын хэрэглэгчдэд дотоодын бүтээгдэхүүний талаар мэдээлэл өгөх зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг ²⁶ .	Экспортлогчдыг экспортын даатгалд хамруулах
Экспортын санхүүжилт	БНСУ-ын Экспортыг дэмжих байгууллага (KOTRA) нь дотоодын үйлдвэрлэгчдэд гадаад зах зээлд гарахад тулгарч буй	Экспортын санхүүжилтийн сан байгуулах эсвэл Хөгжлийн банк буюу Экзим банкиг зориулалтын дагуу

²⁶ https://www.mongolbank.mn/documents/press_conference/20190521_04.pdf

	<p>хүндрэлийг шийдэж, мэдээллээр хангаснаар гадаадын зах зээлд нэвтрэхэд нь туслалцаа үзүүлдэг. Энэхүү байгууллага нь дараах чиглэлийн үйл ажиллагааг эрхэлдэг:</p> <ul style="list-style-type: none"> • Зураг төсөл, сурталчилгаа, өмгөөлөл; • Бүтээгдэхүүний маркетинг, үзэсгэлэн худалдаа, худалдааны шоу болон мэдээлэл түгээх; • Экспортлогчдод үйлчилгээ үзүүлэх, бизнес эрхлэгчдийн экспортлох сонирхлыг нэмэгдүүлэх, гаднын зах зээлд нэвтрэхэд хэрэгцээт мэдээллээр хангаж туршлагажуулах; • Экспортлох арга замын талаарх мэдлэгийг олгох, зорилтот бизнесийн түншүүдийг тодорхойлоход чиглэсэн зах зээлийн судалгаа хийх 	ажиллуулах
Хүнд, суртал, авлигыг бууруулах чиглэлээр:		
Хүнд суртал, авлигал	Сингапур улсад контрабанд нэвтрүүлэх, тээврийн хэрэгслийн үзлэгийг "хурдасгах" зорилгоор хахууль өгөх явдлыг таслан зогсоох арга хэмжээ авчээ. Эрүүгийн хариуцлага хүлээлгэж, торгуулийг эрс нэмэгдүүлсэн. Авлигын гэмт хэргийн хамгийн бага торгууль нь 100 мянган Сингапур доллар юм. Албан тушаалтны гэм буруутайг нотолсон тохиолдолд торгууль ногдуулан мөнгийг хурааж, 10 -аас доошгүй жил хорих ял оноох бөгөөд гэр бүлийг гишүүдийн хэн нь ч сайн ажилд орох боломжгүй болно.	Төрийн байгууллагууд дахь авлигыг бууруулах, авлигатай тэмцэх арга хэмжээг бодитоор авч хэрэгжүүлэх
Логистикийн чиглэлээр:		
Логистикийн чиглэлээр хууль эрх зүй, дэд бүтцийн орчин хангалтгүй	Дэлхийн банкны LPI-үзүүлэлтээр нэгдүгээрт байгаа ХБНГУ-ын туршлага	Гурван улсын "Эдийн засгийн коридор" хөтөлбөрийн хүрээнд логистикийн дэд бүтцийг бий болгох
Логистикийн чиглэлээр нэгдсэн мэдээлэл байхгүй, хууль эрх зүйн орчин бүрдээгүй, ачаа барааг тээврийн замд нь хянах зориулалт бүхий сүүлийн үеийн техник технологиор хангагдаж чадаагүй болон гадаад улс орнуудтай нэгдсэн нэг логистикийн сүлжээнд орж чадаагүй	Английн Information Technology for Efficient Road Freight Operations Department-ийн хэрэгжүүлсэн "Fleet менежмент" системийг нэвтрүүлэх	ДХБ-ын Худалдааг Хөнгөвчлөх Хэлэлцээр болон "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийн хүрээнд олон улсын чанартай, байнгын ажиллагаатай хилийн боомтууд дээр логистикийн нэгдсэн төвийг байгуулах, хилийн боомтуудыг орчин үеийн техник хэрэгслээр хангах, боомтуудын уялдаа холбоог сайжруулах

Олон улсын борлуулалтын чиг хандлага цахим болж байгаатай уялдуулан экспортын зардлаа бууруулах, зах зээлдээ хүрч болох хамгийн ашигтай онлайн борлуулалтын сувгийг ашиглах боломж байна. eBay, Zappos, AliBaba зэрэг e-commerce сайтад бүртгүүлж, e-commerce-ийн мэргэжилтнүүдийг ажиллуулах, өөрийн компанийн вэбсайтыг өндөр түвшинд ажиллуулан шууд худалдаа хийх хэлбэрээр ажиллах нь ач холбогдолтой.

4.3.ЭКСПОРТЫН ҮЙЛ ЯВЦЫН “ТО ВЕ” ШИНЖИЛГЭЭ

Дэлхийн Банкнаас жил бүр улс орнуудад судалгаа явуулан бизнес эрхлэлт, Барилгын зөвшөөрөл, Эрчим хүч хангалт, Хөрөнгө бүртгэл, Татвар төлөлт, Гадаад худалдаа, Гэрээний хүчин төгөлдөр байдал гэх мэт 10 төрлийн үзүүлэлтээр үнэлгээ өгдөг бөгөөд тус үнэлгээнд тулгуурлан жагсаалт гаргадаг.

Тус жагсаалтад манай улсын гадаад худалдаа эрхлэлтийн үзүүлэлт 2020 оны байдлаар 60.8 оноотойгоор 211 орноос 143 дугаарт бичигдсэн байх бөгөөд 2019 онд мөн ижил үзүүлэлттэй

байсан байна. Аливаа улс орны нийт үзүүлэлт 2 хувиас дээш хэмжээгээр сайжирсан нөхцөлд Дэлхийн Банкны Шинэчлэл хийгдсэн улсуудын жагсаалтад багтах бөгөөд олон улсын хэмжээнд сурталчилгаа болдог.

Монгол Улсын хувьд, импортын үзүүлэлтүүд болон зардлын үзүүлэлтүүд харьцангуй сайн буюу улс орнуудын жагсаалтад дээгүүрт ордог бөгөөд хойш татаж буй ганц үзүүлэлт нь экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн цаг хугацааны үзүүлэлт байна. Иймд экспортын бичиг баримт бүрдүүлэлтэд шаарддаг хугацаа болон бичиг баримтын тоог цөөрүүлэх нь Дэлхийн Банкнаас гаргадаг улс орнуудын жагсаалтад эзлэх манай улсын байрыг өргөөд зогсохгүй ингэснээр олон улсад манай улсын гадаад худалдаа эрхлэлтийг сурталчилна гэж үзэж байна.

4.3.1.Мах, махан бүтээгдэхүүн, өлөн гэдэс

Мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл явцын “ТО ВЕ” шинжилгээг дараах байдлаар дэлгэрүүлж судаллаа. Үүнд:

- Урьдчилж авах зөвшөөрөл
- Бичиг баримтын бүрдүүлэлт
- Гаалийн хяналт шалгалт

Урьдчилж авах зөвшөөрөл

Урьдчилж авах зөвшөөрөл гэдэгт ХХААХҮЯ-аас олгодог стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох квот, ХХААХҮЯ-тай байгуулдаг бодлогын гэрээ, түүнд шаардагддаг дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ зэргийг хамруулан авч үзлээ. Стратегийн хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох квотыг олгосны дараа бодлогын гэрээ байгуулдаг нь хяналт тавих талаас ашиг тустай боловч гадаад худалдаа, экспортыг дэмжих тал дээр төдийлөн ач холбогдолтой харагдахгүй байна. Аж ахуйн нэгжүүд бодлогын гэрээг экспорт хийх болгонд байгуулах шаардлагатай болдог бөгөөд (тухайн жилийн квотын хэмжээгээ нэг дор бус жилийн турш хэсэгчлэн ашигладаг) ХХААХҮЯ-аас Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар гэх мэт холбогдох хяналтын байгууллагуудад зөвшөөрөл олгосон тухай албан бичиг дагалдуулж өгдөг. Тус албан бичгийг экспортлогч аж ахуйн нэгж холбогдох байгууллагуудад биеэр хүргэж өгдөг нь төрийн удирдах, хяналтын байгууллагуудын хооронд цахим сүлжээ холбоо төдийлөн хөгжөөгүй, дундын цахим мэдээллийн бааз байдаггүйг харуулж байна. Бодлогын гэрээ байгуулахад заасан тоо хэмжээг гаалийн байгууллага хүлээн авч гаалийн бүртгэлийн дотоод системд бүртгэдэг бөгөөд экспортын бүрдүүлэлт хийж гааль мэдүүлэхэд тухайн бүртгэгдсэн тоо хэмжээг давхар шалгадаг байдал нь гааль дээр зарцуулах хугацаанд мөн сөргөөр нөлөөлдөг.

Бичиг баримтын бүрдүүлэлт

Экспортын бичиг баримт бүрдүүлэхэд хэд хэдэн байгууллагаар орох шаардлагатай байдаг бөгөөд тухайн байгууллага бүр ижил төрлийн бичиг баримт шаардах, зарим бичиг баримтыг (жишээ нь улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, худалдах худалдан авах гэрээ г.м.) нотариатаар батлуулсан байхыг шаардах зэрэг тохиолдлууд байдаг. Цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх нь бичиг баримтын давхардлыг арилгахад ач тустай бөгөөд ингэснээр бичиг баримтын бүрдүүлэлтэд шаардагдах хугацааг багасгах боломжтой.

Мөн түүнчлэн, мах, сүү, ноос ноолуур гэх мэт хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлт болон хяналтыг Австрали улсын жишгээр нэг байгууллага хариуцах нь экспортлогчдод олон байгууллагаар явах цаг хугацааг хэмнэж, хүндрэл чирэгдлийг багасгах бололцоотой байна. Бичиг баримт бүрдүүлэхэд цахим сүлжээг ашиглах нь аж ахуйн нэгж, байгууллагууд болон төрийн албан хаагчдын хоорондын шууд харилцааг багасгаж, хүнд суртал, авилгийн боломжийг бууруулахад чухал ач холбогдолтой.

Хүснэгт 121. Мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал

	ХХААХҮЯ		СХЗГ	МҮХАҮТ	МЭЕГ	МХЕГ	Давхардал
	СХБ экспорт квот	Бодлогын гэрээ	Тохирлын гэрчилгээ	Гарал үүслийн гэрчилгээ	ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	Экспорт гэрчилгээ	
	9 бичиг	7 бичиг	7 бичиг	5 бичиг	6 бичиг	9 бичиг	
Байгууллагын танилцуулга	+						1
Экспортлох бүтээгдэхүүний нэр төрөл, багцын хэмжээг заасан албан бичиг	+						1
Мал, мах бэлтгэлийн талаар мэдээлэл, төлөвлөгөө		+					1
Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ		+					1
Сүүлийн жилийн санхүүгийн тайлангийн хуулбар /Аудитаар баталгаажсан/	+						1
Бэлтгэсэн түүхий эдийн 30-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрт нийлүүлсэн тухай гэрээ, төлбөрийн баримт эсхүл экспортод гаргахаар зориулалтын агуулахад хадгалж буй баримт		+					1
Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, шинжээчийн дүгнэлт		+					1
Хуулийн этгээдийг төлөөлөн сонгон шалгаруулалтад оролцох этгээдэд итгэмжлэл олгосон эрх бүхий албан тушаалтны шийдвэр	+						1
Малын гаралтай болон энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрсөн цэгт хог хаягдлын гэрээ		+					1
Хоёр орны хооронд байгуулсан протоколын дагуу боловсруулж, батлуулсан технологийн заавар		+					1
Мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт	+						1
Татварын албаны тодорхойлолт	+						1
Шаардлагатай тохиолдолд импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн байгууллагаас итгэмжлэгдсэн байх	+						1
Хүн амын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд ХХААХҮЯ-тай бодлогын гэрээ байгуулахад татгалзах зүйлгүй талаар мэдэгдсэн албан бичиг	+						1
Үйлдвэрийн танилцуулга/ Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил		+			+		2
Худалдааны гэрээ/ Гадаад худалдааны гэрээ/Худалдах, худалдан авах гэрээ	+		+	+	+	+	5
УБГ-ний хуулбар			+	+	+	+	4
Өргөдлийн маягт			+	+			2
Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг/ Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт/			+	+		+	3
Бүтээгдэхүүний сорилт, туршилт хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн/ Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт			+		+		2
Мэргэжлийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл (шаардлагатай тохиолдолд)/ Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл, чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар			+	+			2
Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл					+		1
Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа					+		1

Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл, экспортлох тоо хэмжээ						+	1
ХХААХҮЯ-тай байгуулсан бодлогын гэрээ, гэрчилгээ олгох тухай албан бичиг						+	1
Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл						+	1
Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ						+	1
Экспортыг хүлээн авах улсын тухайн бүтээгдэхүүнийг бүртгэсэн бүртгэлийн хуулбар						+	1
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт/Үйлчилгээний төлбөр тушаасан баримтын хувь			+			+	2

Худалдааны гэрээг 5 удаа, аж ахуйн нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээг 4 удаа (1 нь баталгаажсан), сав баглаа боодлын жагсаалт, үнийн нэхэмжлэх, мэдээллийг 3 удаа, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн, тусгай зөвшөөрөл зэрэг бичиг баримтыг 2 удаа давхардсан байдлаар гаргаж өгдөг. Түүнчлэн, ижил агуулгатай мэдээлэл агуулсан бичиг баримтуудын нэрийг өөр өөрөөр нэрлэн шаарддаг байна.

Нэг цэгийн цахим цонхны үйлчилгээг амжилттай нэвтрүүлснээр эдгээр бичиг баримтуудын давхардал арилах бөгөөд мөн заавал цаасаар бичиг цаас солилцдог байдлыг халж, мэдээллийн сүлжээгээр бичиг баримтыг авч шалгаснаар багагүй цаг хугацаа болон зардал хэмнэх боломжтой.

Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг МЭЭГ-аас олгох хуулийн хугацаа нь 30 хоног боловч туршлагатай экспортлогчид 1-3 өдөр зарцуулдаг хэмээн судалгаагаар гарсан. Судалгаанд хамрагдсан экспортлогчдын үзэж байгаагаар, хэрэв зөвхөн ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээг авахад хуулийн хугацаа буюу 30 хоног зарцуулбал бодит байдалд экспорт хийгдэх боломжгүй бөгөөд итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн дээжийн хариуны хүчинтэй хугацаа бусад экспортын зөвшөөрөл гэрчилгээг авахаас өмнө дуусах буюу экспортод гаргах боломжгүй байдалд хүрнэ. Хэдийгээр бодит байдалд дунджаар 2 хоног зарцуулж буй боловч хуулийн шаардагдах хугацаа бодит зарцуулж буй хугацаа хоёр нь хоорондоо хэт зөрүүтэй байгаа нь анхаарал татаж байна.

Экспортын гэрчилгээ, ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ нь Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын байцаагчийн авсан дээжид Улсын мал эмнэлгийн ариун цэврийн лаборатори эсхүл Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораторид хийгдсэн шинжилгээний хариунд тулгуурлан гардаг. Гадаад улс орнуудын сайн туршлагаас харахад, экспорт хийх бүрд шинжилгээ хийдэггүй бөгөөд тухайн махыг бэлтгэж буй экспортлогчид үйлдвэрийг хянаж магадлан итгэмжлэл олгодог. Тус туршлагыг хэрэгжүүлбэл экспорт хийх бүрд НМХГ-аас байцаагч томилуулдаг, томилогдсон байцаагч дээж авдаг, авсан дээжийг лабораторид шинжилдэг байдлыг хөнгөвчлөх боломжтой бөгөөд ингэснээр дээрх үйл явцад зарцуулагддаг 5 өдөр буюу 120 цагийг хэмнэх боломжтой байна. Энэ нь үндсэндээ экспортлогч хувийн хэвшлийг хяналтын үйл явцад оролцоотой байлгаж, зөвхөн экспортлох үед шинжилгээ хийлгэдэг бус тогтмол шинжилгээтэй, хяналттай болгох тухай асуудал бөгөөд шийдвэрлэхэд багагүй цаг хугацаа, хүчин чармайлт зарцуулна. Гэвч урт хугацаандаа экспортлогчдод үр өгөөжтэй тул хэрэгжүүлэх боломжтой.

Гаалийн хяналт шалгалт

Бараа бүтээгдэхүүний экспортод гаалийн хяналт шалгалт нь бичиг баримтын бүрдүүлэлтээс хамаарч харьцангуй хялбар явагддаг. Хэдий хялбар явагддаг боловч зарцуулж буй хугацаа нь зөвхөн нэг мэдүүлэгт хамгийн хурдан нь нэг өдөр бүтэн зарцуулагдаж байгаа тул “хангалттай сайн” гэж дүгнэхээргүй байна. Олон улсын жишгээс харахад, Австрали улс мах, махан бүтээгдэхүүн экспортлоход хил дээр гаалийн хяналт шалгалтад зарцуулагдах хугацаа нь ердөө 1 цаг бөгөөд хил дээрх гаалиас бусад хяналтын байгууллагуудын зарцуулах хугацаа нь 4.5 цаг гэж Дэлхийн банкны судалгаагаар тодорхойлсон байна. Манай улс хэдийгээр 1 цаг хүртэл багасгах боломжгүй ч тодорхой түвшинд бууруулах боломжтой гэдэг нь судалгааны явцад харагдсан. Үүнд:

- ✚ Барааны гаалийн мэдүүлэгт (бичиг баримтын хяналт, биет үзлэг шалгалт) хяналт шалгалт хийхэд гаалийн байцаагчдад тодорхой норматив хугацаа байдаггүй нь хяналт тавихад

сайшаалтай ч нөгөө талдаа гадаад худалдаанд сөргөөр нөлөөлдөг. Үүгээр зогсохгүй эл байдал нь хүнд суртал, авиалгалд автах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой бөгөөд мөн гаалийн улсын байцаагчдын ур чадварт сөргөөр нөлөөлөх боломжтой.

- ✚ Хэдийгээр гаалийн бүрдүүлэлтэд хяналт тавих улсын байцаагчдыг цахим системээр цаг алдалгүй томилж байгаа нь сайшаалтай боловч бүх гаалийн байцаагчдын гаргасан шийдвэр зөвшөөрлийг нэг л гаалийн ахлах байцаагч баталгаажуулдаг үйл явц нь аж ахуйн нэгжүүдэд ээлж дараалал хүлээх, цаг хугацааны хувьд хүндрэл болдог байна.
- ✚ Мах, махан бүтээгдэхүүний экспортын хувьд гүний гааль буюу Улаанбаатар хотын гаальд ихэвчлэн гаалийн бүрдүүлэлтийг хийдэг бөгөөд гаалийн итгэмжлэгдсэн тээврийн компаниар тээвэрлэлтээ хийлгэж хилийн дээс гардаг. Ийнхүү гаалийн бүрдүүлэлтийг 1-2 өдөр зарцуулж хийж бараагаа илгээсний дараа хил дээр гаалийн байгууллага дахин шалгадаг бөгөөд тус шалгалт нь гаалийн байцаагч тээврийн хэрэгсэл болон гүний гаалийн байцаагчийн тавьсан лац ломбыг шалгадаг боловч мөн л хил дээрх цор ганц гаалийн ахлах байцаагч эцсийн зөвшөөрлийг өгдөг нь тодорхой цаг хугацаа зарцуулахад хүргэдэг.

Бичиг баримт бүрдүүлэлтийн болон гаалийн хяналт шалгалтын талаарх дээр дурдсан хүндрэлүүдийг таатай байдлаар шийдвэрлэх нь экспортод зарцуулж буй цаг хугацаа болон зардлын хэмнэлтийг нөхцөлдүүлнэ.

Зураг 54. Мах, махан бүтээгдэхүүний экспортын “ТО ВЕ” шинжилгээний зураглал

	Өнөөгийн байдал	Асуудал	Шийдэл	ТО ВЕ
Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ	120 цаг / 104,000₮	НМХГ-т хүсэлт гаргаж, байцаагч томилуулах, томилсон байцаагч дээж авч авсан дээжийг байцаагчийн шаардлагын дагуу шинжилгээнд хамруулдаг	Австрали улсын жишгээр үйлдвэр, экспортлогчийг хянах магадлан итгэмжлэл олгодог системийг нэвтрүүлснээр экспорт хийх бүрд давтагддаг процессыг өөрчлөх	0 цаг / 0₮
Тохирлын гэрчилгээ	148 цаг / 141,500₮ - 2 цаг / 79,000₮ - 2 цаг / 40,000₮ - 2 өдөр / 12,500₮ - 4 өдөр / 10,000₮	Цахимаар маягт татаж бөглөсний дараа цаасаар хүсэлтээ өгдөг	Нэг цонхны цахим үйлчилгээ нэвтрүүлснээр экспортлогч нэг системд хүсэлтээ холбогдох бичиг баримтын хамт оруулахад бүх хяналтын байгууллагууд тухайн бичиг баримтыг зэрэг хүлээн авч, мөн шаардлагатай мэдээллийг экспортлогчийн гараар дамжуулалгүй өөр хоорондоо солилцож, хариу зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгодог болох	74 цаг / 141,500₮ - 1 цаг / 79,000₮ - 1 цаг / 40,000₮ - 1 өдөр / 12,500₮ - 2 өдөр / 10,000₮
Гарал үүслийн гэрчилгээ		Цахимаар хүсэлтээ илгээдэг боловч заавал цаасаар давхар өгдөг		
ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ		Хүсэлтээ цаасан хэлбэрээр гаргадаг, Хуулийн хугацаа: 30 хоног		
Экспортын гэрчилгээ		Хуулийн хугацаа 14 хоног. МЖЕГ-ын хяналт шалгалт, олгох процесс хугацаа их шаарддаг		
Гаалийн бүрдүүлэлт	48 цаг / 89,200₮	- Гаалийн бүрдүүлэлтийг хянах, шалгахад тогтсон стандарт хугацаа байхгүй. - Бүх гаалийн мэдүүлэг нэг ахлах байцаагчийн хяналтаар дамждаг - Гүний гаальд хяналт шалгалтад хамрагдсны дараа бүх бараа хил дээр хилийн гаальд мөн нэг ахлах байцаагчийн зөвшөөрлөөр гардаг	- Гаалийн бүрдүүлэлтийг хянах, шалгахад норматив хугацаа тогтоож, экспортлогчдоод ил болгож гаалийн байцаагчийн ур чадвар, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх. - Бүх гаалийн мэдүүлэг нэг ахлах байцаагчийн гараар дамждаг үйл явцыг өөрчлөх. - Гүний гаальд хяналт шалгалтад хамрагдсны дараа бүх бараа хил дээр хилийн гаальд дахин ахлах байцаагчийн гараар дамждаг процессыг өөрчлөх	24 цаг / 89,200₮
Нийт	316 цаг / 334,700₮			98 цаг / 230,700₮

Дээрх зургаас үзэхэд, экспортын бичиг баримт бүрдүүлэлт болон гаалийн хяналт шалгалтад тодорхой сайжруулалтыг хийснээр экспортод нийт 316 цаг зарцуулж байгааг 98 цаг болгож 69 хувиар буурах боломжтой байна.

Эцэст нь дүгнэхэд, урьдчилж авах зөвшөөрөл, бичиг баримтын бүрдүүлэлт, гаалийн хяналт шалгалтын үйл явцад бичиг баримтын давхардал, хяналт, шалгалтын үйл явцын үр ашиггүй алхмуудыг арилгах зэрэг арга хэмжээнүүдийг авснаар мах, махан бүтээгдэхүүний экспортод зарцуулагдах цаг хугацаа тодорхой хэмжээнд буурах боломжтой.

4.3.2. Сүү, сүүн бүтээгдэхүүн

Монгол Улс “Цахим үндэстэн” болох зорилгоор дижитал шилжилтийн бодлогоо тодорхойлж эхний ээлжид төрийн үйлчилгээг цахимжуулах “E-Mongolia” нэгдсэн порталыг байгуулсан.

Цахим шилжилтийг аль болох хурдан хийж, төрийн үйлчилгээг цахимжуулснаар ил тод, нээлттэй төрийн үйлчилгээг хүргэх болно.

Хүснэгт 122. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал

	СХЗГ	МҮХАҮТ	МЭЕГ	МХЕГ	Давхардал
	Тохирлын гэрчилгээ	Гарал үүслийн гэрчилгээ	ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	Экспорт гэрчилгээ	
	7 бичиг	5 бичиг	6 бичиг	9 бичиг	
Үйлдвэрийн танилцуулга/ Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил			+		2
Худалдааны гэрээ/ Гадаад худалдааны гэрээ /Худалдах, худалдан авах гэрээ	+	+	+	+	5
УБГ-ний хуулбар	+ нотариат	+	+	+	4
Өргөдлийн маягт	+	+			2
Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг/ Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт/	+	+		+	3
Бүтээгдэхүүний сорилт, туршилт хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн/ Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт	+		+		2
Мэргэжлийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл (шаардлагатай тохиолдолд)/ Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл, чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар	+	+			2
Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл			+		1
Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа			+		1
Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл, экспортлох тоо хэмжээ				+	1
Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл				+	1
Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ				+	1
Экспортыг хүлээн авах улсын тухайн бүтээгдэхүүнийг бүртгэсэн бүртгэлийн хуулбар				+	1
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт/ Үйлчилгээний төлбөр тушаасан баримтын хувь	+			+	2

Дотоодын жижиг компаниуд гадаад зах зээлд ганц нэгээр гарахаас илүүтэйгээр хамтран ажиллаж, бизнесийн эрсдэлээ бууруулахын тулд үндэсний хэмжээний гадаад худалдааны нэг цонхны цахим үйлчилгээг ойрын хугацаанд нэвтрүүлэх, мөн оролцогч талуудын эрх үүрэг, цахим процессын алхам, харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлэх саналыг дэвшүүлж байна.

Зураг 55. Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын "То Ве" шинжилгээний зураглал

	Өнөөгийн байдал	Асуудал	Шийдэл	TO BE
Итэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ	96 цаг / 124,000₮	Монгол улс нь бруцеллёз, шүлхий зэрэг малын гоц халдварт өвчин гардаг бус нутагт хамаардаг тул аюулгүй, эрүүл малын бүтээгдэхүүн гэсэн баталгаа шаардагддаг. БНХАУ-ын гаалийн байгууллага зарим үед мод, модон эдлэл, хүнс, ахуйн бараа ачсан чингэлгийг түүвэрлэн зогсоож, биет болон рентген үзлэгт оруулж, сул зогсолтын төлбөр авдаг. Сул зогсолтын төлбөр, рентген үзлэгийн хураамжийн дүн зогссон хугацаанаас шалтгаалж 80-250 ам.долларын хооронд хэлбэлзэнэ.	"Quality trend" системд бүтээгдэхүүний шинжилгээ, танилцуулга оруулсанаар экспорт хийх бүрт давтагддаг тус үйл ажиллагааг хөнгөвчлөх боломжтой	0 цаг / 0₮
Тохиrolын гэрчилгээ				
Гарал үүслийн гэрчилгээ	100 цаг / 136,500₮		Нэг цонхны цахим үйлчилгээ нэвтрүүлснээр экспортлох нэг системд хүсэлтээ холбогдох бичиг баримтын хамт оруулахад, бүх хяналтын байгууллагууд тухайн бичиг баримтыг зэрэг хүлээн авч, мөн шаардлагатай мэдээллийг экспортлогчийн гараар дамжуулалгүй өөр хоорондоо солилцож, хариу зөвшөөрлийг мөн цахим хэлбэрээр олгодог болох	24 цаг / 136,500₮
ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	- 24 цаг / 79,000₮ - 168 цаг / 40,000₮ - 72 цаг / 25,000₮ - 48 цаг / 12,500₮	Бүтээгдэхүүн экспортлогч нар экспортын холбогдох бичиг баримт бүрдүүлэлт, дүгнэлт гаргуулах явцад төрийн болон хувийн хэвшлийн 4 байгууллагатай харьцаж нийт 312 цаг, 156,500 төгрөг зарцуулж байна. Дээрх 4 байгууллагатай харьцах явцад ижил нэр төрлийн 5-6 бичиг баримтыг 5-6 байгууллагад давтан хүргэдэг процесс нь мэдээлэл технологийн хөгжил хүртээмжтэй, хурдтай болсон өнөө цаг үед зөвхөн экспортлогч төдийгүй нийт системийн хувьд их цаг хугацаа, зардал шаардсан хамгийн үр дүнгүй хувилбар юм.		- 1 цаг / 79,000₮ - 1 цаг / 40,000₮ - 1 өдөр / 12,500₮ - 2 өдөр / 10,000₮
Экспортын гэрчилгээ				
Гаалийн бүрдүүлэлт	48 цаг / 37,700₮	Гүний гаальд хяналт шалгалтанд хамрагдсаны бүх бараа хил дээр очоод хилийн гаальд мөн нэг ахлах байцаагчийн зөвшөөрлөөр гардаг	Олон улсад мөрдөгдөж буй "eTR" програмыг бүрэн нэвтрүүлж Турк улсын жишээгээр машин орох гарах код зохицуулах	24 цаг / 37,700₮
Нийт	244 цаг / 298,200₮			48 цаг / 174,200

Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлт болон гаалийн хяналт шалгалтыг хөнгөвчилснээр нийт 244 цаг 298200₮ зарцуулж байгааг 48 цаг 174200₮ болгож бууруулах боломжтой.

Гадаад улс орнуудын туршлагад тулгуурлан Экспортын даатгалд хамруулах, Экспортын санхүүжилтийн сан байгуулах эсвэл Хөгжлийн банк буюу Экзим банкныг зориулалтын дагуу ажиллуулах саналыг дэвшүүлж байна.

4.3.3.Гоо сайхны бүтээгдэхүүн

Олон улсын стандартад нийцсэн тэргүүний дэвшилтэт шинэ технологи, инновацыг нутагшуулах, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, нэмүү өртөг өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь чухал байна.

Хүснэгт 123. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал

Бичиг баримтын жагсаалт	СХЗГ	МҮХАҮТ	Давхардал
	Тохирлын гэрчилгээ	Гарал үүслийн гэрчилгээ	
	7 бичиг	5 бичиг	
Худалдааны гэрээ/ Гадаад худалдааны гэрээ/Худалдах, худалдан авах гэрээ	+	+	2
УБГ хуулбар	+ нотариат	+	2
Өргөдлийн маягт	+	+	2
Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг/ Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт/	+	+	2
Мэргэжлийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл (шаардлагатай тохиолдолд)/ Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл, чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар	+	+	2
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт/ Үйлчилгээний төлбөр тушаасан баримтын хувь	+		1

*Бүтээгдэхүүн экспортолж буй орноос хамааран импортын гэрчилгээ авах тохиолдол байдаг.

Зураг 56. Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын "То Ве" шинжилгээний зураглал

	Өнөөгийн байдал	Асуудал	Шийдэл	TO BE
Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ	96 цаг / Дээжийн тоо хэмжээнээс шалтгаалж үнэ ялгаатай	- Гоо сайхны бүтээгдэхүүн хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй гэсэн болгоомжлол, үндэслэл байгаа тохиолдолд эрх бүхий байгууллага нь шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг авах, эргүүлэн татах эсвэл хязгаарлах талаар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах болно. - Монгол улс дахь лабораториуд нь олон улсын түвшинд эрх зүйн хувьд чадамжтай шинжилгээний хариу гаргадаг ч зарим орон дотооддоо хүлээн зөвшөөрөгдсөн дээжийн шинжилгээ шаарддаг.	-Олон улсын "Quality trend" системд бүтээгдэхүүний шинжилгээ, танилцуулга оруулсанаар экспорт хийх бүрд давтагддаг үйл ажиллагааг цөөлөх боломжтой. - Монгол улсын лабораториудын шинжилгээг импортлогч нарт хүлээн зөвшөөрүүлэх, итгэлцэл бий болгох	0 цаг / 0₮
Тохирлын гэрчилгээ	4 цаг / 99 000₮ - 2 цаг/ 79,000₮ - 2 цаг/ 20,000₮	Бүтээгдэхүүн экспортлогч нар экспортын холбогдох бичиг баримт бүрдүүлэлт, дүгнэлт гаргуулах явцад төрийн болон хувийн хэвшлийн 4 байгууллагатай харьцаж нийт 148 цаг, 137,700 төгрөг зарцуулж байна. Дээрх 4 байгууллагатай харьцах явцад ижил нэр төрлийн 5-6 бичиг баримтыг 5-6 байгууллагад даван хүргэдэг процесс нь мэдээлэл технологийн хөгжил хүртээмжтэй, хурдтай болсон өнөө цаг үед зөвхөн экспортлогч төдийгүй нийт системийн хувьд их цаг хугацаа, зардал шаардсан хамгийн үр дүнгүй хувилбар юм.	Нэг цонхны цахим үйлчилгээ нэвтрүүлснээр экспортлогч нэг системд хүсэлтээ холбогдох бичиг баримтын хамт оруулахад, бүх хяналтын байгууллагууд тухайн бичиг баримтыг зэрэг хүлээн авч, мөн шаардлагатай мэдээллийг экспортлогчийн гараар дамжуулалгүй өөр хоорондоо солилцож, хариу зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгодог болох	4 цаг / 99 000₮ - 4 цаг / 79,000₮ - 4 цаг / 20,000₮
Гарал үүслийн гэрчилгээ				
Гаалийн бүрдүүлэлт	48 цаг / 37,700₮	Гүний гаальд хяналт шалгалтанд хамрагдсаны бүх бараа хил дээр очоод хилийн гаальд мөн нэг ахлах байцаагчийн зөвшөөрлөөр гардаг	Гүний гаальд хяналт шалгалтанд хамрагдсаны бүх бараа хил дээр очоод хилийн гаальд дахин ахлах байцаагчийн гараар дамждаг процессийг халах	24 цаг / 38,700₮
Нийт	148 цаг / 136,700₮			28 цаг / 136, 700₮

Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын бичиг баримт бүрдүүлэлт болон гаалийн хяналт шалгалтад тодорхой сайжруулалтыг хийснээр экспортод нийт 148 цаг зарцуулж байгааг 28 цаг болгож бууруулах боломжтой.

Экспортын "Нэг цонх"-ны бодлогыг хувийн хэвшлийн санаачилга, манлайллыг дэмжих замаар хэрэгжүүлэхээс гадна өмнөх ижил төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн Олон улсын төсөл хөтөлбөрийн үр дүн, үйл ажиллагаа, төрийн байгууллагуудын өнөөгийн хэрэглэж буй системийн уялдаа холбоох, дижитал шилжилттэй уялдуулан зөөлөн дэд бүтцийг давхар хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, системийн дизайныг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн анхнаас нь зөв төлөвлөхөд мэргэжлийн баг бүрэлдэхүүн, хүний нөөцийн хөгжүүлэх, экспортын худалдаанд тавих хил, гааль, мэргэжлийн хяналтыг хөнгөвчлөн чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах хэрэгтэй юм.

4.3.4. Монгол гэр

Экспортын бичиг баримт бүрдүүлэхэд хэд хэдэн байгууллагаар орох шаардлагатай байдаг бөгөөд тухайн байгууллага бүр ижил төрлийн бичиг баримт шаардах, зарим бичиг баримтыг (жишээ нь улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, худалдах худалдан авах гэрээ г.м.) нотариатаар батлуулсан байхыг шаардах зэрэг тохиолдлууд байдаг. Цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх нь бичиг баримтын давхардлыг арилгахад ач тустай бөгөөд ингэснээр бичиг баримтын бүрдүүлэлтэд шаардагдах хугацаа багасах боломжтой.

Хүснэгт 124. Монгол гэрийн экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал

	МҮХАҮТ	МХЕГ	Давхардал
	Гарал үүслийн гэрчилгээ	Экспорт гэрчилгээ	
	4 бичиг	4 бичиг	
Худалдааны гэрээ/ Гадаад худалдааны гэрээ/Худалдах, худалдан авах гэрээ	+	+	2
УБГ-ний хуулбар	+	+	2
Өргөдлийн маягт	+		1
Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг/ Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт/	+	+	2
Бүтээгдэхүүний сорилт, туршилт хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн/ Ургамлын ариутгал, халдваргүйтгэл хийлгэсэн акт			1
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт/ Үйлчилгээний төлбөр тушаасан баримтын хувь		+	1

Худалдааны гэрээг 2 удаа, аж ахуйн нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээг 2 удаа, сав баглаа боодлын жагсаалт, үнийн нэхэмжлэх, мэдээллийг 2 удаа давхардсан байдлаар гаргаж өгдөг. Түүнчлэн, ижил агуулгатай мэдээлэл агуулсан бичиг баримтуудын нэрийг өөр өөрөөр нэрлэн шаарддаг байна.

Нэг цэгийн цахим цонхны үйлчилгээг амжилттай нэвтрүүлснээр эдгээр бичиг баримтуудын давхардал арилах бөгөөд мөн заавал цаасаар бичиг цаас солилцдог байдлыг халж, мэдээллийн сүлжээгээр бичиг баримтыг авч шалгаснаар цаг хугацаа болон зардал хэмнэх боломжтой.

Бичиг баримт бүрдүүлэлтийн болон гаалийн хяналт шалгалтын талаарх дээр дурдсан хүндрэлүүдийг гадаад худалдааг дэмжих, экспортын үйл явцыг хөнгөвчлөхөд таатай байдлаар шийдвэрлэх нь экспортод зарцуулж буй цаг хугацаа болон зардлын хэмнэлтийг бүрдүүлэхэд ач холбогдолтой бөгөөд доорх зурагт харууллаа.

Зураг 57. Монгол гэрийн экспортын “TO BE” шинжилгээний зураглал

	Өнөөгийн байдал	Асуудал	Шийдэл	TO BE
Гарал үүслийн гэрчилгээ Экспортын гэрчилгээ	98 цаг / 50,000₮ - 2 цаг / 40,000₮ - 4 өдөр / 10,000₮	Цахимаар хүсэлтээ илгээдэг боловч заавал цаасаар давхар өгөхийг шаарддаг	Нэг цонхны цахим үйлчилгээ нэвтрүүлснээр экспортлогч нэг системд хүсэлтээ холбогдох бичиг баримтын хамт оруулахад бүх хяналтын байгууллагууд тухайн бичиг баримтыг зэрэг хүлээн авч, мөн шаардлагатай мэдээллийг экспортлогчийн гараар дамжуулалгүй өөр хоорондоо солилцож, хариу зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгодог болох	49 цаг / 50,000₮ - 1 цаг / 40,000₮ - 2 өдөр / 10,000₮
		Хуулийн хугацаа 14 хоног, МХЕГ-ын хяналт шалгалт, олгох процесс нь хугацаа их шаарддаг		
Гаалийн бүрдүүлэлт	48 цаг / 29,200₮	- Гаалийн бүрдүүлэлтийг хянах, шалгахад тогтсон стандарт хугацаа байхгүй. - Бүх гаалийн мэдүүлэг нэг ахлах байцаагчийн хяналтаар дамжих шаардлага гардаг - Гүний гаальд хяналт шалгалтад хамрагдсны дараа бүх бараа хил дээр хилийн гаальд мөн нэг ахлах байцаагчийн зөвшөөрлөөр гардаг	- Гаалийн бүрдүүлэлтийг хянах, шалгахад норматив хугацаа тогтоож, экспортлогчдод ил болгож гаалийн байцаагчийн ур чадвар, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх. - Бүх гаалийн мэдүүлэг нэг ахлах байцаагчийн гараар дамждаг үйл явцыг халах. - Гүний гаальд хяналт шалгалтад хамрагдсны дараа бүх бараа хил дээр хилийн гаальд дахин ахлах байцаагчийн гараар дамждаг процессыг халах	24 цаг / 29,200₮
Нийт	146 цаг / 79,200₮			73 цаг / 79,200₮

Экспортын бичиг баримт бүрдүүлэлт болон гаалийн хяналт шалгалтад тодорхой сайжруулалтыг хийснээр экспортод нийт 146 цаг зарцуулж байгааг 73 цаг болгож бууруулах боломжтой.

4.3.5. Арьс шир

Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын бичиг баримтын бүрдүүлэлтэд олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг авахад ХАА-н биржийн тодорхойлох бичгийг авах шаардлагатай бөгөөд тус бичиг нь ажлын 5 өдөрт хүчинтэй гэж холбогдох журамд заасан байна. Гэтэл МЭЕГ-аас олгодог Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг олгох хуулийн хугацаа 30 хоног гэж заасан нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нийцгүй байдлаас шалтгаалж экспортлогчийн цаг хугацаа, зардлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Арьс ширний үйлдвэрүүдэд НҮБАҮХБ-ын Бенчмарк аргачлал, арьс ширний олон улсын зөвлөлийн LWG стандартыг нэвтрүүлж экспорт хийх бүрд зарцуулах төрөл бүрийн

нарийвчилсан шинжилгээний цаг хугацааг хэмнэж улмаар олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай болох чухал юм.

Хүснэгт 125. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал

	СХЗГ	МҮХАҮТ	МЗЭГ	МХЕГ	ХАА-н бирж	Давхардал
	Тохирлын гэрчилгээ	Гарал үүслийн гэрчилгээ	ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	Экспорт гэрчилгээ	Тодорхойлох бичиг	
	7 бичиг	5 бичиг	8 бичиг	9 бичиг	2 бичиг	
Үйлдвэрийн танилцуулга/ Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил			+			1
Албан бичгээр хүсэлт гаргах				+	+	2
Худалдааны гэрээ/ Гадаад худалдааны гэрээ/Худалдах, худалдан авах гэрээ	+	+	+	+		4
УБГ хуулбар	+	+	+	+		4
Өргөдлийн маягт	+	+				2
Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг/ Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт/	+	+		+		3
Бүтээгдэхүүний сорилт, туршилт хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн/ Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт	+	+	+	+		4
Мэргэжлийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл (шаардлагатай тохиолдолд)/ Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл, чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар	+					1
Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл			+			1
Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа			+			1
Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл				+		1
ХАА-н биржээр бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан тухай тодорхойлох бичиг			+			1
Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ				+		1
Экспортыг хүлээн авах улсын тухайн бүтээгдэхүүнийг бүртгэсэн бүртгэлийн хуулбар				+		1
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт/ Үйлчилгээний төлбөр тушаасан баримтын хувь	+		+	+	+	4

Худалдааны гэрээг 4 удаа, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээг 4 удаа (1 нь баталгаажсан), сав баглаа боодлын жагсаалт, үнийн нэхэмжлэх, мэдээллийг 3 удаа, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн 4, тусгай зөвшөөрөл зэрэг бичиг баримтыг 2 удаа давхардсан байдлаар гаргаж өгдөг байна.

Зураг 58. Арьс ширэн бүтээгдэхүүний экспортын ТОВЕ шинжилгээний дүн

	Өнөөгийн байдал	Асуудал	Шийдэл	ТОВЕ
Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ	48 цаг / 130,000-155,000₮	НМХГ-т хүсэлт гаргаж, байцаагч томилуулах, томилсон байцаагч дээж авч, авсан дээжийг байцаагчийн шаардлагын дагуу шинжилгээнд хамруулдаг	ОУ-ын LWG стандартыг нэвтрүүлснээр экспортлогч олон улсад хүлээн зөвшөөрөгдөж экспортын байнгын давтагддаг процессыг хөнгөвчилнө	0 цаг / 0₮
Тохиролын гэрчилгээ	120 цаг / 163,500 ₮ - 2 цаг / 79,000₮ - 2 цаг / 15,000-80,000₮ - 24 цаг / 12,500₮ - 3 цаг / 7,000 ₮ - 24 цаг / 5000-10000₮ - 72 цаг / 10,000₮	Цахимаар маягт татан бөглөөд цаасаар хүсэлтээ өгхийг шаарддаг	Нэг цонхны цахим үйлчилгээ нэвтрүүлснээр экспортлогч системд бичиг баримтын хамт оруулахад бүх хяналтын байгууллагууд тухайн бичиг баримтыг зэрэг хүлээн авч шаардлагатай мэдээллийг экспортлогчийн гараар дамжуулалгүй өөр хоорондоо солилцож, хариу зөвшөөрлийг мөн цахим хэлбэрээр олгодог болох	96 цаг / 116,000 ₮ - 1 цаг / 79,000₮ - 24 цаг / 12,500₮ - 1 цаг / 7,000 ₮ - 1 цаг / 7,500₮ - 72 цаг / 10,000₮
Гарал үүслийн гэрчилгээ		Цахимаар хүсэлтээ илгээдэг боловч заавал цаасаар давхар өөгийг		
ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ		Хүсэлтээ цаасан хэлбэрээр гаргадаг, хуулийн хугацаа: 30 хоног		
Тээврийн бичиг баримт		ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ авахад ХАА-н биржээр арилжаалагдсан бичиг шаарддаг.		
ХАА-н биржийн бичиг		Хуулийн хугацаа 14 хоног, МХЕГ-ын хяналт шалгалт, олгох процесс нь хугацаа их шаарддаг хүндрэлтэй		
Экспортын гэрчилгээ				
Гаалийн бүрдүүлэлт, тээврийн бичиг баримт	48 цаг / 30,000₮	- Гаалийн бүрдүүлэлтийг хянах, шалгахад тогтсон стандарт хугацаа гэж байхгүй. - Бүх гаалийн мэдүүлэг нэг ахлах байцаагчийн хяналтаар дамжих шаардлага гардаг - Гүний гаальд хяналт шалгалтанд хамрагдсаны бүх бараа хил дээр очоод хилийн гаальд мөн нэг ахлах байцаагчийн зөвшөөрлөөр гардаг	- Гаалийн бүрдүүлэлтийг хянах, шалгахад норматив хугацаа тогтоож, экспортлогчдод ил болгон, гаалийн байцаагчийн үр чадвар, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх. - Бүх гаалийн мэдүүлэг нэг ахлах байцаагчийн гараар дамждаг үйл явцыг халах. - Гүний гаальд хяналт шалгалтанд хамрагдсны дараа хилийн гаальд дахин ахлах байцаагчийн гараар дамждагийг болиулах	24 цаг / 30,000₮
Нийт	216/336,000₮			120 цаг / 146,000₮

Арьс ширэн бүтээгдэхүүнийг экспортын үйл явцыг нэг цонхны цахим системд шилжүүлснээр хугацаа 106 цаг буюу 51 хувиар, зардал 146,000₮ буюу 56 хувиар бууруулах боломжтой.

Зардлын хувьд, холбогдох эрх бүхий байгууллагын баталсан тарифын үнэлгээг хэвээр тооцсон ч онлайн бус горимд ажиллаж байсан үеийн захиргааны шинжтэй зардлуудыг хэмнэж байгаа бөгөөд энэ нь нийт системийн хувьд тооцвол үр ашигтай байгаа нь тодорхой юм.

4.3.6.Ноос, ноолууран бүтээгдэхүүн

Ноолууран бүтээгдэхүүн нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн дотроос экспортын орлогоор тэргүүлж байгаа бөгөөд дэлхийн маш олон оронд экспортлогдож байна. Иймээс Монгол ноолуурын давуу талд түшиглэн гадаад улс орнуудтай ноолууран бүтээгдэхүүний экспортыг дэмжих тусгайлсан бодлого, хамтын ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх боломжтой.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас тээврийн зардал өсөж, хил гаалийн саадаас болж дотоодын үйлдвэрлэгч нар олон улсын борлуулалтын чиг хандлага цахимжиж байгаатай уялдуулан экспортын зардлаа бууруулах, хүссэн зах зээлдээ хүрч болох хамгийн ашигтай онлайн борлуулалтын сувгийг ашиглаж эхэлж байна.

Хүснэгт 126. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, зөвшөөрлүүдэд шаардлагатай бичиг баримтын давхардал

	СХЗГ	МУХАҮТ		МЭЕГ	МХЕГ	ХАА-н бирж	Давхардал
	Тохирлын гэрчилгээ	Гарал үүслийн гэрчилгээ	REX-ийн дугаар	ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ	Экспорт гэрчилгээ	Тодорхойлох бичиг	
	7 бичиг	5 бичиг	1	8 бичиг	9 бичиг	2 бичиг	
Үйлдвэрийн танилцуулга/ Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил				+			1
Албан бичгээр хүсэлт гаргах					+	+	2
Худалдааны гэрээ/ Гадаад худалдааны гэрээ/Худалдах, худалдан авах гэрээ	+	+		+	+		4
УБГ хуулбар	+ нотариат	+		+	+		4
Өргөдлийн маягт	+	+					2
Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг/ Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт/	+	+			+		3
Бүтээгдэхүүний сорилт, туршилт хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн/ Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт	+	+		+	+		4
Мэргэжлийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл (шаардлагатай тохиолдолд)/ Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл, чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар	+						1
Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл				+			1
Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа				+			1
Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл					+		1
ХАА-н биржээр бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан тухай тодорхойлох бичиг				+			1
Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ					+		1
Экспортыг хүлээн авах улсын тухайн бүтээгдэхүүнийг бүртгэсэн бүртгэлийн хуулбар					+		1

REX-ийн системд бүртгүүлж дугаар авах				+			1	
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт/ Үйлчилгээний төлбөр тушаасан баримтын хувь	+				+	+	+	4

Худалдааны гэрээг 4 удаа, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээг 4 удаа (1 нь баталгаажсан), сав баглаа боодлын жагсаалт, үнийн нэхэмжлэх, мэдээллийг 3 удаа, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн 4, тусгай зөвшөөрөл зэрэг бичиг баримтыг 2 удаа давхардсан байдлаар гаргаж өгдөг байна.

Зураг 59. Ноолууран эцсийн бүтээгдэхүүний экспортын To Be шинжилгээний үр дүн

	Өнөөгийн байдал	Асуудал	Шийдэл	TO BE
Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ	72 цаг / 37,500₮	НМХГ-т хүсэлт гаргаж байцаагч томилуулах, томилсон байцаагч дээж авч, авсан дээжийг байцаагчийн шаардлагын дагуу шинжилгээнд хамруулдаг	Экспортлогч нарт магадлан итгэмжлэл олгодог систем нэвтрүүлснээр экспорт хийх бүрд хийх процессыг давтахгүй болох	0 цаг / 0₮
Тохирлын гэрчилгээ	144 цаг / 216,000 ₮	Цахимаар маягт татан бөглөөд цаасаар хүсэлтээ өгхийг шаарддаг	Нэг цонхны цахим үйлчилгээ нэвтрүүлснээр экспортлогч системд бичиг баримтаа оруулснаар бүх хяналтын байгууллагууд тухайн бичиг баримтыг зэрэг хүлээн авч шаардлагатай мэдээллийг экспортлогчийн гараар дамжуулалгүй өөр хоорондоо солилцож, хариу зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгодог болох	120 цаг / 133,500₮ - 1 цаг / 79,000₮ - 72 цаг/10,000₮ - 1 цаг/7,000₮
Гарал үүслийн гэрчилгээ	- 2 цаг / 79,000₮ - 2 цаг / 162,500₮	Цахимаар хүсэлтээ илгээдэг боловч заавал цаасаар давхар өгөхийг шаарддаг		
Тээврийн бичиг баримт	- 72 цаг / 10,000₮ - 3 цаг/7,000₮	Хүсэлтээ цаасан хэлбэрээр гаргадаг, хуулийн хугацаа: 30 хоног		
Экспортын гэрчилгээ		Хуулийн хугацаа 14 хоног, МХЕГ-ын хяналт шалгалт, олгох процесс нь их хугацаа шаарддаг		
Гаалийн бүрдүүлэлт, тээврийн бич	24 цаг / 30,000₮	- Гаалийн бүрдүүлэлтийг хянах, шалгахад тогтсон стандарт хугацаа гэж байхгүй. - Бүх гаалийн мэдүүлэг нэг ахлах байцаагчийн хяналтаар дамжих шаардлага гардаг - Гүний гаальд хяналт шалгалтад хамрагдсаны дараа бүх бараа хил дээр мөн нэг ахлах байцаагчийн зөвшөөрлөөр гардаг	- Гаалийн бүрдүүлэлтийг хянах, шалгахад норматив хугацаа тогтоож, экспортлогчдод ил болгон, гаалийн байцаагчийн ур чадвар, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх. - Бүх гаалийн мэдүүлэг нэг ахлах байцаагчийн гараар дамждаг үйл явцыг халах. - Гүний гаальд хяналт шалгалтад хамрагдсны дараа бүх бараа хил дээр хилийн гаальд дахин ахлах байцаагчийн гараар дамждаг процессыг халах	12 цаг / 30,000₮
Нийт	216/326,000			132 цаг / 126,000

Ноолууран эцсийн бүтээгдэхүүний экспортын үйл явцыг нэг цонхны онлайн горимд шилжсэнээр нийт зарцуулах цаг 84 цагаар, зардал 200,000 төгрөгөөр буюу 61 хувиар бууруулах боломжтой байна.

Зураг 60. Ноолууран топс бүтээгдэхүүний экспортын To Be шинжилгээний дүн

	Өнөөгийн байдал	Асуудал	Шийдэл	TO BE
Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ	72 цаг / 37,500₮	НМХГ-т хүсэлт гаргаж, байцаагч томилуулах, томилсон байцаагч дээж авч, авсан дээжийг байцаагчийн шаардлагын дагуу шинжилгээнд хамруулдаг	Экспортлогч нарт магадлан итгэмжлэл олгодог систем нэвтрүүлснээр экспорт хийх бүрт хийх процессыг давтахгүй болох	0 цаг / 0₮
Тохирлын гэрчилгээ	144 цаг / 278,500 ₮ - 2 цаг / 79,000₮ - 2 цаг / 162,500₮ - 24 цаг / 12,500₮ - 24 цаг / 5000-10000₮ - 72 цаг / 10,000₮ - 3 цаг / 5,000-9,000	Цахимаар маягт татан бөглөөд цаасаар хүсэлтээ өгхийг шаарддаг	Нэг цонхны цахим үйлчилгээ нэвтрүүлснээр экспортлогч нэг системд хүсэлтээ холбогдох бичиг баримтын хамт оруулахад, бүх хяналтын байгууллагууд тухайн бичиг баримтыг зэрэг хүлээн авч, мөн шаардлагатай мэдээллийг экспортлогчийн гараар дамжуулалгүй өөр хоорондоо солилцож, хариу зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгодог болох	120 цаг / 116,000 ₮ - 1 цаг / 79,000₮ - 24 цаг / 12,500₮ - 24 цаг / 7,500₮ -- 1 цаг / 5,000-9,000 - 72 цаг / 10,000₮
Гарал үүслийн гэрчилгээ		Цахимаар хүсэлтээ илгээдэг боловч заавал цаасаар давхар өгөхийг шаарддаг		
ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ		Хүсэлтээ цаасан хэлбэрээр гаргадаг, хуулийн хугацаа: 30 хоног		
ХАА-н биржийн бичиг		ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ авахад ХАА-н биржээр арилжаалагдсан бүтээгдэхүүний тодорхойлох бичиг шаарддаг.		
Тээврийн бичиг баримт		Хуулийн хугацаа 14 хоног, МХЕГ-ын хяналт шалгалт, олгох процесс нь хугацаа их шаарддаг хүндрэлтэй		
Экспортын гэрчилгээ				
Гаалийн бүрдүүлэлт	48 цаг / 30,000₮	- Гаалийн бүрдүүлэлтийг хянах, шалгахад тогтсон стандарт хугацаа гэж байхгүй. - Бүх гаалийн мэдүүлэг нэг ахлах байцаагчийн хяналтаар дамжих шаардлага гардаг - Гүний гаальд хяналт шалгалтанд хамрагдсаны бүх бараа хил дээр очоод хилийн гаальд мөн нэг ахлах байцаагчийн зөвшөөрлөөр гардаг	- Гаалийн бүрдүүлэлтийг хянах, шалгахад норматив хугацаа тогтоож, экспортлогчдод ил болгон, гаалийн байцаагчийн ур чадвар, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх. - Бүх гаалийн мэдүүлэг нэг ахлах байцаагчийн гараар дамждаг үйл явцыг халах. - Гүний гаальд хяналт шалгалтанд хамрагдсаны бүх бараа хил дээр очоод хилийн гаальд дахин ахлах байцаагчийн гараар дамждаг процессыг халах	24 цаг / 30,000₮
Нийт	264 цаг / 346,000₮			148 цаг / 146,000₮


Ноолууран топс бүтээгдэхүүний экспортын үйл явцыг нэг цонхны онлайн горимд шилжүүлснээр нийт экспортын үйл явцад зарцуулах цаг 116 цагаар буюу 44,0 хувиар, зардал 200,000 төгрөг буюу 58 хувиар тус тус буурсан үр дүн гарч байна. Дээрх шинжилгээнүүдээс дүгнэхэд, гадаад худалдааны нэг цонхны цахим системд шилжихэд дээрх үр дүнгээс гадна Дэлхийн банкны

аргачлалын дагуу тооцсон судалгаанд авч үзээгүй үзүүлэлтэд тооцогдоогүй хүчин зүйлт зарцуулах цаг хугацаа, зардлыг хэмнэж байгаа давхар ач холбогдолтой юм. Тухайлбал, УБ хотод үйлдвэрлэлийн бүсээс гаалийн мэдүүлэг өгөхөөр гааль руу явахад замын түгжрэлээс шалтгаалан ирж очиход хамгийн багадаа 4 цаг зарцуулах тооцоо гарч байгаа тул нийт системийн хувьд дижитал шилжилт хийх нь ач холбогдолтой гэж дүгнэж болно.

4.4.ЭКСПОРТЫН ҮЙЛ ЯВЦЫГ САЙЖРУУЛАХ САНАЛ

Экспортод оролцогч талуудын чиг үүргийн шинжилгээг арьс ширэн бүтээгдэхүүний жишээн дээр гүйцэтгэлээ.

Зураг 61. Экспортод оролцогч талууд, тэдгээрийн чиг үүргийн уялдаа




Тэмдэглэгээний тайлбар:

- ▲ -Экспортын холбогдох зөвшөөрөл, гэрчилгээг бие даан олгодог байгууллага
- ☑ -Экспортын холбогдох зөвшөөрөл, гэрчилгээнд шаардлагатай шинжилгээний дүгнэлт, тодорхойлолт гаргадаг байгууллага
- -Экспортын үйл явцын дарааллын тэмдэглэгээ
- - Ямар нэг зөрчилгүй болохыг баталсан тэмдэглэгээ


Дээрх зургаас дүгнэхэд, бүтээгдэхүүн экспортлогч нар экспортын бичиг баримт бүрдүүлэлт, хил гаалийн хяналт шалгалт болон бусад холбогдох лабораторийн шинжилгээний дүгнэлт гаргуулах явцад төрийн болон хувийн хэвшлийн 9 байгууллагатай 12 удаа харьцаж нийт 223 цаг, 343500 төгрөг зарцуулж байна. Дээрх 9 байгууллагатай харьцах явцад ижил нэр төрлийн 5-6 бичиг баримтыг 5-6 байгууллагад давтан хүргэдэг процесс нь мэдээлэл технологийн хөгжил хүртээмжтэй, хурдтай болсон өнөө цаг үед зөвхөн экспортлогч төдийгүй нийт системийн хувьд их цаг хугацаа, зардал шаардсан үр дүнгүй хувилбар гэж дүгнэж байна.

Зураг 62. МХЕГ-ын экспортын гэрчилгээ олгох үйл явц




Хяналтын шатны үйл ажиллагаа нь ердөө 2 хүн дээр явагдаж байгаа боловч хүсэлтийг дамжуулах үе шат нь 6 хүний гар дамжин 8 үйл явцыг туулж байна. Мөн нэгэнт гарсан (зөвшөөрөгдсөн) шийдвэр нь 3 хүний гар дамжин 5 шат дамжлагын дараа экспортлогчийн гар дээр ирж байна. Энэхүү үйл явцын хуулийн хугацаа нь 14 хоног боловч туршлагатай экспортлогчдын хувьд 3-5 өдөр зарцуулагддаг нь судалгаагаар тогтоогдсон. Гэсэн хэдий ч дээрх зураглалаас харахад, нийт зарцуулж буй хугацааны 20-25 орчим хувь нь бодит хяналт шалгалт болон шийдвэр гаргалтад оногдож буй бөгөөд үлдсэн 75-80 орчим хувь нь хүсэлт болон гарсан шийдвэрийг дамжуулах бичиг цаас, бүртгэл, цохолт зэрэг шийдвэр гаргалтад ач холбогдол багатай үйл явцад зарцуулагдаж байна.

Зураг 63. Экспортын үйл явцыг нэг цонхны онлайн горимд шилжих үеийн процессын өөрчлөлт /Ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдээр хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүний жишээн дээр/



Зураг 64. Орцуудын импортын үйл явцыг нэг цонхны онлайн горимд шилжих үеийн процессын өөрчлөлт



Гадаад худалдааны нэг цонхны цахим системд шилжихэд импортын үйл явцад зарцуулах хугацаа төдийлөн буурахгүй өмнөх үетэй ойролцоо байхаар харагдаж байгаа хэдий ч Дэлхийн банкны аргачлалын дагуу тооцсон судалгаанд авч үзээгүй, тооцогдоогүй цаг хугацааг хэмнэх ач холбогдолтой юм. Тухайлбал: УБ хотод үйлдвэрлэлийн бүсээс импортын гаалийн мэдүүлэг өгөхөөр гаалийн газар руу явахад замын түгжрэлээс шалтгаалж ирж очиход хамгийн багадаа 4

цаг зарцуулдаг гэсэн тооцоо гарч байгаа тул нийт системийн хувьд тус дижитал шилжилтийн ач холбогдол өндөр гэж дүгнэж байна.

Хүснэгт 127. Экспортын үйл явцыг хөнгөвчлөхөд оролцогч талуудын хариуцах ажлын санал

	Экспортын үйл явц дахь ажилбарууд	Оролцогч тал	Гүйцэтгэх ажлын санал
Бодлогын түвшинд:			
1	Цахим нэг цонхны үйлчилгээг олон улсын жишгээр нэвтрүүлэх	УБЕГ, МХЕГ, ХХААХҮЯ, ГЕГ, МЭЕГ, МҮХАҮТ, СХЗГ АХБ, Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл	-Төрийн байгууллагуудын экспортын гэрчилгээ, зөвшөөрлийн бичиг баримт бүрдүүлэлтийн цахим сүлжээг бүрдүүлэх -Төрийн байгууллагуудын системийг МХАҮТ, мэргэжлийн холбоод зэрэг оролцогч талуудтай холбох
Экспортын дэд бүтэц, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр:			
2	Олон улсад нэр хүндтэй чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага судлах	ЗГ, МҮХАҮТ	Олон улсад нэр хүндтэй хөндлөнгийн чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллагуудтай МҮХАҮТ холбоо тогтоож Монгол улсад хамтран ажиллах, туршлага судлах, нутагшуулах
2	Бүтээгдэхүүний дээжийн шинжилгээг хийх лабораториудын тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэх	ЗГ, ГЕГ, СХЗГ, МХЕГ, хувийн хэвшлийн байгууллагууд	ОУ-д магадлан итгэмжлэгдсэн үндэсний лабораторийн тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэх
4	Гадаад улс орноос импортын бүтээгдэхүүнд заавал шаарддаг стандарт, тэмдгийг урьдчилан авах	Экспортлогчид, Мэргэжлийн холбоод МҮХАҮТ	Холбогдох стандарт шаардлагыг хангах, тэмдгийг авах процесст туслах мэдээллийг бэлтгэж улс орноор ялгаатай байдлаар онлайн байршуулах
5	Экспортлогч нарт Монгол улсын гадаад худалдааны хүрээнд эдлэх хөнгөлөлт, чөлөөлөлт болон импортлогч орны шаардлагын талаарх мэдээллийн хүртээмжийг сайжруулах	МҮХАҮТ ГХЯ	Мэдээлэл, сургалт зөвлөгөө, гарын авлага, веб-д суурилсан платформ үүсгэх, цахим сурталчилгааг явуулах
Экспорт, импортын үйл явцыг хөнгөвчлөх чиглэлээр:			
6	Стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох аж ахуйн нэгжүүдийг МХЕГ хариуцан магадлан итгэмжлэл олгох	МХЕГ	Тухайн үйлдвэрийг магадлан итгэмжилж, экспортлох эрх олгосноор олон удаагийн бичиг баримтын хөөцөлдлөгөө буюу НМХГ байцаагч томилуулах, дээж авч шинжлүүлэх, ОУ-ын мал эмнэлгийн гэрчилгээ авах гэх мэт ажлуудыг хөнгөвчлөх
7	Экспортын үйл явц дахь хяналт, шалгалтын шат дамжлагыг цөөлөх	ХХААХҮЯ, ХААБ, МЭЕГ, МХЕГ	Оролцогч талуудын чиг үүргийн шинжилгээг хийж, дүрэм журам, ажлын уялдааг хангаж, чиг үүргийн давхардлыг арилгах
8	Импортын бүтээгдэхүүний төлбөр шилжүүлэх, Улс хоорондын төлбөрийн шилжүүлгийн шимтгэлийн хувь өндөр байгааг бууруулах, хугацааг богиносгох	Дотоодын болон Олон улсын банк, Монгол банк, Арилжааны банк	Сангийн яам, Монгол банк, Улс хоорондын шилжүүлгийг хийхдээ банкнаас бусад төрлийн санхүүгийн цахим хэрэгслийн хэрэглээг нэвтрүүлж эрх зүйн орчинг бий болгох
9	Ноос, ноолууран бүтээгдэхүүний химийн гаралтай орц, будаг материалыг тусгай зөвшөөрөл авах, шинжилгээ хийлгэх ажилбарыг хөнгөвчлөх	УИХ, Мэргэжлийн холбоод	Ноос, ноолууран бүтээгдэхүүний химийн гаралтай орц материалыг хортой химийн бодис ангиллаас хасах эрх зүйн орчинг бүрдүүлэх
Логистикийг сайжруулах чиглэлээр:			
10	Олон улсын тээвэр логистикийн үйлчилгээг явуулах	Засгийн газар, ЗТХЯ	-Олон улсын стандарт шаардлагад нийцсэн хатуу болон зөөлөн дэд бүтэц, орчинг бүрдүүлэх -Олон улсын чанартай, байнгын ажиллагаатай хилийн боомтууд дээр логистикийн нэгдсэн төвийг байгуулах, хилийн боомтуудыг орчин үеийн техник хэрэгслээр хангах, боомтуудын уялдаа холбоог сайжруулах
11	Гааль болон тээвэр логистикийн үйлчилгээний зуучлагчтай хамтрах	Мэргэжлийн холбоод, МҮХАҮТ	Гаалийн болон тээвэр зуучийн байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах

Монгол Улсад мэдээлэл технологийн нэгдсэн бодлого, менежмент, хүний нөөцийн хомсдолоос шалтгаалж төрийн байгууллагуудын ашиглаж буй системүүдийн уялдаа холбоо, хоорондын интеграци, ашиглалтын түвшин хангалтгүй, хэрэглэгчийн шаардлагыг анхнаас нь зөв төлөвлөөгүй, явцын программ хөгжүүлэлтийг орхигдуулсан зэрэг сул талаас шалтгаалан нийт системийн үр ашиг, үр дүн муу байгаа нь гадаад худалдааны хөгжилд ч сөргөөр нөлөөлдөг.

ГХЯ, Олон улсын санхүүгийн корпорац болон Гаалийн ерөнхий газар, АХБ-тай хамтран “Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан” төсөл, Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн “Гадаад цонхны нэг үйлчилгээ” ажлуудыг хийж байна. Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн “Гадаад цонхны нэг үйлчилгээ”-ний цахим хөгжүүлэлтийн ажил нь 2022 оноос хийгдэж 2023 оноос “Гадаад цонхны нэг үйлчилгээ”-г экспортлогчид хүргэж эхэлнэ. Харин “Гадаад цонхны нэг үйлчилгээ”-г Харилцаа холбооны зохицуулах газраас хариуцаж ажиллуулах саналыг өгч байна.

Цар тахлын нөлөөг богино хугацаанд багасгаж экспорт, импортыг хөнгөвчлөхөд чиглэсэн дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- ✚ Экспорт, импортын бичиг баримтад бүрдүүлж буй цаг хугацаа, зардлыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх замаар бууруулах
- ✚ Хилийн боомтуудын халдвар хамгааллын тоног төхөөрөмжийн хангамжийг дээшлүүлэх, ариутгалыг автоматжуулах
- ✚ Гадаадаас ирэх, гарах тээвэрлэлтийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг хангаж ажиллах
- ✚ Тээвэр логистикийн үйл ажиллагааг цахимжуулах, импортлогч орны шаардлагыг тээврийн хэрэгсэл, үйл явцад хангах
- ✚ Экспортлогчдод хөнгөлөлттэй, урт хугацааны зээлийг олгох
- ✚ Шийдвэр гаргагчдын мэдээллийн тэгш байдлыг хангах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах
- ✚ Импортын зарим бараа бүтээгдэхүүнийг гаалийн болон нэмүү өртгийн албан татвараас чөлөөлөх арга хэмжээнүүдийг хэвээр үргэлжлүүлэх
- ✚ Гадаад улс орнуудтай экспорт, импортын үйл явцыг хөнгөвчлөх, түргэсгэх талаар ковидын нөхцөл байдалтай уялдуулан шинээр гэрээ хэлцэл хийх.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, үйл явцыг хөнгөвчлөх асуудлын хүрээнд дараах саналуудыг дэвшүүлж байна. Эдгээр саналуудын одоогийн мөрдөгдөж буй хууль, эрх зүйтэй нийцэж буй эсэхийг дараах хүснэгтээр нэгтгэн харуулав.

Хүснэгт 128. Экспортын үйл явцыг хөнгөвчлөх саналууд ба тэдгээрийн хууль эрх зүйн хүрээнд тусгагдсан байдал

№	Өөрчлөлт оруулах санал	Өнөөгийн мөрдөгдөж буй хуульд зохицуулагдаж байгаа байдал
Экспортын үйл явцыг хөнгөвчлөх чиглэлээр		
1	Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах барааны брокерын зуучлалын шимтгэлийг бууруулах, бараа бүтээгдэхүүн бүрээр ялгавартай тогтоох	“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн 4.6-т зааснаар иргэн, хуулийн этгээд нь Засгийн газрын баталсан жагсаалтад орсон хөдөө аж ахуйн түүхий эдийг экспортод гаргахдаа заавал биржээр арилжсан байх ёстой.
2	Экспортын даатгалын тогтолцоог практикт хэрэгжүүлэх	“Монгол экспорт хөтөлбөр”-ийн “4.1.10. экспортын даатгалын тогтолцоог хөгжүүлэх” гэж заасан.
3	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний хугацааг уян хатан тогтоох	“Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”-ын 4.8. Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ нь олгосон өдрөөс хойш амьд мал, амьтанд 1 сар хүртэл, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд 5 дугаар сарын 1-ний өдрөөс 9 дүгээр сарын 31-нийг хүртэлх хугацаанд 21 хоног, 10 дугаар сарын 1-ний өдрөөс дараа оны 4 дүгээр сарын 30-ыг хүртэлх хугацаанд 30 хоног хүчинтэй байна.
4	МХЕГ-ын дотоод үйл ажиллагааны дахь шат дамжлагыг цөөлөх	“Гэрчилгээ, мэдэгдэл олгох бичиг баримтыг хүлээн авах, хариу өгөх журам”-ын “5.1. Томилгогдсон чиглэлийн улсын /ахлах/ байцаагч албан хүсэлттэй танилцан хууль, журмын дагуу бичиг, баримтын хяналт шалгалт хийнэ”. “5.2. Олон улсын гэрээ, хэлэлцээр, холбогдох хууль, тогтоомжид заасан импорт, экспортын шаардлага, бичиг баримтын иж бүрдлийг хангасан тохиолдолд гэрчилгээ, мэдэгдлийг хэвлэнэ”. “5.3. Хэвлэгдсэн гэрчилгээ, мэдэгдлийг эрх бүхий албан тушаалтанд танилцуулан гарын

		үсэг зуруулна". "5.4. Эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурсан гэрчилгээ, мэдэгдэлд байгууллагын тэмдэг дарж баталгаажуулна". "5.5. Баталгаажсан гэрчилгээ, мэдэгдлийг томилогдсон улсын /ахлах/ байцаагч бүртгэх дэвтэрт тэмдэглэл хөтлөн, дугаарлана". "5.6. МХЕГ-аас олгох гэрчилгээ, мэдэгдлийг бүртгэлд тэмдэглэн дугаар олгож баталгаажсан гэрчилгээг зөвлөгөө мэдээллийн төвд томилогдсон улсын /ахлах/ байцаагчид шилжүүлэх, аймгийн МХЕГ-аас олгох гэрчилгээг улсын /ахлах/ байцаагч иргэн, аж ахуйн нэгжид олгож хүлээн авсан этгээдээр гарын үсэг зуруулна". "5.7. Зөвлөгөө мэдээллийн төвийн мэргэжилтэн гэрчилгээ, мэдэгдлийг олгоно" гэж заасан.
5	Стратегийн хүнсийг экспортлох, импортлох квотыг бодлогын яам тогтоож, зөвшөөрөл олгох ажлыг агентлагууд хариуцаж гүйцэтгэх	"Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-ын "3.1. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох үйл ажиллагааг нэг цонхны бодлогоор зохион байгуулахаар хүнсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэснээс бусад тохиолдолд стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр яам зохион байгуулна".
6	Сангийн яам, ГЕГ, төрийн байгууллагуудаас олгодог тусгай зөвшөөрлүүдийг цахим хэлбэрээр олгодог болох	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу дараах тусгай зөвшөөрөл, зөвшөөрлүүдийг 3 жилийн хугацаатай олгож 3 жил тутам дахин баримт бичиг бүрдүүлж, хугацааг нь сунгуулдаг. Үүнд: Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл; Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл; Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл; Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл; Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл; Гаалийн тусгай бүсийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл; Гаалийн хяналтын бүс тогтоох; Түр агуулахын зөвшөөрөл олгох; Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох
7	Угааж самнасан ноолуур, түүхий болон идээлсэн үхрийн ширний экспортод 2-3 жилд экспортын татвар тогтоож турших	Гаалийн тухай хуулийн "113.1.Хилийн чанадад гаргах горимд байршуулсан бараанд гаалийн байгууллага экспортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ" гэж заасан байдаг. НӨАТ-ын тухай хуулийн "13.1.21. экспортод гаргасан түүхий болон угаасан, самнасан ноолуур, арьс ширийг албан татвараас чөлөөлнө" гэж хуульд заасан байдаг. Угааж самнасан ноолуур, түүхий болон идээлсэн үхрийн ширийг экспортод гаргахдаа татварыг тодорхой тогтоож, барааны ангилалтад оруулж, туршиж үзэх
Орцын импорт		
8	Ноос, ноолууран бүтээгдэхүүний орц болох будгийн импортын тусгай зөвшөөрөл авах, шинжилгээ хийлгэх ажилбарыг хөнгөвчлөх	"Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам"-ын 2.1.4. Доорх төрлийн химийн бодис, химийн бодис агуулсан бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, худалдахад энэхүү журам хамаарахгүй" гэсэн заалтад ноолууран бүтээгдэхүүний боловсруулалтад ашигладаг будгийн импортыг хамруулаагүй.
9	Импортын бараанд чанар, стандартын шаардлагыг ОУ-ын түвшинд шаардах	"Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам"-ын "1.4. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт" (цаашид "жагсаалт" гэх)-д заасан бүтээгдэхүүнийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тохирлын баталгаанд заавал хамруулна", "2.2. Баталгаажуулалтын байгууллага хүсэлт гаргагчаас ирүүлсэн өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ" гэж заасан.

4.5.ЗӨВЛӨМЖ

Төрийн байгууллагуудад хандаж:

- ✚ Цахим нэг цонхны үйлчилгээг олон улсын жишгээр нэвтрүүлж гадаад худалдааг хөнгөвчлөх, төрийн байгууллагууд тус бүрдээ олон бичиг баримт нэхэж экспортлогчдыг чирэгдүүлж байгааг анхаарах.
- ✚ Экспортын бичиг баримтын бүрдүүлэлтийг заавал цаасаар шаардахыг халах замаар төрийн албан хаагчдыг аж ахуйн нэгж, байгууллагуудтай шууд уулзах боломжийг хязгаарлах. Экспортын үйл явц дахь бичиг баримтын бүрдүүлэлтэд эх хувийг шаарддагийг болиулах.

- ✚ Экспортын үйл ажиллагаанд оролцож буй төрийн албан хаагчдын үйлчилгээ, хяналт шалгалтын ажлын гүйцэтгэлийг хугацааны норм, стандарттай болгох, ажил гүйцэтгэх хугацааг тодорхой бодит байдалд нийцсэн байдлаар тогтоох.
- ✚ Экспортын үйл явц дахь олон шатны давхар хяналтууд, дээрээс доошоо босоо шатны бичиг баримт хяналт, цохолтуудыг халах.
- ✚ Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлд үйлчлүүлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудаар үнэлгээ, дүгнэлт өгөх аргачлалыг сайжруулж хөгжүүлэх, ажлын гүйцэтгэл хангалтгүй тохиолдолд хариуцлагын арга хэмжээг тодорхой ил болгох.
- ✚ Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар болон бусад төрийн байгууллагууд өөрийн цахим хуудсанд үзүүлж буй үйлчилгээний үнэ тариф болон бусад мэдээллийг нийтэд ил тод, ойлгомжтой байдлаар байршуулах.
- ✚ Мэргэжлийн хяналтын байгууллага нь хилээр нэвтэрч буй импортын бараа бүтээгдэхүүнд хатуу хяналт тогтоохоос илүүтэйгээр дотоодын зах зээл дээр худалдаалагдаж буй бараа бүтээгдэхүүнд стандартын шаардлага өндрөөр тавих.
- ✚ Гүний гаалийн болон мэргэжлийн хяналтын тогтолцоог орчин үеийн шаардлагатай нийцүүлэх.
- ✚ Лабораториуд бүтээгдэхүүний дээжийн шинжилгээний хариуг цахимаар олгодог болох.
- ✚ Бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд шинжилгээ хийх лабораториудын хүчин чадал, тоог нэмэгдүүлэх, шинжилгээний дүнг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх тал дээр анхаарах.
- ✚ Бараа, бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалт, лиценз, зөвшөөрөл олгох ажилд хувийн хэвшлийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах.

Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдэд хандаж:

- ✚ Төрийн байгууллагуудыг холбосон цахим мэдээллийн сүлжээг бүрдүүлэхэд төрийн байгууллагууд болон бусад оролцогчдод техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх.
- ✚ Олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хоорондын уялдааг сайжруулах, асуудалд цогцоор хандах.
- ✚ Экспортын даатгал, санхүүжилт, эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалтыг дэмжсэн олон улсын туршлагыг Монгол улсын хөрсөнд амжилттай нутагшуулах арга замыг судлах.
- ✚ Олон улсын худалдааны талаар мэргэшсэн зөвлөх, эксперт бэлтгэх сургалт зохион байгуулах.

Экспортлогч компаниудад хандаж:

- ✚ Экспортыг тогтвортой анхаарч гадаадын худалдан авагчидтай найдвартай, удаан хугацааны түншлэлийг бий болгох.
- ✚ Гадаадын худалдан авагчтай тээвэр, төлбөр тооцооны нөхцөлийг тохирох гэрээнд анхаарч аль болох эрсдэлийг тэнцүү үүрэх тал дээр ач холбогдол өгөх.
- ✚ Олон улсын хууль эрх зүйн мэдлэг, олон улсын худалдаа хийх гэрээний сургалтад хамрагдах, судалгаа хийх.
- ✚ Шинжилгээнд хайнга хандаж ямар нэг байдлаар хуурамч санагдсан дүгнэлтийг импортлогчдод төрүүлснээр манай улсын шинжилгээ, стандартад үл итгэх байдлыг бий болгож байгааг анхаарах, үүнээс урьдчилан сэргийлсэн сургалт, таниулга зохион байгуулах.
- ✚ Бүтээгдэхүүн, үйлчилгээ, боловсон хүчин, хуваарилалт, маркетинг, техникийн үйлчилгээ зэрэг гол гол үзүүлэлтүүд дээр давуу болон сул талаа судалж экспортод судалгаатай, төлөвлөгөөтэй оролцох.
- ✚ Орцуудын импортын чанар, стандартад анхаарч аль болох олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, чанарын шаардлага хангасан үйлдвэрлэгчээс бараа бүтээгдэхүүн импортлох.

Мэргэжлийн холбоодод хандаж:

- ✚ Мэргэжлийн холбоод нь тухайн салбартаа олон улсын жишгийг нэвтрүүлэхэд анхаарч, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллагуудтай холбоо тогтоож хамтран ажиллах.

- ✚ Гадаад худалдааг хөнгөвчлөх олон улсын төсөл, хөтөлбөрүүд болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, ингэснээр урт хугацаанд гадаад худалдаа эрхлэх үйл ажиллагаанд нь чухал ач холбогдолтой гэдгийг анхаарах.
- ✚ Салбараа таниулах сурталчилгаа хийх, шинээр нэвтрэх бизнес эрхлэгчдийг хааж боох бус, дэмжих, татан оролцуулах, салбараа хөгжүүлэхэд анхаарах.
- ✚ Монгол улсад үйлдвэрлэсэн бүхэн органик, цэвэр, чанартай гэж ярихаас илүүтэй бүтээгдэхүүний чанарыг олон улсын чанар, стандартад нийцүүлж үндэсний онцлог брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж экспортлоход аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах
- ✚ Экспортын эхэн үед зах зээлийн талаарх мэдээ, мэдээлэл хомс, төлөвлөлтийн зарим асуудлууд тодорхой бус байдаг тул энэхүү нөхцөл байдалд тохируулж экспортын төлөвлөгөөг аль болох энгийн, ойлгомжтой боловсруулахад туслах. Харин хангалттай мэдээ мэдээлэл, эх сурвалжуудтай болсон тохиолдолд экспортын төлөвлөгөөг илүү нарийн, тодорхой боловсруулахад аж ахуйн нэгжүүдэд туслах.
- ✚ Экспортын баримт бичгүүдийн загвар, хэрэглэх аргачлал, зах зээлийн мэдээлэл зэргийг агуулсан “Гарын авлага”-ыг жил бүр хэвлүүлж нийтийн хүртээл болгох.

Ашигласан материалын жагсаалт

Англи хэл дээр:

- ADB (2005). MONGOLIA: Trade Facilitation and Customs Modernization.
- ADB. (2009). Mongolia Country Progress Report on Implementation of Action Plan for Transport and Trade Facilitation Strategy.
- Bayarkhuu.B (2019)., “One Belt One Road and Us”. Economic Journal, Ulaanbaatar, 28-29
- Economic Research Institute. (2018). *Assessment of Export Promotion Activities*.
- Gulguu.J, B.Indra (2018)., “The Interests of China and Russia in Building the Economic Corridor of China, Mongolia and Russia”. International trade Journal, 82-83
- Dulguun.D (2019)., “Foreign Direct Investment and Comparative Research”, Institute of Economics, 2-7
- Enkhbold.I (2017)., Mongolia, Trade Relation with Korea, International Research №1 (107), 101-121
- Economic Research Institute. (2018). *Assessment of Export Promotion Activities*.
- Mongolian National Chamber of Commerce and Industry (2018), “Handout of export of cosmetics”
- MOFALI (2019)., Introduction of Skin sector.
- One Northeast Asia Region (2014), One Community, NEAR International Forum, NEAR
- Otgonsaikhan.N (2018)., “Preconditions for Mongolia and China to Establish Cross-border Free Zones”, Mongolian National University, 2-5
- Parliament of Mongolia. (2016). *Concept of Sustainable Development of Mongolia – 2030*.
- Parliament of Mongolia. (2017). *The fiscal framework statements of 2019 and 2020*.
- Saaty. (1991). AHP analysis
- MNCCI. (2019). Mongolia Export Roadmap.
- Shurkuu.D (2014)., “Regarding the friendly relations between Mongolia and China, the political and legal significance of cooperation contract”. Academy of Science News, (211) 2-3, <http://dx.doi.org/10.5564/pmas.v54i3.642>
- UNAIDS. (2014). An Introduction to Triangulation. https://www.unaids.org/sites/default/files/sub_landing/files/10_4-Intro-to-triangulation
- World Bank. (2021, January 22). Doing Business. DoingBusiness.Org.

Монгол хэл дээр:

- “Бодлогын шийдэл” ТББ (2018)., “Монгол улсын гадаад худалдааны талаар баримтлах бодлого” зөвлөх үйлчилгээний тайлан
- ЖАЙКА. (2016). Монгол улсын ХАА-н салбарын суурь судалгаа.
- Монгол Улсын Их Хурал. (2016). Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030 он.

- МҮХАҮТ. (2018). “Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын гарын авлага”.
- Энхболд.И (2017)., Монгол улс, БНСУ-ын худалдааны харилцаа, Олон Улс Судлал №1 (107), 101-121.
- MNCCI. (2019). Mongolia Export Roadmap.
- ХХААХҮЯ (2019)., Арьс ширний салбарын танилцуулга.
- Монгол Улсын Их Хурал. (2020). “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.
- ГХЯ, МҮХАҮТ. (2020). МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАМЫН ЗУРАГЛАЛ 2019-2023.
- INRAE Institute, MOFALI. (2020). БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох.
- MNCCI, MOFALI. (2020). ОХУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох.

Цахим хуудас:

https://www.doingbusiness.org/en/data/exploreconomies/mongolia#DB_tab

<http://eagle.mn/r/57244>

<https://www.montsame.mn/ru/read/47367>

<https://www.monireedui.mn/%D0%B1%D0%B8%D0%B4%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9/>

<https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/noos22.pdf>

<https://mofa.gov.mn/exp/blog/10/81>

<https://www.icegate.gov.in/eSANCHIT.html>

www.sinoconsult.ru/cases/license

[www.dripcapital.com/resources/blog/export-logistics-process#3.](http://www.dripcapital.com/resources/blog/export-logistics-process#3)

<https://www.tdbcapital.mn/article/gowi-khk-2020-onii-ekhnii-khagas-jiliin-tailangaa-taniitsuullaa>

<https://www.customs.gov.mn/>

<https://lpi.worldbank.org>

lpi.worldbank.org/international/scorecard/

<https://1212.mn/>

Хавсралт

Маягт 8

МАЛ, АМЬТНЫ ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДЭД ЭКСПОРТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХОД ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЛИЙГ ШАЛГАХ ХУУДАС

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Экспорт		
1	Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хандсан албан хүсэлт			
2	Хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэний иргэний үнэмлэхний хуулбар			
3	Худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг /Орос, англи хэлээр бичигдсэнээс бусад тохиолдолд монгол хэл дээр баталгаат орчуулгаар орчуулсан байх/			
4	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ /Мал эмнэлгийн ерөнхий газар/			
5	Сав баглаа, боодлын мэдээлэл /тоо хэмжээ/ Англи хэлээр			
6	Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн			
7	Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл			
8	Арьс, шир, ноос, ноолуурыг боловсруулсан газрын тодорхойлолт, стандартын шинжилгээний дүн /шаардлагатай тохиолдолд/			
9	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт			
Хүсэлт хүлээнгэн өгсөн		Хуудасны тоо	Хүсэлт өгсөн огноо, цаг	Гарын үсэг
Албан тушаал				
Нэр				
Утас				

Тасалбар хуудас

Иргэн, хуулийн этгээдийн нэр:	Хүсэлт өгсөн огноо, цаг	Хариу авах огноо

Та хүсэлтийг хариуг МХЕГ-ын Зөвлөгөө мэдээллийн төвөөс авна уу.

Байгууллагын цахим хаяг: www.inspection.gov.mn

Лавлах утас: 51-264786

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны
 03 дугаар сарын 16-ны өдрийн 1167 дугаар
 тушаалын гуравдугаар хавсралт



Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээний загвар:

№	МЭДЭЭЛЭЛ	ТАЙЛБАР
1	Тодорхойлолт гаргасан гэрээт эмчийн нэр эсхүл код, огноо	
2	Баталгаажуулсан мал эмнэлгийн улсын байцаагчийн нэр (код), огноо	
3	Мал эмнэлгийн гэрчилгээний дугаар	
4	Амьд, мал амьтны мэдээлэл: төрөл, нас, хүйс, бүртгэлийн дугаар	
5	Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мэдээлэл: төрөл, тоо, хэмжээ	
6	Мал эмнэлгийн гэрчилгээний хүчинтэй хугацаа	
7	Гарал үүслийн мэдээлэл: улс, аймаг, сум, баг, малчны нэр, регистр	
8	Тээвэрлэх маршрутын мэдээлэл	
9	Тээвэрлэж/ хариуцаж буй хүний мэдээлэл, холбоо барих хаяг	
10	Эцсийн хүрэх газрын нэр, хаяг	
11	Давтагдахгүй QR кодтой байна.	
12	Хөдөө аж ахуйн биржийн итгэмжлэгдсэн агуулахад анхан шатны тордолт, чанарын хамгаалалт хийсэн тухай тодорхойлолттой байна.	2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс энэхүү заалтыг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны
 03 дугаар сарын 16-ны /ий өдрийн 167 дугаар
 тушаалын дөрөвдүгээр хавсралт

Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний ерөнхий загвар

4.1. Амьд мал, амьтны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ

Хэсэг 1. Барааны мэдээлэл	1. Бараа нийлүүлэгчийн Нэр: Хаяг:	2. Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний дугаар
		3. Эрх бүхий малын эмч:
	4. Бараа хүлээн авагчийн Нэр: Хаяг:	
	5. Улсын нэр /ISO код/	6. Гарал үүслийн бүс, тусгаарлагдсан аж ахуйн мэдээлэл:
	7. Хүрэх улсын нэр:	8. Хүрэх газрын бүс, тусгаарлагдсан аж ахуйн мэдээлэл:
	9. Гарал үүслийн тухай мэдээлэл:	
	10. Ачигдаж байгаа газар	11. Ачигдаж буй огноо:
Хэсэг 2. Мал эмнэлэг, эрүүл ахуйн мэдээлэл	12. Тээврийн хэрэгслийн мэдээлэл: /онгоц, усан онгоц, галт тэрэг, автомашин, бусад/	13. Нэвтрүүлэх боомтын мэдээлэл:
		14. Зөвшөөрөл No:
	15. Бараа, бүтээгдэхүүний талаарх мэдээлэл: /код, төрөл, тоо толгой/	16. Бараа бүтээгдэхүүний код:
		17. Тоо, толгой, төрөл:
	18	19. Нийт савлагааны тоо хэмжээ
	20. Агуулах, чингэлэгийн дугаар:	21
22 Нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүний зорилго :		

- Үржлийн:
- Уралдааны:
- Нядалгааны:
- Зэрлэг амьтдын менежмент:
- Гэрийн тэжээвэр амьтад:
- Үзэсгэлэн худалдаа:
- Бусад:

23. Импорт эсхүл нэвтрүүлэх зөвшөөрөл

- Бүр нэвтрүүлэх,
- Дахин нэвтрүүлэх,
- Түр нэвтрүүлэх

24. Бараа бүтээгдэхүүний тодорхойлолт:

- Төрөл, зүйл
- Үүлдэр
- Бүртгэлийн систем
- Бүртгэлийн дугаар
- Нас
- Хүйс
- Тоо/ хэмжээ

Мал эмнэлгийн эрх бүхий байгууллагын албан ёсны олон улсын гэрчилгээ бичих эрхтэй малын эмч дараах шаардлагыг хангасныг тодорхойлж байна.

- ...
- ...
- ...
- ...
- ...
- ...

Эрх бүхий малын эмч:

Нэр, хаяг /ТОМ ҮСГЭЭР/:

Албан тушаал:

Гарын үсэг:

Огноо:

Тамга:

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны
 03 дугаар сарын 14 ны/ий өдрийн 167 дугаар
 тушаалын тавдугаар хавсралт



**УЛСЫН МАЛ ЭМНЭЛЭГ
 АРИУН ЦЭВРИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**



5.1 МАЛ ЭМНЭЛГИЙН ЛАБОРАТОРИ МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ ГЭРЧИЛГЭЭ

Бүртгэлийн дугаар:	Хүлээн авсан: он сар өдөр
	Шинжилгээ эхэлсэн:он сар өдөр
	Шинжилгээ дууссан: он сар өдөр
	Баталгаажсан: он сар өдөр

Тасгийн нэр:

Лабораторийн нэр:

Дээжийн тоо:

Дээж ирүүлсэн, үзлэгт орсон газрын нэр хаяг:

Шинжилгээний зорилго:

Эх материалын хэмжээ:

Дээжийн нэр	Шинжилгээний			Зөвшөөрөгдөх хэмжээ	Шинжилгээний дүн
	Үзүүлэлт	арга	стандарт		

Шинжилгээний ерөнхий дүн:

.....

ТЭМДЭГ

Ерөнхий эмч:

Тасгийн дарга:

Шинжлэгч их эмч:

СХЗГ-ын Баталгаажуулалтын газарт
(баталгаажуулалтын байгууллагын нэр / (name of certification body)

Өргөдөл гаргагчийн талаарх мэдээлэл / Information regarding the applicant/:

Хүсэлт гаргагчийн нэр, бүртгэгдсэн албаны хаяг /Applicant's name, address of registered office/:	Бүтээгдэхүүний үйлдвэрийн газрын байршил /Place of manufacture of the product/:
Утас, факсын дугаар/ Phone and fax numbers/:	Утас, факсын дугаар/ Phone and fax numbers/:

Баталгаажуулалтад хамруулах бүтээгдэхүүний талаарх мэдээлэл /Designation of product for which
conformity certification is requested/:

Бүтээгдэхүүний нэр /Denomination of products/:
Холбогдох стандарт, НТББ-ийн тэмдэглэгээ / Designation standards or normative technical documents/:
Барааны код /Code/:
Гарал үүсэл /Country of origin/:
Тоо хэмжээ, хэмжих нэгж /Quantity & unit/:
Үнийн дүн/Value/:
Тээвэрлэлтийн мэдээлэл /Transport details/:
Импортологч /Exporter/:
Хүлээн авагчийн хаяг /Consignee/:
Гэрээний дугаар /Contract No/:
Хавсаргасан баримт /Attached documents/:
1.
2.
3.
4.
5.

Мэдэгдэх нь /Statement/: Бид өргөдөл гаргахтай холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна /We
herewith declare that we will settle the cost related to this application/

Хүсэлт гаргасан огноо /Date of application/:


Хүсэлт гаргагчийн нэрийн өмнөөс гарын үсэг зурах эрх бүхий ажилтаны нэр, албан тушаал

/Name and title of person authorized to sign on behalf of the applicant (in block letters):

.....

/Гарын үсэг/Signature/:

Хянасан: Баталгаажуулалтын шинжээч:



УРГАМЛЫН ЭРҮҮЛ АХУЙН ГЭРЧИЛГЭЭ ХҮСЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

/ Монгол үндэсний гэр, модон тавилга экспортлох үед /

Д/Д	Бүрдүүлэх баримт бичиг	Шаардлага
1	Монгол үндэсний гэр экспортлох хүсэлт	- Бүтээгдэхүүний нэр, тоо хэмжээ, экспортлох хугацаа, хилийн боомт, тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл зэрэг мэдээллийг тус тус тодорхой тусгах.
2	Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар)	- ЗГ-ын 2013 оны 173 дугаар тогтоолоор баталсан / Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам /-ын дагуу
3	Худалдах, худалдан авах гэрээ	- ЗГ-ын 2013 оны 173 дугаар тогтоолоор баталсан / Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам /-ын дагуу
4	Бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ	Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас авах
5	Ариутгал халдваргүйтгэлийн АКТ	Ургамал хамгааллын мэргэжлийн байгууллага
6	Гэрчилгээний үнэ тушаасан баримт	- 2010 оын 12-р сарын 25 өдөр баталсан /Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль/ дагуу 32 дугаар зүйл. Мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

Тайлбар:

-Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ нь олгосон өдрөөс хойш 1 сарын хугацаанд хүчинтэй.

-Мод, модон бүтээгдэхүүнд экспортлоход ургамал хамгааллын мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэл хийлгэсэн байх.



МХЕГ-ын даргын 2019 оны
12 сарын 16 өдрийн /16/ дугаар
тушаалын хавсралт

Аймаг, нийслэл, ХМХА, хэлтсээс олгох гэрчилгээ,
мэдэгдэл, боомтын жагсаалт

№	Аймаг, ХМХА-ны нэр	Гэрчилгээ мэдэгдэл олгох бүтээгдэхүүний нэр	Импортын мэдэгдэл олгох боомтын нэр	Экспортын гэрчилгээ бичих боомтын нэр	Тайлбар
1	Дорнод	Гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, Үржлийн мал, амьтнаас бусад мал амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдэд импортын мэдэгдэл. Монгол гэр, хадлангийн зориулалттай өвс, ургамлын болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. Ургамлын ур, урслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл.	Баян-хошуу Хавирга Ульхан Эрзэнцав Сүмбэр Чойбалсан	Баян-хошуу Хавирга Ульхан Эрзэнцав Сүмбэр Чойбалсан	Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.

2	Сүхбаатар	<p>Гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, Үржлийн мал, амьтнаас бусад мал амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдэд импортын мэдэгдэл.</p> <p>Монгол гэр, хадлангийн зориулалттай өвс, ургамлын болон хөрсний дээжил ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл.</p>	Бичигт	Бичигт	<p>Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.</p>
3	Дорноговь	<p>Гэрийн тэжээвэр амьтанд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, Монгол гэрт ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, тасалсан цэцэг, мод гуалин, модон бэлдэц, шахмал модон хавтан, фанерд импортын мэдэгдэл</p>	Замын-Үүд	Замын-Үүд Ханги	<p>Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт</p>

2	Сүхбаатар	<p>Гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, Үржлийн мал, амьтнаас бусад мал амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдэд импортын мэдэгдэл.</p> <p>Монгол гэр, хадлангийн зориулалттай өвс, ургамлын болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. Ургамлын ур, урслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл.</p>	Бичигт	Бичигт	<p>Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.</p>
3	Дорноговь	<p>Гэрийн тэжээвэр амьтанд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, Монгол гэрт ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, тасалсан цэцэг, мод гуалин, модон бэлдэц, шахмал модон хавтан, фанерьд импортын мэдэгдэл</p>	Замын-Үүд Ханги	Замын-Үүд	<p>Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт</p>

<p>Замын- Үүд боомт дахь ХМХА</p>	<p>Гэрийн тэжээвэр амьтанд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ Монгол гэрт ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ</p> <p>Тасалсан цэцэг, мод гуалин, модон бэлдэц, шахмал модон хавтан, фанерьд импортын мэдэгдэл</p>	<p>Замын-Үүд</p>	<p>Замын-Үүд</p>	<p>МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх. Ханги боомтоор нэвтрэх бараа, бүтээгдэхүүний гэрчилгээ, мэдэгдлийг Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтсийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хянаж холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн гэрчилгээ бичих. БНХАУ-аас импортлогдож буй тасалсан цэцэг, мод гуалин, модон бэлдэц, шахмал модон хавтан, фанерийн Импортын мэдэгдлийг болон монгол гэр ургамлын эрүүл ахуйн гэрчилгээг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагч хянаж бичиг баримтын бүрдлийг хангаж гэрчилгээ мэдэгдэл бичиж, гэрчилгээнд ХМХА-ны дарга болон хэлтсийн дарга гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарж баталгаажуулах.</p>
		<p>Замын-Үүд</p>	<p>Замын-Үүд</p>	<p>Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын /ахлах/ байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж гэрчилгээ мэдэгдэл бичиж, гэрчилгээнд ХМХА-ны дарга түүний эзгүйд хэлтсийн дарга гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарж баталгаажуулах. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн</p>

Өмнөговь	Гэрийн тэжээвэр амьтанд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, Монгол гэрт ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ.	Гашуун-Сухайт Шивээ-Хүрэн	Гашуун-Сухайт Шивээ-Хүрэн	хяналтын газарт илгээх. Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.
Говь-Алтай	Гэрийн тэжээвэр амьтанд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, Монгол гэрт ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ	Бургастай	Бургастай	Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.
Ховд	Гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд	Булган, Ховд	Булган, Ховд, Байтаг	Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч,

	<p>экспортын мал эмнэлгийн гэрчилгээ,</p> <p>Монгол гэр, ургамал болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ.</p> <p>Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал болон ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл.</p>		<p>ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ.</p> <p>Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах.</p> <p>Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.</p> <p>БНХАУ-аас импортлогдож буй хатаасан, хөлдөөсөн, шинэ жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, нарийн ногоо, тасалсан цэцэг, мод гуалин, модон бэлдэц, шахмал модон хавтан, фанерийн импортын мэдэгдлийг болон монгол гэр ургамлын эрүүл ахуйн гэрчилгээг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагч холбогдох бичиг баримтыг шалган гэрчилгээ бичих.</p>
<p>Баян-Өлгий</p>	<p>Мах, махан бүтээгдэхүүн, угаасан ноос, ноолуур, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ,</p> <p>Үржлийн мал, амьтнаас бусад мал амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдэд импортын мэдэгдэл.</p> <p>Монгол гэр, ургамлын болон хөрсний дээжид</p>	<p>Цагааннуур, Өлгий</p>	<p>Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ.</p> <p>Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах.</p> <p>Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн</p>

			ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл			хяналтын газарт илгээх.
9	Увс	Боршоо	Мах, махан бүтээгдэхүүн, угаасан ноос, ноолуур, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, Үржлийн мал, амьтнаас бусад мал амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдэд импортын мэдэгдэл. Монгол гэр, ургамлын болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл	Боршоо Цагааннуур Булган Бургастай Тэс	Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.	
10	Завхан	Арцсуурь	Мах, махан бүтээгдэхүүн, угаасан ноос, ноолуур, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн	Арцсуурь Бургастай Булган	Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт	

11	Хөвсгөл	<p>гэрчилгээ, Үржлийн мал, амьтнаас бусад мал амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдэд импортын мэдэгдэл. Монгол гэр, ургамал болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл</p>	Ханх		<p>бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.</p>
		<p>Мах, махан бүтээгдэхүүн, угаасан ноос, ноолуур, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, ОХУ-аас импортлох зөвшөөрөгдсөн Үржлийн мал, амьтнаас бусад мал амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдэд импортын мэдэгдэл. Монгол гэр, ургамлын болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын</p>	Ханх		<p>Газар, нэгжийн удирдлагын цохолтоор экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамлын экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид тус тус холбогдох баримт бичгийн бүрдэл, биет үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн хянаж, үзээд бичилт хийнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.</p>

	мэдэгдэл			
12	Булган			
13	Сүхбаатар боомт дахь ХМХА	Гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, ОХУ-аас импортлогдож буй тасалсан цэцэг, мод гуалин, модон бэлдэц, шахмал модон хавтан, фанерьяд импортын мэдэгдэл монгол гэр экспортын гэрчилгээ.	Алтанбулаг Сүхбаатар	Алтанбулаг Сүхбаатар
14	Дархан- Уул	Мах, махан бүтээгдэхүүн, угаасан ноос, ноолуур, арьс, шир, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, Рапс, модон бэлдэц, хивэг,	Замын-Үүд Алтанбулаг Булган Буянт-Ухаа Гашуунсухайт Шивээхүрэн Хавирга Баянхошуу Бичиг	Гэрийн тэжээвэр амьтны болон зорчигчийн хувийн хэрэглээний махны экспортын гэрчилгээг албаны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хянан үзэж, холбогдох бичиг баримтын бүрдүүлбэр бүрэн тохиолдолд гэрчилгээ бичих, гэрчилгээнд ХМХА-ны дарга болон хэлтсийн дарга гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарж баталгаажуулах. Тасалсан цэцэг, мод гуалин, модон бэлдэц, шахмал модон хавтан, фанер импортлох импортын мэдэгдэл болон монгол гэр, ургамлын эрүүл ахуйн гэрчилгээг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагч хянан үзэж, гэрчилгээ мэдэгдэл бичих, гэрчилгээнд ХМХА-ны дарга болон хэлтсийн дарга гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарж баталгаажуулах. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх. Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл авах хүсэлтийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагч шинжилгээний дүн, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж бичнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын

		<p>Гурвалжин будаа, монгол гэр, ургамлын болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, хивэг экспортлох гэрчилгээ</p>			<p>Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах. Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.</p>
15	Орхон	<p>Мах, махан бүтээгдэхүүн, угаасан ноос, ноолуур, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ,</p> <p>Ралс, хивэг, гурвалжин будаа, монгол гэр, ургамлын болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, хивэг экспортлох гэрчилгээ</p>		<p>Замын-Үүд Алтанбулаг Булган Буянт-Ухаа Гашуунсухайт Шивээхүрэн Хавирга Баянхошуу Бичиг</p>	<p>Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл авах хүсэлтийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагч шинжилгээний дүн, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж бичнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах.</p> <p>Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.</p>
16	НМХГ	<p>Мал, амьтны гаралтай түүхий эд /угаасан ноос, ноолуур, боловсруулсан арьс, шир/, лавораторийн шинжилгээний дээж, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, мал, амьтны тэжээлд импортын мэдэгдэл,</p>	<p>Замын-Үүд Алтанбулаг Буянт-Ухаа</p>	<p>Замын-Үүд Алтанбулаг Буянт-Ухаа Гашуунсухайт Шивээхүрэн Булган Хавирга Баянхошуу Бичиг</p>	<p>Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл авах хүсэлтийг ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагч шинжилгээний дүн, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж бичнэ. Гэрчилгээ, мэдэгдлийг бичихдээ МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын холбогдох улсын ахлах байцаагч нараас зөвлөмж, чиглэл авах.</p> <p>Бичсэн гэрчилгээ, мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээг</p>


	<p>Хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мод гуалин, тасалсан цэцэг, төрөл бүрийн зөрөг цэцэгэнд импортын мэдэгдэл, Гэрийн мод, ургамлын болон хөрс, чулууний дээж, хатаадаст ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ</p>			<p>чиглэл тус бүрээр 7 хоног бүрийн баасан гаригт МХЕГ-ын Экспорт, импорт, хиллийн хорио цээрийн хяналтын газарт илгээх.</p>
--	--	--	--	--

Нэмэлт тайлбар:

- 1.Зөвхөн өөрийн харьяа нутаг дэвсгэрт бүртгэлтэй аж ахуйн нэгж, иргэнд гэрчилгээ, мэдэгдэл бичих.
- 2.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зориулалтын тоноглолтой тээврийн хэрэгслээр тээвэрлэх шаардлагыг хангуулсан байх;
- 3.Хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох аж ахуйн нэгж нь "Хүнсний тухай" хуулийн 11 дүгээр зүйл, "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай" хуулийн 13 дугаар зүйл, "Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай" хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, журамд заасан шаардлага хангасан байх.
- 4.Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох аж ахуйн нэгжид импортын мэдэгдэл олгохдоо эрсдэлийн хянан магадалгаа хийж Монгол Улсад бүртгэгдсэн аж ахуйн нэгжээс эсвэл "Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай" хуулийн 26.4 дэх "Эрсдэлийн задлан шинжилгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулан улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас томилогдсон мэргэжлийн баг гүйцэтгэнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлэх мэргэжлийн багийн шийдвэрийг үндэслэнэ.
- 5.Гэрчилгээг аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дарга, түүний эзгүйд дэд дарга, хэлтсийн дарга гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарж баталгаажуулна.
- 6.Өвс, үржлийн бус мал, амьтан экспортлох, гэрчилгээ бичих бол Засгийн газар болон ХХААХҮЯ-ны шийдвэрийг үндэслэн МХЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу бичнэ.

ооОоо

Ебаримт ашиглан төлбөр хийх



Economy	Trading Across Borders						Enforcing Contracts				Resolving Insolvency						
	Time to export: Documentary compliance (hours)	Cost to export: Border compliance (US\$)	Cost to export: Documentary compliance (US\$)	Time to import: Border compliance (hours)	Time to import: Documentary compliance (hours)	Cost to import: Border compliance (US\$)	Cost to import: Documentary compliance (US\$)	Ease of trading across borders score	Ease of Trading RANK	Time (days)	Cost (% of claim)	Quality of judicial processes index (0-18)	Ease of enforcing contracts score	Contracts RANK	Recovery rate (cents on the dollar)	Strength of insolvency framework index (0-16)	Ease of insolvency
Luxembourg	1	0	0	0	1	0	0	100.0	1	321.0	9.7	8.5	73.3	18	43.9	7.0	
Madagascar	49	868	117	99	58	595	150	61.0	140	811.0	33.6	8.0	50.0	136	12.4	9.0	
Malawi	75	243	342	55	55	143	162	65.3	127	522.0	69.1	9.5	47.4	149	15.6	8.5	
Malaysia	10	213	35	36	7	213	60	88.5	49	425.0	37.9	13.0	68.2	35	81.0	7.5	
Maldives	48	596	300	100	61	981	180	55.9	157	760.0	18.5	5.5	52.5	124	50.2	2.0	
Mali	48	242	33	98	77	545	90	73.3	95	620.0	52.0	5.0	42.8	159	28.3	9.0	
Malta	24	370	25	2	1	230	0	88.9	48	505.0	21.5	10.5	67.6	41	39.2	5.5	
Marshall Islands	24	298	20	84	60	298	43	78.9	76	616.0	32.1	8.0	55.9	106	17.1	0.0	
Mauritania	51	749	92	69	64	580	400	60.3	144	370.0	23.2	8.0	66.0	48	0.0	0.0	
Mauritius	9	303	128	41	9	372	166	81.0	72	490.0	25.0	13.5	72.2	20	67.4	12.0	
Mexico	8	400	60	44.2	17.6	450	100	82.1	69	340.7	33.0	10.1	67.0	43	63.9	11.5	
Mexico Mexico City	8	400	60	44	18	450	100	82.1	69	350.0	33.5	9.5	65.5	43	63.9	11.5	
Mexico Monterrey	8	400	60	44	18	450	100	82.1	69	295.0	30.4	13.0	74.6	43	63.9	11.5	
Micronesia, Fed. Sts.	26	168	60	56	35	180	80	84.0	65	885.0	66.0	4.5	29.4	184	3.4	11.5	
Moldova	48	76	44	4	2	83	41	92.3	38	585.0	28.6	11.0	63.6	62	32.1	12.0	
Mongolia	168	225	64	48	115	210	83	60.8	143	374.0	22.9	5.5	61.4	75	18.2	6.5	
Montenegro	5	85	26	23	6	306	60	91.9	41	545.0	25.7	11.5	66.8	44	50.3	12.5	

DB20_Score_Calculator

Select Language:

English

Note: For economies for which

Economy	Cross Borders				Enforcing Contracts				Resolving Insolvency			Ease of Doing Business				
	Time to import: Documentary compliance (hours)	Cost to import: Border compliance (US\$)	Cost to import: Documentary compliance (US\$)	Ease of trading across borders score	Ease of Trading RANK	Time (days)	Cost (% of claim)	Quality of judicial processes index (0-18)	Ease of enforcing contracts score	Ease of Contracts RANK	Recovery rate (cents on the dollar)	Strength of insolvency framework index (0-16)	Ease of resolving insolvency score	Ease of Resolving Insolvency RANK	Rank as of Current Data	Overall ease of doing business score as of current data (0-100)
Luxembourg	1	0	0	100.0	1	321.0	9.7	8.5	73.3	18	43.9	7.0	45.5	93	72	69.6
Madagascar	58	595	150	61.0	140	811.0	33.6	8.0	50.0	136	12.4	9.0	34.8	135	161	47.7
Malawi	55	143	162	65.3	127	522.0	69.1	9.5	47.4	149	15.6	8.5	34.9	134	109	60.9
Malaysia	7	213	60	88.5	49	425.0	37.9	13.0	68.2	36	81.0	7.5	67.0	40	12	81.5
Maldives	61	981	180	55.9	157	760.0	18.5	5.5	52.5	124	50.2	2.0	33.3	141	147	53.3
Mali	77	545	90	73.3	95	620.0	52.0	5.0	42.8	159	28.3	9.0	43.4	102	148	52.9
Malta	1	230	0	88.9	48	505.0	21.5	10.5	67.6	41	39.2	5.5	38.3	121	88	66.1
Marshall Islands	60	298	43	78.9	76	616.0	32.1	8.0	55.9	106	17.1	0.0	9.2	167	153	50.9
Mauritania	64	580	400	60.3	144	370.0	23.2	8.0	66.0	48	0.0	0.0	0.0	168	152	51.1
Mauritius	9	372	166	81.0	72	490.0	25.0	13.5	72.2	20	67.4	12.0	73.8	28	13	81.5
Mexico	17.6	450	100	82.1	69	340.7	33.0	10.1	67.0	43	63.9	11.5	70.3	33	60	72.4
Mexico Mexico City	18	450	100	82.1	69	350.0	33.5	9.5	65.5	43	63.9	11.5	70.3	33	60	71.7
Mexico Monterrey	18	450	100	82.1	69	295.0	30.4	13.0	74.6	43	63.9	11.5	70.3	33	60	75.7
Micronesia, Fed. Sts.	35	180	80	84.0	65	885.0	66.0	4.5	29.4	184	3.4	11.5	37.8	125	158	48.1
Moldova	2	83	41	92.3	38	595.0	28.6	11.0	63.6	62	32.1	12.0	54.8	67	48	74.4
Mongolia	115	210	83	60.8	143	374.0	22.9	5.5	61.4	75	18.2	6.5	30.1	150	81	67.8
Montenegro	6	306	60	91.9	41	545.0	25.7	11.5	66.8	44	50.3	12.5	66.1	43	50	73.8

DB20_Score_Calculator